

# БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ ДУНД ШАТНЫ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

(II ЦУВРАЛ)

Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч,  
туслах байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч нарт зориулав.

Захиалагч:



БАЙГАЛЬ ОРЧИН,  
УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлэн зохион байгуулж, нэгтгэн боловсруулсан:



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ  
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ

KFW



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН  
(WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ  
ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

Гүйцэтгэсэн:



МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН  
ИХ СУРГУУЛЬ



ДОТООД ХЭРГИЙН  
ИХ СУРГУУЛЬ

Хамтран ажилласан:



МОНГОЛЫН  
БАЙГАЛЬ  
ХАМГААЛАГЧДЫН  
ХОЛБОО



ГЕРМАНЫ ОЛОН  
УЛСЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ  
НИЙГЭМЛЭГ (GIZ)



ИРВЭС  
ХАМГААЛАХ  
САН



ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН ЭСРЭГ  
ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ  
ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ



БАЙГАЛЬ, ЗЭРЛЭГ АМЬТДЫГ  
ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ  
(WCS)-ИЙН МОНГОЛ ДАХЬ  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Улаанбаатар хот  
2025 он

ДАА: 351.84  
ННА: 20.18  
Б-174

## РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ:

### Ерөнхий редактор:

Б.Чимэддорж, Ц.Уранчимэг, С.Пүрэвсүрэн

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

С.Баярхүү, С.Цэндсүрэн, П.Сайнбилэг,  
О.Баярмаа, М.Амгалан, Ч.Бат-Өлзий,  
Маркус Пеш

### Хэвлэлийн эхийг хянасан:

Профессор Р.Самъяа

### Хянаж, хэвлэлд бэлтгэсэн:

Зөвлөх С.Пүрэвсүрэн

---

### Зохиогчийн эрх:

© Байгаль орчин, уур амьсгалын  
өөрчлөлтийн яам

© Дэлхийн байгаль хамгаалах сан  
(WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн  
газар

---

Хавтас, хавчуулга зураг © Дэлхийн байгаль  
хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь  
хөтөлбөрийн газар

ISBN: 978-9919-9323-1-2

## БОЛОВСРУУЛСАН:

### Нэгдүгээр бүлэг:

Х.Тэрбиш  
М.Эрдэнэбаяр  
Д.Бадамцэцэг

### Хоёрдугаар бүлэг:

Х.Тэрбиш  
Р.Самъяа  
С.Шар  
С.Ганзориг  
Ж.Гэрэлтуяа  
Н.Жамъянхүү  
С.Пүрэвсүрэн

### Гуравдугаар бүлэг:

Б.Нарангуа  
Э.Төгөлдөр  
Н.Нямжаргал  
Б.Билгүүн  
Б.Чойдогжамц  
Б.Гантулга  
Э.Сэргэлэн  
Ц.Мөнхзул  
С.Цэндсүрэн

### Дөрөвдүгээр бүлэг:

Л.Ариунжаргал  
М.Цэрэннадмид

### Тавдугаар бүлэг:

Ц.Сэр-Од  
Х.Тэрбиш

# ГАРЧИГ

## ӨМНӨХ ҮГ . . . . . 6

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН . . . . . 7

1.1. Монгол төрийн байгаль орчны бодлогын залгамж чанар . . . . .	8
1.2. Уур амьсгалын өөрчлөлт ба төрийн бодлого . . . . .	14
1.3. Байгаль орчны салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчин. . . . .	21
1.3.1. Эрх зүйн хэм хэмжээний акт . . . . .	22
1.3.2. Эрх зүйн дэд акт . . . . .	28
1.3.3. Эрх зүйн бусад акт . . . . .	34
1.4. Байгаль орчны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, нэгдэн орсон гэрээ, конвенц . . . . .	35
1.4.1. Олон улсын хэмжээнд тулгамдаж буй байгаль орчны асуудлууд . . . . .	36
1.4.2. Байгаль орчны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа . . . . .	39
1.4.3. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээр . . . . .	44
Асуулт . . . . .	48
Дасгал . . . . .	48
Мэдлэг сорих тест. . . . .	49
Ашигласан болон гүнзгийрүүлэн сонирхож унших материал. . . . .	55

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА . . . . . 56

2.1. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны тухай үндсэн ойлголт. . . . .	57
2.2. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны олон улсын хэмжээний эрх зүйн зохицуулалт, зарим орны жишиг туршлага . . . . .	59
2.2.1. Амьтны эрхийн түгээмэл тунхаглал . . . . .	59
2.2.2. Амьтан авран хамгаалах олон улсын байгууллага . . . . .	60
2.2.3. Европын зарим улс оронд мөрдөж буй зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны онцлог. . . . .	63
2.3. Монгол Улсад амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалт. . . . .	65
2.4. Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд стандартчиллын үүрэг, ач холбогдол . . . . .	74
2.5. Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа ба ёс суртахуун . . . . .	77
2.5.1. Биологийн зүйлийг хамгаалахад дагаж мөрдөх ёс зүйн үндсэн зарчим. . . . .	77
2.5.2. Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ. . . . .	79
2.5.3. Ил тод байдал ба зөвшилцөл . . . . .	80
2.6. Зэрлэг амьтан авран хамгаалагчдын эзэмшвэл зохих үндсэн мэдлэг, чадвар, дадал . . . . .	81
2.7. Зэрлэг амьтанд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ . . . . .	83
2.8. Амьтны маллагаа, асаргааны үед нийтлэг илэрч болох эмгэг. . . . .	88
2.9. Амьтны маллагаа, асаргааны үед анхаарах зүйлс . . . . .	91
2.9.1. Хорио цээр, тусгаарлах болон дасан зохицох үе . . . . .	92
2.9.2. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх арга, бодис урвалж ба халдвар, хамгааллын хувцасны тухай . . . . .	92

2.9.3. Амьтан аврах, асран хамгаалах байранд өвчин тархахаас хамгаалж, сэргийлэх нь. . . . .	95
2.10. Зэрлэг амьтны ангилал зүйн бүлэг бүрийн аврах, асран хамгаалах ажлын онцлог. . . . .	97
2.10.1. Хөхтөн амьтадтай зөв харьцах онцлог. . . . .	97
2.10.2. Тусламж шаардлагатай болсон шувууг асрах, авран хамгаалах ажлын онцлог . . . . .	98
2.10.3. Хоёр нутагтан ба мөлхөгчдийг аврах, асран хамгаалах ажлын онцлог . . . . .	104
Даалгавар . . . . .	107
Мэдлэг сорих тест. . . . .	108

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ СМАРТ ПРОГРАММААР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙ . . . . . 111**

3.1. СМАРТ программын тухай. . . . .	112
3.2. Зорилгоо тодорхойлох . . . . .	116
3.3. Эргүүл, хяналтын ажлын төлөвлөлт . . . . .	117
3.4. Эргүүл, хяналт шалгалт, мониторингийг хэрэгжүүлэх, мэдээлэл цуглуулах . . . . .	118
3.5. СМАРТ мэдээллийн сангийн менежмент . . . . .	128
3.6. Тайлагнах . . . . .	130
3.7. Холбоос (Connect) . . . . .	132

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР БА ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ . . . . . 137**

4.1. Харилцааны үндэс ба соёл . . . . .	138
4.1.1. Харилцааны ур чадвар гэж юу вэ?. . . . .	138
4.1.2. Харилцаа гэж юу вэ? . . . . .	138
4.1.3. Харилцааны ач холбогдол . . . . .	138
4.1.4. Өөрийгөө таних тухай . . . . .	139
4.1.5. Харилцааны үндсэн ойлголтууд . . . . .	140
4.1.6. Харилцааны үүрэг . . . . .	141
4.2. Харилцааны соёл, ёс зүй, зарчим . . . . .	143
4.2.1. Харилцааны соёл. . . . .	143
4.2.2. Харилцааны ёс зүй . . . . .	144
4.2.3. Харилцааны үндсэн зарчмууд . . . . .	145
4.2.4. Харилцааны хэлбэрүүд. . . . .	146
4.3. Гэр бүл болон ажлын байран дахь харилцаа. . . . .	151
4.3.1. Гэр бүлийн харилцаа . . . . .	151
4.3.2. Ажлын байрны харилцаа . . . . .	152
Бүлгийн дүгнэлт . . . . .	155
4.4. Манлайлал ба үр дүнтэй харилцааны арга барил . . . . .	156
4.4.1. Удирдан манлайлах чадвар . . . . .	156
4.4.2. Ухаалаг манлайлал ба дотоод итгэл . . . . .	157
4.4.3. Дотоод, гадаадын түншүүдтэй харилцах арга хэлбэр, зарчим. . . . .	159
4.4.4. Нутгийн иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг бэлтгэж хүргэх, танилцуулах . . . . .	160
4.4.5. Аман судалгаагаар мэдээлэл цуглуулж, боловсруулах арга техник. . . . .	164
Бүлгийн дүгнэлт . . . . .	166
4.5. Эерэг хандлага ба хувь хүний манлайлал . . . . .	167
4.5.1. Эерэг хандлага ба үлгэрлэх хүч . . . . .	167
4.5.2. Ёс зүй ба хариуцлагатай байдал. . . . .	168
4.5.3. Асуудал шийдвэрлэх ба санаачилга гаргах . . . . .	170
4.5.4. Бусдыг дэмжих ба урамшуулах . . . . .	171

4.5.5. Дасан зохицох ба тодорхойгүй нөхцөлд орших ур чадвар . . . . .	173
Бүлгийн дүгнэлт . . . . .	175
4.6. Стрессийн удирдлага ба багаар ажиллах ур чадвар . . . . .	176
4.6.1. Ажлын байрны стресс, түүнийг даван туулах арга техник . . . . .	176
4.6.2. Багаар ажиллах ур чадвар . . . . .	178
4.6.3. Маргаан шийдвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чадвар . . . . .	179
4.6.4. Сөргөлдөөн, түүнийг намжаах арга техник . . . . .	181
Бүлгийн дүгнэлт . . . . .	183
Даалгавар . . . . .	184
Бие даалт . . . . .	185
Мэдлэг сорих тест. . . . .	187
Ашигласан болон гүнзгийрүүлэн сонирхож унших материал. . . . .	190
<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЧ, ТАЙЛБАРЛАГЧ. . . . .</b>	<b>191</b>
5.1. Орон нутгийн түүх, соёл, уламжлал, ёс заншил . . . . .	192
5.1.1. Соёлын тухай ойлголт, түүний тодорхойлолт . . . . .	192
5.1.2. Монголчуудын уламжлалт зан заншил . . . . .	194
Бүлгийн дүгнэлт . . . . .	197
5.2. Чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийн онцлох дурсгалууд, булш бунхан, археологийн олдворууд. . . . .	198
5.2.1. Чулуун зэвсгийн үеийн онцлог, дурсгалууд . . . . .	198
5.2.2. Хүрэл зэвсгийн үе. . . . .	201
Бүлгийн дүгнэлт . . . . .	202
5.3. Монгол орны байгаль, газарзүйн тогтоц, бүс бүслүүрийн онцлог . . . . .	203
5.3.1. Бүс ба бүслүүрийн ялгаа, нөлөөлөх хүчин зүйл . . . . .	203
5.3.2. Байгалийн бүс, бүслүүр . . . . .	204
Бүлгийн дүгнэлт . . . . .	208
5.4. Монгол орны ургамал, амьтны аймгийн онцлог . . . . .	209
5.4.1. Монгол орны ургамлын аймгийн судалгааны тойм . . . . .	209
5.4.2. Монгол орны амьтны аймгийн судалгааны тойм . . . . .	212
Бүлгийн дүгнэлт . . . . .	215
5.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн газарзүйн тогтоц, биологийн олон янз байдал, түүх, соёл . . . . .	216
5.5.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ойлголт . . . . .	216
5.5.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн олон улсын ангилал . . . . .	217
5.5.3. Газар нутгийг дархлан хамгаалж ирсэн түүхийн тойм . . . . .	219
5.5.4. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал . . . . .	221
Бүлгийн дүгнэлт . . . . .	232
Асуулт, даалгавар. . . . .	233
Бие даалтын сэдэв . . . . .	233
Мэдлэг сорих тест. . . . .	234
Ашигласан болон гүнзгийрүүлэн сонирхож унших материал. . . . .	238
Тестийн зөв хариулт . . . . .	240
<b>ХАВСРАЛТ . . . . .</b>	<b>241</b>
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/189 дүгээр “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр батлах тухай” тушаал ба хавсралтууд . . . . .	242

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын байгаль орчныг хамгаалах үйл хэрэг, түүний төлөөх зүрх сэтгэл эрхэм. Энэ үйлсэд, энэ зорилгод хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж буй “Байгаль хамгаалагч” Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны гуравдугаар сарын 29-ний өдрийн А/189 тоот тушаалаар “**Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр**”-ийг батлан, хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Уг хөтөлбөрийн хүрээнд байгаль хамгаалагчдыг мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол, хандлага, хариуцлагын түвшнээр нь тогтмол хөгжүүлэн чадавхжуулж, мэргэшүүлэх зорилгыг зарчим болгосон бөгөөд **анхан, дунд, ахисан шатны сургалтын гарын авлагуудыг** боловсруулан бэлтгээд байна.

Энэ нь зөвхөн байгаль хамгаалагч нарт зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн төдийгүй байгаль орчныг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй, ухамсартай иргэн бүрд нээлттэй. Мөн хүртээмжтэй түгээгдэж буйгаараа онцлог юм. Эл хандлага, зохион байгуулалт нь байгаль орчныг хамгаалах үйл хэрэг зөвхөн тодорхой салбарын бус, нийгмийн нийт цуг хамтын оролцоотой, хариуцлагатай үйлс, зарчимт мөрдлөг гэдгийг харуулж байна.

Мөн уг гарын авлага нь байгаль хамгаалагчдыг чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болж, олон талт хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна.

Бид байгаль орчныг хамгаалах үйлсэд бодит хувь нэмэр оруулж буй хүн бүрийн идэвх санаачилга, дэмжлэгт гүн талархалтай ханддаг. Иймд гарын авлагыг өдөр тутмын ажилдаа өргөнөөр ашиглаж, мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлэн, эх орныхоо байгалийг хамгаалах нэр хүндтэй үйл хэрэгт улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөгөө, техникийн туслалцаа үзүүлэн хамтран ажилласан холбогдох бүх байгууллага, хамт олон, эрдэмтэн, судлаач, багш нарт гүн талархал илэрхийлье.

Цаашид бид хамтын ажиллагаагаа шинэ шатанд гаргаж, байгаль хамгаалагчдын чадавхыг бүх талаар бэхжүүлэн, Монгол Улсын газар нутгийн хамгаалалтын “30х30” зорилтыг амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт гүн бат итгэж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД



Б.БАТБААТАР

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**



## 1.1 МОНГОЛ ТӨРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАР

Төрийн бодлого нь үзэл баримтлалд тулгуурласан, ихэвчлэн хөтөлбөрөөр хэрэгжиж бодит амьдралын асуудлуудыг шийдвэрлэх буюу шийдвэрлэхэд чиглэсэн хууль тогтоомж, дүрэм журам, заавар, арга хэмжээ зэрэг зохион байгуулалттай санал эсхүл шийдвэрлэсэн багц элементүүд юм. Эдгээр бодлого нь боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, ажил эрхлэлт, санхүү, эдийн засаг, тээвэр зэрэг нийгмийн амьдралын бүхий л салбарыг хамарна.

Төрийн бодлогын хэрэгжилтийг төрийн удирдлага гэж нэрлэнэ. Төрийн бодлогыг төрийн шууд болон шууд бус үйл ажиллагааны нийлбэр гэж үзэж болох бөгөөд олон янзаар үзэл баримтлалыг гаргаж ирдэг. Тэдгээрийг ихэвчлэн Засгийн газар олон нийтийн нэрийн өмнөөс бий болгож эсхүл баталдаг. Зарим тохиолдолд ашгийн бус иргэний нийгмийн байгууллагууд иргэд, олон нийттэй хамтран боловсруулдаг бөгөөд түүнд шинжээч, эрдэмтэн, инженер, сонирхогч талууд оролцохоос гадна, шинжлэх ухааны өгөгдөл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг ашиглана.

Иймээс бодлогын үйл явц нь олон оролцогчтой (сонгогдсон улстөрчид, улс төрийн намын удирдагчид, шахалтын бүлэг, төрийн албан хаагчид, шүүгчид, төрийн бус байгууллагууд, олон улсын агентлагууд, эрдэм шинжилгээний судлаач, шинжээчид, сэтгүүлчид болон зарим идэвхгүй иргэд г.м) улс төрийн нарийн төвөгтэй үйл явц юм.


Манай улсын хувьд 1990 оноос өмнө БНМАУ-ын хөгжлийн бодлогыг тав таван жилээр төлөвлөн МАХН, Ардын Их Хурлаар (АИХ)-аар хэлэлцэгдэн хэрэгжиж байв (Зураг 1.1).

1990 оноос хойш бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг төрөөс зохион байгуулж ирсэн бөгөөд ихэвчлэн алсын хараа буюу урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг бус, сонгуульд ялсан намын мөрийн хөтөлбөрт тулгуурласан бодлого хэрэгжиж иржээ. Өөрөөр хэлбэл, урт хугацааны залгамж чанартай биш, харин дунд, богино хугацааны бодлого голлож байв (Зураг 1.2).

Төрийн бодлого ялангуяа, байгалийн баялгийг хамгаалах, ашиглах талаар Монгол Улсын үндсэн хуульд тусгайлан зааж өгчээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ”, “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” хэмээн заажээ.

Шилжилтийн хэмээн нэрлэдэг үе 1999 оноор дуусгавар болж байх үетэй зэрэгцэн дэлхийн улс орнуудад шинэ мянганы босгон дээр хөгжлийн цоо шинэ төлөвлөлтийг хийж эхэлсэн юм. 2000 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейд оролцсон 189 орны Засгийн газар оролцсон шинэ **Мянганы тунхаглалыг** баталсан. Дэлхийн улс орны тэргүүнүүд даян дэлхийд энх тайван, хөгжил цэцэглэл болон шударга ёсыг тогтоохоор хамтран ажиллах амлалт авсан нь урьд өмнө тохиолдож байгаагүй цоо шинэ зүйл болсон юм. Хүний аж байдлыг сайжруулах, ядуурлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг нэмэгдүүлэх, хүний эрх болон ардчиллыг хангах, байгаль орчныг хамгаалах үйл явцыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн даян дэлхийн эрхэм зорилгын хэрэгжилтийг хангахын тулд Мянганы хөгжлийн зорилт нэртэй амлалтыг 2001 онд баталсан юм.

**Зураг 1.1. БНМАУ-ын хөгжлийн бодлого, аж үйлдвэрийн түүхэн хөгжил (1945-1988 он)**



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Мянганы хөгжлийн зорилтууд нь Монгол Улсын төрийн бодлогод тусгалаа олж УИХ-аас Мянганы хөгжлийн зорилтуудыг харьцуулах үзүүлэлт болгон 2005 онд баталсан бөгөөд түүнийг 2008-2021 оны Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын суурь болгон ашигласан. Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтуудад 2008 онд дахин тодотгол хийж 9 зорилгын хүрээнд 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлт баталсан байдаг. Тус зорилгын 7 дугаарт Байгаль орчны тогтвортой байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлсэн зарим ажлаас товч дурдвал, улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь 1990 онд 3.6% байсан бол 2000 онд 13.1% болж нэмэгдсэн боловч төдийлөн хангалттай бус байлаа. Харин 2012 онд 1.3 сая га талбай бүхий 15 газрыг УИХ-ын шийдвэрээр улсын тусгай хамгаалалтад шинээр хамруулснаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ манай улсын нийт нутаг дэвсгэрийн 17.4%-ийг эзлэх болсон байна. Энэ мэт амжилтууд багагүй. Мянганы хөгжлийн зорилтуудын 24 зорилтоос 8 зорилт бүрэн биелсэн, 7 зорилтын хувьд нэмэлт арга хэмжээ авсан, 5 зорилтын хэрэгжилтийг дүгнэж чадаагүй байна. Мянганы хөгжлийн зорилтоос гадна, 1998 оноос хойш эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байлаа.

Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх хугацаа 2015 онд дуусгавар болж, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан бөгөөд хэрэгжээгүй зорилт бүрийг нөхөн хэрэгжүүлэх, дараагийн арван таван жилийн хөгжлийн зорилтыг дэлхийн Улс орнуудын хэмжээнд тодорхойлсон.

**Зураг 1.2. Монгол Улсын хөгжлийн бодлогын үндсэн баримт бичгүүд**



2015 оны 9 дүгээр сард НҮБ-ийн гишүүн 193 орны төрийн тэргүүнүүд бүгд санал нэгтгэйгээр “Эх дэлхийгээ шинэчилье” нэртэй 17 зорилго, 169 зорилт бүхий **“2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”**-ийг баталсан. Нийт 17 зорилгод ядуурал, боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндээс эхлээд бидний амьдарч буй нийгэмд дэлхийн хаана ч очсон түгээмэл тулгардаг асуудал бэрхшээлүүдийг энд багцалсан юм. Тогтвортой хөгжлийг олон талаас нь, төрөл бүрээр тодорхойлж болно. Гэхдээ түгээмэл ашиглагдаж буй тодорхойлолт нь “Ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийнхөө хэрэгцээг хангах бодлогыг тогтвортой хөгжил гэнэ” ойлгомжтой байгаа биз? Хойч үедээ эх дэлхийгээ энэ чигээр нь өвлүүлэхийн тулд, шударга-энх тайван-хүртээмжтэй нийгэмд амьдруулахын тулд, аз жаргалтай-сэтгэл хангалуун-сайн сайхан орчныг бэлтгэхийн тулд бид өнөөдөр хариуцлагатайгаар аж төрөх учиртай. Мөн хөгжлийн төлөө хэнийг ч орхихгүй гэсэн уриатай. Монгол Улс ч **“2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”**-ийг батлан гаргаж, шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Яагаад хүн бүр эдгээр зорилгуудын талаар мэдэх ёстой гэж? Нийгмийн амьдралд хамаарагдаж буй оролцогч талууд бүгд хувь нэмрээ оруулж байж бид эдгээр зорилгуудад хүрэх учиртай. Төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгмээс эхлээд олон нийт ч үүнд багтана. Эдгээр зорилгууд эх дэлхий дээр амьдран суугаа 8 тэрбум хүмүүст бүгдэд нь нөлөөлөхүйц учир хүн бүр тодорхой хэмжээний мэдлэг, мэдээлэл, дадалтай байх нь нэн чухал юм. Ингэж байж л бид хамтдаа илүү сайхан дэлхийг цогцлоож чадна гэсэн агуулгатай.

Манай улс дэлхий нийтийн хөгжлийн бодлогын чиг хандлагыг бүтээлчээр судалж, өөрийн орны онцлогийг тусгасан хөгжлийн урт хугацааны бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.

Ийнхүү 2019 оноос Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулж эхлэв. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 52 дугаар тогтоолоороо **“Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан юм.

Төрийн бодлогыг урт, дунд, богино хугацааны гэж ангилан хэрэгжилтийг үе шаттайгаар ханган ажилладаг. Энэ бодлогын баримт бичиг нь урт хугацааны бодлогын баримт бичиг юм. Энэ баримт бичигт байгаль орчны талаар хэрхэн тусгагдсаныг дараа нь товч үзнэ.

Дэлхийн улс орнууд аж үйлдвэржсэн эринээс мэдээлжсэн эринд шилжих үйл явц улам эрчимжиж, улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарын хүрээнд цахим мэдээллийн технологийг өргөнөөр нэвтрүүлж, хөгжлийн хурдасгуур болгон хэрэглэж байна. Түүнтэй нэгэн адил байгаль орчны бодлогод ч гэсэн шинжлэх ухаан техник, технологи, инновац нэвтрэн орж байна.

Байгаль орчны чиглэлийн төрийн бодлого нь ганцхан бодлогын баримт бичгээр хэрэгждэггүй. Хуулиудад тусгалаа олдог. Тодруулбал, Үндсэн хууль болон салбарын бусад хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, бодлогын баримт бичгээр дамжин хэрэгждэг. Манай улсын хувьд байгаль орчны талаарх төрийн бодлогыг Үндсэн хууль, байгаль орчин болон бусад салбарын хэмжээний хууль, тогтоомж, бодлого, үндэсний хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Ойн тухай хууль зэрэг 30 гаруй хуулиуд, “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”, “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” гэх мэт баримт бичгүүд батлагдан гарсан нь амьтан, ургамлын аймгийг хамгаалах, нөөц баялгийг зүй зохистой ашиглах, экосистемийн тогтворт байдлыг хадгалан үлдээх эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн. Бодлого гэдэг бол угтаа үйл ажиллагааны төлөвлөгөө юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн 6 дугаар хэсэг бүхэлдээ **ногоон хөгжилд** зориулагджээ.

**Зорилго 6.** Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.

- Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- Хүрээлэн байгаа орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн, эх дэлхийн экосистемийн үйлчилгээг тэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулна.
- Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.
- Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ.
- Стратегийн үнэт баялаг усны талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж усны нөөц бохирдож, хомсдохоос сэргийлнэ.
- Хөв цөөрөм, урсцын тохируулгатай усан сан, ус нөөцлөх, дамжуулах далд систем байгуулах ажлыг эрчимжүүлж усны хуримтлалыг нэмэгдүүлнэ.
- Газрын доорх усны судалгааг өргөжүүлж, олборлолт, ашиглалт, нөхөн сэргээлтэд тэргүүний дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.
- Байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлж хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хэмнэх хаягдалгүй эдийн засгийн хөгжүүлнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.
- Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, хот, суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно.

Урт хугацааны бодлогод ийм стратеги төлөвлөгдсөн бол өнөө цагт буюу дунд болон ойрын хугацааны зорилтод байгаль орчны талаар хэрхэн тусгагдсаныг авч үзье. Гэхдээ салбарын бодлогыг ярихын өмнө Монгол Улсын Засгийн газрын бодлого мөрийн хөтөлбөрт анхаарлаа хандуулах ёстой.

Монгол Улсын Их Хурлаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдөр баталсан байна.

Тус мөрийн хөтөлбөрт Үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашгийг эрхэмлэж, эрх зүйт төрийн үндсэн зарчмуудыг удирдлага болгон, улсын эрх ашиг нэгдүгээрт байх зарчмыг үнэт зүйлээ болгон “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин 4 бодлогын хүрээнд 16 чиглэлийн 620 зорилтыг хэрэгжүүлэхээр боловсруулжээ.

Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн үндсэн дөрвөн бодлогын гуравдугаарт буюу эдийн засгийн бодлогын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт гэсэн хэсэгт байгаль орчны салбарын бодлогыг тусгажээ. Үүнд:

Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн чиглэлээр:

- Байгалийн унаган төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна.
- Биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоож, генетик нөөцийг нэмэгдүүлэн тогтвортой ашиглаж, байгалийн нөөцийг хамгаалж, экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоон, био аюулгүй байдлыг хангана.
- Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ.
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8.8%-д хүргэнэ.
- Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, ойн хомсдол, доройтлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ.

Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр:

- Уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгслийг ил тод, байгаль орчны үр нөлөөг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Говийн болон ус хангамжийн дутагдалтай бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Усны чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлж, экологийн чухал ач холбогдолтой Хөвсгөл нуур, Ганга нуур, Өгий нуур, Хэрлэн гол зэрэг усны сан бүхий газрыг нөхөн сэргээж, хамгаална.
- Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маяг, хандлага, дадлыг хэвшүүлнэ.
- Уул уурхайн нөхөн сэргээлтийн чанар, хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагыг чангатгана.

Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загварын чиглэлээр:

- Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлд тулгуурласан «Стандартаар байгаль орчны салбар» хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын үр дүнд суурилсан, хүрээлэн буй орчин, хүнд ээлтэй орчныг төлөвлөж, нийгэм, эдийн засгийн ногоон хөгжлийн загварыг бий болгоно.
- Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ.
- Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг нэвтрүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин, Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж, хөгжүүлнэ.
- Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

Дээрх бодлого, стратеги болон дэлхийн хэмжээнд тулгамдаж буй асуудлаас шалтгаалан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хэмээн шинэчлэн зохион байгуулж, цаашдын бодлого чиглэл зорилгоо тодорхойлсон байна.

**Эрхэм зорилго.** Байгаль хамгаалах нэгдмэл удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн нөөц, баялгийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамжтай үндэсний нийгэм, эдийн засгийн ногоон хөгжлийн загварыг бий болгоно.

*Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь:*

- Монгол Улсад хүрээлэн байгаа орчны тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг Улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон Улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан тодорхойлж төлөвлөх, хэрэгжүүлэх энэ чиглэлд Засгийн газрын манлайллыг хангах
- Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан чиглүүлэх
- Яам, салбарын албан хаагчдыг байгаль орчныг хамгаалах, ногоон технологийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход шинжлэх ухааны ололт, олон Улсын сайн тэргүүний арга туршлага, стандарт, бүтээмжийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын бодлого, хууль тогтоомж, стандарт, нормын шинэчлэл, зохицуулалтыг хэрэгжүүлэх зэрэг ажээ.

## 1.2 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ТӨРИЙН БОДЛОГО

Байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого нь иргэнийхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгаль орчин, байгалийн нөөцийнхөө харьцангуй давуу байдалд тулгуурлан нөөц баялгийг нь зохистой ашиглахад зохицсон аж ахуйн уламжлалт болон орчин үеийн нийтлэг хэвшлийг хослуулан хөгжүүлэх замаар байгалийн баялгийг нөхөн сэргээж, төрх байдлыг нь хамгаалж, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход чиглэгдэнэ хэмээн тодорхойлж байлаа.

Гэвч цаг хугацааны эрхээр энэхүү үзэл баримтлалын агуулгад өөрчлөлт орж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс шалтгаалсан бодлого баримтлах болж ирсэн. Өнөө цагт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтаа хоёр дахин бууруулж, 1.5°C-ийн зорилтод хүрэх боломжтой болгохын тулд шатах ашигт малтмалаас сэргээгдэх эрчим хүч рүү хурдан шилжих ёстой. Мөн хүнсний үйлдвэрлэл нь дэлхийн байгаль орчны өөрчлөлтийн хамгийн том шалтгаан бөгөөд хурдацтай явагдаж буй байгаль орчны доройтолд голлох түлхэц болж байна. Ийм учраас бид уур амьсгалын өөрчлөлтийн талаар зохих мэдлэгтэй байх ёстой. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үндсэн бодлого стратегитай байх ёстой.

**Уур амьсгалын өөрчлөлт** гэдэг нь урт хугацааны туршид дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүдсэн агаар мандал, далай, хуурай газрын дулаарлыг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлт нь амьдрал, биологийн олон янз байдлыг дэмждэг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахын зэрэгцээ эрүүл мэндэд ч сөргөөр нөлөөлж байна<sup>1</sup>. Түүнчлэн хар салхи, үер, хэт халалт, ган гачиг зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж, эрч хүч нэмэгдэж, далайн дулаарал, мөсөн голууд, мөсөн бүрхүүл хайлж далайн түвшин дээшлэхийн хэрээр далай тэнгисийн эрэг орчмын газрын элэгдэл нэмэгдэх эрсдэлд хүргэж байна.

2030 он гэхэд байгалийн алдагдлыг зогсоож, чиг хандлагыг эргүүлэхийн тулд уламжлалт байгаль хамгааллын үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэхээс гадна, хүнсний үйлдвэрлэл, хэрэглээ ба хаягдал, бидний хэрэглэж буй эрчим хүчний хэмжээ болон төрөл, эдгээр системийн өөрчлөлт шинэчлэлтийг дэмжих санхүүжилт зэрэг байгалийн алдагдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг системтэйгээр шийдвэрлэх шаардлагатай.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хамтын үйл ажиллагааны үр дүнд шинэ ойлголт, нэр томъёо бий болж байна. Үүнийг бид мэдэж байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тухайлбал, цаг агаар, уур амьсгал, хүлэмжийн хий, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт гэсэн нэр томъёог төрийн алба хаагч болох байгаль хамгаалагч төдийгүй иргэн бүр, хүүхэд залуучууд бүгд мэддэг байх хэрэгцээ үүссэн. Дэлхийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшигт үзэгдлийн давтамж 1970 оноос хойш 5 дахин нэмэгджээ.

Зарим нэр томъёог тайлбарлая.

**Цаг агаар** гэдэг нь тодорхой цаг хугацаа, газар нутгийн агаарын хэм, хур тунадас, ууршилт, чийгшил, үүлэн бүрхүүл, салхи, үзэгдэх орчин зэрэг үзэгдлийн төлөв байдлыг илэрхийлнэ. Цаг агаарын нөхцөл байдал нь дангаараа тохиолддоггүй, долгиолсон нөлөө үзүүлж байдаг. Нэг бүс нутгийн цаг агаар нь эцэстээ хэдэн зуун, бүр хэдэн мянган километрийн зайд байгаа бүс нутгийн цаг агаарт нөлөөлж байдаг.

<sup>1</sup> <https://www.undp.org/mn/mongolia/>

**Уур амьсгал** гэдэг нь аливаа газар нутгийн удаан хугацааны туршид буюу ихэвчлэн 30 болон түүнээс олон жилийн цаг агаарын төлөв байдлын дундаж үзүүлэлтээр тодорхойлогдох бөгөөд уур амьсгалын тогтолцооны ерөнхий төлөв байдлыг илэрхийлдэг. Аж үйлдвэржилт, хүний үйл ажиллагаанаас үүдсэн хүлэмжийн хийн ялгаруулалт нь манай гарагийн уур амьсгалыг эрс өөрчилж байна.

**Хүлэмжийн хий** нь манай гарагийн агаар мандалд нарны дулааныг барьж, дулааныг нь хадгалж байдаг хий юм. Аж үйлдвэржилтийн эрчимтэй хөгжлийн үеэс эхлэн хүлэмжийн хийн ялгарал эрчимтэй нэмэгдсэнээр дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг өдөөж ээдрээтэй түвшинд хүргэж байна. Хүлэмжийн хийн бүтцэд нүүрстөрөгчийн давхар исэл, метан хий, азотын исэл, хөргөлт, хөлдөөлтөд ашигладаг фторжсон хий хамаарна. Нүүрстөрөгчийн давхар исэл нь хүний үйл ажиллагаанаас, ялангуяа малтмал түлш шатаах, ойн нөөцийн хомсдол, газрын зохисгүй ашиглалт зэргээс үүдэлтэйгээр үүсэх хүлэмжийн хий юм. Малтмал түлш хэрэглэж эхэлснээс хойших сүүлийн 200 гаруй жилийн хугацаанд агаар мандал дахь нүүрстөрөгчийн давхар ислийн агууламж 50%-аар нэмэгдсэн байна.

**Дэлхийн дулаарал.** Агаар мандалд хүлэмжийн хийн агууламж нэмэгдэх үед үүсдэг дэлхийн гадаргуугийн дундаж температурын өсөлт юм. Эдгээр хий нь нарны цацрагийг илүү шингээж, илүү их дулааныг барьж, улмаар дэлхийг илүү халуун болгодог гэсэн үг.

**Уур амьсгалын өөрчлөлтийн эргэх гинжин холбоо.** Уур амьсгалын тогтолцоонд гарч буй нэг өөрчлөлт дараа дараагийн өөрчлөлтийг өдөөж, цаг хугацаа өнгөрөх тусам улам хүчтэй болж гинжин урвалууд нь эрчимжинэ. Энэ үед уур амьсгалын өөрчлөлтийн эргэх гинжин холбоо үүснэ. Гинжин холбооны үр дүн эргэлтийн цэгийг өдөөх бөгөөд энэ үед дэлхийн уур амьсгалын тогтолцоонд ноцтой өөрчлөлт гарч эргэж хэвдээ орох боломжгүй нөхцөл үүснэ.

**Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах.** Хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, улмаар бууруулах, эдгээр хийг агаар мандлаас зайлуулдаг нүүрстөрөгч шингээгчийг нэмэгдүүлэх зорилго бүхий засгийн газар, бизнес эрхлэгчид, хүмүүсийн авч буй хариу арга хэмжээ юм.

Салхи, нар гэх зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих, эрчим хүчийг илүү хэмнэлттэйгээр ашиглах, нүүрстөрөгч бага ялгаруулдаг буюу нүүрстөрөгч ялгаруулдаггүй тээврийг нэвтрүүлэх, тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалтыг дэмжих, үйлдвэрлэл, хэрэглээний загвар, хоол хүнсний дэглэмийг өөрчлөх замаар хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах буюу урьдчилан сэргийлэх боломжтой. Ой мод, чийглэг болон намгархаг газрыг нөхөн сэргээх, хөрсийг эрүүлжүүлэх, хуурай газрын болон далай, тэнгисийн экосистемийг хамгаалах замаар нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх боломжтой.

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох.** Цаг агаарын эрс тэс үзэгдэл, гамшигт нөхцөл байдал, далайн түвшний нэмэгдэлт, биологийн олон янз байдлын доройтол, хоол хүнс, усны аюулгүй байдал зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн өнөөгийн тулгамдаж байгаа болон цаашид тулгарч болзошгүй эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ.

Бид хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц хэмжээгээр түргэн бууруулахаар өөдрөгөөр тооцсон хувилбаруудыг хэрэгжүүлээ ч системийн хэмжээнд хэдийнээ хуримтлагдсан эрчим хүчний асуудлын улмаас уур амьсгалын өөрчлөлт манай дэлхийд ойрын хэдэн арван жилийн турш сөргөөр нөлөөлсөөр байх болно. Иймээс хүн төрөлхтөн, байгаль дэлхийгээ хамгаалахын тулд эдгээр нөлөөнд өргөн хүрээнд дасан зохицох шаардлагатай болж байна.

**Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвар.** Энэ бол тухайн улс орон, бүс нутагт байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг урьдчилан таамаглах, сэргийлэх, зохицуулах, тэдгээрээс үүдэх хохирлыг багасгах, анхны цочролын дараа шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх, өөрчлөх чадварыг хэлнэ.

Нийгмийн сайн сайхан байдал, эдийн засгийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгийн сайнаар хамгаалахын тулд хүмүүс, олон нийт, улс орнууд уур амьсгалын өөрчлөлтөөс зайлшгүй тулгарах нөлөөллийг даван туулах бэлтгэлтэй байх шаардлагатай. Хүмүүсийг шинэ ур чадварт сургах, өрхийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах, сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх, цаг агаарын мэдээлэл, эрт сэрэмжлүүлэх системийг сайжруулан бэхжүүлэх, урт хугацааны төлөвлөлтийг хөгжүүлэх замаар үүнийг хийж болно.

Эцсийн дүндээ уур амьсгалын өөрчлөлтөд үнэхээр тэсвэртэй нийгэм бол нүүрстөрөгч бага ялгаруулдаг нийгэм юм. Учир нь хүлэмжийн хийн ялгарлыг эрс бууруулах нь ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтийн ноцтой нөлөөллийг хязгаарлах хамгийн сайн арга болно. Нүүрстөрөгч бага ялгаруулдаг нийгэм нь эрх тэгш байдалд тулгуурлах учир уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд хамгийн ихээр өртөж байгаа, түүнийг даван туулах чадваргүй хүмүүс, олон нийтэд үзүүлэх дэмжлэгийг нэн тэргүүнд тавьж байдаг.

**Уур амьсгалын шударга ёс.** Эрх тэгш байдал, хүний эрх нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх шийдвэр гаргах болон үйл ажиллагааны үндэс суурь байхыг хэлнэ.

Улс орнуудын зүгээс уур амьсгалын хямралд хүлээх хариуцлага харилцан тэгш бус байж ирсэн явдал бол уур амьсгалын шударга ёсны нэг гол асуудал болж байна. Энэ нь хүлэмжийн хийг хамгийн ихээр ялгаруулдаг үйл ажиллагаанаас хөрөнгөжсөн улс орон, салбар, аж ахуйн нэгжүүд нь хэдийгээр уур амьсгалын хямралд хамгийн багаар нөлөөлж байгаа ч уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд хамгийн ихээр өртөж буй хүмүүс, улс орон, нийгэмд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, даван туулахад нь туслах үүрэгтэй.

Улс орнууд дотооддоо ч гэсэн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх асуудлыг шийдвэрлэх үүрэг хариуцлагыг шударгаар хуваалцаж үүрэх шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтийг өдөөж уур амьсгалын хямралд хүргэхэд хувь нэмэр оруулж, үр шимийг нь хүртэж буй хүмүүс, талууд хамгийн том хариуцлагыг нийгмийн өмнө хүлээх ёстой.

Уур амьсгалын шударга ёсны бас нэг гол асуудал нь үе дамжсан асуудал юм. Уур амьсгалын өөрчлөлтийн уршиг нөлөөллийн хамгийн хүндийг өнөөгийн хүүхэд, залуучууд амьдралынхаа туршид үүрэх болно. Тэдний хүний эрхийн асуудал өмнөх үеийнхний шийдвэрээс болж аюул эрсдэлд өртөж байна. Учир иймд амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүхий л шийдвэр, үйл ажиллагаанд залуучууд гол үүрэг гүйцэтгэх ёстой.

*Цаашид бид юуг хийх ёстой бэ?*

**Байгальд суурилсан шийдэл.** Энэ бол уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг сааруулах хүчин чармайлтыг дэмжих, биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор экосистемийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, удирдах үйл ажиллагаа юм. Эдгээр арга хэмжээ нь экосистемийн болоод биологийн олон янз байдлын ач холбогдлыг нэн тэргүүнд тавьдаг бөгөөд байгаль хамгаалах талаар үеэс үед уламжлагдан ирсэн мэдлэг бүхий орон нутгийн оршин суугчид, уугуул хүмүүсийн бүрэн оролцоо, зөвшөөрлөөр боловсруулж хэрэгжүүлдэг.

**Хүмүүсийн мэдлэг.** Энэ бүхний эцэст бид мэдлэгтэй, ойлголттой байж нэгдсэн нэг санаа зорилгодоо хүрнэ. Энэ мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх нь тэмцлийн нэг хэлбэр мөн.

**Уур амьсгалын санхүүжилт.** Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг дэмжихэд ашигладаг санхүүгийн эх үүсвэр, хэрэгслийг хэлнэ. Дэлхий нийтээр нүүрстөрөгчийн ялгарал багатай эдийн засагт шилжих, нийгэмд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, улмаар дасан зохицох чадавхыг бэхжүүлэхэд туслахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай тул уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд уур амьсгалын санхүүжилтийн механизм чухал ач холбогдолтой юм.

**Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэх.** Энэ бол хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг хүний хүчин чармайлтаар (*жишээлбэл, нүүрстөрөгчийн давхар ислийг шингээх нүүрстөрөгчийн шингээгч бий болгох замаар*) тэнцвэржүүлж, улмаар агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийн цаашдын өсөлтийг хязгаарлахыг хэлнэ. Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэхийн тулд бид эрчим хүч, тээвэр, үйлдвэрлэл, хэрэглээний тогтолцоогоо бүрэн өөрчлөх шаардлагатай. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн муу үр дагавар үүсэхээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай.

**Нүүрстөрөгчгүйжүүлэх.** Ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулахаас гадна, шингээж буй хэмжээг нэмэгдүүлэхийг хэлнэ. Энэ нь эрчим хүч, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн үйлдвэрлэж, хүргэх, барилга байгууламжийг хэрхэн барих, газар нутгийг хэрхэн яаж удирдах зэргээс эхлээд эдийн засгийн бүх харилцааг биш юмаа гэхэд олон зүйлийг өөрчлөхийг шаардана.

**Сэргээгдэх эрчим хүч.** Салхи, нарны гэрэл, усны урсгал, газрын гүний дулаан зэрэг байнга нөхөгдөж байдаг байгалийн эх үүсвэрээс гаргаж авсан эрчим хүч юм. Уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэж буй хүлэмжийн хийн ялгарлын 75%-ийг бүрдүүлдэг нүүрс, газрын тос, байгалийн хий зэрэг малтмал түлшнээс гаргаж авдаг эрчим хүчнээс ялгаатай нь сэргээгдэх эх үүсвэрээс гаргаж авах эрчим хүч нь хямд, байгаль орчинд ээлтэй, тогтвортой бөгөөд илүү олон ажлын байр бий болгох давуу талтай. Эрчим хүч, халаалт, хөргөлт, тээвэр, аж үйлдвэр зэрэг бүх салбарт малтмал түлш хэрэглэхээс түдгэлзэж, сэргээгдэх эрчим хүч ашиглахад шилжих нь уур амьсгалын хямралыг шийдвэрлэх гол түлхүүр юм.

**Нүүрстөрөгч шингээгч.** Агаар мандалд ялгарч байгаагаас илүү нүүрстөрөгчийн давхар ислийг шингээж авдаг аливаа процесс, үйл ажиллагаа, механизмыг хэлнэ. Ой мод, далай тэнгис, хөрс, ургамал нөмрөг нь манай дэлхийн хамгийн том байгалийн нүүрстөрөгч шингээгчид юм.

**Нүүрстөрөгчийг агаараас ялгах.** Агаараас нүүрстөрөгчийг шууд ялгаж, эрдэсжилтийг сайжруулах зэрэг технологийн шийдлүүд юм. Энэ шийдэлд ойжуулалт, хөрсний менежмент гэх мэт байгалийн шийдлүүд эсхүл техник технологийн шийдлүүд байна. Ийнхүү агаараас нүүрстөрөгчийг ялгах нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахыг бүхэлд нь орлох арга биш боловч уур амьсгалын өөрчлөлтийг удаашруулж болох бөгөөд бид уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилтдоо хүрэх хугацааг түр зуурч болсон богиносгох шаардлагын үүднээс авч буй арга хэмжээ юм.

**Нүүрстөрөгчийн зах зээл.** Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, арилгахад чиглэсэн үйл ажиллагаанд санхүүгийн хөшүүргийг бий болгодог арилжааны схемүүд юм. Эдгээр схемд хүлэмжийн хийн ялгарлыг нүүрстөрөгчийн зээлээр тооцож, зарж, худалдаж авах боломжтой. Борлуулж болох нүүрстөрөгчийн зээлийн нэг нэгж нь нэг тонн нүүрстөрөгчийн давхар исэл

буюу түүнтэй тэнцүү хэмжээний бууруулсан, шингээсэн, зайлуулсан хүлэмжийн хийтэй тэнцэнэ.

**Нөхөн сэргээгдэх газар тариалан.** Хөрсийг эрүүлжүүлж сэргээх, улмаар усны хэрэглээг бууруулж, газрын доройтлоос урьдчилан сэргийлж, биологийн олон янз байдлыг хамгаалах газар тариалангийн арга юм. Хөрс боловсруулах ажлыг багасгаж, сэлгэн тариалах аргыг нэвтрүүлэх, малын бууц, бордоо ашиглах зэргээр нөхөн сэргээгдэх газар тариалангийн арга техникийг нэвтрүүлснээр хөрсөнд илүү их нүүрстөрөгч хуримтлуулж, чийгийг хадгалж, мөөгөнцрийн бүлгэмдэл цэцэглэх, хөрс эрүүлжих нөхцөлийг бүрдүүлдэг.

Эрчимжсэн хөдөө аж ахуй нь манай дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын гуравны нэгийг бүрдүүлдэг бөгөөд бидний хэрэглэж буй цэвэр усны 70%-ийг ашиглахын зэрэгцээ хүнд машин механизм, химийн бордоо, пестицидийн ашиглалтаас болж хөрсний доройтолд хүргэдэг. Түүнчлэн биологийн олон янз байдлыг алдагдуулж буй хамгийн том хүчин зүйл юм. Харин эсрэгээрээ нөхөн сэргээгдэх газар тариалангийн арга техникийг нэвтрүүлснээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, усны нөөцийг хамгаалж, газрыг нөхөн сэргээхэд тусална. Түүгээр ч зогсохгүй эрүүл хөрс нь илүү их хүнс үйлдвэрлэж, тэжээллэг чанарыг сайжруулж, экосистем, биологийн олон янз байдлыг сэргээхэд эерэг нөлөө үзүүлнэ.

**Ойжуулалт.** Урьд өмнө нь ой модоор бүрхэж байсан боловч ой хээрийн түймэр, ган гачиг, өвчин эмгэг, хөдөө аж ахуйн зориулалтаар мод бэлтгэх зэрэг хүний үйл ажиллагааны улмаас ой мод нь устаж үгүй болсон газар нутгуудад ой мод дахин тариалж нөхөн сэргээх үйл явц юм.

Ой үржүүлэг гэдэг нь ойрын түүхэн хугацаанд ой модгүй байсан газар нутагт шинээр мод тарьж ойжуулах ажил юм. Ой үржүүлэг нь эвдэрч доройтсон газар тариалангийн талбайг нөхөн сэргээх, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, нүүрстөрөгчийн шингээлтийг бий болгох, орон нутгийн иргэдэд эдийн засгийн шинэ шинэ боломжийг бий болгоход тусална.

**Байгалийн дахин сэргээлт.** Хүний үйл ажиллагааны улмаас доройтож сүйдсэн экосистемийг бүхэлд нь дахин сэргээн босгох үйл явц юм. Хүн төрөлхтний зорилтот оролцоотойгоор тодорхой төрөл зүйлийг аврахад чиглэдэг байгаль хамгаалах үйл явцаас илүүтэйгээр байгалийг дахин сэргээх гэдэг нь байгаль дэлхийг жам ёсоороо эргэж сэргэн төлжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор томоохон газар нутгийг тусгаарлаж хамгаалах үйл явц юм. Заримдаа экосистемийг бүхэлд нь нөхөн сэргээхэд туслах минж, чоно, томоохон өвсөн тэжээлт амьтад зэрэг тухайн бүс нутагт устаж үгүй болсон биологийн тодорхой зүйлүүдийг дахин нутагшуулах шаардлага ч гарч болно.

**Хаягдалгүй эдийн засаг.** Тойрог эдийн засаг гэж ч бас нэрлэгдэг. Хог хаягдлыг багасгаж, бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийн зохистой хэрэглээг дэмжих, байгалийг нөхөн сэргээхэд туслах үйлдвэрлэл, хэрэглээний загвар юм. Тойрог эдийн засгийн арга хандлага бидний эргэн тойронд хэрэгжиж байдаг. Ийм арга хандлагыг нэхмэл эдлэлийн үйлдвэрлэлээс эхлээд орон сууц, барилга байгууламж барих зэрэг олон салбарын зураг төсөл, үйлдвэрлэл, түгээлт, устгалт зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мөчлөгийн үе шат бүрд ашиглаж болно.

Тойрог эдийн засгийн арга хандлагыг ашигласнаар бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд туслахаас гадна, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал устаж доройтох зэрэг бусад олон сорилтуудыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тойрог эдийн засагт шилжсэнээр шинээр ногоон ажлын байр бий болгохын зэрэгцээ улс орнуудын нүүрстөрөгчийн ялгарал багатай, эрсдэлийг даван туулах чадвартай эдийн засагт шилжих үйл явцыг түргэсгэнэ.

**Ногоон ажлын байр.** Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулдаг зохистой ажлын байрыг хэлнэ. Сэргээгдэх эрчим хүч гэх зэрэг ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, дахин боловсруулалт хийх зэрэг байгаль орчинд ээлтэй үйл явцад ногоон ажлын байр бий болж байдаг.

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө.** Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөмтгий байдлыг бууруулах, дасан зохицох чадавх, даван туулах чадварыг бэхжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд улс орнуудад тусалдаг. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө нь Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр, үндэсний болон салбарын бусад бодлого, хөтөлбөрүүдтэй нягт уялдаатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө нь оролцоонд түшиглэсэн, хүртээмжтэй, жендерийн мэдрэмжтэй, ил тод байх аваас амжилттай хэрэгжинэ. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг боловсруулах эхний шатнаас эхлээд улс орны хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээ, эмзэг байдлыг үнэлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд хамгийн өртөмтгий хэсэг бүлэгт онцгой анхаарал хандуулж, стратеги, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх явцад тэднийг татан оролцуулах нь нэн чухал.

**Урт хугацааны стратеги.** Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх богино хугацааны үндэсний зорилтуудтай уялдаатай байх төдийгүй хэрэгжилтийг нь дэмжих алсын хараатай зорилтуудыг тодорхойлсон байна. Эдгээр стратеги нь улс орнууд нүүрстөрөгч бага ялгаруулах хөгжлийг замнах, малтмал түлш ихээр шаардах хөрөнгө оруулалтаас зайлсхийх зэрэгт чиглүүлж, ногоон шилжилтийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлсон байна. Эдгээр стратеги нь инновацыг эрчимжүүлж, нүүрстөрөгч багатай шийдэл, тогтвортой дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхэд тусална. Ийм стратеги нь хамгийн ихээр хохирол амсаж буй хэсэг бүлгүүдэд шилжилтийн үр нөлөө шударга, эрх тэгш тусах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх шийдлүүд нь алагчлалгүй бөгөөд хүртээмжтэй байхад туслахуйц байхаар тодорхойлогдсон байна.


Уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн ноцтой үр дагавраас урьдчилан сэргийлэхэд шаардагдах хэмжээний хүлэмжийн хийн ялгарлын бууралтын дөрөвний нэгээс илүү хувийг ойг хамгаалж, нөхөн сэргээснээр бүрдүүлэх боломжтой. **Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нэмэлт үйл ажиллагаа (REDD+)**<sup>2</sup> нь хөгжиж буй орнуудын ойн хомсдол, доройтлыг бууруулах, ойг зохистой удирдах, хамгаалах замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор олон улсын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх хэлэлцээрт оролцогч Улс орнуудын тохиролцсон хамтын ажиллагааны хүрээ юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой дараах бодлогын баримт бичгүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Парисын хэлэлцээр
- Алсын хараа 2050
- Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Үндэсний дасан зохицох төлөвлөгөө
- Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Олон улсын байгууллагын хамтын ажиллагаа
- Төсөл хөтөлбөрүүд гэх мэт.

2 REDD гэдэг нь “Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэсэн утгатай. Харин “+” тэмдэг нь ойг хамгаалах, зохистойгоор удирдах, ойн нүүрстөрөгчийн нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх үүрэг хүлээж байгааг илэрхийлнэ.

**Зураг 1.3. Уур амьсгалын үндэсний хорооны бүтэц**



Бодлогын түвшинд дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

- Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт салбарын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 31 арга хэмжээг тусгасан байна.
- Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох Үндэсний төлөвлөгөө баталсан.
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан.
- Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангах дэд, салбар хороо байгуулах шийдвэр гаргасан.
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Үндэсний ил тод байдлын тайланг боловсруулж Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн.
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд “Нүүрстөрөгчийн нэгдсэн бүртгэлийн журам”-ыг баталсан.
- Автотээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, нотлох хялбаршуулсан аргачлал баталсан.
- Уур амьсгалын ногоон сан, Дэлхийн байгаль орчны сан, Алдагдал хохиролд хариу арга хэмжээ авах сан зэрэг томоохон сангуудаас татах санхүүжилтийг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллаж байна.
- Япон, БНСУ, Сингапур улсын Засгийн газартай Нүүрстөрөгчийн зах зээлд хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.
- Бүх шатны боловсролын хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийг сургалтын агуулгад багтаахаар Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран ажиллаж байна.

## 1.3 БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүн бол байгалийн бүтээгдэхүүн, нэгэн эд эс юм. Хүн байгальд төрж, өсөж, байгальдаа шингэдэг. Өөрөөр хэлбэл байгальтай салшгүй холбоотой. Байгаль, хүний үйл ажиллагаа хоёр өөр хоорондоо харилцан шүтэлцээтэй. Түүнийг эс ухаарвал тогтвортой байдал алдагдаж, байгаль орчин муудан доройтож, улмаар мөхнө.

Байгаль орчныг хамгаалах маш олон арга, хэлбэр байдгийн нэг нь эрх зүйн зохицуулалтаар хийгдэх хамгаалалт юм. Олон хууль тогтоомжид “байгаль”, “байгаль орчин”, “байгалийн нөөц баялаг”, “хүрээлэн буй орчин”, “байгаль хамгаалах”, “экологи”, “экологийн аюулгүй байдал” гэх зэрэг олон нэр томъёо хэрэглэдэг. Эдгээрийн заримыг хуульд тодорхойлсон нь ч бий, тодорхойлоогүй нь бий. Угтаа бол бид нэг л юмны тухай яриад байгаа юм. Бид сургалтын энэ хөтөлбөрийн хүрээнд экологийн эрх зүй гэсэн ойлголтоор нь явъя.

Экологийн эрх зүйн талаар үзэхийн өмнө эрх зүй, хууль гэж юу болох, түүний ялгааны талаар товчхон танилцах шаардлагатай.

Эрх зүй нь нарийн төвөгтэй, олон талтай ойлголт юм. Эрх зүй нь өөрөө үнэн, шударга ёс, тэгш эрх, эсхүл тэдгээрт хүрэх арга хэрэгсэл гэж ихэвчлэн томъёолж байна. Эртний римийн хуульч Ульпиан эрх зүй гэж юу болохыг мэдэхийн тулд тухайн үгийн гарал үүслийг авч үзэхийг сануулж, “эрх зүй нь юуны өмнө **justitia-үнэн, шударга ёс** гэсэн үгнээс гаралтай бөгөөд **эрх зүй нь тэгш байдал ба шударга ёс, сайн сайхны урлаг мөн**” гэжээ.

Эрх зүй гэдэг нь нийгмийн харилцаанд оролцогчдын харилцан зөвшөөрөлцсөн хүсэл зориг, зохицол дээр үндэслэгдсэн нийгмийн зохицуулалт, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, төрөөс зөвшөөрөгдөж, хангагдаж хамгаалагдаж байгаа хэм хэмжээний нийлбэр, тогтолцоо юм.

Зохицуулагдаж буй харилцаанд оролцогчдын харилцан зөвшөөрөлцсөн хүсэл зориг, ашиг сонирхлууд нь эрх зүйд илэрхийлэгдэх тохиолдолд эрх зүй нь бүх нийтийн зайлшгүй мөрдөгдөх шинжтэй болно. Эрх зүй нь нийгмийн амьдралын бүтээгдэхүүн, хүсэл зоригийн илэрхийлэл юм.

Эрх зүй нь дараах онцлогтой. Үүнд:

1. Нийгмийн харилцааг хамгаалах, зохицуулах зорилгоор уг харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлно.
2. Тухайн улсын нийт нутаг дэвсгэр болон тодорхой хүрээнд заавал биелэгдэх шинжтэй байна.
3. Эрх зүйн хэм хэмжээ нь тодорхой баримт бичигт тухайлбал, хууль, зарлиг, тогтоол, захирамж, шийдвэр зэрэг эрхийн актаар тусгалаа олдог төрийн албадлагаар хамгаалагдсан байхын зэрэгцээ зөрчигдсэн тохиолдолд эрх зүйн үр дагаврыг бий болгоно.

Эрх зүйг нийгмийн харилцааны зохицуулах, хамгаалах, нийгэмд ашигтай харилцааг бэхжүүлэх, нийгмийн хэв журам тогтоох шаардлагаар түүнийг хууль болгон хувиргах шаардлага үүснэ.

### 1.3.1 Эрх зүйн хэм хэмжээний акт

Эрх зүйн хэм хэмжээний акт гэсэн ойлголт нь өөртөө хууль тогтоох, гүйцэтгэх, зарим тохиолдолд шүүх засаглалын байгууллагуудаас батлан гаргасан эрх зүйг тогтоох шинжтэй актуудын өргөн хүрээг хамарна. Энэхүү ойлголт нь өргөн агуулгаар “хууль тогтоомж” гэсэн ойлголттой адил юм. Хууль тогтоомж нь эрх зүйн хэм хэмжээг илэрхийлэх хэлбэр мөн.

Эрх зүйн хэм хэмжээний актууд нь төрийн эрх бүхий байгууллагаас тухайн байгууллагын эрх хэмжээний хүрээнд тодорхой журам хэлбэрээр батлан гаргана. Батлан гаргаж байгаа байгууллагын статусаас хамаарч эрх зүйн хэм хэмжээний актын хуулийн хүчин чадал тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хэм хэмжээний актын шаталсан тогтолцоо нь төрийн бүтцийг тусгаж байдаг.

Эрх зүйн эх сурвалжийн нэг чухал хэсгийн хувьд эрх зүйн хэм хэмжээний акт нь босоо (шаталсан) болон хэвтээ (салбарын) зарчмаар зохион байгуулагдсан нарийн төвөгтэй бүтцийг бүрдүүлнэ.

**Экологийн эрх зүй.** Экологийн эрх зүй нь эрх зүйн нэг салбар мөн бөгөөд энэ нь өргөн утгаараа бидний хүрээлэн буй орчны талаарх нийгмийн хүсэл зоригийн харилцаа юм. Экологийн эрх зүйгээр зохицуулагддаг энэхүү хүсэл зоригийн харилцаа нь хүн, нийгмээс хүрээлэн буй орчинд хандаж буй харилцаа, мөн хүн, байгалийн тодорхой төрөл зүйлсийн хоорондын харилцаа тус тус багтана.

Экологийн эрх зүйгээр зохицуулагддаг харилцааг байгалийн нөөц баялгийг хамгаалах, ашиглах, хүний амьдралын эрүүл аюулгүй байдлыг хамгаалах гэсэн хоёр хэсэгт ангилж үзэж болно. Эрх зүйн илрэн гарах хэлбэр нь хууль, тогтоомж байдаг гэж өмнө дурдсан. Одоо эрх зүйн тэр илрэн гарах хэлбэрийг байгаль орчны салбарын жишээн дээр авч үзье.

**Хууль.** Манай улсын байгаль орчныг хамгаалах тухай багц хуульд байгаль орчныг хамгаалах агуулга голлох байр суурийг эзлэх бөгөөд нөхөн сэргээх, зөв зохистой ашиглах бодлогыг тууштай баримталсан байдаг. Жишээ нь, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зорилтод “... байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, ... нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэжээ.

*Ойн тухай хуулийн* зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*Байгалийн ургамлын тухай хуулийн* зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*Усны тухай хуулийн* зорилт нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Байгалийн нөөц баялгийг хамгаалах, ашиглах, хүний амьдралын эрүүл аюулгүй байдлыг хамгаалах гэсэн байр суурь Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаж, улмаар тус хуулийг хэрэгжүүлэх салбар хуулиудаар нарийвчлан зохицуулагджээ.

Ер нь манай экологийн чиглэлийн хууль, тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон Улсын гэрээ, конвенц, ердийн хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэц болон шүүх эрх мэдлийн байгууллагаас гаргасан эрх зүйн акт, Сайдын тушаал, аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон шат шатны Засаг даргын шийдвэрүүдээс бүрдэнэ.

Экологийн талаар Монгол Улсын Үндсэн хуульд хэрхэн, ямар байдлаар тусгагдсан талаар үзье.

Үндсэн хууль бол аливаа эрх зүйн салбарт гол тулгуур эх сурвалж нь болдог. Экологийн эрх зүйд ч мөн адил. Ийнхүү тулгуур болдгийн учир нь Үндсэн хуулиар улс орны бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, тэдгээрийг хангах баталгаа, төрийн байгуулал (төрийн эрх барих дээд байгууллага, гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдэл), засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, Үндсэн хуулийн хяналт зэрэг улс орны амьдралын хамгийн гол, түгээмэл эрх зүйн төлөв байдлыг хамгийн дээд хэмжээнд хуульчлан баталгаажуулсан байдаг оршино. Монгол Улсын Үндсэн хууль (1992) экологийн талаар онцлон оноосон болон түгээмэл шинж чанар бүхий хэм хэмжээг өөртөө агуулсан байдаг.

Үндсэн хуулийн **түгээмэл шинж чанар** бүхий хэм хэмжээнд дор дурдсан хэм хэмжээ орно. Үүнд:

Нэг. **Үндсэн хуулийн оршил хэсэгт** *“Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”* гэж заасан. Энд байгаль орчныг тууштай хамгаалах төрийн бодлого агуулагдаж, түүний хэрэгжилтийн үр дүнгээр *“хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлон хөгжих”* нэг нөхцөл бүрдэх болно.

Хоёр. **Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд** *“Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах Улс мөн”* гэж заасан нь экологийн аливаа асуудалд хамаарах түгээмэл шинжийг агуулж байгаа юм. Хүний амьдралын орчин, эдийн засаг, нийгэм, эрх зүйн ямар ч асуудлыг **“тусгаар тогтносон”, “бүрэн эрхт”** улсын хувьд Монгол Улс эзний ёсоор шийдвэрлэх эрх зүйн үндэс үүнд давхар хадгалагдаж байна. Мөн зүйлд *“Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”* гэж заасан. Энэ нь экологийн эрх зүйн зарчимд ч бас л түгээмэл хамаарна. Экологийн талаарх хүний эрх, эрх чөлөө, байгаль орчныг хамгаалах иргэний үүрэг, энэ бүхэн бүгд л “тэгш байдал”, “хууль дээдлэх” төрийн үйл ажиллагаагаар дамжиж амьдралд хэрэгждэг учиртай.

Гурав. **Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд** *“Монгол Улсын засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна”* гэж заасан. Энэ нь зөвхөн сонгуульд оролцож төрийн үйл хэргийг удирдах асуудлаар хязгаарлагдахгүй, эх газар нутгийнхаа эзэн нь мөнхүү ард түмэн байж, байгаль орчноо бүхэлд нь төдийгүй, баялаг тус бүрийг нь хамгаалах, зохистой ашиглах “засгийн эрхийг” ард түмэн мэднэ гэсэн түгээмэл шинжийг энд бас л харгалзсан хэрэг.

Дөрөв. **Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд** *“Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.... Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”* гэж заасан. Энэ нь экологийн баримжаатайгаар эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх, байгалийн нөөц баялгаас боломжтойг нь хувьд өмчлүүлэх гэх зэрэг төрийн экологи-эдийн засгийн хосолмол бодлого тусгалаа олсон түгээмэл шинжийг хадгалсан байна.

Зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд Монгол Улсын Үндсэн хууль экологийн асуудалд онцгой анхаарал тавьж, орчин цагийн экологийн эрх зүйг баяжуулан хөгжүүлсэн олон тооны хуулийн заалтуудыг өөртөө суулгаж баталгаажуулсан юм. Үүнийг **онцлон оноосон** хэм хэмжээ буюу хуулийн заалт гэж нэрлэж болно. Ийм хуулийн заалтад хүний экологийн эрх, түүнийг хангах баталгаа, байгалийн нөөц баялгийг өмчлөх, эзэмших, ашиглах, хамгаалах хууль зүйн үндэс, байгаль орчноо хамгаалах иргэний журамт үүрэг, хүрээлэн байгаа орчныг хамгаалах төрийн үйл ажиллагаа зэрэг экологийн талаарх “амин чухал” асуудлаар нийгмийн харилцааны зохицуулалтын эрх зүйн үндэслэлийг эрх зүйн дээд түвшинд хуульчлан баталгаажуулсан байдал харагдаж байгаа болно.

Онцлон оноосон хуулийн заалтад:

**1. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т** Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Энэ нь хүний экологийн эрхийг Улсынхаа түүхэнд анх удаа Үндсэн хуулиар баталгаатай болгож, түүнийг хангах арга замыг “орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах” үйл ажиллагааг төр өөртөө тохоон оноосноор илэрч байгаа юм.

**2. Үндсэн хуулийн 6 дугаар зүйл** экологийн эрх зүйн нарийн төвөгтэй олон асуудалд нэгдсэн хариу өгөхөд бүхэлдээ чиглэгдсэн байна. Юуны өмнө “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж цохон заажээ. Энэ заалт өмнө дурдсан 1, 3 дугаар зүйлүүдийн нийтлэг шинжээс үүдэлтэй, байгаль орчин, түүнийхээ баялгийг ард түмэн нь эзний ёсоор мэдэж, төртэйгөө хамтран буюу түүний хүчинд тулгуурлан хамгаалах, төр байгаль орчныхоо асуудлыг шийдвэрлэх онцгой дэглэмийг тогтоосон хэрэг мөн.

**3. Зургаадугаар зүйлийн 2-т** байгалийн нөөц баялгийг өмчлөх эрхийн асуудлыг онцлон шийдвэрлэж, “Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан байна. Энэ нь газрыг зөвхөн өөрийн Улсын иргэнд өмчлүүлж болохыг хуульчилж, байгалийн бусад баялаг зөвхөн төрийн нийтийн өмчид байна гэсэн утга агуулгыг илэрхийлжээ. Тиймээс ч Үндсэн хуулийн уг зүйл дараачийнхаа 3, 4 дэх хэсэгт Монгол Улсын иргэнд ямар газрыг өмчлүүлж болох тухай, өмчлүүлсэн газрын хэвлийг өмчлөх эрх эдлэхгүй байх тухай, хувийн өмчийн газрын эзэн уг газрынхаа талаар эрх зүйн ямар хязгаарлал бүхий чадамжтай байх тухай, төр болоод газрын эзний хооронд эрх зүйн ямар харилцаатай байх тухай хууль зүйн тодорхой зохицуулалтыг нарийвчлан тогтоож өгсөн байна.

- ✓ *Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба Улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.*
- ✓ *Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, Улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.*
- ✓ *Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.*

4. Зургаадугаар зүйлийн 5 дахь хэсэгт төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар зөвхөн ашиглуулж болохыг хуульчлан тусгажээ.

Дээрх 3, 4-д дурдсан заалтууд Монголд газрын өмчийн асуудал хууль зүйн болон зан заншлын уламжлалын хувьд ямар их нарийн төвөгтэй, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчдийн соёл иргэншил, суурин соёл иргэншлийнхээс ямар өвөрмөц онцлогтойн жишээг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд харуулсан хэрэг юм.

5. Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд *“байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”* гэж заасан. Энэ бол эрхээ эдлэхийн зэрэгцээ үүргээ гүйцэтгэж, эрх, үүргийн нэгдлийг хангах онолын үндэслэлийг давхар баталгаажуулав. Монгол Улсын иргэн хууль ёсны хувьд ч, ёс суртахууны хувьд ч ажил, мэргэжил, албан тушаал харгалзахгүйгээр байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, ашигласнаа нөхөн сэргээх, байгаль орчныг хамгаалах төрөл бүрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байх үүргийг хүлээнэ. Тийм учраас энэ үүргийг Үндсэн хуулиар *“журамт үүрэг”* гэж цохон нэрлээд хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргүүдтэй эн зэрэгцүүлэн байрлуулсан нь ч тохиолдлын хэрэг биш юм.

6. Төрийн гүйцэтгэх дээд байгууллага Засгийн газрын үндсэн бүрэн эрхийг Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд заан тодорхойлохдоо түүний нэгэн бие даасан хэсгийг *“хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авна”* гэж томъёолжээ. Энэ нь экологийн салбарт гүйцэтгэх засаглалын дээд шатны байгууллагын эрх, үүргийн үндсийг баталгаажуулсан хэрэг мөн.

7. Байгалийн баялгийг хэрхэн зөв оновчтой, үр ашигтай ашиглах төрийн бодлогыг тодорхойлж өгсөн. Байгалийн баялаг нь зөвхөн тухайн цаг үед амьдарч буй хүний хэрэгцээг хангах бус ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх шударга ёсны зарчмыг тодорхойлж өгсөн. Тухайлбал, Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд *“Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ”*, мөн *“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”* гэжээ.

8. Мөн зүйлд *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй”* гэж хуульчилсан нь байгаль орчны талаар иргэний эрхийг улам тодотгож өгөхийн зэрэгцээ хөндлөнгийн хяналтыг тогтоож өгсөн байна.

9. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тодорхойлохдоо *“...нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэхийн хамт Улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна”* гэж заасан. Энэ нь байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчныг хамгаалах асуудлаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид тус тусын нутаг дэвсгэртээ бие дааж хуулийн хүрээнд шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, түүний зэрэгцээ дээд шатны байгууллагаас байгаль орчны талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд хүн амыг зохион байгуулан оролцуулж байх ийм хоёр талт үйл ажиллагаа явуулах эрх, үүрэг олгосон эрх зүйн хамгийн дээд хэм хэмжээ юм.

Үндсэн хуулиас гадна, салбар хуулиуд нь байгаль орчны хамгаалал, ашиглалт, нөхөн сэргээх харилцааг зохицуулж байдаг хүрээлэн буй орчны талаар төрөөс баримтлах бодлогын нэг илрэл болдог. Энэ салбар хууль нь бие биетэйгээ харилцан холбоо хамааралтай олон хуулиудаас бүрдэнэ. Тэдгээр хуулийг байгалийн объектоор нь, материаллаг, процессын, шууд заасан эх сурвалж бүхий хууль, иш татан хэрэглэх эх сурвалж бүхий хууль гэх мэтээр ангилан авч үзэж болно.

#### Байгалийн объектоор нь:

*Газар, түүний хөрс.* Газрын төлбөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль.

*Газрын хэвлий, түүний баялаг.* Ашигт малтмалын тухай хууль, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль.

*Ус.* Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль.

*Ургамал.* Байгалийн ургамлын тухай хууль, Ойн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль.

*Амьтан.* Амьтны тухай хууль, Генетик нөөцийн тухай хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, Хувиргасан амьд организмын тухай хууль.

*Агаар.* Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын тухай хууль зэрэг болно.

*Материаллаг хуулиуд:* Хуулиар эрх олгосон, үүрэг болгосон, зөвшөөрсөн, хориглосон байдлаар оролцогчдын зан үйлийг зохицуулсан хууль ёсны болон хууль бус үйлдлийг тогтоосон, хууль зөрчигч нарт хариуцлагыг тодорхойлсон хуулиуд байна. Жишээ нь, иргэн газар өмчлөх, эзэмших, ашиглах, ойгоос мод бэлтгэх, ан агнах, ургамал, ус ашиглах талаар ямар эрхтэй болох, ямар үүрэг эрхээ хэтрүүлж, үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээлгэхийг холбогдох хуульд тодорхой заасан байдаг. Жишээлбэл, Амьтны тухай хуульд;

5.6-д Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.6.1. харьяалах нутаг дэвсгэртээ амьтан хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө баталж, биелэлтэд нь хяналт тавих

5.6.2. сум, дүүргийн Засаг даргын амьтан хамгаалах талаар авч хэрэгжүүлэх ажлын тайланг хэлэлцэх

39 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

39.1. Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчиж зөвшөөрөл, гэрчилгээ олгосон нь гэмт хэргийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

39.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**Процессын хуулиуд:** Материаллаг хэм хэмжээг ямар нөхцөлд, ямар арга ажиллагаа, ямар хэлбэрээр хэрэгжүүлэхийг заасан хуулийн заалт байна. Жишээ нь, иргэн газар өмчлөх хуульд заасан эрхээ эдлэхдээ хаана, ямар зориулалтаар, хэдий хэмжээний газраа өмчилж авах хүсэлт, өргөдлөө ямар албан тушаалтанд гаргах зэргийг хуульд тодорхой заасан байдаг. Тухайлбал, Амьтны тухай хуульд;

29<sup>1</sup> дүгээр зүйл. Дуудлага худалдаа зохион байгуулах

29<sup>1</sup>.2. Энэ хуулийн 29<sup>1</sup>.1-д заасан зөвшөөрлийн дуудлага худалдааг мөн хуулийн 26.3-т заасны дагуу Засгийн газраас тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлж, 30 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулна.

29<sup>1</sup>.6. Анхны үнийн санал гарснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцох бөгөөд хамгийн өндөр үнийн саналаар ялагч тодорсноор дуудлага худалдааг дуусгавар болгоно. Дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй тохиолдолд долоо хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна.

30 дугаар зүйл. Ангийн буу, сумны захиалга, зарцуулалт

30.1. Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тухайн жилд агнах агнуурын амьтны тоо, хэмжээний дээд хязгаарыг үндэслэн цагдаагийн төв байгууллага ангийн буу, сумны гадаад захиалга, хуваарилалтыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

30.2. Ангийн буу, сумыг захиалах, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага хянаж, зохион байгуулна.

Экологийн хэлбэрийн эх сурвалж болдог хуулийг **шууд заасан эх сурвалж бүхий хууль** гэнэ. Үүний эхний бүлэгт байгаль орчны асуудлаар дагнан төрөлжүүлж баталсан хууль багтана. Жишээ нь, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газар, Газрын хэвлий, Ой, Ус, Ургамал, Амьтан, Агаарын тухай хууль зэргийг нэрлэж болно. Ийнхүү дагнан төрөлжсөн хуулиудыг дотор нь **нийтлэг ба байгалийн төрөл зүйлсийн тусгай хууль** гэж хоёр ангилна.

**Нийтлэг хуульд** Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль, Ой, хээрийн түймрээс хамгаалах тухай хууль зэрэг орно.

**Байгалийн төрөл зүйлсийн тусгай хуульд** Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Амьтны тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль гэх мэтийг нэрлэж болно.

**Иш татан хэрэглэх хууль** гэдэгт экологийнхоос бусад нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулах, хамгаалахаар батлагдсан боловч экологийн холбогдолтой аль нэгэн буюу хэд хэдэн хэм хэмжээг тодорхойлсон зүйл, заалтыг өөртөө багтаасан хууль хамаарна.

**Хамгаалалтын хуулиуд.** Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль.

**Зохицуулалтын хуулиуд.** Авто замын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Барилгын тухай хууль<sup>3</sup>, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль<sup>4</sup>, Цөмийн энергийн тухай хууль.

Эдгээр хууль экологийн эрх зүйд дагнасан биш, харин аль нэгэн тодорхой эрх зүйн салбарын, ихэвчлэн захиргааны эрх зүйн гол эх сурвалж болж байдаг. Гэсэн хэдий ч экологийн эрх зүйн зохицуулалтад зайлшгүй шаардлагатай хэм хэмжээг тогтоосноороо иш татан хэрэглэх эх сурвалжийн шинж чанарыг хадгалдаг онцлогтой. Ийм хуульд жишээлбэл, Хот байгуулалтын тухай хууль, Тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Ариун цэврийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль болон Иргэний, Эрүүгийн зэрэг хуулиуд хамаарна.

### 1.3.2. Эрх зүйн дэд акт

Экологийн эрх зүйн харилцааг зөвхөн хуулиар зохицуулахаас гадна, тодорхой субъектүүдээс гаргасан шийдвэрээр зохицуулж байдаг. Эдгээрийг эрх зүйн дэд акт ч гэж нэрлэгдэг. Өөрөөр хэлбэл, тодорхой субьектээс гаргаж буй нийтээрээ дагаж мөрдөх хэм хэмжээний акт болох тогтоол, тушаал, захирамж гэх мэт. Иймд эдгээр хэм хэмжээг гаргаж буй субьектүүд болон тэдгээр нь ямар эрх зүйн баримт бичиг гарч болохыг үзье.

Эрх зүйн хэм хэмжээний эдгээр актууд нь экологийн харилцааг зохицуулах эрх зүйн нэг хэсгийг бүрдүүлдэг. Ийм актад хуулиар тусгайлан заасан эсвэл эрх олгосноор, түүнчлэн хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн санаачилгаар Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Улсын Дээд Шүүхээс гаргадаг тогтоол, зарлиг, тушаал, тэдгээрээр баталсан дүрэм, журам, заавар, стандарт, нормчлол зэрэг хамаарна.

**Улсын Их Хурал.** Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдана.

- 3 2.1. Барилгын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.  
11.1.3.хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр төлөвлөгдөн баригдаж, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө болон амьтан, ургамалд аюул учруулахгүй байх;
- 4 Хог хаягдлын тухай хууль. 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт  
1.1.Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.  
2 дугаар зүйл. Хог хаягдлын тухай хууль тогтоомж  
2.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.  
2.2.Монгол Улсын олон Улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон Улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх:

- 1) Хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах
- 2) Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон Улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад Улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах.

Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байна.

Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.

Улсын Их Хурлын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана. Энэхүү захирамж нь нийтээр дагаж мөрдөх бус байгууллагын дотоод ажлын зохицуулгын шинж чанартай байна. Тодруулбал,

- Чуулганыг түр завсарлуулах болон хаах асуудлыг Зөвлөлөөр хэлэлцүүлэн, захирамж гаргаж шийдвэрлэх
- Хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах гэх мэт.

Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна. Байнгын хороо тогтоол гаргана. Энэхүү тогтоол нь мөн дотоод зохицуулалтын шинжтэй.

**Монгол Улсын Ерөнхийлөгч.** Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг, захирамж гаргана. Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөнө. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх зарлиг түүнд өөрөөр заагаагүй бол төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа, бусад зарлиг, захирамж тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно. Жишээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 215 дугаар Зарлиг “Олон нийтийн оролцоот хөгжил “хуримтлалын бүлэг”-ийн үйл ажиллагааг дэмжиж орон даяар өрнүүлэх тухай” ... “Байгаль орчноо зөв зохистой ашиглах, хамгаалах, амьдарч буй орчноо тохижуулах, хамтарч ажиллан амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилгоор “Хуримтлалын бүлэг” байгуулан ажиллах үүсгэл санаачилгыг орон даяар өрнүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэдэд уриалсугай”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар захирамж “Төрийн тахилгын ёслолд оролцох төлөөлөгчдийг томилох тухай” гэх мэт.

**Засгийн газар.** Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага юм. Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд нар гарын үсэг зурна.

Засгийн газрын шийдвэр нь Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана. Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй. Засгийн газрын

тогтоол, Ерөнхий сайдын захирамж нь тэдгээрт болон хуульд өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаарх Засгийн газрын бүрэн эрх:

1. Байгаль, орчныг хамгаалах эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, энэ хүрээн дэх Засгийн газрын болон Засгийн газрын бус (олон нийтийн) байгууллагын үйл ажиллагааг зохицуулна.
2. Байгалийн баялгийг судалж нөөцийн хэмжээ, эдийн засгийн нэгдсэн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шүтэлцээг хангах нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.
3. Байгалийн тэнцвэрт байдлын хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгоно.
5. Газар, түүний хэвлий, ус, ойн сан, агаар мандал, ургамал, амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
6. Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горим, дурсгалт болон нөөц газрын хилийн зааг, хамгаалалтын горим тогтоож, биелэлтийг нь зохион байгуулна.

**Тогтоол.** Аливаа байгууллага, Засгийн газар эсвэл удирдлагын байгууллагаас гаргасан албан ёсны шийдвэр, журам эсвэл баримт бичиг юм. Тогтоол нь тухайн байгууллага эсвэл улсын хэмжээнд хэрэгжих эрх зүйн болон удирдлагын зааварчилгаа, хэм хэмжээ, үүрэг хариуцлагыг тодорхойлдог.

**Төрийн захиргааны төв байгууллага.** Засгийн газар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүллнэ. Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага юм. Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана. Үүнд:

Ерөнхий чиг үүргийн:

1. Эдийн засаг, хөгжлийн яам
2. Гадаад харилцааны яам
3. Сангийн яам
4. Хууль зүй, дотоод хэргийн яам

Чиглэлийн:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
2. Батлан хамгаалах яам
3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
4. Боловсролын яам
5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
6. Зам, тээврийн яам
7. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
8. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
10. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
11. Эрчим хүчний яам
12. Эрүүл мэндийн яам.

Яамыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд тэргүүлнэ. Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

**Тушаал.** Тодорхой нэг удирдах албан тушаалтны албан ёсны заавар, үүрэг даалгавар юм. Энэ нь байгууллага, албан газар эсвэл бусад үйл ажиллагаанд оролцогчдын хийх ёстой ажлуудыг тодорхойлсон шийдвэрийг илэрхийлдэг.

**Төрийн захиргааны байгууллага.** Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайдын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.

Агентлагийг томилогдсон дарга тэргүүлнэ. Агентлагийн дарга холбогдох хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана.

**Хүснэгт 1.1.** Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралт)

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Тагнуулын ерөнхий газар Төрийн тусгай хамгаалалтын газар Биеийн тамир, спортын Улсын хороо	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Онцгой байдлын ерөнхий газар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар Стандарт, хэмжил зүйн газар	Төрийн худалдан авах ажиллагааны газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Үндэсний хөгжлийн газар	
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		Цаг уур, орчны шинжилгээний газар Усны газар
Батлан хамгаалахын сайдын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Зэвсэгт хүчний жанжин штаб	
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		Гаалийн ерөнхий газар Татварын ерөнхий газар

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Цагдаагийн ерөнхий газар Хил хамгаалах ерөнхий газар	Улсын бүртгэлийн ерөнхий газар Архивын ерөнхий газар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Гадаадын иргэн, харьяатын газар Оюуны өмчийн газар Шүүх шинжилгээний ерөнхий газар
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		Нийгмийн даатгалын ерөнхий газар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

**Нутгийн өөрийн удирдлага.** Нутгийн өөрийн удирдлагад аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал хамаарна.

Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо нь нийтийн эрх зүйн этгээд байна. Эрх зүйн харилцаанд аймаг, сум, нийслэл, дүүргийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор Засаг дарга төлөөлнө.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн, баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар батална.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд Хурлын дарга, харин баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын тогтоолд Хуралдааны дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн Хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлага.** Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.

Засаг даргыг томилуулахаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал нэр дэвшүүлнэ.

Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Засаг дарга хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн **захирамж** гаргана.

Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ тогтоосон акт гаргасан бол Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд хүчингүй болгоно.

Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлж болно. Зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын чиг үүргийг шилжүүлэхдээ нэгжийн чиг үүргийг хот, тосгонд, нэгж дэх өөрийн удирдлагын чиг үүргийг хотын Зөвлөлд, төрийн удирдлагын чиг үүргийг хот, тосгоны Захирагчид шилжүүлнэ.

Хот, тосгоны Зөвлөл, Захирагч нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагад олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**Захирамж.** Хуульчилсан актын нэгэн төрөл (Засгийн газрын захирамж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж г.м), засаг төрийн буюу удирдлагын байгууллагаас өөрийн эрх хэмжээний хүрээнд гаргасан ба түүнийг дагаж мөрдөх ёстой хувь хүн ба хуулийн этгээд заавал биелүүлэх хүчин чадал бүхий захирамжилсан акт.

**Захиргааны бусад акт.** Захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон, амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагаанууд багтана. Захиргааны актын үзүүлэх нөлөөллийн эерэг болон сөрөг талыг харгалзан ангилна.

Эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх олгосон, эсхүл ашигтай нөхцөл байдлыг бий болгосон захиргааны актыг эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж үзнэ.

Эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд үүрэг бий болгосон, эсхүл түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан захиргааны актыг сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж үзнэ.

Захиргааны актын агуулга ойлгомжтой тодорхой байна. Амаар эсхүл бичгээр түүнчлэн цахимаар, техник хэрэгслийн тусламжтайгаар захиргааны актыг гаргаж болно. Бичгээр гаргасан акт дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Захиргааны актыг гаргасан захиргааны байгууллагын нэр, хаяг, тамга тэмдэг болон гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, захиргааны актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх
2. Захиргааны акт хаяглагдсан этгээд нь хувь бол эцэг эхийн нэр, өөрийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл, хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, бүртгэлийн дугаар, холбоо барих мэдээлэл, хуулийн этгээдийн эрхгүй бусад этгээд бол түүний төлөөлөгч, нэр, хаяг, холбоо барих мэдээлэл
3. Захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах
4. Захиргааны шийдвэр гаргах ажиллагааг өргөдөл, гомдлын үндсэн дээр үүсгэсэн бол түүнийг тусгах
5. Захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлыг хандан гаргах этгээд болон хугацааг заах.

Дараах тохиолдолд захиргааны актыг амаар эсхүл бичмэл бус хэлбэрээр гаргана. Үүнд:

1. Захиргааны актыг хойшлуулшгүй гаргах шаардлагатай бол
2. Хууль захиргааны хэм хэмжээний актад тодорхой хэлбэрийг заасан бол
3. Эрх зүйн ялимгүй үр дагавар бүхий асуудлыг шийдвэрлэх бол.

**Дүрэм.** Дүрэм нь эрх зүйн төрөлжсөн актын нэгэн төрөл, тодорхой байгууллага эсхүл аж ахуйн үйл ажиллагааны аливаа нэгэн хүрээний эрх зүйн байдлыг зохицуулсан хэм хэмжээний иж бүрдэл акт юм. Өөрөөр хэлбэл, тодорхой төрийн байгууллага, албан газрын эрх зүйн статус, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам буюу нэг төрлийн байгууллага, албан газрын тогтолцоог нарийвчлан зохицуулсан, түүнчлэн эдгээрийн бусад байгууллага, албан газар ба иргэнтэй харилцах харилцааг тодорхойлсон эрх зүйн хэм хэмжээний акт. Дүрмийг хууль тогтоох төдийгүй эрх зүй бүтээх бусад байгууллага баталсан байж болно.

**Журам.** Эрх зүйн хэм хэмжээний актын нэгэн төрөл, ямар нэгэн төрлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын журмыг тодорхойлсон процедурын хэм хэмжээний цогц.

**Заавар.** Тодорхой үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх, хэрэгжүүлэх талаар өгч буй нарийвчилсан заавар, чиглэл юм.

**Захиргааны дотоод журам.** Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, ажилтнуудын хоорондын харилцаа, үүрэг хариуцлагыг тодорхойлох, ажлын байранд эмх цэгцгийг хангах зорилгоор боловсруулсан албан ёсны баримт бичиг юм. Энэ журам нь байгууллагын онцлогт нийцсэн, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах үндэс суурь болдог.

### 1.3.3. Эрх зүйн бусад акт

**Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр.** Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт шүүх засаглалын эрх зүйн акт болохынхоо хувьд экологийн эрх зүйн нэг эх сурвалж болно. Үндсэн хуулийн бүтцээр Үндсэн хуулийн Цэцийг шүүх засаглалын (шүүх эрх мэдлийн) бүлэгт оруулалгүй тусгайд нь Тавдугаар бүлэг болгон тодорхойлсон хэдий ч Цэцийн үйл ажиллагаа, үүрэг, зорилт бүхэлдээ шүүн таслах ажиллагаанд хамаарна.

Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага мөн гэж заасан. Энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд аливаа хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу болон Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1-д заасан эрх бүхий бусад субъектийн хүсэлтээр хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах эрхтэй.

Цэцийн гаргасан хүчин төгөлдөр, эцсийн дүгнэлт нь экологийн эрх зүйн эх сурвалж болдог хууль, эрх зүйн бусад акттай холбоотой буюу шууд чиглэгдэж байгаа нөхцөлд эх сурвалж болж үйлчлэх бүрэн чадвартай.

**Шүүхийн шийдвэр.** Шүүх эрх мэдлийн байгууллагын акт нь экологийн эрх зүйн эх сурвалжийн нэг болно. Юуны өмнө Улсын дээд шүүхээс экологийн эрх зүйд хамаарах хуулийг тайлбарласан тогтоол байх юм.

Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд Монгол Улсын Дээд Шүүх “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрх эдэлнэ гээд Улсын Дээд Шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ гэж заажээ.

Иймээс Улсын Дээд Шүүхээс экологийн эрх зүйн харилцааны зохицуулалтад шууд ба дамжуут холбогдох аливаа хууль, түүний зохих зүйл, заалтыг тайлбарлаж гаргасан тогтоол шүүхийн практикт ч, шүүхэд гомдол гаргах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд ч, хууль хэрэглэх, биелүүлэх бүх байгууллага, иргэдэд ч аль алинд нь заавал дагаж мөрдөх хүчинтэй үйлчилнэ.

## 1.4 БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР ДАХЬ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НЭГДЭН ОРСОН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

Энэ сэдэвт байгаль орчны салбар дахь гадаад хамтын ажиллагаа, манай улсын нэгдэн орсон гэрээ хэлэлцээрийн талаар авч үзнэ. Дэлхийн олон улс өөрийн дотоод асуудлаас гадна, гадаад тулгамдсан аливаа асуудлыг хамтран, хамтын хүчээр шийдвэрлэж ирсээр хэдэн зууныг үджээ.

Нэг улс дангаараа шийдэж чадахгүй эсвэл аюулгүй байдал, гадаад худалдаа арилжаа, эдийн засгийн гээд олон олон асуудлуудтай нүүр тулгарч байдаг. Эдгээр асуудлаа шийдэхийн тулд олон улсын түвшинд эрх зүйн баримт бичиг боловсруулж, харилцан зөвшөөрч дагаж мөрддөг байна.

**Олон улсын гэрээ** гэдэг нь хоёр буюу хэд хэдэн улс, олон улсын эрх зүйн бусад субъектүүд улс төр, эдийн засгийн болон бусад харилцаанд тэдгээрийн хооронд харилцан эрх, үүрэг тогтоох буюу эсхүл өөрчлөх эсхүл дуусгавар болгох хэлэлцээр юм. Олон улсын гэрээ нь олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж болдог.

Олон улсын гэрээ нь гэрээ, хэлэлцээр, пакт, трактат, конвенц, тунхаглал, албан ёсны мэдээ (коммюник), протокол гэх зэргээр олон янзаар нэрлэгдэх олон улсын бүх хэлэлцээрийг хамарсан төрлийн шинжтэй ухагдахуун. Эдгээр нэршилд хатуу тогтоосон нарийн зааг ялгаа байдаггүй. Хэрхэн нэрлэхээс үл шалтгаалан бүх гэрээ нь хууль зүйн нэгэн адил хүчин чадалтай байна. Олон улсын гэрээнд оролцогчдын тооноос хамааран хоёр ба олон талын хэмээн ангилна.

**Монгол Улсын олон улсын гэрээ** гэж Монгол Улс, Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг болон хэд хэдэн Улс, тэдгээрийн Засгийн газар, эсхүл Олон Улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, Олон Улсын эрх зүйгээр зохицуулагдах, түүний төрөл, нэрээс үл хамааран хоёр болон олон талын бичгээр үйлдсэн нэг, эсхүл өөр хоорондоо холбоотой хоёр болон хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа олон Улсын тохиролцоог ойлгоно.

**Олон улсын гэрээ байгуулах** гэж Монгол Улс, Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг болон хэд хэдэн Улс, тэдгээрийн Засгийн газар, эсхүл олон Улсын байгууллагатай харилцан тохиролцсон болон тухайн Олон Улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн гэрээнд гарын үсэг зурах, гэрээг бүрдүүлэгч баримт бичгийг солилцох, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох, эдгээртэй адилтгах бусад аргаар тухайн Олон Улсын гэрээг заавал биелүүлэхээ олон Улсын хэмжээнд зөвшөөрсөн үйлдлийг ойлгоно.

**Гэрээнд нэгдэн орох** гэж хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээг Монгол Улс тухайн гэрээгээр хүлээн зөвшөөрсөн арга, энэ хуульд заасны дагуу заавал биелүүлэхээ Олон Улсын хэмжээнд зөвшөөрсөн үйлдлийг хамруулан ойлгоно.

Байгаль орчны асуудал бол хил хязгааргүй бөгөөд манай гариг дээрх хамгийн их даяаршсан асуудал юм. Байгаль орчны салбар бол нийгэм, эдийн засгийн аль ч салбарт хүрч, хүрэлцэж байдаг хөрвөгч шинж чанартай. Энэ утгаараа тухайн улс орны хэмжээнд төдийгүй олон улсын хэмжээнд байгаль орчны асуудлыг хамтран хэлэлцэн ярилцаж зөв шийдэл гаргалгааг гаргахыг улс орнууд эрмэлздэг. Аливаа улс орон өөрийн хүчээр хийж барахааргүй асуудалтай

тулгарах тохиолдолд бусдаас дэмжлэг авах, хамтран ажиллах, бие биеэ харилцан нөхөх зэргээр ажиллах шаардлагатай болдог.

### 1.4.1. Олон улсын хэмжээнд тулгамдаж буй байгаль орчны асуудлууд

Байгаль орчны хамгаалалтай холбоотой ихэнх асуудал нэг улсын хил хязгаараас хальж бүс нутаг, дэлхий дахины шинжтэй байна.

**Цэвэр усны хомсдол.** Цэнгэг усны эх булаг болсон мөнх цаст ноён оргилууд уур амьсгалын дулаарлаас болж жил ирэх тусам хайлсаар байна. Энэ хэвээрээ үргэлжилбэл гол горхи ширгэж, хуурайшилт, хөрсний элэгдлийг араасаа дагуулах юм.

Манай дэлхийн гадаргын 71%-ийг ус эзлэх боловч нийт усны ердөө 2.5% нь цэнгэг ус байдаг. Энэ цэнгэг усны нөөцийн дийлэнхийг өмнөд, хойд туйлын мөс цас, мөсөн голууд эзэлдэг учир газарзүйн байршил, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалаад 31%-ийг нь л хүмүүс хэрэглэх боломжтой. Өнөөдөр дэлхий даяар хүний хэрэгцээнд зориулан 4600 гаруй шоо километр ус олборлож буйгаас 69%-ийг нь хөдөө аж ахуй, газар тариалангийн усалгаанд, 19%-ийг нь аж үйлдвэрлэл, 12%-ийг нь хотын хүн амын унд, ахуйн хэрэгцээнд ашиглаж байна.

Хотжилт эрчимтэй явагдсанаар цэвэр усны хүртээмжийн тэнцвэр алдагдаж, хүн ам болон цэвэр усны нөөцийн жигд биш тархалттай холбоотойгоор ойрын хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн олон улс оронд цэвэр усны нөөцийн хомсдол нүүрлэх төлөвтэй байна. Жилд хүмүүс бидний хэрэглэж буй усны хэмжээ зарим бүс нутгуудад байгалиасаа нөхөн сэргээгдэж байгаа хэмжээнээс аль хэдийнээ давсан байна.

Уур амьсгалын дулаарлын улмаас усны ууршилт нэмэгдэж газрын гадарга дээрх ус ширгэж, цөлжилт эрчимжиж байгаа бол сүүлийн арван жилийн хотжилт төвлөрлөөс болж усны хэрэглээ урьд байгаагүй ихээр нэмэгдсээр байгаа ба дэлхийн хотуудын 95% нь хэрэглэсэн усаа гол, цэвэр усны эх үүсвэр рүү цутгаж байна.

Усны хомсдол нь хоол хүнсний гачигдал, уснаас үүдсэн бүс нутгийн чанартай мөргөлдөөнүүд, эдийн засгийн өсөлт удаашрах, байгаль орчны доройтол зэрэг олон хямралын эх үүсвэр болж байна. Бидний ашиглаж буй гүний ус нь харьцангуй нөхөн сэргэх чадвар муутайгаас гадна, бохирдуулбал эргээд нөхөн сэргээх боломж бараг байхгүй юм.

Дэлхийн гол мөрний 60% нь 2 болон түүнээс олон орны хил дамжин урсдаг учир ус хамтран ашиглах талаар дэлхийн олон улс орны Засгийн газар хооронд 300 гаруй хэлэлцээр байгуулсан байна. Харин НҮБ-ын усны урсгалын асуудлаарх 1997 оны конвенц байдаг боловч хангалттай тооны орон (35) нэгдэн ороогүйн улмаас хүчин төгөлдөр болоогүй байна.

**Дэлхийн дулаарал.** Дэлхийн дулаарал гэдэг нь дэлхийн хуурай газар, далайн гадаргуу орчмын агаарын дундаж температур ихсэх үзэгдлийг хэлнэ. Агаарын дундаж температур сүүлийн хэдэн арван жилд тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд цаашид ч мөн үргэлжилнэ гэж үзэж байгаа болно.

2001-2010 он дэлхийн цаг уурын хяналт шинжилгээний түүхэн дэх хамгийн дулаан арван жил болжээ. Уур амьсгалын өөрчлөлт хүний хүчин зүйлээс ихээхэн шалтгаалж байгаа бөгөөд олон сөрөг үр дагаврыг араасаа дагуулсаар байна. Дулааралд хүргэж байгаа гол эх сурвалж нь хүлэмжийн хий бөгөөд агаар мандалд хуримтлагдсанаар агаарын хэмийг өсгөж байна.

Агаарын найрлага дахь хүлэмжийн хий нэмэгдэж цаг агаар дулаарсны улмаас дэлхийн мөсөн бүрхүүл багасаж байгаа нь бөмбөрцгийн буцаж ойх нарны цацрагийн дулаарал илүү хурдацтай явагдахад хүргэж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн хойд хагаст эрчимтэй явагдаж байгаа ажээ. Энэхүү өөрчлөлтийн улмаас эх газрын өндөрлөгт орших Орос, Хятад, Иран, Монголд нэг болон түүнээс дээш хэмээр дулаарсан байна.

**Ой модны хорогдол.** Ой мод устай адил бидний амьдралын эх булаг. Учир нь мод ургамал агаар дахь нүүрсхүчлийн хийг багасгаж, хүчилтөрөгчөөр баяжуулан амьд биетүүдийг тэтгэхээс гадна, усны урсцыг сайжруулж, газрын үржил шимийг дээшлүүлэх чухал ач холбогдолтой. Хүмүүс бид одоог хүртэл цаас, түлш, орон байр, хашаа, хүнс зэрэг олон зүйлд нөхөн сэргэх нөөцөөс нь хэтрүүлэн ашиглаж байгаа нь ой устгах аюулд хүргэж байна. Ой мод нь хүлэмжийн хий буюу нүүрсхүчлийн хийг шингээгч болдгоор дэлхийн дулаарлыг сааруулахад чухал үүрэгтэй. Өнгөрсөн зууны турш хүмүүн төрөлхтөн тариан талбайг ихээхэн нэмэгдүүлэх зорилгоор ойн томоохон нөөцөө сүйтгэж устгасан нь том алдаа байв. Мөн сүүлийн жилүүдэд хуурайшилтай холбоотой ойн түймэр ихээхэн гарах болжээ.

**Хөрсний доройтол, цөлжилт.** Өнгөрсөн зууны туршид газрыг их хэмжээгээр хагалж, хортон шавжийг химийн бодис ашиглан устгаж, талбайг их хэмжээгээр услан арвин ургац авахад чиглэж байлаа. Дэлхийн хуурай гадаргын нийт талбай 149 сая км<sup>2</sup> бол түүний 51 саяыг нь хөдөө аж ахуйд ашиглаж байна. Мөн нийт ойн талбай 38 сая км<sup>2</sup> байгаа нь дэлхийн хэмжээнд нэг хүнд дунджаар 0.3 га ноогдож байгаа ажээ. Гэхдээ дэлхийн улс орнуудын тариалангийн талбай харилцан адилгүй байгааг бас бодолцох хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулааралтай холбоотой ган, цөлжилт, байгалийн гамшигт үзэгдэл зэргээс шалтгаалан ургац алдах, бүтээмж буурах болсон учраас хүнсний хомсдолд орох, ядууралд нэрвэгдэх зэрэг олон сөрөг үр дагавар араасаа дагуулж байна. Мөн газрын хөрсний доройтол 1.5 тэрбум хүний амьжиргаанд аюул учруулж, газар тариалангийн талбайн 30-35% нь ашиглах боломжгүй болж, цөлжилтэд жил бүр 12 сая га талбай өртөж, жилд хураан авч болохуйц буудайн ургац 20 сая тонноор буурч байна. Цөлжилтийн улмаас ойрын арван жилд 50 сая хүн орон байраа орхин нүүх шаардлагатай болох ажээ.

**Экосистемийн доройтол, биологийн олон янз байдлын хомсдол.** Экосистемийг хадгалах, биологийн олон янз байдлыг хамгаалах нь хүн амын аж амьдралыг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэхэд нөлөөтэй. Хулгайн анд өртөх, идээшил нутгаа алдах зэрэг олон шалтгаанаар сүүлийн хэдхэн жилийн дотор 100-120 зүйл амьтан, ургамал аюулд учраад байгаа ажээ. Иймд дэлхий нийтийн хойшлуулшгүй чухал зорилтын нэг нь биологийн төрөл зүйлийг хамгаалах асуудал юм. Үүний тулд газар нутгийг тусгай хамгаалалтад авах, түүний менежментийг сайжруулах, амьтан, ургамлын олон улсын худалдааны зохицуулалтыг сайжруулах, тогтвортой ашиглалт, хамгаалалтыг гэрчилгээжүүлж, газар нутгийн бүх нөөц баялгийг хамтад нь нутгийн уугуул иргэдэд урт хугацаанд эзэмшүүлж зохистой ашиглуулан хамгаалах, удмын болон гений санг бий болгох, өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх зэрэг олон арга хэмжээ авах хэрэгтэй хэмээн зарим эрдэмтэд үзэж байгаа боловч нөгөө хэсэг нь амьтад болон ургамал дэлхийн дулааралд дасан зохицохын тулд хойд зүг рүү тэмүүлэн нүүдэллэж байхад энд тэндхийн газрыг тусгай хамгаалалтад авах нь утгагүй асуудал гэж үзэж байна. 2050 он гэхэд дэлхийн дулаарал 2 хэмээр нэмэгдэх үед дэлхийн нийт биологийн төрөл зүйлийн гуравны нэгээс илүү нь устсан, мөн сая гаруй зүйл нь устгах аюулд орсон хэмээн бүртгэгдэх өндөр магадлалтай гэж үзэж байна.

**Химийн хортой болон аюултай бодис, хаягдал.** Хүн төрөлхтний нийгэм, эдийн засгийн хөгжилд химийн бодисын хэрэглээ их үүрэгтэй. Өнөөгийн байдлаар дэлхийд 10 сая гаруй нэр төрлийн химийн бодис бүртгэгдсэний 70 мянга орчим нь бидний амьдрал ахуйд өдөр

тутам ашиглагдаж байгаагаас 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлж, эдгээрээс одоогийн байдлаар 200 гаруй нь хорт хавдар, өмөн үүгийн эх үүсвэр болдог нь батлагдаад байна. Олон улсын зах зээлд жил тутам 1000 төрлийн химийн бодис шинээр гардаг бөгөөд 400 сая тонн химийн бодис үйлдвэрлэдгээс болж мөн ийм хэмжээний хаягдал бий болж байна. Химийн бодисын хор аюулын болон аюулгүй ажиллагааны мэдээлэлгүйгээс шалтгаалан ямар осол аюултай бодистой харьцаж байгаагаа хэрэглэгчид тэр бүр мэддэггүй, аюулгүй ажиллагааны зохих шаардлагыг хангаагүй байдаг зэрэг нь хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд ноцтой нөлөөлж байна.

Дэлхийн улс орнууд цөмийн цахилгаан станц ашиглаад 60-аад жил болжээ. Одоогоор 30 гаруй улсад 420 гаруй цөмийн станц байгаа бөгөөд тэдгээр нь жилдээ 2300 орчим тонн хаягдал ялгаруулдаг. Хаягдлыг аюулын түвшнээр нь өндөр, дунд, бага гэж ангилах ба цацраг идэвхт бодис агуулагдах хугацаа нь өөр өөр байдаг. Бага, дунд түвшнийх нь 1000 жилийн дараа аюулгүй болох бол өндөр түвшнийх нь хэдэн арван мянган жилийн настай байдаг ажээ.

**Хүн амын өсөлт.** 2024 оны 8 дугаар сарын байдлаар дэлхийн хүн ам 8.12 тэрбумд хүрээд байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна. НҮБ-ын мэдээлж буйгаар 2011 онд дэлхийн хүн ам 7 тэрбум, 2021 онд 7.9 тэрбум хүрсэн бөгөөд 2030 онд 8.5 тэрбум, 2050 онд 9.7 тэрбум, 2100 онд 10.9 тэрбум хүн амд хүрэх төлөвтэй байгаа ажээ.

Хүн амын тоо ихээр өсөж байгаа нь том хотуудын нягтаршил нэмэгдэх бас нэг шалтгаан болж байгаа бөгөөд ингэснээр хүн амын ундны ус, хаягдал бохирдол зэрэг олон асуудлууд тулгамдаж байна.

**Ядуурал.** Хүмүүний амьдралын чанарыг тодорхойлогч хүнс тэжээл, хувцас, гэр орон зэрэг ердийн хэрэгцээний дутагдал гачигдлыг ядуурал гэнэ. Дэлхийн хүн амын тал хувь нь ядуу гэх статистик байдаг. Ядуурлыг үнэмлэхүй ба харьцангуй ядуурлаар хэмжиж болно. Үнэмлэхүй ядуурал гэж улс гүрнүүд ба цаг хугацааны турш тогтмол байж ирсэн стандартыг хэлнэ. Үнэмлэхүйн хэмжилтийн жишээ гэвэл хүнд зайлшгүй хэрэгтэй хоол тэжээлийгээ (насанд хүрсэн эр хүнд 2000-2500 калор орчим) хүртэж чадахгүй байгаа хүн амын хувийг хэлнэ.

Дэлхийн банк нь туйлын ядуурлыг өдөрт 1 америк доллароос доош мөнгөөр амьдарч байгаа, дунд зэргийн ядуурлыг хоёр америк доллароос доош мөнгөөр амьдарч байгаа хэмээн тодорхойлдог.

Ядуурлыг чухамдаа ундны ус, хоол тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, хувцас, орон сууц зэрэг хүний наад захын хэрэглээний хомсдолоос үүдэлтэй гэж үзэж болно. Ядуурлын улмаас байгаль орчин мөн доройтож байдаг. Ядуурал нь нийгмийн үзэгдлийн хувьд тухайн нийгмээ тогтворгүй болгож асуудлыг улам хурцатгах шалтгаан болдог учраас макро эдийн засгийн тулгуур ойлголтын нэг болно.

**Байгалийн баялаг.** Байгалийн баялаг хязгаарлагдмал, тархац нь жигд бус тул тэдгээрийг эзэмших, хүртэх эрх хязгаарлагдмал байна. Дэлхийн эдийн засаг, худалдааны интеграцилал өргөжихийн хэрээр орчин үеийн техник ямар ч томоохон ордыг хэдхэн жилийн дотор ухаж дуусгах чадалтай болсон, тээвэр хөгжиж зардал буурснаар баялгийг дэлхийн аль ч оронд шуурхай хүргэх бололцоотой болсноор хөгжиж буй нэлээд орнуудын эдийн засагт хүчтэй түлхэц өгч байна. Тиймээс байгалийн хэрэгцээт баялгаас хүртэх бололцоотой байх, орд газруудыг эзэмшихийн төлөө дэлхийн хэмжээний өрсөлдөөн явагдаж, баялагтай орны эрх баригчдыг худалдан авч, өөрт ашигтай нөхцөлөөр гэрээ хэлэлцээр байгуулах, хуйвалдах, зарим тохиолдолд зэвсэгт мөргөлдөөн гарч байгаа нь нууц биш болжээ.

Өнөөдөр дэлхийн хэмжээнд үйлдвэрлэл хэзээ ч байгаагүй хэмжээнд тэлж түргэн өсөж байгаа нь түүхий эд, эрчим хүчний эх булгийг ихээр шаардах болсон. Үүнээс харахад, байгалийн баялгийн дийлэнх хэсгийг дэлхийн нөлөө бүхий хөгжилтэй орнууд хэрэглэж байна. Хэдий тийм ч сүүлийн жилүүдэд хөгжиж буй орнуудын жин нөлөө нэлээд нэмэгдэж байгаа бөгөөд хэрэглээний хувь хэмжээ нь нэмэгдсээр байна.

**Эрчим хүч.** Дэлхийн эрчим хүчний хэрэглээ 2006-2030 онд жил тутам 1.6%-аар өсөх, эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглах эрдэс түүхий эдийн оролцоо 80%-аас буурахгүй байх төлөвтэй байна. Энэхүү хэрэглээний өсөлтийн 3/4 нь хөгжиж буй орнуудын хэрэглээнд ногдож байна. Эрчим хүчний үндсэн эх үүсвэрийн газар зүйн тархац харилцан адилгүй, нөөц нь хязгаарлагдмал, орд газруудыг ашиглах нөхцөл хүндэрч буйн улмаас улсуудын хувьд эрчим хүчний байнгын найдвартай хангамжтай байх асуудал тулгамдаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс олон арга замыг эрэлхийлж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн нэгэн үндэс болсон сэргээгдэх эрчим хүчийг ашиглан эрчим хүчээр хангагдах бодлогод улс орон бүр анхаарал хандуулж байна.

Сэргээгдэх эрчим хүч гэдэг нь нар, салхи, бороо, далайн давлагаа, газрын гүний дулаан зэргээс гарган авдаг, байгалиас тасралтгүй сэргээгддэг энергийг хэлэх ба энэ нь байгалийн үзэгдлээр тасралтгүй нөхөгдөнө. Дэлхийн нийт эрчим хүчний 3%-ийг сэргээгдэх эрчим хүчнээс гарган авч ашиглаж байна. Сэргээгдэх эрчим хүчинд шилжинэ гэдэг нь аж үйлдвэрийн хувьсал эхэлснээс хойших хамгийн өргөн хүрээтэй, одоогийн тогтолцоог үндсээр нь өөрчлөх шилжилтийг хийнэ гэсэн үг.

#### 1.4.2. Байгаль орчны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа

Дэлхийн улс орнуудын хэмжээнд шийдвэрлэж чадахгүй олон асуудлыг хамтаар шийдвэрлэхийн төлөө хамтын ажиллагааг олон арга хэлбэрээр хийж байна. Үүний нэг тод жишээ нь улс орны төрийн тэргүүн, олон улсын байгууллагууд хамтран гарц гаргалгаа, шийдэл олохын тулд хуралдан зохих шийдвэрийг гарган хэрэгжүүлдэг. Үүнээс байгаль орчинтой холбоотой томоохон үйл явц, гаргасан шийдвэрийг тодруулж үзье. Үүнд:

**1992 оны НҮБ-ын дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт.** Бразил улсын Рио де Жанейро хотноо НҮБ-ын “Байгаль орчин ба Бразил” сэдэвт хуралд нийтдээ 178 орны 115 төрийн тэргүүн, төрийн бус байгууллагын 15000 төлөөлөгчид оролцон чуулсан ба анх удаа төрийн тэргүүнүүд тогтвортой хөгжлийн дэлхийн чиг хандлага болон үндэстэн бүрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсноороо онцлогтой болсон юм.

Уг хурлаас “Дэлхий дахины XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчныг хамгаалах, нийгмийн үндсэн бүлгүүдийн үүргийг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийн тогтолцоог хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг дэвшүүлсэн байна. Үүний дагуу улс орнууд XXI зууны хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн билээ. XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ямар нэгэн тогтсон нэг загвар байхгүй. Улс орон бүр өөрийн онцлог, тулгамдсан асуудлаараа харилцан адилгүй. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Чадавх 21” сан улс орнуудын онцлог ялгааг цогц авч үзэж чадсан бөгөөд тогтвортой хөгжлийн чадавх бүрдүүлэхэд үнэтэй туршлага хуримтлуулснаар тогтвортой хөгжлийн ерөнхий загварыг бий болгожээ.

Энэ хурлаар **Биологийн олон янз байдлын тухай конвенцыг** баталсан юм. Уг конвенцод биологийн олон янз байдлыг хадгалах нь хүн төрөлхтний хамтын зорилго, үндэстэн бүрийн хариуцлага, түүнийг зохистой ашиглах явдлыг хангах нь улс нэг бүрийн үүрэг гэж заажээ.

### **Биологийн олон янз байдал гэж юу вэ?**

Биологийн олон янз байдал (Biodiversity) гэдэг нь дэлхий дээрх амьдралын олон янз байдал, тэдгээрийг бүрэлдүүлэх олон янз, хэв маягт оноосон нэр томъёо юм. Үүнд манай гаригийн амьтан, ургамал, мөөг, бичил биетний зүйлийн бүрдэл төдийгүй тэдгээрийн генийн сан хөмрөг, амьдралын хам бүрдэл, амьдрах орчны олон янз байдал, тэнд явагдах эволюци, экологийн нэгдмэл үйл явц цогцоороо хамаарна.

**2000 оны Мянганы тунхаглал.** Шинэ Мянганы босгон дээр буюу 2000 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанд төрийн тэргүүн нар хуран чуулж, энх тайван, байгаль орчин, хүний эрх, эмзэг асуудлууд, өлсгөлөн, ядуурал, Африкийн асуудал болон НҮБ-тай холбоотой 60 гаруй зорилгыг баталсан юм. Эдгээр зорилтын ихэнх нь 2015 он гэхэд ядуурлыг 50% бууруулах, анхан шатны боловсролыг дэлхий нийтээр эзэмших зэрэг тусгайлсан зорилтууд дэвшүүлжээ. Томоохон 8 зорилгын хэрэгжилтэд олон улсын агентлагууд хяналт тавихаар болсон.

Энэ хүрээнд ядуурал, өлсгөлөнг бууруулах, хүний дархлал хомсдолын нян, сүрьеэ өвчинтэй тэмцэх, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх зэрэг асуудлыг дэвшүүлсэн.

**НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр.** НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр нь ерөнхийдөө НҮБ-ын систем дэх байгаль орчны байгууллагуудыг чиглүүлэх үүрэгтэй. Энэ үүргийнхээ хүрээнд ирээдүй үеийнхний амьдралын чанарыг муутгахгүйгээр өнөө үеийнхний амьдралын чанарыг дээшлүүлэхэд улс үндэстэн, ард түмэнд байгаль орчноо хамгаалах хүрээнд хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх юм. Уг хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд нь:

- Уур амьсгалын өөрчлөлт
- Экосистемийн менежмент
- Байгалийн гамшиг ба хямралт байдал
- Байгалийн нөөцийн үр ашигтай байдал
- Аюултай бодис, хог хаягдал
- Байгаль орчны засаглал зэрэг болно.

НҮБ нь XXI зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Риогийн тунхаглалд заасан олон үүрэг амлалтын хамт бодлогын арга хэмжээг нэгтгэн тогтвортой хөгжлийн үндэсний стратеги боловсруулахад улс орны засгийн газруудад дэмжлэг үзүүлэн, олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн улс орнуудын хүчин чармайлтыг дэмжиж, улмаар эдийн засгийн хөгжил, байгаль орчны асуудлууд дээр хамтран ажиллаж байна.

Сүүлийн үед дэлхийн эрчим хүч, хүнсний нөөцийн хомсдол, санхүүгийн хямрал гүнзгийрч экологийн асуудал хурцдаж байгааг эрдэмтэд анхааруулж байна. Засгийн газрууд өнөөдөр эдгээр хомсдож буй нөөцийн асуудлыг шийдвэрлэхдээ улс орноо хэрхэн зөв зүйтэй удирдах арга замыг хайж ногоон эдийн засгийн чиглэлээр үндэсний бодлого боловсруулах, олон талт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, мэдлэг туршлагаа солилцохыг зорьж байна.

2008 оны санхүүгийн хямралаас хойш болсон 2012 оны НҮБ-ын тогтвортой хөгжлийн чуулга уулзалтын үзэл баримтлал нь улс орнуудын анхаарлыг ихээр татсан бөгөөд олон улсын байгууллагууд, засгийн газрууд, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллагуудаас ногоон эдийн засгийн талаарх шинэлэг судалгаа, үзэл санаа ихээр гарах болсон. Африк, Латин Америк, Ази-Номхон далайн болон Европын ихэнх бүс нутагт хөгжиж буй орнууд үндэсний ногоон эдийн засгийн стратеги боловсруулан хэрэгжүүлж байна.

**НҮБ-ын тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр.** 2015 оны 9 дүгээр сард Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаар дэлхийн 150 гаруй улсын төр, засгийн тэргүүн нар оролцож “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг баталсан нь дэлхий нийтээрээ ирэх 15 жилийн хөгжлийн зорилтуудыг тодорхойлох түүхэн чухал ач холбогдолтой алхам болов. Хүний аж байдлыг сайжруулах, ядуурлыг бууруулах, хүний эрх болон ардчиллыг бэхжүүлэх, байгаль орчныг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд Мянганы хөгжлийн 2001 онд баталсан зорилтуудыг 2015 он хүртэл хэрэгжүүлсэн юм. Бразил улсын Рио де Жанеро хотноо 2012 онд чуулсан Рио+20 НҮБ-ын бага хурлаас баталсан “Бидний хүсэж буй ирээдүй” баримт бичиг, шийдвэрийн дагуу даян дэлхийн тогтвортой хөгжлийг тодорхойлж боловсруулах үүрэг бүхий Нээлттэй ажлын хэсэг байгуулсан. Дээрх ажлын хэсэг 2013-2014 онд өргөн хүрээг хамруулан 13 удаа хуралдаж, яриа, хэлэлцээ хийсний үр дүнд 17 үндсэн зорилгыг хамрах 169 зорилтод хүрэх **“Тогтвортой хөгжлийн зорилтууд”**-ыг боловсруулсан юм. Дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн зорилтууд нь:

- 1) Ядуурлыг устгах
- 2) Өлсгөлөнг зогсоох
- 3) Эрүүл мэндийг дэмжих
- 4) Чанартай боловсролыг дэмжих
- 5) Жендерийн эрх тэгш байдлыг хангах
- 6) Ундны баталгаат ус, ариун цэврийн байгууламжаар хангах
- 7) Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
- 8) Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох
- 9) Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх
- 10) Тэгш бус байдлыг бууруулах
- 11) Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
- 12) Хариуцлагатай хэрэглээг дэмжих
- 13) Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
- 14) Далай тэнгисийн нөөцийг хамгаалах
- 15) Хуурай газрын экосистемийг хамгаалах
- 16) Энх тайван, шударга ёсыг цогцлоох
- 17) Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг болно.

Тогтвортой байна гэдэг нь эдийн засгийн өсөлтөөс илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд зохистой хөдөлмөр эрхлэлтийг агуулдаг. Дэлхий нийтээрээ ядуурлаас ангижрах, эх дэлхийгээ хамгаалах, хүн болгоны ирээдүйн сайн сайхны төлөө эдгээр 17 зорилтыг зайлшгүй биелүүлэх учиртай болжээ. Энэхүү үйл явцад НҮБ-ын гишүүн бүх улс төдийгүй иргэний нийгэм, бизнес эрхлэгчдийн төлөөллийг хамруулан оролцогч бүх талуудын саналыг баримт бичигт тусгаж, нийтийн зөвшилцлөөр баталсан нь чухал алхам байв.

Хөгжлийн хөтөлбөр, тогтвортой хөгжлийн зорилтуудыг тодорхойлох яриа хэлэлцээнд Монгол Улс ядуурал, ажилгүйдэл, боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, усны нөөц, байгаль орчны бохирдол, ногоон хөгжил, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хэрэгцээ, шаардлага гэх мэт асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч байв.

**2015 оны Парисын гэрээ.** Парис хотноо 2015 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан цаг уурын хуралдаанаар 195 орон дэлхийн цаг уурын хэлэлцээрт нэгджээ. Хэлэлцээр нь дэлхийн цаг уурын аюулт байдлаас сэргийлэхийн тулд дэлхийн дулаарлыг 2°C-ээр багасгах алхам хийснээрээ ач холбогдолтой юм. Уг хэлэлцээр 2020 он хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Европын холбоо нь 2030 он гэхэд наад зах нь 40%-аар хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр гарын үсэг зурж гэрээг соёрхон батлав. Засгийн газрууд дараах тохиролцоонд хүрчээ. Үүнд:

- Дэлхийн дундаж дулаарлыг 2°C-ээр багасгах урт хугацааны зорилтыг хэрэгжүүлэх
- Шинжлэх ухаан, технологийн хамгийн оновчтой ололт, амжилтыг нэвтрүүлэн хүлэмжийн хийн ялгаруулалтыг огцом бууруулахад хамтарч ажиллах
- Технологийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 5 жил тутам хуралдах
- Зорилгын биелэлтээ улс орнууд харилцан болон ард түмэндээ мэдэгдэх, тайлагнах
- Урт хугацааны зорилтын хүрээнд ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулан ахиц дэвшилд хүрэх
- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадварыг бэхжүүлэх.

**Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблей.** Ерөнхий ассамблей нь улс төр, эдийн засаг, нийгмийн болон бусад салбарт олон улсын хамтын ажиллагааны зарчмын талаар зөвлөмж гаргадаг дээд эрх мэдлийн байгууллага юм. НҮБ-ын дүрмийн заалтын дагуу Ерөнхий ассамблей дараах чиглэлийн үндсэн асуудлуудыг авч хэлэлцэх эрхтэй байна. Үүнд:

- Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх
- Зэвсэглэлийг хорогдуулах, зэвсэг хураах
- Улс хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлуудад дөхөм үзүүлэх
- Хүн амын бодлого, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах хэрэгт дөхөм үзүүлэх
- Байгаль орчныг хамгаалах
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэн эмхэтгэх, дэвшилттэйгээр хөгжүүлэх гэх мэт.

Дээрх асуудлуудыг авч хэлэлцсэн НҮБ-ын гишүүд Аюулгүйн зөвлөлд хандан зөвлөмж гаргана.

**НҮБ-ын Хүрээлэн байгаа орчин хөтөлбөр (UNEP).** 1972 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоолоор байгуулсан. Гол зорилго нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудлаар олон улсын хамтын ажиллагааны зорилтыг тодорхойлж, хэрэгжилтийг нь зохион байгуулахад оршино.

Энэхүү зорилгын хүрээнд НҮБ-аас байгаль орчны талаар явуулах үйл ажиллагааны зорилго, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг нь хангах ажлыг зохицуулах, байгаль орчны ажиглалт хийх, үнэлэлт дүгнэлт гаргах, зохистой ашиглах эдийн засгийн ажиллагааны талаар судалгаа хийх, хүний эрүүл мэнд, тохитой амьдралын орчныг сайжруулах зэрэг үйл ажиллагаа явуулна.

**НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО, UNESCO).** 1945 онд Лондонд болсон олон улсын хурлаас хүн төрөлхтний оюун билэг, зан суртахууны эв нэгдэлд үндэслэн бат бэх энх тайван тогтоох зорилгоор байгуулсан. 1946 оны 12 дугаар сараас НҮБ-ын төрөлжсөн байгууллага болжээ. Гол зорилго нь:

- Нийтийн боловсрол, гэгээрэл, шинжлэх ухаан, соёлын салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Нийтийн мэдээллийн хэрэгслийг энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх үйлсэд ашиглах ажиллагаанд дөхөм үзүүлэх
- Хүний эрх, шударга ёс, хууль зүйг бүх нийтээр хүндэтгэх тусын тулд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд нөлөө үзүүлэхэд оршино.

Монгол Улс 1962 онд тус байгууллагад гишүүнээр элсжээ.

**НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ФАО, FAO).** 1945 онд байгуулагдсан. НҮБ-ын төрөлжсөн байгууллага. Уг байгууллагын зорилго нь хүн амын хүнс, тэжээлээр хангах, амьдралын түвшнийг дээшлүүлэх, хөдөө аж ахуй, загасны болон ойн аж ахуйн бүтээгдэхүүний

ашиг шимийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай хүнс, тэжээлийн бүтээгдэхүүний хуваарилалтын системийг боловсронгуй болгох, хүнсний аюулгүй байдлыг хангахад оршино.

Монгол Улс 1973 онд тус байгууллагын гишүүн болжээ.

*Олон Улсын далайн тээврийн байгууллага (ИМО).* 1948 онд байгуулагдсан. 1959 оноос НҮБ-ын төрөлжсөн байгууллага болсон. Гол зорилго нь далайн тээврийн аюулгүй байдлыг хангах, дэлхийн далайг цэвэр байлгах явдалд оршино. Үйл ажиллагааны гол чиглэл нь далайн тээврийн салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, далайд аюулгүй байдлыг хангахад дөхөм үзүүлэхэд чиглэгдэнэ.

*Дэлхийн цаг уурын байгууллага (ВМО, WMO).* НҮБ-ын төрөлжсөн байгууллага. 1973 онд үндэс суурь нь тавигдаж, 1981 оноос үйл ажиллагаагаа эхэлжээ. Гол зорилго нь цаг уурын станцуудын сүлжээ байгуулах, цаг уурын шинжилгээний нэгдсэн норм тогтоох, агаар, тэнгис, далайн тээвэр, усны ашиглалт, хөдөө аж ахуй зэрэг салбарт цаг уурын шинжилгээг ашиглахад тус дөхөм үзүүлэх, шуурхай мэдээлэл харилцан солилцох системтэй болох, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршдог байна.

Монгол Улс 1963 онд тус байгууллагад гишүүнээр элсжээ.

*Атомын эрчим хүчний олон улсын агентлаг (МАГАТЭ, IAEA).* Цөмийн эрчим хүчийг энх тайвны зорилгод ашиглах олон улсын хамтын ажиллагааг эрхлэх дэлхийн гол байгууллага. Атомын эрчим хүчний олон улсын агентлагийг 1954 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуралдсан НҮБ-ын Ерөнхий ассамблейн шийдвэрээр байгуулжээ. Нью-Йорк хотноо 1956 оны 10 дугаар сард хуралдсан олон улсын бага хурлаас тус агентлагийн дүрмийг баталж, 1957 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Гол зорилго нь атомын эрчим хүчийг ашигласнаас дэлхий дахины аюулгүй байдал, хүн төрөлхтний хөгжил, дэвшил, эрүүл мэндийн үйлсэд орох хувь нэмрийг эрчимжүүлэхэд оршино гэжээ. Мөн цацраг идэвхжилээс хамгаалах ажиллагааны заавар дүрмийг боловсруулж, мөрдүүлэх, аюул тохиолдоход яаралтай тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах, хүнс тэжээл, хөдөө аж ахуй, үйлдвэр, усан хангамжийн салбарт цөмийн судалгаа явуулах, байгаль орчныг бохирдлоос хамгаалах, энэ талаарх мэдээлэл солилцох тараах зэрэг үндсэн чиглэл баримтална.

Монгол Улс 1973 онд Атомын эрчим хүчний олон улсын агентлагт гишүүнээр элсжээ.

### 1.4.3. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээр

Байгаль орчныг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон хүрээлэн буй орчны талаарх олон улсын олон талт гэрээ, конвенц болон Монгол Улсын бусад улс орнуудтай байгуулсан хоёр талт хэлэлцээр зэргийг доорх хүснэгтүүдээр харуулав.

**Хүснэгт 1.2.** Монгол Улсын нэгдэн орсон хүрээлэн буй орчны талаарх олон улсын олон талт гэрээ, конвенц

№	Конвенцын нэр	Байгуулагдсан огноо	Хүчин төгөлдөр болсон огноо	УИХ-аас соёрхон баталсан огноо	Монгол Улсын нэгдэн орсон огноо
1.	Биологийн олон янз байдлын тухай конвенц	1992.06.05	1993.12.29	1993.09.24	1993.09.30
2.	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын ерөнхий конвенц	1992.05.09	1993.03.21	1994.09.24	1994.03.21
3.	Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц	1979.06.23	1983.11.01	1996.01.05	1999
4.	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц	1973.03.03	1975.07.01	1995.05.04	1996.04.04
5.	Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венын конвенц	1985.03.22	1988.09.22	1995.10.16	1996.03.07
6.	Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протокол	1987.09.16	1989.01.01	1995.10.16	1996.03.07
7.	Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протоколын Лондонгийн нэмэлт, өөрчлөлт	1990.06.26	1992.08.10	1996.03.07	1996.03.07
8.	Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протоколын Копенгагены нэмэлт, өөрчлөлт	1992.11.25	1994.06.14	1996.03.07	1996.03.07
9.	Ган цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц	1994.10.14	1996.12.26	1996	1996.09.03
10.	Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай Рамсарийн конвенц	1971.02.02	1975.12.21	1997	1997

№	Конвенцын нэр	Байгуулагдсан огноо	Хүчин төгөлдөр болсон огноо	УИХ-аас соёрхон баталсан огноо	Монгол Улсын нэгдэн орсон огноо
11.	Аюултай хог хаягдлын хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц	1989.03.22	1992.05.05	1996.12.05	1997.04.15
12.	Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалагдахад хэрэглэх урьдчилгааг мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц	1998.09.10	2004.02.24		2001.03.08
13.	Байгалийн гамшигг даван туулах, учирсан хохирлыг нөхөн барагдуулахад цахилгаан холбооны эх үүсвэрээр хангах тухай Засгийн газар хоорондын конвенц	1998.06.18	2005.01.08	1998	1998.06.18
14.	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Ерөнхий конвенцын Китогийн протокол	1997.12.11	2005.02.16	1999.07.08	1999.12.15
15.	Халим агнуурыг зохицуулах тухай олон улсын конвенц	1946.12.02	1948.11.10	2002.05.16	2002.05.16
16.	Биологийн олон янз байдлын тухай конвенцын биоаюулгүй байдлын тухай Картагены протокол	2000.01.29	2003.09.11	2003.07.22	2003.07.22
17.	Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай конвенцод Монреалын протоколын 9 дүгээр хуралдаанаас оруулсан нэмэлт, өөрчлөлт	1997.09.17	1999.11.10	2002.03.18	2002.03.28
18.	Бээжингийн нэмэлт, өөрчлөлт (1999) Монреалын протоколын талуудын 11 дүгээр хурлаар баталсан Монреалын протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлт	1999.11.29-12.03	2001.01.01	2007.10.18	2008.06.24
19.	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц	2001.05.22	2004.05.17	-	2004.04.30
20.	Ургамал хамгааллын тухай Ромын конвенц	1951.12.06	1952.04.03	2008.10.09	2009.05.26
21.	Антарктидын тухай гэрээ	1959.12.01	1961.06.23	2015.03.23	2015.03.23

**Хүснэгт 1.3.** Монгол Улсын бусад улс орнуудтай байгуулсан хоёр талт хэлэлцээр

№	Хэлэлцээр байгуулсан улс, төрийн байгууллага	Хэлэлцээр байгуулсан хугацаа, газар
1	Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1998.03.12 Алмата
2	Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	1994.02.15 Улаанбаатар
3	Монгол Улсын засгийн газар болон БНТУ-ын Засгийн газар хооронд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын хүрээнд хамтран ажиллах тухай санамж бичиг	2025.01.16 Анкара

Эдгээр олон улсын гэрээ, конвенцоос заримыг танилцуулъя.

**Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц.** Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр байгуулсан хамгийн анхны Конвенц бол Ираны Рамсар хотод 1971 оны 2 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдсан “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц” юм. Анх байгуулсан хотын нэрээр нэрлэгдэх болсон энэхүү конвенцын үзэл санааны үндсэн санаа нь ухаалаг хэрэглээ юм.

Энэ конвенцыг байгуулах болсон үндсэн шалтгаан нь усны шувууд нь улирлын чанартай хил дамжин нүүдэллэж явдаг учир түүнийг олон улсын нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстой, мөн үүгээр дамжуулан усны шувуудын амьдрах үндсэн орчин болсон ус, намгархаг газрыг хамгаалах шаардлагатай байсанд оршино.

Конвенцод манай улс 1998 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр албан ёсоор нэгдэн орсон билээ. Улмаар усны шувууд олноор амьдардаг, олон улсад ач холбогдол бүхий ус намгархаг газруудын РАМСАР-ын жагсаалтад манай орны 11 нуурыг хамруулаад байна.

**Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц.** Энэхүү конвенцыг анх 1973 онд Вашингтон хотод олон улсын хэмжээнд танилцуулсан бөгөөд эдүгээ дэлхийн 175 улс орон нэгдэн орсон байна. Англи нэрийн товчлол болох “CITES” нэрээрээ олны танил болсон энэхүү конвенц 1975 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд конвенцын зорилго нь зэрлэг амьтан ба ургамлын аль нэгэн зүйл олон улсын худалдаанд хэт их хэмжээгээр ашиглагдаж, үүнээс шалтгаалан устах аюулд орохоос сэргийлэх, хамгаалах явдал юм.

Энэ конвенцын хүрээнд устах аюулд орсон хамгаалах шаардлагатай зэрлэг амьтан ба ургамлыг гурван бүлэгт хувааж тус бүрд нь тохирсон дэглэм бүхий олон улсын хяналт тогтоох зарчмаар ажилладаг. Конвенцод нэгдэн орсон тал, нэгдэн ороогүй аль нэг улстай зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлээр, мөн түүний эд эрхтнээр хийсэн бүтээгдэхүүний худалдаа хийхдээ конвенцын заалтыг мөрдөх үүрэг хүлээнэ.

**Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц.** Улс орны хил дамжин нүүдэллэн амьдардаг зүйлүүд аюул заналд өртөх магадлал их байдагтай холбогдуулан тэдгээрийн хамгаалалт, үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх нь чухал юм. Үүнийг

ухамсарлан энэ конвенцыг Германы Бонн хотноо 1979 онд байгуулсан бөгөөд 1983 онд тус конвенц хүчин төгөлдөр хууль эрхийн баримт бичиг болсон байна.

Конвенцын үндсэн зорилго нь тухайн тодорхой зүйл амьтны тархац нутаг бүхий улс орнууд нүүдлийн зүйлүүдийг хамгаалах бөгөөд энэ зорилгод нийцүүлэн тохирсон, мөн зохицсон арга хэмжээ авч байх, хамгаалалтын статус нь доогуур байгаа нүүдлийн зүйлүүдэд онцгой анхаарал тавьж, тэдгээр зүйлүүдийг болон идээшил нутгийг нь хамгаалах талаар тохиромжтой, зайлшгүй алхмуудыг дангаараа болон хамтын ажиллагааны явцад хэрэгжүүлэх явдлыг дэмжихэд оршино. Энэхүү конвенцод нэгдэн орсон талууд нүүдлийн зүйлүүдтэй холбоотой судалгаа шинжилгээний ажилд хамтран ажиллаж, харилцан тусламж дэмжлэг үзүүлнэ.

**Биологийн олон янз байдлын тухай конвенц.** Бразилийн Рио де Жанейро хотод 1992 онд хуран чуулсан Дэлхийн дээд хэмжээний уулзалтаар ирээдүй хойч үедээ оршин тогтнох чадвартай дэлхийг үлдээх явдлыг баталгаажуулахын зэрэгцээ бидний хэрэгцээнд нийцэх “тогтвортой хөгжил”-ийн цогц стратегийг баталсан. Риогийн уулзалтын үеэр батлагдсан гол хэлэлцээрүүдийн нэг нь Биологийн олон янз байдлын тухай конвенц юм. Энэ гэрээ нь эдийн засгийн хөгжлийг чухалчилж буй өнөө үед дэлхийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үүргийг томъёолсон болно. Энэхүү конвенц нь экосистем, биологийн бүх зүйл, генетик нөөцийг хамран тэдгээрийн зохистой хэрэглээ, ашиглалт, хамгаалалтыг авч хэлэлцдэг дэлхийн хэмжээний анхны конвенц юм. Конвенцын үндсэн зорилго нь:

- Биологийн олон янз байдлыг хамгаалах
- Түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг зүй зохистой ашиглах
- Генийн нөөцийг ашигласнаар үүсэх ашгийг тэнцвэртэй хуваарилах гэсэн гурван үндсэн зорилтыг биелүүлэхэд оршино.

Монгол Улсын Ерөнхий сайд 1992 онд Рио де Жанейро хотод хуралдсан НҮБ-ын “Байгаль орчин ба Хөгжил” бага хурлын үеэр уг конвенцод гарын үсэг зурж, Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 6 дугаар сарын 01-ний өдөр соёрхон баталсан байна.

**Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц.** Энэ нь 1992 оны 6 дугаар сарын 3-14-нд Рио Де Жанейро хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын “Байгаль орчин ба эдийн засгийн хөгжил” бага хурлаар гаргасан олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээр юм. Энэхүү хэлэлцээрийн гол зорилго нь агаар мандал дахь хүлэмжийн хийн нягтаршлыг уур амьсгалд ноцтой нөлөөлөхөөргүй түвшинд тогтворжуулах юм.

Конвенцод орон тус бүрд тусгайлан хүлээлгэсэн хүлэмжийн хийг бууруулах үүрэг тусгагдаагүйгээс гадна, албадан шахах механизм байхгүй юм. Ийм ч учраас конвенц нь олон улсын хэмжээнд үүрэг хүлээлгэсэн эрх зүйн баримт бичиг биш юм. Харин конвенцод цаашид хуулийн дагуу хүчин төгөлдөр протокол гаргах талаар тусгаж өгсөн байна. Үүний дагуу хийгдсэн гол протокол нь Киотогийн протокол бөгөөд конвенцоос ч илүү олонд танигдах болсон.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцод 1992 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхэлж дэлхийн улс орнууд гарын үсэг зурж эхэлсэн бөгөөд 1994 оны 5 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд уг конвенцод 196 орон нэгдэн оржээ.

### Асуулт

- Төрийн бодлого, стратеги гэж юуг ойлгох бэ? Жишээ гарган тайлбарла.
- Төрийн бодлогод ямар ямар асуудлууд багтах бэ? Жишээн дээр ярих.
- Байгаль орчны талаарх төрийн бодлогын үндсэн зарчмын агуулгын талаар ярилцана уу.
- Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялгийг ашиглах төрийн бодлогын агуулгыг юу гэж тодорхойлсон бэ?
- Дэлхийн улс орнуудын хөгжлийн бодлогыг тодорхойлсон хоёр том баримт бичгийг нэрлэнэ үү.
- Монгол Улсын 2050 он хүртэлх хөгжлийн бодлогыг тодорхойлсон баримт бичгийн талаар ярилцана уу?
- Монгол Улсын байгаль орчныг хамгаалах чиглэлээрх хууль тогтоомжийн тоймыг нэрлэх үү.
- Экологийн эрх зүйн талаар харилцан ярилцана уу?
- Олон улсын хамтын ажиллагааны зорилго юу бэ?
- Олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцын талаар харилцан мэдлэгээ хуваалцана уу.

### Дасгал

Нэг. Байгаль орчны хууль тогтоомжийг байгалийн объектоор нь ялган нэрлэж бичнэ үү.

Газар, түүний хөрс .....

Газрын хэвлий, түүний баялаг .....

Ус.....

Ургамал .....

Амьтан .....

Агаар .....

Хоёр. Монгол Улсын байгаль орчны чиглэлээр нэгдэн орсон конвенцын талаар мэдлэгээ бусадтай хуваалцаж дараах асуултад хариулаарай.

- 1) Нэгдэн орсон конвенцыг нэрлэх
- 2) Агуулга, зорилгыг нь тайлбарлах

## Мэдлэг сорих тест

1. Төрийн бодлого, стратегид тусгагдах тохирох сонголтыг олох
  - а. Боловсрол, эрүүл мэнд
  - б. Ажил эрхлэлт, эдийн засаг
  - в. Байгаль орчин
  - в. Дээрх бүгд
  
2. Байгалийн баялгийг ашиглах талаар Монгол Улсын үндсэн хуульд тусгайлан хэрхэн зааж өгсөн бэ?
  - а. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах
  - б. Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ
  - в. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлнэ
  - г. Дээрх бүгд
  
3. Мянганы хөгжлийн зорилт хэдэн оноос эхлэн хэрэгжиж дууссан бэ?
  - а. 1999-2015 он
  - б. 2008-2021 он
  - в. 2000-2015 он
  - в. Зөвхөн “а”
  
4. Тогтвортой хөгжлийн хөтөлбөр хэдэн зорилттой бэ?
 

а. 17	б. 19	в. 10	г.12
-------	-------	-------	------
  
5. Бодлого гэдэг бол угтаа ..... юм. Өгүүлбэрийг гүйцээж бич.
  - а. Үйл ажиллагааны төлөвлөгөө
  - б. Алс хэтийн зорилго
  - в. Одоо хэрэгжүүлэх ажил
  - г. Урт хугацаанд хийх ажил
  
6. “Алсын хараа-2050”-д ногоон хөгжлийн талаар хэрхэн тусгасан бэ?
  - а. Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
  - б. Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана.
  - в. Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.
  - г. Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.
  
7. Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн үндсэн дөрвөн бодлогын аль хэсэгт байгаль орчны бодлогыг тусгасан бэ?

- а. Нэгдүгээрт буюу бүсчилсэн хөгжлийн бодлогод Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт гэсэн хэсэгт байгаль орчны салбарын бодлогыг тусгажээ.
- б. Хоёрдугаарт буюу хүний хөгжлийн бодлогод Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт гэсэн хэсэгт байгаль орчны салбарын бодлогыг тусгажээ.
- в. Гуравдугаарт буюу эдийн засгийн бодлогод Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт гэсэн хэсэгт байгаль орчны салбарын бодлогыг тусгажээ.
- г. Дөрөвдүгээрт буюу хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогод Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт гэсэн хэсэгт байгаль орчны салбарын бодлогыг тусгажээ.

8. Хүлэмжийн хий нь.....

- а. Манай гарагийн агаар мандалд нарны дулааныг барьж, дулааныг нь хадгалж байдаг хий юм.
- б. Манай гарагийн агаар мандлаас гадна байдаг хий юм.
- в. Зөвхөн “а”
- г. Зөвхөн “б”

9. Дэлхийн дулаарал гэж .....

- а. Агаар мандалд хүлэмжийн хийн агууламж нэмэгдэх үед үүсдэг дэлхийн гадаргуугийн дундаж температурын өсөлт юм.
- б. Агаар мандалд хүлэмжийн хийн агууламж багасах үед үүсдэг дэлхийн гадаргуугийн дундаж температурын бууралт юм.
- в. Зөвхөн “а”
- г. Зөвхөн “б”

10. Уур амьсгалын өөрчлөлт нь .....

- а. Экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулдаг
- б. Хар салхи, үер, хэт халалт, ган гачиг зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж, эрч хүч нэмэгддэг
- в. Мөсөн голууд, мөсөн бүрхүүл хайлж далайн түвшин дээшилнэ
- г. Дээрх бүгд

11. Эргэлтийн цэг гэдэг нь .....

- а. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй өөрчлөлтүүд эргүүлж хэвд нь оруулах ямар ч боломжгүй болох цэг юм.
- б. Манай дэлхийг өөрчилж, шинэчлэх цэг
- в. Дэлхийн дундаж температур нэмэгдэх цэг
- г. Шинэ дэг журамд шилжих цэг

12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэдэг нь

- а. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих
- б. Хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх
- г. Нүүрстөрөгч шингээгчийг нэмэгдүүлэх
- в. Дээрх бүгд

13. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гэдэг нь .....

- а. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн өнөөгийн тулгамдаж байгаа болон цаашид тулгарч болзошгүй эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа юм.
- б. Цаг агаарын эрс тэс үзэгдлийг тэвчихэд чиглэсэн үйл ажиллагаа юм.

- в. Биологийн олон янз байдлын доройтолд хариу арга хэмжээ авахгүй байх үйл ажиллагаа юм.  
г. Зөвхөн “б”
14. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах чадвар гэж юу вэ?  
а. Тухайн орон нутаг болон байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг урьдчилан таамаглах, сэргийлэх чадварыг хэлнэ.  
б. Тухайн орон нутаг болон байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг зохицуулах чадварыг хэлнэ.  
в. Тухайн орон нутаг болон байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэх хохирлыг багасгах, нөхөн сэргээх, өөрчлөх чадварыг хэлнэ.  
г. Дээрх бүгд
15. Уур амьсгалын шударга ёс гэдэг нь .....  
а. Эрх тэгш байдал, хүний эрх нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх шийдвэр гаргах болон үйл ажиллагааны үндэс суурь байхыг хэлнэ.  
б. Уур амьсгалын өөрчлөлтөд шударга ёс гэх ойлголт байхгүй  
в. Дээрх бүгд биш  
г. Зөвхөн “б”
16. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хэлбэрийг нэрлэнэ үү.  
а. Уур амьсгалын талаарх мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх  
б. Уур амьсгалын талаарх сурталчилгаа  
в. Уур амьсгалын талаарх идэвхтэй үйл ажиллагаа  
г. Уур амьсгалын талаарх сургалт
17. Уур амьсгалын санхүүжилт гэж юу вэ?  
а. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг дэмжихэд ашигладаг санхүүгийн эх үүсвэр  
б. Нүүрстөрөгчийн ялгарал багатай эдийн засагт шилжихэд зориулсан мөнгөн хуримтлал  
в. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, улмаар дасан зохицох чадавхыг бэхжүүлэхэд туслах сан  
г. Дээрх бүгд биш
18. Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэх гэдэг нь .....  
а. Агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийн цаашдын өсөлтийг хязгаарлах  
б. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг тэнцвэржүүлэх  
в. Дээрх хоёр хариулт бүгд зөв  
г. Зөвхөн “а”
19. Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэхийн тулд .....  
а. Эрчим хүч, тээвэр, үйлдвэрлэл, хэрэглээний тогтолцоогоо бүрэн өөрчлөх  
б. Төрийн бодлого боловсруулах  
в. Засгийн газар бүр тус тусдаа бодлого боловсруулах  
г. Дээрх бүгд зөв
20. Тойрог эдийн засаг гэж .....  
а. Хаягдалгүй эдийн засаг  
б. Байгалийн нөөцийн зохистой хэрэглээг дэмжих

- в. Хог хаягдлыг багасгаж, бохирдлыг бууруулах
- г. Дээрх бүгд зөв

21. Ногоон ажлын байр гэдэг нь .....
- а. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулдаг зохистой ажлын байрыг хэлнэ.
  - б. Сэргээгдэх эрчим хүч гэх зэрэг ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, дахин боловсруулалт хийх зэрэг байгаль орчинд ээлтэй үйл явц
  - в. Дээрх бүгд
  - г. Зөвхөн “а”
22. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн гол агуулга нь .....
- а. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зөв зохистой ашиглах
  - б. Байгаль орчныг нөхөн сэргээх, зөв зохистой ашиглах, хамгаалах
  - в. Байгаль орчныг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх
  - г. Байгаль орчныг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх
23. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан заалтад .....
- а. Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан.
  - б. Байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж заасан.
  - в. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авна
  - г. Бүгд биш
24. Нийтээрээ дагаж мөрдөх хэм хэмжээний акт болох тогтоолыг ямар субъект гаргах бэ?
- а. Улсын Их Хурал
  - б. Ерөнхийлөгч
  - в. Бүх шатны засаг дарга
  - г. Төрийн захиргааны төв байгууллага
25. Нийтээрээ дагаж мөрдөх хэм хэмжээний акт болох захирамжийг ямар субъект гаргах бэ?
- а. Улсын Их Хурал
  - б. Ерөнхийлөгч
  - в. Бүх шатны засаг дарга
  - г. Төрийн захиргааны төв байгууллага
26. Нийтээрээ дагаж мөрдөх хэм хэмжээний акт болох журмын тодорхойлолт аль нь вэ?
- а. Журам - эрх зүйн хэм хэмжээний актын нэгэн төрөл, ямар нэгэн төрлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын журмыг тодорхойлсон процедурын хэм хэмжээний цогц
  - б. Журам - эрх зүйн хэм хэмжээний актын нэгэн төрөл, ямар нэгэн төрлийн үйл ажиллагааны эхлэлийг тодорхойлсон процедурын хэм хэмжээний цогц
  - в. Журам - эрх зүйн хэм хэмжээний актын нэгэн төрөл, ямар нэгэн төрлийн үйл ажиллагааны зааварчилгааг процедурын хэм хэмжээний цогц
  - г. Дээрх бүгд биш
27. Олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг нэрлэнэ үү.
- а. Цэвэр усны хомсдол
  - б. Дэлхийн дулаарал

- в. Хөрсний доройтол, цөлжилт
- г. Дээрх бүгд

28. Биологийн олон янз байдал гэж юу вэ?

- а. Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьдралын олон янз байдал, тэдгээрийг бүрэлдүүлэх олон янз, хэв маягт оноосон нэр томьёо юм.
- б. Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьд амьтны олон янз байдал, тэдгээрийг бүрэлдүүлэх олон янз, хэв маягт оноосон нэр томьёо юм.
- в. Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх ургамлын олон янз байдал, тэдгээрийг бүрэлдүүлэх олон янз, хэв маягт оноосон нэр томьёо юм.
- г. Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх агаар хөрсний олон янз байдал, тэдгээрийг бүрэлдүүлэх олон янз, хэв маягт оноосон нэр томьёо юм.

29. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцод манай улс хэдэн онд нэгдэн орсон бэ?

- а. 1996.04.04
- б. 1990.02.02
- в. 1995.04.04
- г. 1985.04.04

30. Дээд хэсэгтээ агаар мандлын озоны зонхилох хэсгийг агуулсан давхрааг хэрхэн нэрлэдэг вэ?

- а. Мезосфер
- б. Трофосфер
- в. Стратосфер

31. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд ус гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлсон вэ?

- а. Ус гэдэгт Монгол улсын нутаг дэвсгэр дэх гадаргын ба газрын доорх бүх төрлийн ус, хур тунадас хамаарна.
- б. Ус гэдэгт Монгол улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорх ус хамаарна.
- в. Ус гэдэгт Монгол улсын нутаг дэвсгэрийн газрын гадарга дахь бүх төрлийн ус хамаарна.

32. Усны тухай хуульд заасны дагуу усны нөөц гэж юуг хэлэх вэ?

- а. Усны нөөц нь Монгол улсын хилийн дотор орших газрын дээрх болон доорх ус, рашаан, хур тунадаснаас бүрдэнэ.
- б. Усны нөөц нь Монгол улсын хилийн дотор орших газрын гадаргын болон газрын доорх ус, рашаан, мөнх цас, мөсөн гол, хур тунадаснаас бүрдэнэ.
- в. Усны нөөц гэдэгт Монгол улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа газрын гадаргын болон газрын доорх усыг хамааруулна.

33. Усны тухай хуульд зааснаар “ашиглах боломжит усны нөөц” хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлох вэ?

- а. Усны сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр тодорхой хугацаанд ашиглаж болох усны нөөцийн хэмжээ
- б. Үйлдвэр, аж ахуй, хүн амын хэрэгцээнд зориулан тухайн жилд байгалиас авч ашиглах усны дээд хэмжээгээр тодорхойлно.
- в. Байгаль дахь усны тэнцлийг алдагдуулахгүйгээр үйлдвэр, аж ахуй, хүн амын хэрэгцээнд зориулан тухайн нэг жилд байгалиас авч ашиглах усны дээд хэмжээгээр тодорхойлно.

34. Монгол Улсын ургамлын сан юунаас бүрдэх вэ?
- а. Монгол улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ.
  - б. Монгол улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн дээд ба доод ургамлаас тус улсын ургамлын сан бүрдэнэ.
  - в. Монгол улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетэн, тэдгээрийн биомассын цогц нийлбэрээс ургамлын сан бүрдэнэ.
35. Нэн ховор ургамал гэж .....
- а. Байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац нөөц багатай, устаж болзошгүй ургамлууд орно.
  - б. Байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, дэлхийд нэн ховордож устах аюулд орсон ургамлууд орно.
  - в. Байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал хамаарна.
36. Ховор ургамал гэж .....
- а. Байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна.
  - б. Байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, дэлхийд нэн ховордож устах аюулд орсон ургамлууд орно.
  - в. Байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамлууд орно.
37. Ойн тухай хуульд ой гэдгийг хэрхэн тодорхойлсон бэ?
- а. Монгол улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн бүх төрлийн мод, заг, сөөгнөөс бүрдэх экосистемийн иж бүрдлийг ой гэнэ.
  - б. Монгол улсын нутаг дэвсгэрт ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал моддоос бүрдэх экосистемийн иж бүрдлийг ой гэнэ.
  - в. Мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг, хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газар зүйн онцлог нөхцөл бүхий орчинг ой гэнэ.
38. Монгол улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетнийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд ямар ойлголтоор илэрхийлдэг вэ?
- а. Амьтны аймаг
  - б. Монгол улсын амьтны нөөц
  - в. Монгол улсын амьтны сан
  - в. Амьтан
39. Газар нутгийг тусгай хамгаалалтад авахад дараах хүчин зүйлсийн аль нь гол үндэслэл болох вэ?
- а. Хүн амын суурьшил, нягтшил өндөр байх
  - б. Хэд хэдэн зүйлийн нэн ховор, ховор амьтад идээшин амьдардаг
  - в. Авто болон төмөр зам зэрэг дэд бүтцийн хөгжил сайтай
  - г. Газар тариалан эрчимтэй хөгжсөн бүс нутаг

40. Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгуулсан улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь аль ангилалд хамаарах вэ?
- а. Дурсгалт газар
  - б. Дархан цаазат газар
  - в. Байгалийн нөөц газар
  - г. Байгалийн цогцолборт газар

### Ашигласан болон гүнзгийрүүлэн сонирхож унших материал

- Амархүү, О. (2009). *Монголын орчин цагийн экологийн эрх зүй*. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар
- Амьд ертөнцийн тайлан 2024. Системийн гажуудал. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (United Nations Development Programme) <https://www.undp.org/mn/mongolia/about-us>
- Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоол “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”
- Уур амьсгалын өөрчлөлтийн толь бичиг: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх өдөр тутмын гарын авлага <https://www.undp.org/mn/mongolia/>

**ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

**ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАХ, АСРАН  
ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**



## 2.1 ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Тодорхой зүйлийн амьтан устаж үгүй болох, тархац нутаг нь хумигдан, тоо толгой нь хорогдох зэргээр амьтны аймаг доройтоход хүргэж буй байгалийн болон хүний хүчин зүйлээс улбаатай маш олон нөхцөл, шалтгаан байх ба энэ хирээр зэрлэг амьтдыг хамгаалах арга, аргачлал ч мөн төдий хэмжээгээр баяжин боловсронгуй болж байна. Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйлчилгээ бол тэдгээр арга, аргачлалын нэг чухал хэлбэр нь болно.

Байгалийн нөөц баялаг шавхагддаг болохыг хүн төрөлхтөн гүн гүнзгий ойлгон, ухаарч эхэлсэн байгаль хамгаалах хөдөлгөөн ХХ зууны эхэн үеэс эхэлсэн бол зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагаа 1970-аад оноос дэлхийн улс орнуудад эрчимтэй хөгжих эхлэл тавигджээ. 1990-ээд оны дунд үед зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах эрх зүйн болон стандартын иж бүрэн тогтолцоо дэлхийн олон улс оронд бүрэлдэн тогтож, тусгай мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан, санхүүгийн өндөр хүчин чадалтай мэргэшсэн байгууллагууд бий болов.

Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжиж, байгалийн нөөц баялгийг ашиглах эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж, нийгмийн амьдрал, байгаль орчны унаган төлөв байдал өөрчлөгдөхийн хирээр байгалийн зэрлэг хөхтөн амьтдын хэвийн амьдралд байгалийн болон хүний зүгээс үзүүлэх сөрөг нөлөө улам ихсэж байгаа боловч гэмтсэн, шархадсан, өнчирсэн амьтдын тоо толгойн талаар тоймтой мэдээ баримт байхгүй төдийгүй тэдгээрийг аврах, асран хамгаалах, нөхөн сэргээх үүрэг бүхий албан ёсны байгууллага, хүмүүс ч одоогоор албан ёсоор бүрдээгүй байна. Тиймээс ган, зуд, түймэр, үер, газар хөдлөлт, салхи шуурга зэрэг байгалийн олон үзэгдлүүдийн нөлөөгөөр эрсдэлд орж буй амьтдыг аварч, асран хамгаалан эрүүлжүүлээд байгалийн амьдрах орчинд нь буцаан тавих ажлыг эхлүүлэх шаардлага тулгарч байна. Нөгөө талаас манай улсад эдгээр эрсдэлд орсон зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах стандартын шаардлага хангасан төрийн ба төрийн бус байгууллага, асран хамгаалах төв зэрэг амьтны эрүүл мэнд, эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа эрхлэх бодит ажил олон улсын жишгээс хоцорч байна.

Иймээс өвдсөн, гэмтсэн, өнчирсэн зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах тухай Монгол Улсын стандартыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас санаачлан боловсруулж, эдгээр үйл ажиллагааг олон улсын жишиг, Монгол Улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлэхэд туслах зорилгоор “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах аргачлал (2021)” хэмээх гарын авлагыг нийтлүүлжээ. Иймд байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх дунд шатны сургалтад дээр дурдсан гарын авлага, стандартын үндсэн агуулгыг тусган оруулав.

Зэрлэг амьтдыг аварч, асран хамгаална гэдэг нь янз бүрийн шалтгааны улмаас хүний тусламж шаардлагатай болсон тодорхой зүйлийн бодгаль биесийг байгалиас олж илрүүлэн, эмчлэн илаарьшуулж, асран тордож тэнхрүүлээд байгальд нь буцаан нутагшуулах цогц үйл ажиллагаа юм. Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үндсэн зорилго нь тухайн бүс нутгийн зэрлэг амьтдыг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах, амьтдын байгалийн жам ёсны эрхийг хүндэтгэн сахих, асран хамгаалахад ард, иргэд, төрийн ба иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог бүтээлчээр хангах явдал болно.

Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа бол нэг ёсондоо хүний зүгээс тухайн амьтанд үзүүлж буй олон төрлийн үйлчилгээний цогц нийлэмж юм. Энэ цогц ажиллагаанд бодгаль биесийг цаг алдалгүй олж, осол аюулгүй барих, тээвэрлэхээс эхлээд үзлэг, оношилгоо хийх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эмчлэх, асран сувилж тордох, адуулан маллаж тэжээх, зохиомол амьдрах орчныг бүрдүүлэн хяналт тавих, сайжруулах, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэм сахих, эдгэрч, тэнхэрсний дараа байгальд нь буцаан тавьж нутагшуулах зэрэг олон төрлийн үйлчилгээ багтана. Амьтдын ангилал зүйн бүлгээс хамаарч эдгээр үйл ажиллагаа өөр өөрийн онцлогтой байдгийг дараа дараагийн бүлэгт авч үзэх болно.

Дараах нөхцөлүүдээс нэг нь, эсвэл хэд хэд нь илэрч байгаа амьтныг хүний тусламжтайгаар аварч, асран хамгаалах шаардлагатай гэж үзнэ. Үүнд:

- Төрөл бүрийн байдлаар гэмтэж бэртсэн, шархадсан, түлэгдсэн амьтан. Амьтад байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн нөлөөгөөр гэмтэж, бэртэх нь байгальд үлэмж элбэг.
- Хүнд өвчтэй амьтан. Байгальд буй өвчилж, шаналсан зэрлэг амьтныг зөвхөн хүний тусламж дэмжлэгээр эмчилж, эдгэрүүлэх боломжтой. Эс тэгвээс өвчилсөн амьтныг ихэвчлэн үхэл мөхлийн хувь заяа л хүлээж байдаг. Өвчилсөн амьтдыг байгалиас олж эмчлэх нь зөвхөн тухайн бодгаль төдийгүй тухайн байгалийн популяцийг өвчин эмгэгээс сэргийлэхэд нэн өндөр ач холбогдолтой. Өвчилсөн амьтдын хувьд ямар нэг халдварт өвчин туссан эсэхэд онцгой анхаарах ёстой.
- Хаягдсан, төөрсөн, бие даах чадваргүй нялх төл амьтан. Тэгэхдээ тухайн нялх амьтан үнэхээр эх, эцгээс хаягдан төөрч, бие даах чадваргүй болсон эсэхийг сайтар нягтална. Осол, аюул тохиолдсон үед олон зүйлийн амьтан үр төлөө хаа нэгтээ нуун далдалж, өөрсдөө тухайн газраас алсан холдох аргаар үр төлөө авран хамгаалах төрөлх зан араншин хөгжсөн байдгийг анхаарах шаардлагатай. Амьтны үр төлийг аврах гээд санамсаргүйгээр эх, үрийг хагацуулах үйлдэл хийж огт болохгүй.
- Ган, зуд, үер, аянга цахилгаан, түймэр болон байгалийн бусад гэнэтийн бэрхшээлд өртсөн амьтан. Байгалийн эдгээр хүчин зүйлд өртсөн амьтад ихэнх тохиолдолд бэртэж, гэмтсэн байдаг.
- Идэш тэжээл, унд усны хомсдолын улмаас турж эцэн, хүч тамир нь барагдсан амьтан.

Зэрлэг амьтныг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны явцад амьтдыг зохиомол орчин, хүнд дасаж, эргээд байгальдаа бие даан амьдрах чадвар, боломжоо алдахаас ямагт сэргийлэх шаардлагатай байдаг. Үүний тулд амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг бол аль болох богино хугацаанд хийж гүйцэтгэх ёстой.

## 2.2 ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЗАРИМ ОРНЫ ЖИШИГ ТУРШЛАГА

Хүмүүс бид байгалийн түүхэн хөгжлийн бүтээгдэхүүн болохын хувьд байгалийн тогтолцоонд бусад бүх амьд биетийн нэгэн адил байр эзэлнэ. Байгаль дэлхий зөвхөн хүн төрөлхтний тусын тулд бүтээгдээгүй, нөгөө талаас ухаант хүн төрөлхтөн байгалийн бусад баялгийг зөвхөн өөрийн явцуу эрх ашгийн төлөө эрхшээх учиргүй. Иймээс байгалийн түүхэн хөгжлийн явцад бий болсон бүх амьд биет нэгэн адил амьдрах эрхтэй. Үүний илрэл бол олон улсын амьтны эрхийн холбооноос баталсан амьтны эрхийн түгээмэл тунхаглал юм. Дэлхийн олон орон амьтны эрхийг хамгаалах төрөлжсөн хуультай байдаг.

### 2.2.1. Амьтны эрхийн түгээмэл тунхаглал

Энэхүү тунхаглалыг 1977 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Лондон хотноо Олон улсын амьтны эрхийн холбооноос баталж, 1978 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ЮНЕСКО-оос Дэлхий дахинд тунхаглан зарлажээ. Уг тунхаглалыг Олон улсын амьтны эрхийн лигээс 1989 онд шинэчлэн найруулж, 1990 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд өргөн барьснаар мөн ондоо олон нийтийн хүртээл болжээ.

Амьтны эрхийн түгээмэл тунхаглал бол хүн төрөлхтний зүгээс манай дэлхийн амьтны аймагт хандах хандлага, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг өндөр дээд түвшинд тодорхойлон тунхагласан, дэлхий дахинаар даган мөрдөх Олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг юм.

Амьтны эрхийн түгээмэл тунхаглалын оршилд:

- Манай дэлхийн амьдрал, бүх амьд бие махбод бол нэг гарал үүсэлтэй нэгдмэл тогтолцоо бөгөөд түүхэн хөгжлийн явцад тэдгээрийн олон янз байдал бүрэлдэн бий болсныг,
- Бүх амьд бие махбод байгалиас заяасан жам ёсны эрхтэй, мөн мэдрэлийн системтэй аливаа амьтан бусдаасаа онцлох эрхтэйг,
- Эдгээр байгалийн жам ёсны эрхийг үл хүндэтгэх, бүр энгийнээр үл тоомсорлох нь байгальд асар их хор хохирол учруулж, амьтдын эсрэг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж байгааг харгалзан үзэхийг,
- Хүн төрөлхтөн зэрэгцэн оршин тогтнодгийнхоо хувьд бусад амьтдын амьдрах эрхийг хүлээн зөвшөөрөхөд анхаарлаа хандуулахыг,
- Хүмүүс амьтдыг хүндлэх нь хүн хүнээ хүндлэхтэй утга нэг болохыг тус тус хүн төрөлхтөнд хандан сонордуулсан билээ.

Олон улсын эрх зүйн энэ баримт бичигт нийт хүн төрөлхтөн, улс үндэстэнд хандан амьтны эрхийн талаар дор дурдсан 10 зүйлийг тунхаглан зарласан байна. Үүнд:

**Нэгдүгээр зүйлд** Бүх амьтад биологийн тогтвортой нөхцөлд оршин тогтнох тэгш эрхтэй. Эдгээр эрхийн тэгш байдал нь төрөл зүйл ба бодгаль биеийн хоорондын ялгааг харгалзахгүйгээр хэвээр хадгалагдана.

**Хоёрдугаар зүйлд** Бүх амьтдын амьдрал нь хүндэтгэл хүлээх эрхтэй.

**Гуравдугаар зүйлд** (1) Амьтадтай зүй бус харьцаж, түрэмгий үйлдэл гаргаж болохгүй, (2) Зайлшгүй шаардлагаар амьтны амь хороох үйл ажиллагааг агшин зуур, өвдөлтгүйгээр

гүйцэтгэх бөгөөд урьдчилан сэтгэл зүйн болон бие махбодын ямар нэгэн зовлон шаналал учруулахгүй байх ёстой, (3) Үхсэн амьтдад ёс зүйтэй хандах ёстой.

**Дөрөвдүгээр зүйлд** (1) Зэрлэг амьтад байгалийн хүрээлэн буй орчин, нөхцөлд эрх чөлөөтэй амьдарч, өсөн үржих эрхтэй, (2) Зэрлэг ан амьтдыг удаан хугацаагаар хорих, зугаа цэнгэлийн зорилгоор агнах, загасчлах, түүнчлэн зайлшгүй амин чухал бус шалтгаанаар зэрлэг амьтдыг ашиглах нь энэхүү үндсэн эрхэд харш болно.

**Тавдугаар зүйлд** (1) Хүмүүсээс хамааралтай орчинд амьдарч буй аливаа амьтан зохих ёсоор анхаарал халамж хүртэх эрхтэй, (2) Ямар ч тохиолдолд амьтныг хаях юм уу үндэслэлгүйгээр алж болохгүй, (3) Амьтдыг үржүүлэх, ашиглах бүхий л тохиолдолд тухайн зүйлийн физиологи, байгалийн зан төрхийг хүндэтгэх ёстой, (4) Амьтдыг оролцуулсан үзэсгэлэн, сурталчилгаа, кино нь тэдний эрхийг хүндэтгэсэн байх ёстой бөгөөд хүчирхийлэл огт агуулагдах ёсгүй.

**Зургаадугаар зүйлд** (1) Амьтанд, бие махбодын болон сэтгэхүйн дарамт учруулах аливаа туршилт хийх нь амьтны эрхийг зөрчсөн үйлдэл мөн, (2) Амьтдын тоо толгойг өсгөн олшруулах нь системтэй хөгжүүлсэн үр дүнтэй аргад үндэслэх ёстой.

**Долоодугаар зүйлд** Амьтныг үндэслэлгүй үхэлд хүргэх аливаа үйлдэл, ийм үйлдэл хийхэд хүргэх шийдвэр нь амьдралын эсрэг гэмт хэрэг мөн.

**Наймдугаар зүйлд** (1) Зэрлэг амьтдын оршин амьдрахад аюул заналхийлж буй аливаа үйлдэл, ийм үйлдэл хийхэд хүргэх аливаа шийдвэр нь хомроглон устгах (геноцид) буюу төрөл зүйлийн эсрэг гэмт хэрэг үйлдэхтэй адил хэмээн үзнэ, (2) Зэрлэг амьтдыг алах, биосферийг бохирдуулж, сүйтгэх нь хомроглон устгаж буй (геноцид) үйлдэл мөн.

**Есдүгээр зүйлд** (1) Амьтны эрх зүйн байдал, түүний эрхийг хуулиар хүлээн зөвшөөрөх ёстой, (2) Амьтдын хамгаалал, аюулгүй байдлын асуудлыг Засгийн газрын (төрийн байгууллагын) түвшинд авч үзэх ёстой.

**Аравдугаар зүйлд** Боловсролын байгууллагууд, ан амьтдыг ажиглах, ойлгох, хүндлэх боловсролыг иргэдэд бага наснаас нь гүн гүнзгий эзэмшүүлэх ёстой.

## 2.2.2. Амьтан авран хамгаалах олон улсын байгууллага

Амьтан аврах, асран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллага олон бий. Энд төлөөлөл болгон зарим байгууллагын зорилго, үйл ажиллагаатай товч танилцъя.



Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах Олон улсын зөвлөл (International Wildlife Rehabilitation Council). Олон улсын энэхүү сайн дурын байгууллага 1972 онд АНУ-ын Калифорни мужид байгуулагджээ. Зэрлэг унаган амьтдыг аврах, асран хамгаалах,

сэргээн нутагшуулахад мэргэшсэн мэргэжлийн хүмүүс нэгдэн энэхүү ашгийн бус иргэний нийгмийн байгууллагыг үндэслэсэн байдаг. АНУ-ын хүн амын дунд 1970-аад оны эхээр зэрлэг амьтадтай нүүр тулгарах тохиолдол ихсэж, байгалийн ан амьтдад хүний зүгээс үзүүлэх нөлөөллийн цар хүрээ өргөжин тэлснээр аюулын харанга дэлдэж эхэлсэн нь энэ байгууллагыг байгуулж олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах үндсэн сэдэл нь болжээ.

Тухайн цаг үед амьтан аврах, асран хамгаалах, нутагшуулах хөтөлбөрүүдийг албан ёсоор хэрэгжүүлэх шаардлагатай болсон хэдий ч зэрлэг амьтдыг асран хамгаалах шаардлага хангахуйц төвүүд хомс, мэргэжлийн боловсон хүчин цөөн зэрэг шалтгааны улмаас зохих стандартын дагуу амьтдыг асран эмчлэх асуудал байнга бэрхшээлтэй тулгарч байв. Иймд амьтан аврах, асран хамгаалах, улмаар унаган байгальд нь сэргээн нутагшуулах хөтөлбөрүүдийг эрсдэл багатай, мэргэжлийн түвшинд гүйцэтгэхийн тулд уг ажлыг гардан гүйцэтгэдэг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний сүлжээг бий болгох зорилгоор энэхүү төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулжээ.



Тус зөвлөлийг үүсгэн байгуулагчид зэрлэг ан амьтдыг аврах, асран хамгаалах, байгальд сэргээн нутагшуулах ажлыг шинжлэх ухаан ч мэдлэг, арга технологид суурилсан найдвартай, үр бүтээлтэй хэрэгжүүлэх арга замыг байнга эрэлхийлж иржээ. Байгалийн элдэв хүчин зүйлс, хүний зохисгүй үйлдэл, техникийн нөлөө зэрэг олон янзын шалтгааны улмаас өвдөж шаналсан, гэмтэж бэртсэн зэрлэг амьтдад үзүүлэх анхан шатны тусламж, эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулж, шинэ шатанд гаргах, судалгаа шинжилгээний хамгийн сүүлийн үеийн ололт амжилт, оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох нь энэхүү олон улсын байгууллагын үндсэн зорилго болно.

Тус олон улсын байгууллага зэрлэг амьтдыг авран хамгаалах, арчлан сувилах, унаган байгальд нь сэргээн нутагшуулах чиглэлээр янз бүрийн улс үндэстний 16,000 орчим хүнийг сургаж, мэргэжлийн гэрчилгээ олгожээ. Ийнхүү зэрлэг амьтан аврах, асран хамгаалах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтний хүний нөөцийн асуудлыг АНУ төдийгүй дэлхийн хэмжээнд шийдэхэд энэ байгууллага үлэмж хувь нэмэр оруулж байна.

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд дагаж мөрдөх стандартыг цогцоор боловсруулсан нь байгаль хамгаалах энэхүү олон улсын байгууллагаас санаачлан хэрэгжүүлсэн нэг чухал ажил болно. Жишээлбэл, “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах хамгийн минимум стандарт (Minimum Standards for Wildlife. Fourth edition, 2012)”-ыг дурдах нь зүйтэй. Дашрамд дурдахад, энэхүү гарын авлагад уг баримт бичгийн үзэл санааг зохих түвшинд тусгасан болно.

Одоо тус зөвлөлийн төв нь АНУ-ын Номхон далайн баруун хойд бүсийн Орегон мужийн Южин (Eugene) хотод байрладаг. Тус байгууллагын алсын хараа нь дэлхий дээрх зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах ажлын амжилт нь зэрлэг амьтдыг сэргээн нутагшуулагч мэргэжилтэн болон амьтан хамгаалах чиглэлд ажилладаг бусад мэргэжлийн хүмүүсийн харилцан бие биеэ ойлголцон хамтран ажиллахаас хамаарна гэх үзэлд суурилдаг байна.



Зэрлэг амьтдыг авран хамгаалах Азийн сүлжээ сан (Wild Animal Rescue Network Foundation Asia). Энэ бол Голландын улс төрөөс ангид байх хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг олон улсын байгууллага юм. Энэхүү сангийн төв нь Амстердамд, Азийн бүсийн салбар нь Тайландад тус тус байрладаг.


Зэрлэг амьтдыг авран хамгаалах Азийн сүлжээ олон улсын байгууллагын зорилго нь Зүүн ба Зүүн Өмнөд Азийн зэрлэг ан амьтдыг аврах төвүүдийн амьтан аврах, хамгаалах чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд байгаль хамгаалах мэдлэг олгох, зэрлэг амьтдыг аврах төвийн стандартыг сурталчлах явдал юм.

Анх 2013 онд Тайван, Вьетнам, Тайланд улсуудад болсон уулзалтуудын үр дүнд үүсгэн байгуулагдсан. Хятад, Тайван, Өмнөд Солонгос, Тайланд, Хонг Конг, Филиппин, Малайз, Индонез, Вьетнам, Лаос, Камбожи зэрэг улсууд энэ олон улсын байгууллагын гишүүн юм.

Зэрлэг амьтдыг аврах Азийн сүлжээ олон улсын байгууллага нь Зүүн ба Зүүн өмнөд Азийн улс орнуудын Засгийн газрын зэрлэг амьтны асуудал эрхэлсэн агентлаг, хууль сахиулах байгууллага, зэрлэг амьтан аврах төв, амьтан хамгаалах албад, мал эмнэлэг, зэрлэг амьтны явуулын эмнэлэг, амьтан аврах, асран хамгаалах хөтөлбөр зэрэг төрийн ба иргэний нийгмийн олон байгууллагатай нягт хамтран ажилладаг байна.



**Зураг 2.1.** Зэрлэг амьтан тээвэрлэх үйл ажиллагаа



**Зураг 2.2.** Зэрлэг амьтны үзлэгийн өрөө

Зэрлэг амьтдыг аврах Азийн сүлжээ олон улсын байгууллагын үндсэн зорилго бол:

1. Ан амьтдыг аврах, асран хамгаалах, байгальд буцаан тавих
2. Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах олон нийтийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урамшуулах, туслалцаа үзүүлэх
3. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах, байгальд буцаан тавихад нь мэргэжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх
4. Тухайн зүйл амьтны талаарх олон нийтийн мэдлэгт хувь нэмэр оруулах, холбогдох судалгаа явуулах
5. Амьтан аврах, асран хамгаалах төвүүдэд эмчилж, эдгээн аврагдсан амьтдыг арчлах, тэдний амьдралын чанарыг сайжруулах
6. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах төв хоорондын нөхөрлөл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, сурталчлах
7. Гишүүд, мэргэжилтнүүд, сонирхогчид хоорондоо мэдээлэл, туршлага солилцох боломжийг өргөсгөх, нийтлэг ашиг сонирхлын үйл ажиллагааг зохицуулах боломжтой форум зохион байгуулах
8. Зэрлэг амьтдыг хамгаалах, судлах хөтөлбөрүүдийг дэмжиж, гишүүн байгууллагууддаа хамтран ажиллах боломж олгох
9. Зэрлэг амьтдыг хамгаалах үндэсний болон олон улсын үр дүнтэй хууль, бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх, дэмжихэд тус тус чиглэжээ.

### 2.2.3. Европын зарим улс оронд мөрдөж буй зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны онцлог

**Франц.** Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагаа эрхлэхийн тулд тус ажлыг хариуцаж буй хүнээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл буюу сертификат шаардана. Хүний тусламж, дэмжлэг шаардлагатай болсон зэрлэг амьтдыг стандартын шаардлага хангасан нөхцөлд адуулан маллаж, зохих ёсоор нь арчлан тордож байгааг нотлохын тулд бүх байгууламж, мөн тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Францын зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах төвүүд бие даасан холбооны зохион байгуулалтад нэгдэн, нэгдсэн бодлого, чиглэл, аргачлалаар үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг байна.

**Финлянд.** Өвдөж шаналсан, бэртэж гэмтсэн, өлсөж харангадсан, орхигдож ганцаардсан зэрэг төрөл бүрийн шалтгааны улмаас зовж зүдэрсэн амьтдад туслах үүргийг иргэн бүр хуулиар хүлээдэг. Ийм ч учраас зэрлэг амьтдыг аврах, түр асран хамгаалахыг иргэн бүрд зөвшөөрдөг байна. Харин амьтны хүрээлэн, үзвэр, үзэсгэлэнгийн газарт амьтдыг байлгах бол тусгай зөвшөөрөл авах шаардлагатай ажээ.

**Голланд.** Олон улсын болон өөрийн улсад эрх зүйн хамгаалалтад орсон бүх амьтдыг аврах, асран хамгаалах, тээвэрлэх, байгальд буцаан тавих, унтуулах, устгах үйл ажиллагаанд зориулан улсаас нөхөн төлбөр олгодог журамтай. Гэхдээ энэхүү нөхөн төлбөрийг олж авахын тулд зэрлэг ан амьтдыг эмчлэгч эмч, байр оромж, ажилчдын мэдлэг, асаргаа, сувилгааны талаарх хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл, шаардлагыг хангасан байх ёстой.

**Эстони.** Зэрлэг ан амьтдыг сэргээн нутагшуулах нь хууль бус үйлдэл хэмээн үзнэ. Цаашид амьтан авран хамгаалахыг хуулиар зөвшөөрч, албажуулах ажил хийгдэж байгаа ажээ.

**Ирланд.** Зэрлэг ан амьтдыг аврах, асран хамгаалахад тусгайлан зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд гагцхүү эмчлэн, асарч буй амьтан бүрийг харьяалах Байгаль орчны албануудад бүртгүүлэх шаардлагатай.

**Герман.** Зэрлэг ан амьтдыг хамгаалах тухай нарийн чанд хууль үйлчилнэ. Иргэдэд зэрлэг амьтанд тусалж, авран хамгаалахыг зөвшөөрдөг боловч тэдгээр амьтдыг зохих зөвшөөрөлтэй, энэ талаар мэргэшсэн мэргэжлийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээдэд хүлээлгэн өгөх ёстой. Ийм тусгай зөвшөөрлийг анчид, амьтдыг асран хамгаалах төв, малын эмч нар, амьтан аврах сайн дурын байгууллагуудад зохих шалгуур хангасан байдлыг үндэслэн олгоно.

Германд ан агнуурын тухай хуулиар “агнах боломжтой” жагсаалтад орсон зэрлэг амьтанд тусламж шаардагдах эсэхийг шийдэх онцгой эрхийг анчдад олгодог. Харин малын эмч нар тийм шийдвэр гаргахыг зөвшөөрдөггүй. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах стандарт, заавар зөвлөмжийг амьтдын бүлэг тус бүрээр нарийвчлан боловсруулж, чанд мөрддөг байна. Амьтан аврах, асран хамгаалах төвүүд амьтны ангилал зүйн бүлгээр төрөлжсөн байна. Тухайлбал, сарьсан багваахай аврах, асран хамгаалах төв, шөнийн махчин шувуудыг аврах, асран хамгаалах төв гэх мэт. Энэ төвийг хариуцан ажиллагч субъект нь зохих шаардлагыг хангасан мэргэжлийн чадавхтай, амьтан хамгаалах төрийн бус байгууллага, иргэд байна. Эрх авсан иргэн, амьтан хамгаалах сайн дурын холбоо, нийгэмлэгүүд орон нутгийн байгаль хамгаалах байгууллагатай нягт хамтран ажиллана. Ялангуяа зэрлэг амьтан аврах, асран хамгаалах төвүүд амьтны эрх хамгаалах хуулийн заалтыг хэрхэн ханган биелүүлж байгаад онцгой анхаарал хандуулна.

**Англи.** Зэрлэг ан амьтдыг аврах, асран хамгаалахад тусгай зөвшөөрөл шаардлагагүй. Гэвч амьтан асран хамгаалах тухай хуулийн дагуу асрамжид хамрагдсан аливаа зэрлэг амьтан нь тусгайлан хамгаалагдсан амьтан болно. Зэрлэг амьтдыг асран хамгаалах нийгэмлэгээс зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавьж, зохих журмын дагуу үүргээ сахин биелүүлж, хариуцлагатай ажиллахыг шаардана.

**Бельги.** Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалахын тулд Байгаль, ойн агентлагаас зохих зөвшөөрөл авах шаардлагатай. Энэхүү зөвшөөрөл нь далайн хөхтөн амьтдаас бусад бүх амьтанд хамаарна.

## 2.3 МОНГОЛ УЛСАД АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор, элбэг ямар ч амьтныг барих, тээвэрлэх, хамгаалах байранд байршуулах, эмчлэх, асран хамгаалах, байгальд буцаан суллан тавих, уг үйл ажиллагааг санхүүжүүлэх, удирдан зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг цогцоор нь агуулсан ойлголт хэмээн үзэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа нь тухайн гэмтсэн бэртсэн, цаашид бие даан амьдрах чадваргүйн улмаас хүний тусламж зайлшгүй шаардлагатай болсон амьтныг олж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад мэдээлэхээс эхлээд тухайн амьтныг барих, тээвэрлэх, аврах, асран хамгаалах байранд байршуулж, эмчлэн илаарьшуулах, сувилан тэнхрүүлэх зэрэг үйл ажиллагааг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм.

Энэхүү цогц үйл ажиллагаа, үүнтэй холбоотой харилцааг зохицуулсан, оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх хууль, эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулиас эхтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 2-т “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” хэмээн заасан байдаг. Ийнхүү Монголын төр амьтан аврах, асран хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг болохыг Үндсэн хуульдаа тодорхой зааж өгсөн байна.

Нэн ховор, ховор, элбэг амьтан, тэдгээрийг хамгаалахад анхаарах гол шаардлага, нөхцөлийг тодорхойлж, амьтан аврах, асран хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан гол хууль нь Амьтны тухай хууль болно. Монгол Улсын Үндсэн хуулиар амьтан хамгаалах нь иргэн бүрийн үүрэг байхаар тодорхойлж, үндэс суурийг тогтоож өгсөн бол Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд оролцох эрх, үүргийг тодорхойлж, тэдгээртэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулсан байдаг.

Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа бол Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д зааснаар амьтан хамгаалах нэг хэлбэр юм. Амьтны тухай хуульд заасан амьтан авран хамгаалах үйл ажиллагааг явуулахад шаардлагатай зөвшөөрөл, зөвшөөрлийн төлбөр, хураамжийн хувь хэмжээ, тэдгээрийг хөнгөлөх, чөлөөлөх, зөвшөөрлийн төлбөрөөс эргээд амьтан хамгаалах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоохтой холбоотой харилцааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулдаг. Энэхүү хууль нь амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх гол эх үүсвэр, хөрөнгийн хувь хэмжээг тодорхойлсноороо чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулиар амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн Засаг дарга, захиргааны байгууллагын чиг үүрэг, оролцоог тодорхойлж, үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулж өгсөн байдаг бол амьтан аврах, асран хамгаалах үүргийг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй тохиолдолд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр заасан байна.

Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг дараах хуулиудаар зохицуулна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
- Амьтны тухай хууль (2012)
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль (2017)
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
- Эрүүгийн хууль (2015)
- Зөрчлийн тухай хууль (2017)
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006) зэрэг болно.

Иймд, амьтан аврах, асран хамгаалахад чиглэсэн аливаа үйл ажиллагааг Монгол Улсын дээр дурдсан холбогдох хууль тогтоомжуудыг мөрдлөг болгож, нийцүүлэн явуулах шаардлагатай.

*Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, оролцоо.*

Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг дараах үйлдэл, үйл ажиллагааны цогц хэмээн ойлгох нь зүйтэй. Үүнд:

- Тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор, элбэг амьтны талаар мэдээлэх, олж тогтоох
- Шаардлагатай зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах
- Барих, тээвэрлэх
- Асран хамгаалах төвд байршуулах, эмчлэх, асрах
- Тэдгээр амьтдыг байгальд суллан тавих
- Санхүүжүүлэх
- Удирдлага зохион байгуулалт, хяналт зэрэг болно.

Дээрх хууль тогтоомжид нэн ховор, ховор, элбэг амьтан авран хамгаалах үйл ажиллагааг явуулахад оролцогч талууд (төрийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэд)-ын гүйцэтгэх чиг үүрэг, эрхийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

**а) Амьтны жам ёсны эрх.** Амьтны тухай хуульд “Амьтны жам ёсны эрх гэж амьтад идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтээ дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байх”-ыг ойлгоно хэмээн заажээ. Энэ бол Монголын төрөөс “Амьтны эрхийн түгээмэл тунхаглал”-ын үзэл санааг хүлээн зөвшөөрч, хуульчлан баталгаажуулсан хэрэг мөн. Энэ хуулийн 6 дугаар зүйл (Амьтныг хамгаалах хэлбэр)- ийн 6.1.9-д “өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах” нь амьтан хамгаалах үндсэн нэг хэлбэр мөн болохыг, түүнчлэн 6.2 дахь хэсэгт уг үйл ажиллагааг “байгаль орчны мэргэжлийн байгууллага, . . . иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ” хэмээн хуульчилсан байна.

Мөн энэ хуулийн 34 дүгээр зүйлд “Амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, энэрэнгүй хандах”, “Амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулна” гэж заажээ. Байгалийн нэг чухал нөөц баялаг болсон зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн үзэл санаа, хууль, эрх зүйн үндэслэлийг Монголын төрөөс ийнхүү хуульчилсан байна.

**б) Мэдээлэх.** Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 2-т “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж амьтан хамгаалах, мэдээлэх нь Монгол Улсын иргэн бүрийн журамт үүрэг байдлаар Үндсэн хуульдаа эх үндсийг тавьж өгсөн байна.

**Байгаль орчныг хамгаалах тухай хууль.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт **иргэн** байгаль орчныг хамгаалах талаар “байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх”-ээр зааж, үүрэг болгосон байдаг. Харин иргэнд амьтан аврах, асран хамгаалах, туслах, мэдээлэх шаардлагатай болохыг тусгайлан хуульчилж өгөөгүй боловч дээрх заалтын агуулгад хамааруулан ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу иргэн нь тусламж шаардлагатай байгаа амьтны талаар мэдээлэх үүрэг бүхий этгээд юм.

**Амьтны тухай хууль.** Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална. Үүнд: 6.1.9-д “өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах, 6.2-т “энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага; 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ” хэмээн заажээ. Иймд иргэн өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэл, хууль бус үйлдэлд өртсөн болон бусад шалтгаанаар тусламж шаардлагатай болсон амьтныг аврах, асран, хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэхийг тусгайлан үүрэгтэй байхаар заагаагүй боловч хэрэгжүүлэх субъектийг тодорхойлон заах байдлаар үүрэгжүүлсэн байна.

#### **в) Тусламж шаардлагатай амьтан барих, тээвэрлэх болон шаардлагатай зөвшөөрөл**

**Амьтны тухай хууль болон Эрүүгийн хууль.** Тусламж шаардлагатай байгаа амьтныг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үед тухайн амьтныг барих, тээвэрлэх шаардлага зайлшгүй гарна. Харин амьтныг барих, тээвэрлэхэд тухайн амьтны ховордлын зэрэглэлээс шалтгаалан хуульд заасан зөвшөөрлийг холбогдох байгууллагаас нэн яаралтай авах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл, тухайн амьтан нь нэн ховор, ховор, элбэг амьтан зэргээс шалтгаалан зөвшөөрлийг хаанаас авах эсэх нь тодорхойлогдох юм. Үүнийг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд дараах байдлаар тайлбарлаж болохоор байна.

Монгол орны амьтны аймгийг ховордлын зэрэглэлээр нь нэн ховор, ховор, элбэг амьтан гэж ангилдаг бөгөөд Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нийт 31 зүйл, салбар зүйл амьтныг нэн ховор, Засгийн газрын 2012 оны 7 дугаар “Ховор амьтны жагсаалт батлах тухай” тогтоолоор баталсан 76 зүйл амьтныг ховор амьтан, бусад амьтныг элбэг амьтан хэмээн тус тус ойлгоно.

Энэхүү ховордлын зэрэглэл буюу нэн ховор, ховор, элбэг амьтнаас шалтгаан тухайн амьтан ямар зориулалтаар агнаж, барьж болохыг Амьтны тухай хуульд тусгайлан зааж өгсөн байдаг. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т нэн ховор амьтныг зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болохоор заасан бөгөөд бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж, барихыг хориглосон байна.

Нэн ховор амьтныг эрдэм шинжилгээнээс бусад зориулалтаар барих, агнах, эсхүл тусгай зөвшөөрөлгүй тухайн амьтан агнасан, барьсан, эд эрхтнийг тээвэрлэсэн, гадаад улсад

гаргасан бол Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн 2-т заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан болно.

Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн 2-т *“Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”* гэж заасан байдаг.

Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолоор баталсан “Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох тухай” журмын 2.1-д *“эрдэм шинжилгээ гэдэгт амьтны биеийн бүтцийг судлах, эд, эрхтэнд нь гэмтэл учруулалгүйгээр судалгааны багаж, тэмдэг зүүх, хэмжилт хийх, эд эрхтнээс сорьц авах”* хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, нэн ховор амьтныг зөвхөн тухайн амьтны биеийн бүтцийг судлах, тэмдэг зүүх, хэмжилт хийх, сорьц авах зорилгоор барьж, агнаж болно.

Ховор амьтныг эрдэм шинжилгээний болон тусгай зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тусгай зориулалтад олзворын ан болон спорт агнуурын чиглэлээр ховор амьтныг агнах, соёл спорт, эрдэм шинжилгээ, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор зөвхөн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр агнаж, барьж болохоор зохицуулсан байна.

Иймд, тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор амьтан барих, асран хамгаалах шаардлагатай нөхцөлд тэдгээрийг барих, тээвэрлэх зохицуулалтыг хуульд тусгайлан зааж өгөөгүй боловч Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2 дахь заалт болон Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийг харгалзан үзэж авран хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор амьтан барих, тээвэрлэхэд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг заавал авах нь зүйтэй болно.

Харин тусламж шаардлагатай байгаа элбэг амьтныг барих, тээвэрлэх зөвшөөрлийг ямар субъектээс авах нь тодорхой зохицуулалтгүй байгаа боловч иргэн нь байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт энэ талаар мэдэгдэж, зөвшөөрөл, заавар зөвлөгөөг авах нь зүйтэй болно. Элбэг амьтан барих, тээвэрлэх үйл ажиллагааг орон нутгийн байгаль орчныг хамгаалах газар, тэдгээрийн ажил үүргээ гүйцэтгэж буй албан хаагч нар (мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч) зөвшөөрөл шаардлагагүйгээр гүйцэтгэж болно.

Амьтны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн дагуу тусламж шаардлагатай байгаа амьтныг барьж, тээвэрлэж байгаа байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, орон нутгийн биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн нар нь амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, барих, тавих, ачиж тээвэрлэх, асран хамгаалахдаа эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан технологи, арга хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын дагуу тоногдсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг оролцуулах ёстой. Өөрөөр хэлбэл, амьтан барих, тээвэрлэх, асран хамгаалах үйл ажиллагаанд заавал амьтны мэргэжлийн байгууллагыг оролцуулах үүрэгтэй болно.

## г) Амьтныг аврах, асран хамгаалах үйл ажиллагаа

**Амьтны тухай хууль.** Аймгийн Байгаль орчны газар нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.3-д заасны дагуу ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ёстой. Үүнээс үзвэл, нэн ховор, ховор амьтан авран хамгаалах үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй ч тухайн байгууллага нь аймаг орон нутгийн байгаль орчныг хамгаалах мэргэжлийн байгууллага болох нь тодорхой байна. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2-т амьтан болон агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар заасан нь амьтан асрах, буцааж байгальд нь тавих үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх эрх зүйн үндэстэй байна. Энэ бүгдээс үзвэл, аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага нь амьтдыг авран хамгаалах, тээвэрлэх, асран тэжээх ажлыг хэрэгжүүлж, мэргэжлийн арга зүйгээр хангах үндсэн байгууллага болно. Харин шаардлагатай тохиолдолд дээрх ажлыг Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу мэргэжлийн байгууллага (мэргэжлийн байгууллагын эрхтэй)-аар гүйцэтгүүлж болно.

**Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ” хэмээн заажээ. Ийнхүү амьтан авран хамгаалах, тэдэнд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж голлон гүйцэтгэхээр хуульчилсан байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т зааснаар Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйлчилгээний хүрээнээс хамаарч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

1. Бүх төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний
2. Тодорхой төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, тухайн төрлийн мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний
3. Мал эмнэлгийн тодорхой мэргэшлээр дагнан явуулын болон суурин үйлчилгээ үзүүлэх бол тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр тус тус заасан байна.

Дээрх үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-д зааснаар итгэмжлэлтэй малын эмч дангаараа эсхүл итгэмжлэлтэй малын эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан хуулийн этгээд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж, харьяалах аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлснээр хэрэгжүүлнэ. Энэ нэгж нь тусламж шаардлагатай байгаа амьтанд эмнэлгийн тусламжийг үзүүлэх, эмчлэх гол үүрэг бүхий субъект юм.

Амьтан эмчлэх үйл ажиллагааг төрийн байгууллагаас гадна, мэргэшсэн, итгэмжлэгдсэн хуулийн этгээд эрхлэн явуулж болно.

**Зураг 2.3. Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талууд**



**Тайлбар:**

**БОУАӨЯ:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, аргачлал, норм, дүрэм, журам зэргийг баталж, хэрэгжилтийг хангана.

**ИТХ:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн хэмжээнд зэрлэг амьтан аврах, асран хамгаалах хөтөлбөр, төлөвлөө, төсвийг хэлэлцэж батална.

**Засаг дарга:** Тухайн аймгийн Засаг дарга нь шууд удирдлагаар ханган үйл ажиллагааг зохицуулах, шаардлагатай ажлын хэсгийг байгуулах, шийдвэрийг хэрэгжүүлэх, дүрэм, журам гаргах, санхүүжүүлэх, зэрлэг амьтан аврах, асран хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**БОГ:** Аймгийн Байгаль орчны газар нь сум бүрд байгаль орчны мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай.

**Мал эмнэлгийн газар:** Мал эмнэлгийн газар нь сум бүрд мэргэжлийн малын их эмчтэй.

**Мэргэжлийн байгууллага:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан амьтны мэргэжлийн байгууллага.

**ЗООНОЗ:** Аймгийн Эрүүл мэндийн газрын харьяанд үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг Зооноз халдварт өвчин судлалын төв.

**Цагдаагийн байгууллага:** Аймаг, суман дахь цагдаагийн байгууллага нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, гамшиг осол болсон, амьтны халдварт өвчин гарсан газар орныг хамгаалах, хууль бусаар нэн ховор, ховор амьтад агнагдсан, баригдсан, хууль бус үйлдэлд өртөгдсөн эсэхийг тогтоох мөрдөн шалгах ажиллагаа явуулах, нийтийн хэв журмыг сахиулах үүрэгтэй оролцоно.

**Онцгой байдлын газар:** Аймгийн Онцгой байдлын газар нь гамшиг, аюулт үзэгдэл, осол, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд тухайн газарт хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хамгаалалтад авах, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, гамшиг ослыг арилгах арга хэмжээг авч оролцоно.

**Олон улсын болон олон нийтийн байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн:** Уг үйл ажиллагаанд хандив тусламж өгөх, шаардлагатай техник хэрэгслээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх, амьтны талаар мэдээлэл өгнө.

**д) Санхүүжилт.** Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн дагуу шаардлагатай санхүүжилт, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах зэрэг бүрэн эрхийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллага энэхүү амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэн оролцоно.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь амьтан аврах, асран хамгаалахад шаардлагатай төсвийг Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2-ын амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгахаар заасны дагуу бодлогын баримт бичиг, батлагдсан аймгийн хэмжээний нэн ховор, ховор амьтан хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд шаардлагатай төсөв, хөрөнгийг баталж, санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, аврах, асран хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор, элбэг амьтанд зориулсан байр бариулах, асаргааны санхүүжилт, албан хаагчдын томилолт, тээвэрлэхэд зориулсан санхүүжилт зэргийг аймгийн төсөвт тогтмол суулган баталж байх ёстойг дээрх хууль тогтоомжуудаар баталгаажуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т ан **амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг** амьтныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар заажээ. Ийнхүү тус заалтын дагуу нэн ховор, ховор, элбэг амьтныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний нэг хэсэг болох амьтан аврах, асран хамгаалах арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийн асуудлыг зохицуулах хууль, эрх зүйн бүрэн үндэстэй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 болон 34.3-д мал, амьтныг эрүүлжүүлэх, эмчлэхэд шаардлагатай төсвийг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, сум, дүүргийн төсвийг сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тус тус хэлэлцэн баталж, мал, амьтны эрүүл мэндийн хөтөлбөрт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын санхүүжилтэд зарцуулахаар зохицуулжээ. Үүнээс үзвэл, зөвхөн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсөв хөрөнгөөс гадна, амьтныг аврах, асран хамгаалах ажилд шаардлагатай төсвийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн дагуу мал, амьтан эмчлэх зардлаас санхүүжүүлж болохоор байна. Тухайлбал, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.1-д дуудлагын дагуу анхны онош тогтоох үйл ажиллагааны тээвэр, шатахууны зардал, халдварт өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах халдваргүйтгэлийн бэлдмэлийн үнэ гэх мэтийн зардлыг сум, дүүргийн энэ төрлийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож өгсөн байна.

Амьтан авран хамгаалах үйл ажиллагааг олон улсын байгууллага, Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэний хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж болно. Энэ тохиолдолд аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хандив, тусламжийг олгож, баталгаажуулахаас гадна, тухайн үйл ажиллагаанд хамтран оролцох байдлаар санхүүжүүлэн ажиллаж болно.

**е) Удирдлага зохион байгуулалт, хяналт.** Төрийн захиргааны төв байгууллага нь Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.5 дахь заалтууд болон Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журмыг баримтлан амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгоно. Ийнхүү энэ үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг олгож оролцохоос гадна, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1-д “амьтан хамгаалах, нутагшуулах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах”, 5.3.5-д “агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах”, 5.3.8-д “амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах”, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн заалтын дагуу шаардлагатай санхүүжилт, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

*Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Амьтны тухай хууль.* Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” үүргийг төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хэрэгжүүлнэ.

Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1-д “амьтан хамгаалах, нутагшуулах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах”, 5.3.5-д “агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах” зэрэг бүрэн эрхийг **төрийн захиргааны төв байгууллага** хэрэгжүүлэхээр заасан байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны төв байгууллага тусламж шаардлагатай байгаа амьтан (нэн ховор, ховор болон элбэг амьтад)-ыг барих, тээвэрлэх асран хамгаалах зөвшөөрлийг олгох чиг үүргээс гадна, голлон тухайн амьтан аврах, асран хамгаалахыг ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангаж, норм, норматив, технологийг батлах, үйл ажиллагааг санхүүжүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

*Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал* нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх “Харьяалах нутаг дэвсгэртээ нэн ховор, ховор амьтан хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, биелэлтэд нь хяналт тавих”, 5.4.6 дахь “Амьтны аймгийн хамгаалалт, ашиглалтын талаар Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх”, 5.4.9 дэх “Харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг амьтан хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх” зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, амьтныг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөр, тайланг батлан, шаардлагатай санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, батлах зэрэг үндсэн чиг үүрэгтэй болно. Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.4-д заасны дагуу нутаг дэвсгэртээ байршдаг амьтан хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлнэ.

*Аймгийн Засаг дарга* нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх “Амьтан хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй холбогдуулан гаргаасан Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах”, 5.5.2 дахь “Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8-д биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх”, 6.1.9 дэх “өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвээдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах”, 6.1.11 дэх “Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтан хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн

*мэдээллийн хэрэгслээр сурталчлах”* арга хэмжээг нутаг дэвсгэртээ тус тус авч хэрэгжүүлэх чиг үүрэгтэй болно.

Дээрх чиг үүргээс үзвэл, **аймаг, нийслэлийн Засаг дарга** нь аймгийн Байгаль орчны газрын боловсруулсан амьтан авран хамгаалах үйл ажиллагааг тусгасан амьтан хамгаалах хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Энэ хөтөлбөрт тусламж шаардлагатай байгаа амьтан аврах, асран хамгаалах, үйл ажиллагааг төлөвлөн, санхүүжилтийн хамтаар тусгасан байх ёстой болно.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах, энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2 болон бусад хууль тогтоомжийн дагуу удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжүүлэхээр заажээ. Ийнхүү **тухайн аймгийн Засаг дарга бол харьяалах нутаг дэвсгэртээ амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг бусад төрийн байгууллагуудын хамтын уялдааг хангах замаар удирдан зохион байгуулах үндсэн удирдлага болохыг** хуульчлан баталгаажуулсан байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу **аймгийн Эрүүл мэндийн газрын Зооноз халдварт өвчин судлалын төв** нь Зоонозын болон гоц аюултай халдварт өвчний байгалийн голомтын тандалтыг зохион байгуулж, хөдлөл зүйг тогтоох, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, халдвар тархахаас сэргийлэх, халдварын голомтыг цомтгон дарах, зэрлэг амьтан, мал, тэжээвэр амьтдаас хүнд халдварлах Зоонозын гоц аюулт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, өвчний голомтыг цомтгон дарах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

## 2.4 АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СТАНДАРТЧИЛЛЫН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалахад дагаж мөрдөх хамгийн бага (наад захын) стандартыг анх 1980-аад оны дундуур АНУ-д төвтэй Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах Олон улсын зөвлөл (International Wildlife Rehabilitation Council) болон Зэрлэг амьтан аврах, асран хамгаалагчдын үндэсний холбоо (National Wildlife Rehabilitators Association) санаачилж хамтран боловсруулсныг өдгөө дэлхийн олон улс оронд жишиг болгон мөрдөж байна. Өнгөрсөн 40 шахам жилийн хугацаанд уг стандартыг 4 удаа шинэчлэн сайжруулаад байна.

Манай улсын тухайд хүн амын төвлөрөл, суурьшил, хотжилт хүрээгээ тэлж, дэд бүтцийн барилга байгууламж, уул уурхайн үйлдвэрлэл өсөн нэмэгдэж, цас зуд, ган гачиг, ус үер, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас хамаарч байгалийн зэрлэг амьтдад үзүүлэх тусламж үйлчилгээний хэрэгцээ, шаардлага, энэ ажлын цар хүрээ байнга нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, суурин болон зөөврийн амьтны хүрээлэн, минж үржүүлэх төв, тарвага, буга болон бусад амьтдыг сэргээн нутагшуулах, бэртэж гэмтсэн хөхтөн, шувуудыг авран хамгаалах, урт богино хугацаагаар тэжээн тэнхрүүлэх, зөөж тээвэрлэх, байгальд суллан тавих ажил тодорхой түвшинд хийгдэж эхлээд байна. Үүний нэг жишээ бол нийслэлийн Байгаль орчны газраас санаачлан 2017 оны 11 дүгээр сард байгуулсан “Зэрлэг амьтан асрах төв” юм. Үүнийг одоогоор манай улсад амьтан аврах, асран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй цорын ганц байгууламж хэмээн үзэж болно.

Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүсэд газар олгож, нийслэл маань хаяа тэлэхийн хэрээр хотын ногоон бүсийн зэрлэг амьтдын тархац нутаг хумигдаж, зэрлэгшсэн ноходод хөөгдөх, торон хашаанд сүлбэгдэх, идэш тэжээл хайн хот руу тэнүүлчлэн орж ирэх, иргэд хууль бусаар амьтдыг барин тэжээж байгаад гэмтээх юм уу алдах, машинд дайруулах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх, элдэв өвчинд нэрвэгдэх, шувуудын үр төл унаж бэртэх тохиолдол жил ирэх тусам нэмэгдэж, ард иргэдээс мэдээлэх, дуудлага өгөх үйл явц эрчимжсэнтэй уялдан энэхүү төвийг байгуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсжээ. 2018-2020 онд дээрх төв нийтдээ 112 амьтны холбоотой дуудлага, мэдээлэл хүлээн авснаас 47 бодгаль амьтныг “Зэрлэг амьтан асрах төв”-д эмчлэн, асарснаас 30-ийг нь байгальд буцаан тавьж, 17 нь аргагүй шалтгааны улмаас хорогджээ. Харин 65 амьтанд газар дээр нь тусламж, үйлчилгээ үзүүлээд суллан тавьсан байна.

Энэ ажлыг эрхлэн гүйцэтгэх явцад цаашид анхаарч шийдвэрлэх шаардлагатай олон асуудал тулгарчээ. Тухайлбал, уурга, сачок, могойн уурга, нойрсуулагч буу, амьтан барих тор зэрэг зэрлэг амьтан барих, зөөвөрлөх зэрэгт шаардлагатай наад захын багаж хэрэгсэл байхгүйгээс барих явцдаа амьтнаа гэмтээж бэртээх, зөөвөрлөх үед алдах эрсдэл үүссэн байна. Мөн гэмтсэн амьтдыг уг төвд эмчлэн, асрахад шаардлагатай эм бэлдмэл, идэш тэжээлийн хүрэлцээ муу, батлагдсан төсөв байхгүй зэрэг санхүүгийн хүндрэл ч багагүй тохиолджээ. Түүнчлэн амьтан асрах төвд байлгаж эмчлэн, сувилах шаардлагатай амьтдын байр оромжийн хүрэлцээ, зохистой хэмжээ, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг хэрхэн сахих, унд, тэжээлийн орц, найрлага, тэжээх хэмжээ, давтамж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгсэл, амьтан тээвэрлэх тээврийн хэрэгсэл гэх зэрэг олон тулгамдсан асуудлуудтай нүүр тулжээ. Нөгөө талаас ажиллагсад маань хэдий сэтгэл, зүтгэл гарган хоёргүй сэтгэлээр хичээж байгаа ч байгалийн зэрлэг амьтдыг аврах, эмчлэх, асран сувилах арга, туршлага дутах тал ч бас гарч байна. Гэтэл энэ бүгдийг ядаж хамгийн энгийн түвшинд ч болтугай тодорхойлсон ямар нэг бодлого, стандарт, заавар, аргачлал төрөлх монгол хэлээр өнөө хир боловсорч

гараагүй, нэн тэргүүнд аваад харчих лавлах ном, гарын авлага байхгүйгээс асуудлыг гагцхүү сэтгэлийн дуудлагаар, баримжаалан шийдэхэд хүргэж байна.

Эдгээр болон бусад нөхцөл байдлын улмаас амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах хууль эрхзүй, аж ахуйн зохион байгуулалт, эмнэлгийн үйлчилгээ, тэжээллэг, санхүүжилт, хяналтын ажлыг цаг алдаж хойшлуулалгүй эхлэх, улмаар олон улсын жишигт ойртуулах бодит хэрэгцээ шаардлага нэгэнт бий болсон юм. Иймд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас санаачлан зохион байгуулсан “Амьтан авран хамгаалах бүсийн хэмжээний төв байгуулах үндэслэл, шаардлага” хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж, Алтай Соёны бүс нутагт “Амьтан авран хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж нөхцөлийг судалж, зөвлөмж боловсруулах” зөвлөх байгууллагын санал, санаачилга, Дэлхийн улс орнуудын туршлагыг тус тус үндэслэн “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны ерөнхий шаардлага”, “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтанд тавих тусгай шаардлага”, “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Шувуу аврах, асран хамгаалах тусгай шаардлага”, “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хоёр нутагтан, мөлхөгчдөд тавих тусгай шаардлага” гэсэн багц стандартууд боловсруулсныг Стандарт, хэмжил зүйн газар 2021 онд батлан улс орон даяар мөрдөж эхэлсэн байна.

Дээрх стандартууд бол амьтан авран хамгаалагчид нь юуг хийж болох, юуг хийж болохгүй, өвдөж зовж шаналсан, өнчирч хагацсан амьтдыг өөрсдийн үүрэг хариуцлагын хүрээнд чанарын өндөр түвшинд асран халамжлахын тулд юу юу хийж хэрэгжүүлэх шаардлагатай, техник, технологийн нэн хурдацтай хөгжил, дэвшлийн эрин үед зайлшгүй хийгдэх алхмууд гэх мэт зүйлүүдийг багтаасан үйл ажиллагааны цогц удирдамж юм. Эдгээр багц стандартын үндсэн үзэл санаа, агуулгыг дор товч авч үзлээ.

#### *Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага (MNS 6943:2021).*

Энэ стандартын үндсэн зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрт идээшин амьдарч буй хүний тусламж, дэмжлэг шаардлагатай болсон зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэл, байр, оромжид тавих ерөнхий шаардлагыг тодорхойлж, тэдгээр амьтдыг эмчилж, асран тэнхрүүлж, бие даан амьдрах чадвартай болсон үед байгальд нь буцаан тавих замаар зэрлэг амьтдыг хамгаалах, тэдгээрт учирч буй эрсдэлийг бууруулах явдал болно.

Тус стандартыг зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хяналт шалгалтын болон экологи, байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагууд үйл ажиллагаандаа чиглэл, мөрдлөг болгон хэрэглэнэ.

Уг стандартаар амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа эрхлэхэд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлсон байна. Мөн амьтдын байр оромжийн экологийн нөхцөл, энэ үйл ажиллагааг эрхлэгчдийн мөрдөх нийтлэг хэм хэмжээ, амьтны эмчилгээ, маллагаа, асаргаанд тавих үндсэн шаардлагуудыг тус тус тодорхойлжээ.

#### *Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтдад тавих тусгай шаардлага (MNS 6944:2021).*

Стандартын үндсэн зорилго нь өвдсөн, гэмтсэн, шархадсан, өнчирсөн, эхээс салсан нялх төл зэрэг олон янзын шалтгааны улмаас хүний тусламж, оролцоо зайлшгүй шаардлагатай болсон зэрлэг хөхтөн амьтдыг аврах, түр асрах, байгальд суллан тавих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны хэм хэмжээг тогтооход оршино.

Зэрлэг хөхтөн амьтдыг аврах, асран хамгаалахад ашиглах байр оромж, хайрцаг, сав, тор, хашаанд тавих үндсэн шаардлага, тэдгээрт амьтдыг хэрхэн байршуулах, тэжээх, арчлан маллах, эмчлэх, зөөж тээвэрлэхтэй холбогдсон хэм хэмжээг ангилал зүйн болон экологийн адил төстэй байдлыг харгалзан (1) шавж идэштэн, гар далавчтан, (2) туулай хэлбэртэн, мэрэгчид, (3) мах идэштэн, (4) туруутан, туурайтан, тавхайтан гэсэн 4 үндсэн бүлгээр авч үзсэн байна.

*Шувуу аврах, асран хамгаалах тусгай шаардлага (MNS 6945:2021).* Хүний тусламж, оролцоо зайлшгүй шаардлагатай болсон шувуудыг аврах, асрах, тоо толгойг өсгөн олшруулах, энэ үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны хэм хэмжээг энэ стандартаар тодорхойлсон байна.

Шувууг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тэдний бусдаас ялгарах зарим өвөрмөгц онцлогуудыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагын үүднээс уг үйл ажиллагаанд ашиглах байр оромж, хайрцаг, сав, тор, хашааны хэмжээ, тэдгээрийн экологийн нөхцөл, тэдгээрт шувуудыг хэрхэн байршуулах, тэжээх, арчлан маллах, эмчлэх, зөөж тээвэрлэхтэй холбогдсон хэм хэмжээг ангилал зүйн болон экологийн адил төстэй байдлыг харгалзан (1) бор шувууны баг, (2) галуу, нугас болон ус намгийн бусад шувууд, (3) тагтаа, (4) өдрийн махчин болон ууль, (5) тогоруу, (6) тахианы багийн шувууд гэсэн 6 үндсэн бүлгээр авч үзсэн байна.

*Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хоёр нутагтан, мөлхөгчдөд тавих тусгай шаардлага (MNS 6946:2021).* Хүний тусламж, оролцоо зайлшгүй шаардлагатай болсон хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг эмчлэх, асрах, тоо толгойг өсгөн олшруулах, энэ үйл ажиллагаанд оролцох төрийн ба төрийн бус байгууллага, иргэдийн хэм хэмжээг энэхүү стандартаар тодорхойлсон байна. Тухайлбал, уг стандартад хуурай газрын хүйтэн цуст нугаламт амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд тэдний амьдрах байр оромж, түүний экологийн нөхцөл ямар байх, энэ бүлэг амьтдыг тэжээх, асрах, харьцах, тээвэрлэхэд ямар хэм хэмжээ баримтлах тухай асуудлуудыг анги тус бүрээр авч үзжээ.

## 2.5 АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЁС СУРТАХУУН

Ёс зүйн ухааныг үндэслэгч, эртний Грекийн гүн ухаантан Аристотель “Ёс зүй гэдэг бол хүн юу хийж, юунаас татгалзах ёстойг судалдаг шинжлэх ухаан” хэмээн тодорхойлжээ. Ёс зүй нь нийгэм-хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой. Ёс суртахуун гэдэг бол товчоор хүмүүсийн зайлшгүй баримталж хэрэгжүүлэх зарчим, дагаж мөрдөх зүй зохистой хэм хэмжээ юм. Ёс суртахуунтай байна гэдэг нь зөвийг сурах, түүнийгээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа байнга мөрдөж хэвшүүлнэ гэсэн үг.

Байгаль, биологийн олон янз байдал, зэрлэг амьтдын нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах аливаа үйл ажиллагааны эцсийн үр дүнд нөлөөлдөг маш олон хүчин зүйлсийн нэг нь тухайн салбарт ажиллагсдын баримталж, хэвшсэн ёс суртахууны хүчин зүйл юм. Хүн, байгалийн хоорондын урт удаан харилцааны явцад хүн төрөлхтний зүгээс байгальтай зохистой харьцах, байгалийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага, байгалийн нөөц баялгийн зохистой хэрэглээний ёс зүйн шилдэг зарчмууд бүрэлдэн тогтсон байна. Ялангуяа, байгалийн зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах чиглэлээр ажиллаж буй хэн боловч ёс суртахууны өндөр дээд чанар, нийгмийн амьдралд шигшигдэж шалгарсан үндсэн зарчим, хэм хэмжээг үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй сахиж, ханган биелүүлдэг байх учиртай. Ингэснээр амьтдад байгалиас заяасан жам ёсны эрхийг нь хангах үндсэн боломж бүрдэнэ.

### 2.5.1. Биологийн зүйлийг хамгаалахад дагаж мөрдөх ёс зүйн үндсэн зарчим

Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд биологийн зүйлийг хамгаалах ёс зүйн үндсэн зарчмуудыг хэлбэрэлтгүй ханган, сахиж даган мөрдөх ёстой. Биологийн зүйлийг хамгаалах ёс зүйн зарчим бол юуны өмнө тухайн зүйлийн эдийн засгийн ач холбогдол, үнэ цэнийг үл харгалзан, гагцхүү биологийн зүйл бүхнийг эн тэнцүү авч үзэж, хамгааллын бодлогоо хэрэгжүүлэх үзэл санаанд суурилдаг байна. Энэ нь хүн төрөлхтөнд эдийн засгийн шууд ашиг, үр өгөөж багатай зүйлүүдийг адил тэнцүү хамгаалах үндэслэл болдог билээ. “Байгаль хамгааллын биологи” (Примак нар, 2003) бүтээлд биологийн зүйлийг хамгаалах үндсэн зарчмуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

*Зүйл бүр оршин тогтнох эрхтэй.* Энэ зарчмын дагуу (1) Зүйл болгон оршин тогтнох адил тэнцүү нөхцөлөөр хангагдах ёстой, (2) Зүйл бүр амьд ертөнцийн нэг бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хүний адил амьдрах, оршин тогтнох эрхтэй, (3) Зүйл болгон хүний хэрэгцээнээс үл хамаарсан өөрийн гэсэн дотоод үнэ цэнтэй, (4) Хүмүүс зүйлийг устгах эрхгүйгээс гадна, хүний болчимгүй үйлдлээс шалтгаалан зүйл мөхөж алга болохоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

*Биологийн бүх зүйл хоорондоо харилцан шүтэлцээтэй байдаг.* Нэг зүйлийн алдагдал нь бүлгэмдлийн бусад гишүүдэд асар хортойгоор нөлөөлдөг. Биологийн аль нэг зүйл устсанаар бусад зүйлүүд мөхөх, бүлгэмдлийн тогтворгүй байдал бий болох нөхцөл үүснэ. Тиймээс, хүн төрөлхтний хувьд хожмын оршин тогтнохоо бодож биологийн олон янз байдлыг хадгалж, хамгаалах нь ухаалаг хэрэг болно. Хүн төрөлхтний оршин тогтнож байгаа нь байгаль, ертөнцөөс хамаардаг тул түүний бүрэн бүтэн байдлыг хангах нь бидний амин чухал үүрэг мөн.

*Хүмүүс дэлхийг халамжлах үүрэг, хариуцлага хүлээдэг.* Даян дэлхийн түүхэн хөгжлийн явцад биологийн зүйлүүд үүсэн бүрэлдсэн нь тодорхой. Иймд даян дэлхий, түүний үндсэн бүрэлдэхүүн болсон биологийн олон янз байдлыг авран хамгаалах, зүй зохистой ашиглах нь энэхүү урт удаан хугацааны түүхэн хөгжлийн оргил болсон ухаант хүний эрхэм үүрэг мөн.

*Хүмүүс хойч үеийнхний өмнө хариуцлага хүлээх ёстой.* Өнөөдөр хүмүүс бид байгалийн нөөц баялгийг доройтуулж, биологийн зүйлүүдийг устгаж буйн лай ланчгийг бидний хожмын үе удмууд хүртэнэ. Тиймээс өнөөдөр байгалийн нөөцийг зүйл болон бүлгэмдэлд халгүй байдлаар тогтвортой ашиглах хэрэгтэй. Хэрэв бид байгаль дэлхийг хойчийн үр удмаасаа зээлдэн авч байна гэж үзвэл, зохистой байдлаар нь буцаан олгох ёстой.

*Хүний амь, эрх ашгийг дээдлэх үзэл нь биологийн олон янз байдлыг хүндлэх үзэлтэй нийцдэг.* Зарим хүн байгалийг хадгалж хамгаалах явдлыг хүмүүсийн эрх ашгийг хөсөрдүүлсэн хэрэг хэмээн үздэг нь ташаа ойлголт юм. Хүний соёл заншил, байгаль ертөнцийн харилцан шүтэлцээг ухамсарлах нь биологийн олон янз байдлыг бүхэлд нь хүндэлж дээдлэх байдалд хүргэдэг. Ядуу, бяд муутай хүмүүсийн нийгэм, улс төрийн эрх ашгийг хамгаалах үзэл баримтлал нь байгаль ертөнцийг хадгалан хамгаалах үзэлтэй адил чанартай. Хүмүүс хөгжиж ухамсар суух тусам “амьд биеийн бүхий л хэлбэрийг хүлээн зөвшөөрч”, “тэдгээрийн дотоод үнэ цэнийг мэдэрдэг” (Naess, 1986) байна. Энэ үзэл нь хүмүүсийн өөр бусдыг тухайлбал, төрөл төрөгсөд, найз нөхөд, бусад хүмүүс, амьтад, биологийн бүх зүйл, экосистем цаашилбал, дэлхий ертөнцөө хайрлан халамжлах үүргээ ухамсарлахыг хүмүүст уриалдаг.

*Байгаль дэлхийд эдийн засгийн аргаар илэрхийлж боломгүй гоо зүй, оюун санааны ач холбогдол агуулагдаж байдаг.* Хүн төрөлхтний түүхээс харахад сая сая сүсэгтнүүд, яруу найрагчид, зохиолчид, уран бүтээлчид, хөгжимчид байгаль дэлхийгээс тодруулбал, хүний нөлөөнд автаагүй зэрлэг байгалиас онгодоо хөглөн уран бүтээлээ туурвиж иржээ. Байгаль ертөнц, амьтан, ургамлын тухай ном зохиол уншиж, музей, кино, ургамал ба амьтны хүрээлэн, видео бичлэг үзэх нь хангалттай биш. Хүмүүс зэрлэг ан амьтан, байгаль дэлхийн гоо сайхныг мэдэрч нүд сэтгэлээ баясаж, байгалийн нөхцөлд амарч алжаалаа тайлдаг. Биологийн олон янз байдал алдагдсанаар хүмүүсийн тэрхүү гоо зүй, оюун санааны ханамж алдагдана. Жишээлбэл, тал хээрийн цагаан зээр, зэрлэг цэцэгс, өнгө алагласан эрвээхэй устлаа гэхэд бидний хойч үеийн уран бүтээлчид, үр хүүхдүүдийн маань дүрслэхүйн нэгэн мэдрэмж алдагдана гэсэн үг юм.

*Амьдралын үүсэл, хөгжлийг тодорхойлоход биологийн олон янз байдал чухал шаардлагатай.* Амьдрал хэрхэн үүссэн бэ? Дэлхийн биологийн олон янз байдал хэрхэн үүсэж хөгжсөн бэ? Хүмүүс хэрхэн бий болсон вэ? Эдгээр гурван асуулт нь шинжлэх ухааны төгс төгөлдөр хариултаа хүлээсээр л ... . Олон мянган биологичид эдгээрийн учир шалтгааныг тайлахаар шургуу зүтгэж зарим нь ихээхэн амжилт гаргаад байна. Тухайлбал, ургамлын ангилал зүйчид молекул, филогенетикийн арга зүйг ашиглан Нью Каледони орчим судалгаа явуулах үед Номхон далайн арал дээрээс олсон нэгэн зүйл бургас нь цэцэглэдэг ургамлуудын хамгийн эртний үе удам болохыг тогтоосон байна (Mathews, Donoghue, 1999). Ийм зүйлүүд устаж алга болоход удамшлын ул мөрүүд хамт устаж, мөнөөх гурван оньсогыг таахад улам л хүндрэлтэй болдог. Үүний нэгэн адил хүний ойрын төрөл болох шампанзе, горилл, орангутан зэрэг зүйлүүд байгалиас мөхөж алга болох юм бол хүн төрөлхтний үүсэн бий болсон эволюци хөгжлийн нууцыг тайлах түлхүүрүүд мөн л хамт устаж буй хэрэг юм. Ийм учраас биологийн аливаа зүйл, түүний бодгаль биесийг хадгалан үлдээх зайлшгүй шаардлагатай.

## 2.5.2. Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ

Биологийн аливаа зүйлийг хамгаалах тухай дээр дурдсан ёс зүйн үндсэн зарчмуудад үндэслэн зэрлэг амьтан аврах, асран хамгаалахад баримтлах ёс зүйн хэм хэмжээг дараах чиглэлүүдээр тодорхойлж байна. Үүнд:

1. Амьтан судлал, экологи, байгаль хамгаалал, мал эмнэлэг зэрэг шинжлэх ухааны мэдлэг, дадлага, чадварт тулгуурлан зохих стандартын дагуу амьтныг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг хамгийн энэрэнгүй арга замаар хэрэгжүүлэх ёстой. Амьтан авран хамгаалагч нь эрхэлсэн ажилдаа хариуцлагатай, аливаа зүйлд чин сэтгэлээсээ ханддаг, халамжтай хүн байх ёстой бөгөөд амьтдыг асран хамгаалах ажлын чанарыг хэрхэн сайжруулах талаар идэвх санаачилгатай ажиллах ёстой.
2. Амьтан авран хамгаалагч нь амьтад, тэднийг аврах, асран хамгаалах тухай холбогдох хууль, дүрмийг үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй дагаж мөрдөнө.
3. Амьтан авран хамгаалагч нь үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын журам, заавар, стандартыг нарийн чанд баримтална. Мөн уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад ч амьтан аврах, асран хамгаалах талаар гарсан шинэ арга зүй, хууль эрх зүйн шинэчлэлийн талаар өөрийн мэдлэгээ тогтмол баяжуулах ёстой.
4. Амьтан авран хамгаалагч нь амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны хүрээнд тавьсан хорио цээр, хязгаарлалтыг бүрэн мөрдөж ажиллахын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээд, мэргэжлийн ажилтнаас заавар, зөвлөгөө авна.
5. Амьтан авран хамгаалагч нь амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд хамтран оролцогч талуудыг эрхэмлэн хүндэлж, мэдлэг, туршлагаа хуваалцан хамтарч ажиллана.
6. Амьтан авран хамгаалагч нь амьтан аврах, асран хамгаалах үйлсийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүрт тавина.
7. Амьтан авран хамгаалагч нь амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны аль ч үе шатанд үүсэж болох амьтан тус бүрийн үхэл амьдралтай холбоотой асуудалд хүндэтгэлтэй хандаж, онгон зэрлэг байгалийг дээдлэн мэргэжлийн болон хувь хүний анхаарал арчилгааг хэрэгжүүлж ажиллана.
8. Амьтан авран хамгаалагчийн үндсэн зорилт бол амь насыг нь аварч, арчлан сувилж буй амьтдыг аль болох хурдан хугацаанд байгальд нь буцаан тавьж, суллах явдал юм. Ийм учраас амьтан авран хамгаалагчийн хувьд амьтад амь, нас, эрүүл мэнд бэлэглэх нь тэдний эрхэлсэн ажил, хөдөлмөрийн амт шимт, аз жаргал хэмээн үзэх ёстой.
9. Амьтан авран хамгаалагч нь орон нутгийн иргэдийг дэмжин сайн дурын сургалт зохион байгуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэргээр амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулах замаар амьд байгаль болон хүрээлэн буй орчны сайн сайхны төлөө хариуцлага хүлээх тухай ойлголтыг тэдэнд төлөвшүүлэхэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллах ёстой.
10. Амьтан авран хамгаалагч нь тогтвортой хөгжлийн чиг хандлагыг эрхэлсэн ажлын үндэс болгож, байгаль хамгаалах ёс зүйг баримталж, ажил үүрэгтээ хариуцлагатай хандана.
11. Тухайн хувь хүний аливаа үйл ажиллагаа, амьтдыг аврах, асран хамгаалах үйл явцын үр дүнд бүхэлд нь нөлөөлдөг гэдгийг сайтар ухамсарлаж, бизнесийн болоод бусад үйл ажиллагаанд шударга ёс, эв нэгдэл, хүмүүнлэг энэрэнгүй ёс ба нарийн чанд гүйцэтгэлийг баримталж ажиллана.

### 2.5.3. Ил тод байдал ба зөвшилцөл

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах нэгжид хүлээн зөвшөөрөх нэг гол шалгуур бол үйл ажиллагааны ил тод байдал юм. Асран хамгаалах нэгжид өрнөж буй зэрлэг амьтны эмчилгээ, маллагаа, асаргааны нөхцөл сонирхогч бүх талд ойлгомжтой, ил тод байна. Үүнийг нэгжийн цахим хуудас эсвэл жил бүрийн тайлангаас үзэж танилцах боломжтой байлгах нь зүйтэй.

Арчилгаа, сувилгаа, эмчилгээ хийж байгаа амьтдыг хамгаалах үүднээс хөндлөнгийн хүн байгууламжид орохыг хориглоно.

Тодорхой амьтан хүлээн авах тухай мэдээллээ харьяалах байгууллагатай байнга зөвшилцөнө. Зарим онцгой нөхцөлд ялангуяа, эзэмшигчийн хүсэл сонирхлын эсрэг байгууллагын шаардлагаар хүлээн авсан амьтны талаар нууцлалыг хадгална.

Амьтны асаргаа, байр сав шинээр барьж байгуулах, ариутгах арга хэмжээ авах үед үүссэн аливаа асуудлаар харьяалах дээд байгууллага, эрдэм шинжилгээний удирдлага бүхий амьтны хүрээлэн, малын эмч, амьтан судлаач, зан төрхийн судлаач, бусад мэргэжлийн хүмүүстэй тухай бүр холбоо барьж, зөвлөгөө авах нь зүйтэй.

## 2.6 ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАН ХАМГААЛАГЧДЫН ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ ҮНДСЭН МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ

### **Зэрлэг амьтныг авран хамгаалагчийн нэн тэргүүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар.**

Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үр дүн, амжилт нь хэдийгээр олон хүчин зүйлээс хамаарах ч хамгийн чухал нь тэнд ажиллагсдын суурь мэдлэг, мэргэжлийн үр чадвар, эрхэлсэн ажилдаа хандах хандлагаас ихээхэн хамааралтай. Ер нь амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа бол ёс зүй, амьтан судлал, байгаль хамгааллын биологи, экологи, этологи, мал эмнэлэг, эм зүй, халдвар судлал гэх зэрэг олон шинжлэх ухааны суурь мэдлэг, үр чадвар шаарддаг нарийн нийлмэл үйл явц юм.

Ямар ч тохиолдолд амьтдын анатоми, морфологи, амьтны аймгийн ангилал зүй, биологи, экологи, зан төрх, зэрлэг амьтантай харьцах, амьтдыг аврах, асран сувилах, эмчлэх талаарх зохих түвшний суурь мэдлэг, чадвар дадал эзэмших нь тухайн хүнд амьтан бүрийг илүү сайн асарч хамгаалах боломжийг нээдэг.

Ийнхүү суурь мэдлэг эзэмшин, зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг ойлгож ухаарна гэдэг бол зөвхөн хувь хүнд төдийгүй ерөөс энэ үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулахад чиглэсэн маш ухаалаг хөрөнгө оруулалт юм. Энэ нь дараа дараагийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх суурь нөхцөл болох ба амьтан аврагчдыг зэрлэг амьтдад маш чанартай асаргаа, үйлчилгээ үзүүлэхэд чадавхжуулах үндсэн хүчин зүйл болно.

Эзэмшсэн мэдлэг, чадвар нь шинжлэх ухааны үндэстэй байхын зэрэгцээ амьтан аврах, асран хамгаалах ажил үйлчилгээнд хэрэгжиж үр дүнтэй нь нотлогдсон байх нь чухал. Амьтан аврах, асран хамгаалахад шаардлагатай мэдлэг, чадварыг мэргэжлийн сургалтаас гадна, ажлын байрны сургалт, мэргэжлийн семинар зөвлөгөөн, мэргэшүүлэх сургалт, ижил төрлийн ажил, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ажиллаж, туршлага судлах зэрэг олон арга, хэлбэрээр эзэмших боломжтой.

Эцсийн дүндээ тухайн хүн амьтан аврах, асран хамгаалахад хэрэгтэй мэдлэг, чадварыг эзэмшихийн тулд ажилдаа чин сэтгэлээсээ хандан, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж ажиллах чадвартай байх ёстой. Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг эрхлэн явуулахад тухайн хүн дараах чиглэлээр зохих түвшний мэдлэг, чадварыг зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

**Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах тухай ерөнхий мэдлэг.** Амьтан аврах, асран хамгаалах гэж юу болох, ямар тохиолдолд амьтдыг энэ үйл ажиллагаанд хамруулдаг, уг үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх арга, аргачлал, баримтлах зарчмын талаар анхан шатны мэдлэг, чадвар эзэмшсэн байна.

**Хууль эрх зүйн мэдлэг.** Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Байгаль хамгаалал, Амьтны тухай, Мал эмнэлгийн эрүүл мэндийн тухай хуулиуд, мал, амьтны эмчилгээ, оношилгоо, асаргаа, ариун цэвэр, хорио цээр, халдваргүйжүүлэлтийн талаарх дүрэм, журам, заавар, стандарт зэрэг зэрлэг амьтдыг авран, асран хамгаалахад шууд хамааралтай эрх зүйн баримт бичгүүдийн үзэл, санаа, агуулгыг эзэмшиж үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлэх чадвартай байна.

**Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах ёс зүй.** Амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн, хангах шаардлагад нийцсэн ёс зүйн үндсэн зарчмыг бүрэн эзэмшсэн, түүнийгээ амьтан аврах, асран хамгаалах ажил үйлчилгээний үе шат бүхэнд чанд сахин мөрдөх чадвартай байна. Ер нь төрөл бүрийн шалтгааны улмаас өвчилсөн, өнчирсөн, зовж шаналж буй амьтдыг аварч, асран сувилж, тэдэнд амь, амьдрал бэлэглэнэ гэдэг бол тухайн хүнээс ихээхэн тэвчээр, сэтгэлийн хат, энэрэнгүй нинжин сэтгэл, хичээл зүтгэл шаардсан нарийн чимхлүүр ажил гэдгийг ухаарсан байх ёстой.

**Амьтны аймгийн талаарх суурь мэдлэг, чадвар.** Тухайлбал, амьтны аймгийн ангилал зүй, анатоми, морфологи, физиологи, биологи, экологи, зан төрх зэрэг биологийн суурь болон хавсарга ухааны мэдлэг чадвар эзэмшсэн байна гэсэн үг. Хүний тусламж шаардлагатай амьтад ямар төрөл зүйлд хамаарах, түүний зан төрхийн онцлогт үндэслэн тухайн амьтны хэрэгцээ, шаардлагад нийсэн ямар байр оромжид байршуулах, хоол тэжээлийн орц, найрлага, тэжээх, цочролоос урьдчилан сэргийлэх арга техник гэх мэт тулгамдсан олон асуудлыг оновчтой шийдвэрлэн, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч хэрэгжүүлэхэд энэ талын мэдлэг, чадвар үлэмж тус дэм болно.

**Эмчилгээ, үйлчилгээ, сувилгааны талаарх мэдлэг, чадвар.** Зэрлэг амьтдын стрессээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэднийг осол аюулгүй барих, тээвэрлэх, үзлэг хийж биеийн ерөнхий байдал, бэртэл гэмтлийн тодорхойлох анхан шатны арга барил эзэмшсэн байна. Малын эмч, мэргэжилтний заавар зөвлөмжийн дагуу амьтдыг эмчлэн илаарьшуулах, асран сувилах талаар зохих мэдлэгтэй, тэдгээрийг гардан гүйцэтгэх чадвартай байна. Ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг хэрхэн хангах, ариутгал, устгалын ач холбогдол, тэдгээрийг хэрхэн гүйцэтгэх арга барилд суралцсан байна. Ялангуяа:

- Амьтны зан төрхийн онцлог, түүний өөрчлөлт, саатлыг илтгэх шинж тэмдгийн тухай
- Амьтанд шаардлагатай хоол тэжээл, усны хэмжээ, шаардлагын тухай
- Өвчнийг таних шинж ялангуяа, халдварт өвчний тухай
- Эрүүл бус байдлыг илтгэх шинж тэмдэг, түүний эсрэг авах арга хэмжээний тухай
- Барих, тээвэрлэх, зөөх үед амьтанд ээлтэй арга барил
- Амьтан хамгаалах шаардлагад нийцсэн барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн тухай
- Амьтанд ээлтэй аргаар амьтныг суллан тавихтай холбогдсон мэдлэг, чадварыг зохих түвшинд зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай.

## 2.7 ЗЭРЛЭГ АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах цогц үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг бол хүний туламж шаардлагатай болсон тэдгээр амьтдад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ юм. Амьтан аврах, асран хамгаалахад чиглэсэн эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээг гагцхүү малын эмч л гардан гүйцэтгэж, холбогдох заавар зөвлөмжөөр ханган, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлэн цэгнэх учиртай. Өөрөөр хэлбэл, хүний тусламж шаардлагатай болсон аль нэг амьтанд чухам яг ямар үйлчилгээ хэрэгтэйг оношлон тогтоох, түүнийг хаана, ямар аргаар эмчлэх, хэрхэн асарч тордох, үр дүн нь ямар болсон, байгальд нь буцаан тавьж болох эсэхийг зөвхөн мал, амьтны эмч л бие даан шийдвэрлэнэ гэсэн үг.

Аврах, асрах хэрэгцээ бүхий амьтдад үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ гэдэг бол тухайн амьтанд анхан шатны үзлэг хийх, оношлох, мэдээ алдуулах, анхан шатны тусламж үзүүлэх, боловсруулсан төлөвлөгөө, аргачлалын дагуу эмчлэх, физиологи, биохимийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд амьтныг зориудаар амь хороон унтуулах, элдэв шалтгаанаар үхсэн амьтны хүүр, сэг зэмийг устгалд оруулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, хорио цээр тогтоох, тусгаарлах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамарсан нэн нарийн нийлмэл үйл явц юм.

Эмнэлгийн үйлчилгээ нь хэдийгээр амьтан аврах, асран хамгаалах чиглэлээр ажиллаж буй мал, амьтны эмч мэргэжилтний хийж гүйцэтгэх үндсэн үүрэгт ажил боловч амьтан аврах, асран хамгаалах салбарт ажиллаж буй амьтан маллагчид болон үйлчилгээний бусад ажиллагсад энэ талын ойлголт, мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай. Ийм ч учраас энэхүү гарын авлагад зэрлэг амьтанд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний зарим асуудлыг дээр дурдсан ажилтнуудад зориулан нэн ерөнхий байдлаар тоймлон авч үзэв.

Ирсэн амьтанд нэн тэргүүнд эмнэлгийн ерөнхий үзлэг хийнэ (Зураг 2.5). Энэ ажиллагаа анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх юм уу эмчилж эдгэрүүлээд байгальд буцааж тавих боломж байгаа эсэх, эсвэл амьтан хамгаалах шаардлагад нийцсэн аргаар унтуулах шаардлагатай эсэхийг тогтооно.

**Эмнэлгийн анхан шатны үзлэг.** Энэ бол аврах, асрах шаардлагатай болсон амьтдад үзүүлэх эмнэлгийн хамгийн анхан шатны үйлчилгээ юм. Энэ үйлчилгээг ихэвчлэн эмч мэргэжилтэн үзүүлнэ. Амьтны эмч анхан шатны үзлэг хийж урьдчилсан оношилгоо тогтоохын тулд тухайн зэрлэг амьтдын талаар зохих мэдээлэлтэй байх нь илүү үр дүнтэй. Үүний тулд эмч, мэргэжилтэн нь хүний туслалцаа шаардлагатай болсон амьтан байгаа газарт тодорхой хугацаанд очих, эсвэл мал эмнэлэгт өвчтөнийг тээвэрлэж аваачих, холбогдох мэдээллийг аль болох дэлгэрэнгүй өгөх гэх мэтээр харилцаатай байж өвчтөний ерөнхий нөхцөл байдалтай танилцах боломжийг бүрдүүлнэ.

Зэрлэг амьтанд анхан шатны үзлэг хийх, тусламж үзүүлэх нь амьтанд их хэмжээний хямрал үүсгэдэг. Амьтны төрөл зүйл, хэмжээ, нас хүйс, зан төрхийн онцлогоос хамаарч амьтны гаргах хариу үйлдэл нь асрамжлагч ба үзлэг хийж буй мэргэжилтэнд эрсдэл учруулах магадлал өндөр тул анхан шатны тусламж үзүүлэхдээ амьтнаа аль болохоор хямралд оруулахаас сэргийлэх, булчин сулруулах ба тайвшруулах эм ашиглах, том хэмжээний буюу аюултай амьтантай ганцаар ажиллахгүй байх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

**Зураг 2.5.** Тусламж шаардлагатай амьтдад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх бүдүүвч



Тусламж шаардлагатай амьтантай аль болохоор богино хугацаанд харьцах, аюулгүй байдлыг хангах үүднээс алчуур даавуунд ороох, нүдийг боох, тариа тарих зэргээр тайван байлгах, тайвшруулах нөхцөлийг хангана. Зөөвөрлөх хайрцаг сав, даавуу зэргийг урьдчилан бэлтгэсэн байна. Том махчин амьтанд галзуу, боом болон бусад халдварт өвчний шинж тэмдэг илрэх, хорт могой, сарьсан багваахай зэрэг өндөр эрсдэлтэй амьтанд зөвхөн мал, амьтны эмч мэргэжилтэн хүрч ажиллах юм уу түүний өгсөн заавар, зөвлөмжийн дагуу холбогдох бусад ажил мэргэжлийн хүмүүс оролцон ажиллана. Эмчилгээ шаардлагатай амьтдын жинг мэдэх нь эмийн тун тогтооход хэрэгтэйг анхаарна уу.

Шаардлагатай хэмээн үзэж буй амьтанд анхан шатны үзлэгийг малын эмч бусад ажиллагсадтай хамтран хийж, тухайн амьтны төрөл зүйл, нас хүйс, эрүүл мэндийн төлөв байдал зэрэг мэдээллийг баримтжуулна. Амьтан хүлээн авсан тухай бүртгэл хийж зураг авч, анхан шатны үзлэгийг тодорхой чиглэлээр шат дараалан явуулна.

**Шийдвэр гаргах нь.** Анхан шатны үзлэгийн үр дүнд мал, амьтны эмч юм уу мэргэжлийн ажилтан нь дараах шийдвэрийн аль нэгийг бие даан гаргана. Үүнд:

1. Тухайн амьтанд эмнэлгийн анхан шатны шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлсний дараа цаашид бие даан амьдрах боломжтой хэмээн үзээд байгальд нь буцаан тавих.
2. Анхан шатны үзлэгээр илэрсэн нөхцөлүүдээс нэг нь, эсхүл хэд хэд нь илэрч байгаа амьтныг асран хамгаалах шаардлагатай гэж үзнэ. Үүнд:

- Хүндээр өвчилсөн амьтан (үзлэгийн үед ямар нэг халдварт өвчин туссан эсэхэд онцгой анхаарах)
  - Хөнгөнөөс дээш зэргийн гэмтэл, бэртэлтэй амьтан
  - Хаягдсан, төөрсөн, бие даах чадваргүй нялх төл амьтан
  - Ган, зуд, үер, аянга цахилгаан, түймэр болон байгалийн бусад гэнэтийн бэрхшээлд өртөж хүний тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай болсон амьтан
  - Идэш тэжээл, унд усны хомсдолын улмаас турж эцэн, хүч тамир нь барагдсан амьтан.
3. Анхан шатны үзлэгээр дараах нөхцөлүүдийн нэг нь, эсвэл хэд хэд нь илэрч буй амьтныг зориудаар унтуулж, амь хорооно. Үүнд:
- Нас ахиж хэт хөгширсний улмаас цаашид амьдрах боломжгүй болсон.
  - Мэдрэлийн тогтолцооны гэмтлийн улмаас хөдөлгөөний эрхтнүүд хэвийн хөдөлгөөн хийх чадвараа (гүйх, авирах, мөлхөх, үсрэх, нисэх эсвэл усанд сэлэх г.м) бүрэн алдсан.
  - Мэдрэлийн тогтолцооны гэмтлийн улмаас орчноо мэдрэх (харах, сонсох, үнэрлэх, амтлах, мэдрэх) чадвараа бүрэн алдсан
  - Өнчирсний улмаас нөхөн сэргэх чадвар нь алдагдаж, бие даан амьдрах чадваргүй болсон.

**Зэрлэг амьтдад үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ.** Янз бүрийн шалтгаан, нөхцөлийн улмаас байгалийн зэрлэг амьтад бэртэж гэмтэх юм уу өвчлөх нь нэлээд элбэг. Эдгээрээс түгээмэл тохиолдох зарим хэлбэрүүдийг дор тоймлон авч үзэв.

**Гэмтэл бэртэл.** Арьс зүсэгдэх, ус ноос, өд сөд нь зулгарах, мөлхөгчдийн сүүл тасрах гэх зэрэг хөнгөн гэмтэл бэртэлтэй амьтдад газар дээр нь эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлж, байгальд нь суллан явуулна.

Хүнд ба хүндэвтэр гэмтэлтэй үед эмч мэргэжилтэн нь тухайн амьтныг цаашид эмчлэх эсэхийг шийдвэрлэнэ. Бага зэргийн бэртэл гэмтлийг эмчлэхэд зориулсан гадаргуу ариутгах үхжилийн эсрэг бэлдмэл, тампон, хөвөн, самбай, хайч, хямсаа зэргийг бэлтгэсэн байна.

**Цус алдалт.** Цус алдалт нь амьтныг цочроож (шок) улмаар үхэлд хүргэх өндөр эрсдэлтэй тул аль болох богино хугацаанд арга хэмжээ авах ёстой. Цус алдалтыг артери, вен ба хялгасан судасны гэж ангилах бөгөөд артерийн цус алдалт нь тод улаан өнгөтэй, шахалттайгаар хүчтэй олгойдож гардгаараа онцлог. Харин вений цус нь хар хүрэн өнгөтэй урсаж гарна. Хялгасан судасны цус нь ягаан бөгөөд шүүрэх байдлаар аажим урсаж гарах бөгөөд цус алдалтын хамгийн түгээмэл түгээмэл хэлбэр болно.

Дотуур цус алдалтын үед амьтдад цустай ханиалгах, цусаар бөөлжих, амьсгаа нь хүндрэх зэрэг шинж тэмдэг илэрнэ. Дотоод цус алдалтыг зогсоож чадахгүй бол амьтан эдгэрэх магадлал тун бага байна. Цус алдалтын цэгийн дээд талд нь шууд даралт үзүүлэх аргаар зогсоож болно. Хүчтэй цус алдалтын үед даралттай боолт тавина. Боолт нь цусаар нэвчин шүүрэх тохиолдолд боолтоо авалгүйгээр дээр нь дахин шинэ боолт тавина. Цус алдалт зогсоох боломжгүй тохиолдолд тухайн амьтныг унтуулах эсвэл мал эмнэлэг рүү хүргэх шийдвэр гаргана.

**Шарх.** Хөнгөн буюу өнгөц шархыг шингэн антисептикээр (бетадин г.м) цэвэрлэнэ. Тухайлбал, шалбархай, ил шарх (зүсэлт), нүхэн шарх (амьтанд хазуулсан ор, гаднын биетээр хатгуулсан г.м) зэрэг болно. Шархаар дамжин халдвар орох нь асуудал дагуулдаг. Шархны төрлүүд:

- Хөхрөлт - энэ бол далд шарх бөгөөд арьсан доогуур цус хурсан байх ба эмчлэх шаардлагагүй.
- Шалбархай - энэ бол ил шарх тул арьсны гаднах давхарга ба цусны судас зэрэг нь ил гарсан байна. Шархыг ариутгаж цэвэрлээд амьтнаа суллаж болно.
- Зүсэлт - Ямар нэг хурц иртэй зүйлээр үүссэн ил шарх, арьс, зөөлөн эд ба булчин зүсэгдсэн байна. Ийм шархыг сайтар ариутгаж, гүн биш бол буцаан тавьж болно.
- Урагдсан шарх - амьтны шүд, хумсаар үүсгэгдсэн ил шарх, арьс ба арьсан доорх эд гэмтсэн байна. Шархыг сайтар ариутгана. Шаардлагатай гэж үзвэл 1-2 хоног хүний асрамжид байлгаад амьтнаа суллаж болно.
- Цоорхой шарх - арьс ба зөөлөн эд хурц шовх үзүүртэй зүйлээр нүхлэгдсэнээс эрхтэн гэмтсэн байж болно. Ийм шархыг сайтар ариутгах гүн шархтай тохиолдолд 1-3 хоног хүний асрамжид байлгаж эмчилнэ.
- Уранхай шарх - арьс ба зөөлөн эд нь хэсэгчлэн буюу бүтэн салсан байна. Энэ тохиолдолд шархыг сайтар ариутгаж, урагдсан арьсыг байранд нь буцаан даралттай боолтоор даруулах ба 1-3 хоног асран эмчлээд суллан тавина.
- Гаднын биет зүйл нэвтрэн орсон ил шарх – Эмч, эмнэлгийн ажилтны заавраар эмчилнэ.

**Яс хугаралт, булгаралт ба суналт.** Яс хугаралт нь ил (яс нь арьснаас ил гарсан), далд буюу битүү (арьс нь гэмтээгүй) гэсэн хэлбэрээр тохиолдоно. Тухайн амьтны хөдөлгөөн, хөндүүрлэж буй биеийн хэсэг зэргийг ажиглаж аль нэг нь мөчөө ашиглахгүй байх, хөндүүрлэж байгаа эсэх, мөчний хэлбэр хэмжээ хэвийн бус, хавдсан, мултгарсан зэрэгт анхаарна.

Тухайн амьтны талаар гаргах шийдвэр нь хугаралт хэдэн яснаас тогтсон, байршил, хугарсан цаг хугацаа, ил буюу хаалттай байдал зэргээс хамаарна. Ил хугарал нь гаднын халдвар орсон байх магадлал өндөр тул хүнд бэртэлд хамаарна. Ийм бэртлийн үед анхан шатандаа даралт үүсгэгдэхгүйгээр боолт хийнэ.

Булгаралт, суналттай үеийн шинж тэмдэг нь далд хугаралттай төстэй байна. Амьтанд стресс үзүүлэхгүйгээр бэртлийг газар авахгүй байдлаар тогтоох буюу бэхэлнэ. Дээрх тохиолдлуудыг малын эмч үзэж оношлоод цаашид эмчлэх эсвэл зориудаар унтуулах шийдвэрийн аль нэгийг гаргана. Эмчлэх тохиолдолд доод талын хугацаа 6 долоо хоног бөгөөд энэ хугацааны төгсгөлд байгальд бие даан амьдрах баталгаа тэр бүр байхгүй гэдгийг санах хэрэгтэй.

**Хэвлийн хөндийн гэмтэл.** Ихэвчлэн механик нөлөөллийн (автомашинд мөргүүлэх, цохиулах, амьтанд өшиглүүлэх, мөргүүлэх, хад чулуунд цохиулах, хөл алдан өнхрөх г.м) улмаас амьтад хэвлийн хөндийн бэртэл, гэмтэлд өртдөг. Ийм төрлийн гэмтлийн үед амьтан цочролд орох, өвдөх, бөөлжих, хавагнах, хөхрөх, гэдэс цухуйж гарах зэрэг шинж тэмдэгтэй байна. Ийм төрлийн гэмтлийн эмчлэгдэх магадлал таруу тул амьтныг унтуулах нь олонтоо тохиолдоно.

**Цээжний хөндийн гэмтэл.** Энэ төрлийн гэмтэл нь хөнгөнөөс хүнд амь насанд аюул учруулах хэмжээний хүртэл байна. Шинж тэмдэг нь өвдөлт, амьсгал хүндрэх, ойр ойрхон амьсгалах, амьсгаадах, гэмтлийн хэсэгтээ бэмбийж хавдах, өнгө хувирах зэрэг болно. Амьсгалын замын хүнд хэлбэрийн хүндрэлтэй амьтны толгой урагш сунаж амьсгаадна. Ийм төрлийн гэмтлийн эмчлэгдэх магадлал муу байдаг тул тухайн амьтныг унтуулах нь олонтоо тохиолдоно.

**Толгой ба нугасны гэмтэл.** Толгой нугасны гэмтэл нь хүнд бэртэлд орно. Ухаан алдах, хэвийн бус зан төрх гаргах, хамар чихнээс цус, тунгалаг шингэн гарах, хүүхэн харааны хэмжээ тэгш бус байх зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.

Хэрэв амьтан ухаангүй байвал хажуугаар нь байрлуулж амьсгалын замыг чөлөөтэй болгоно. Амнаас нь шингэн гарах тул толгой нь хүзүү, цээжнээс арай доогуур байх ёстой. Нуруу нугасны гэмтлийн хамгийн нийтлэг шалтгаан бол зам тээврийн осол байдаг. Ийм төрлийн гэмтэлд сэжиглэсэн тохиолдолд амьтанд тун болгоомжтой хүрнэ. Шинж тэмдгүүд нь нурууны сулрал, хойд хөл нь унжиж, сулрах, өвдөлт, хэсэгчилсэн ба бүтэн саажилт зэрэг хэлбэрээр илэрнэ. Ийм төрлийн гэмтлийн эмчлэгдэх магадлал муу байдаг бөгөөд үзлэгийн дараа ухайн амьтныг унтуулах шийдвэрийг мэргэжилтэн нар гаргана.

**Нүдний гэмтэл.** Нүд нь маш мэдрэмтгий тул алив байдлаар гэмтсэн тохиолдолд амьтандаа сөргөөр нөлөөлнө. Гаднын объект, утаа, шарх нь нүдний гэмтлийн нийтлэг шалтгаан. Нүдэнд гаднын биет орсноор нүднээс шингэн гарах, улайх зэрэг шинж тэмдэг ажиглагдана. Тус биетийг зайлуулах шаардлагатай тул нүдийг нээж цэвэр усаар угаана. Угаагдахгүй бол өөр арга хэрэглэх боловч гаднын биет нь нүд рүү нэвтрэн орсон тохиолдолд оролдохгүй байх нь зөв.

Утаанаас үүдэлтэй нүдний гэмтлийг ус буюу физиологийн шингэнээр угаах байдлаар түргэн тусламж үзүүлнэ. Нүдний шарх нь гаднын биет, утаа зэргээс болж цочрохоос ч илүү хүнд өвчлөлийг үүсгэнэ. Шархтай нүдэнд цус, цуст шингэн ялгарна. Малын эмч үзлэг хийсний дараа эмчлэх юм уу унтуулах шийдвэрийн аль нэгийг гаргана. Хөнгөн гэмтлийн үед анхан шатны тусламж үзүүлсний дараа амьтнаа суллаж тавина.

**Түлэгдэлт.** Амьтны түлэгдэлтийг үнэлэхдээ түлэгдэлтийн гүн (өнгөц, хэсэгчилсэн зузаан, бүрэн зузаан), цар хүрээ (биеийн түлэгдсэн хувь), байршлыг харгалзан үзэх шаардлагатай. Түлэгдсэн амьтны түлэгдэлтийн хэмжээ хөнгөн бол анхан шатны тусламж үзүүлж, эмчилнэ. Анхан шатны тусламж нь хүйтэн усаар шавших, нойтон даавуугаар жин (компресс) тавих зэрэг болно. Түлэгдсэн амьтныг түлэгдэлтээс гадна цочрол, өвдөлт, шингэн алдалтыг нь хам эмчлэх шаардлагатай байдаг. Биеийнх нь 50%-аас дээш хэсэг түлэгдсэн амьтныг унтуулах шаардлагатай.

## 2.8 АМЬТНЫ МАЛЛАГАА, АСАРГААНЫ ҮЕД НИЙТЛЭГ ИЛЭРЧ БОЛОХ ЭМГЭГ

**Стресс.** Энэ бол зэрлэг амьтдын үхэл, өвчлөлд хүргэдэг хамгийн нийтлэг хүчин зүйлүүдийн нэг юм. Стрессийн шинж тэмдэг, жишээ нь хөхтөн амьтдад дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Амьтан дайрах эсвэл зугтахыг оролдоно
- Амьдралын идэвх буурах эсвэл унжийг идэвхгүй болно
- Шүдээ хавирна
- Урд мөч, мөр, цээж, хойд мөчөө долооно.

Стрессийг тайлах үндсэн арга нь тухайн амьтныг тайвшруулж харанхуй, нам гүм, дулаан орчинд тодорхой хугацаанд байлгах явдал юм. Жижиг ба дунд зэргийн хөхтөн амьтдыг уутанд байрлуулж тайвшруулахыг зөвлөдөг.

**Цочрол (шок).** Энэ нь цусны эргэлтийн тогтолцооны уналтаас үүдэлтэй бөгөөд стресс, цусны алдагдал, шингэний алдагдал, цусны даралт буурах, зүрхний үйл ажиллагааны доголдлоос үүсдэг.

Хүнд гэмтсэн амьтад цочролд орно. Цочролын шинж тэмдгүүд нь судасны лугшилт ба амьсгалах нь хурдсах, гипотерми (биеийн температур буурч амьтан чичрэх), буйл нь цагаан эсвэл цайвар өнгөтэй болох зэргээр илэрнэ. Тэгэхдээ цочролын эдгээр шинж тэмдгүүд нь үргэлж илэрхий байдаггүй, шокт орсон амьтан ихэвчлэн нам гүм, бие нь хөрсөн байдгийн анхаарах ёстой.

Цочролыг эмчлэхийн тулд эхлээд стрессийг багасгах (амьтны нүдийг боох), цус алдах шинж тэмдгийг зогсоох, дараа нь амьтныг дулаан, чимээгүй орчинд оруулна. Цочролд орсон амьтанд шингэн өгч болохгүй, зөвхөн дулаацуулсны дараа л бүлээн шингэн бага багаар өгнө.

**Гипотерми (биеийн температурын бууралт).** Биеийн температур буурснаас гипотерми үүсдэг. Гипотермийн шинж тэмдэгт арьс нь хөрөх, идэвхгүй байдалд орох, зүрхний цохилт удаашрах зэрэг орно. Ийм амьтныг дулаацуулах шаардлагатай бөгөөд үүний тулд дулаан уутанд хийх юм уу халуун устай лонх, сав, халаагуур хэрэглэнэ.

Гипотермид орсон үсэн бүрхүүл нь хөгжиж амжаагүй үр зулзага, ангаахай, дэгдээхэйг ойролцоогоор 32 хэмийн, үс болон өдөн бүрхүүлтэй залуу амьтныг 28 хэмийн, бие гүйцсэн амьтныг 28 хэмийн орчинд тус тус байлгана. Дулааны эх үүсвэрийг амьтан байршуулсан байр оромж, тор савны гадна талд байрлуулснаар амьтан нь өөрөө ойртох буюу холдоно. Саван дотор байршуулах тохиолдолд заавал тусгаарлагч жийргэвч ашиглана. Хэт халаахаас сэргийлж тогтмол хянах хэрэгтэй. Бүлээцэж, бээрэнгэ нь гарсан амьтанд шингэн өгнө.

**Шингэний дутагдалд орох.** Биеэс их хэмжээний шингэн алдагдсанаар шингэний дутагдалд орно. Ийм тохиолдолд амьтны бүхий л эд, эрхтэн тогтолцооны хэвийн үйл ажиллагаа доголдож амь насанд аюул учруулж болзошгүй юм. Шингэний дутагдалд орсон эсэхийг амьтны арьсыг татаж үзэн хэр хурдан хэвийн байдалдаа орж байгаагаар нь шалгана (арьсны тургор шалгах). Шингэний алдагдалтай амьтны арьс майхан байдалтай буцаж буухгүй, арьс нь уян хатан бус болсон байна. Нүд нь хуурайших буюу гархилах шинжтэй, нуух нь хуурай байх нь шингэн алдалтай байгааг илэрхийлнэ.

Шингэнийг нөхөхийн тулд жижиг хавтгай саванд усыг бага багаар хийж шимэн уулгах нь зохимжтой. Өөрөө ууж чадахгүй байгаа жижиг амьтанд норгож чийглэсэн зүйлсийг аманд нь хүргэх байдлаар ус уулгана. Амьтны хоолой руу ус хийж болохгүй. Жижиг амьтдыг бодвол том амьтад ус уухгүйгээр илүү удаан тэсвэрлэнэ.

**Гипертерми буюу биеийн температур нэмэгдэх эмгэг.** Биеийн температур нэмэгдсэнээр бөөрний үйл ажиллагааны дутагдалд орох, шокт орох, команд орох, үхэлд хүргэх аюултай. Гипертермийн шинж тэмдэг дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Амьсгал хурдсах
- Шүлс их хэмжээгээр ялгарах
- Урд мөч, мөр, цээж, хойд мөчөө долоох (зарим тохиолдолд шүлс эдгээр хэсэгт хатаж наалдсан байна)
- Салст бүрхүүлд нь цус хурсан
- Тахикарди буюу зүрхний цохилт түргэсэх
- Суулгах
- Шингэн алдах.

Сэрүүн агаарт байлгах юм уу нойтон даавуу, ус зэргийг ашиглан амьтны биеийн температурыг аажмаар бууруулж, сэрүүн чимээгүй орчинд байрлуулна.

**Булчингийн эмгэг буюу доройтол (Миопати).** Амьтан барих явцад их биеийн булчингийн эсвэл зүрхний булчингийн доройтолд орох явдал ялангуяа, өндөр хөгжилтэй шувуу, хөхтөн зэрэг амьтдад гардаг. Бүх насны ба хүйсийн амьтад мэдрэмтгий байдаг. Миопатид орсноор гэнэтийн үхэлд хүргэж болзошгүй боловч зарим тохиолдолд биеийн байдал зэргээс шалтгаалан баригдсанаас хойш хэдэн долоо хоногийн дараа ч үхэх тохиолдол бий. Миопати нь толгой ба хүзүү унжих, хүндээр амьсгалах, чичрэх, хөдөлгөөнгүй болох, хөдөлгөөний уялдаа алдагдах, саажих, унах зэрэг шинж тэмдгээр илэрнэ.

Барьсан амьтныг стрессээс сэргийлэх нь миопати зэрэг бусад эмгэгээс хамгаалах үндсэн арга болно. Иймд эмчилгээ эхлэхийн өмнө барьсан амьтныг тайвшруулах арга хэмжээ авах нь булчингийн эмгэгийг илаарьшуулахад нэн үр дүнтэй.

**Тархи хөдлөх (доргих).** Хэрэв амьтан тархины доргилт авсан (барих явцад тор, хатуу гадаргуу руу мөргөх г.м) байх магадлалтай бол харанхуй орчинд байрлуулж 2-4 цагийн дараа биеийн байдлыг шалгаж, хэвийн байдлаар хөдлөх, зогсох чадвартай байгаа эсэхийг тогтооно. Хэвийн байдалдаа ороогүй бол 24 цаг тайван байлгана.

**Паразитын нөлөөлөл.** Паразитын халдварлал нь анхан шатны тусламж хүргэх хэмжээний асуудал биш боловч амьтны нөхөн сэргэх чадварт ихээхэн саад учруулна. Паразит хорхой буюу гельминтийн халдварлал нь амьтныг эцээж тураана. Мөн олон зүйл паразитууд хүнд халдварлах аюултай. Бүүрэг, бөөс, хачиг зэрэг эктопаразитуудыг шавж устгах инсектицидын тусламжтайгаар устгана. Хачиг, хос далавчтаны өт авгалдайг (гуурын авгалдай) хямсаагаар авч цэвэрлэж болно.

**Халдварт өвчин.** Хүнд, гоц халдварт, эмчлэх боломжгүй халдварт өвчнөөр халдварласан нь тогтоогдвол тухайн амьтныг унтуулна. Энэ нь тухайн амьтанд чиглэсэн хүмүүнлэг үйлдлээс гадна, тухайн нутгийн мал, амьтныг мөн эрсдэлээс хамгаалсан онцгой арга хэмжээ юм. Халдварт өвчинтэй амьтны хүүр, сэгийг газрын гүнд булшлах буюу шатаах замаар устгана.

**Автозамын осол.** Зам тээврийн осолд ангилал зүйн ямар ч бүлгийн, аль ч насны бүхий л амьтад нэрвэдэг. Гэмтэл нь цочрол, хугарал, дотоод цус алдалт зэрэг байна. Осол гэмтлийн зэрэг тодорхойлсны үндсэн дээр анхан шатны тусламжийг ямар түвшинд үзүүлэх, аль эсвэл эмчилгээнд өгөх, унтуулах зэргийг шийдвэрлэнэ. Ихэнх тохиолдолд анхан шатны тусламж үзүүлээд буцаан тавьдаг, хүнд гэмтэлтэй амьтныг унтуулна.

**Махчдын дайралтад өртөх.** Махчин амьтдын дайралтад өртсөн амьтад ихэвчлэн янз бүрийн шархтай байдаг. Ил шарх нь зөвхөн механик гэмтлээс гадна, халдвар үүсгэгч нэвтэрсэн байх магадлал тун өндөр. Ил шархыг ариутгаж гаднын нөлөөнөөс хамгаалж бооно.

**Хордлого.** Амьтад хорыг залгих, амьсгалах ба биеийн гадаргуугаар шингээх байдлаар авах боломжтой. Мөн зэрлэг амьтад төрөл бүрийн хоронд хордож үхсэн амьтдыг идэж хордох нь олонтоо тохиолдоно. Хордлоготой болохыг доорх шинж тэмдгүүд илэрхийлнэ. Үүнд:

- Бөөлжих
- Шүлсээ гоожуулах
- Булчингийн чичирхийлэл
- Уялдаагүй хөдөлгөөн
- Таталт
- Саажилт
- Кома
- Үхэл.

Хордлогын шинж илэрсэн тохиолдолд малын эмч эмчилгээ хийх эсэхийг шийдвэрлэнэ.

## 2.9 АМЬТНЫ МАЛЛАГАА, АСАРГААНЫ ҮЕД АНХААРАХ ЗҮЙЛС

Амьтны маллагаа, асаргаа гэдэг бол нэг талаас амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжлийн ажилтан, амьтан маллагч болон үйлчилгээний бусад ажилтан, ажиллагсад, нөгөө талаас хүний тусламж шаардлагатай болсон амьтны хооронд өрнөж буй бүх төрлийн харилцан үйлчлэлийг багтаасан нэн өргөн хүрээтэй ухагдахуун юм.

Маллагаа, асаргааны мөн чанар нь тухайн амьтанд өвдөлт зовлон, шаналлыг аль болох бага мэдрүүлэх, улмаар уг амьтныг богино хугацаанд илаарьшуулан эдгээж, тэнхрүүлээд байгальдаа бие даан амьдрах чадвартай болоход нь тус дэмжлэг үзүүлэхэд оршино. Иймд тусламж шаардлагатай болсон амьтны маллагаа, асаргаа гэдэг нь тухайн амьтныг хээрээс анх олж анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх тэр мөчөөс эхлэн, хэрэв түүнийг амь хороож устгалд оруулахааргүй бол эмчлэн илаарьшуулж, тэнхрүүлээд цаашид төрөлх байгалийн орчиндоо бие даан амьдрах нөхцөл хангагдах хүртэл үргэлжлэх үйл явц болно.

Зан төлөвийн хариу үйлдлээ харуулах хангалттай орон зайг амьтдад бэлтгэж өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, хүний асрамжид орсон амьтад хэвийн амьдарч, зан төрхөө чөлөөтэй илэрхийлэх боломж олгохуйц тийм орон байрны орчныг бий болгох ёстой. Амьдрах орчин таатай биш байх нь амьтдын зан төрх, физиологи, биохимийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, эдгэрэн илаарьших, дасан зохицох үйл явцыг удаашруулах эсвэл бүр үр дүнгүй болгох аюултай.

**Үүрэг, хариуцлага.** Амьтан тэжээх болон арчлах ажил төвийн дарга болон түүний орлогчийн хариуцлагад хамаарна. Эдгээр хүмүүсийн шийдвэргүйгээр амьтан тэжээх, услах болон бусад арчилгаа хийгдэхгүй. Амьтны шаардлагад нийцсэн орчин бүрдүүлсэн бөгөөд зүй ёсны арчилгаа хийх боломжтой амьтныг л хүлээн авч үйлчилгээ үзүүлнэ. Амьтныг хөндлөнгийн хүн арчлахыг хориглоно.

Байнгын арчилгаа маллагаа шаардахгүй амьтдад тавих тэжээл, усны чанар, хэмжээг малын эмчтэй зөвлөн шийднэ. Байнгын эмчилгээ шаардлагатай тохиолдолд жишээ нь, арьс, үсэн бүрхүүл, өдөн бүрхүүлийг тордох, хумс тайрах болон бусад шаардлагатай тордолт, арчилгааг эмчийн заавраар хийнэ. Нялх залуу болон зан төрхийн өөрчлөлтөд орсон амьтанд илүү тордлого шаардагдана.

**Амьтын эрүүл мэндийн талаар.** Амьтан аврах, асран хамгаалах үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд нь амьтны эрүүл мэнд, тав тухыг хангахад баримтлах журам, заавар боловсруулж, дагаж мөрдөнө. Зааварт микробиологийн хяналт, амьтны эрүүл мэндэд хямрал үүссэн үед ажиллах горим, шинээр ирсэн амьтныг бүртгэх, үзлэгт хамруулах тухай тодорхой тусгасан байна.

Аврах, асран хамгаалах байранд байгаа амьтны эрүүл мэнд, асаргаа маллагааны явц, үр дүнг мэргэжлийн ажилтан, амьтан маллагч нар өдөр бүр тогтмол хянаж, бүртгэл, тэмдэглэл хөтөлж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ. Болзошгүй эрсдэлээс хамгаалах, сэргийлэх үүднээс ажилчдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг хангасан байна. Амьтан аврах, асран хамгаалах аливаа байгууламжид зөвшөөрөлгүй хүн орохыг хориглоно. Тодорхой шалтгааны улмаас удаан хугацаагаар эмчлэх шаардлагатай тохиолдолд зүйлийн онцлогоос хамаарч дараах зүйлийг онцгой анхаарах ёстой. Үүнд:

- Гадаад, дотоод шимэгчтэй тэмцэх (шимэгч хорхой, хачиг, гуур, бөөс г.м)
- Болзошгүй бүх халдварт өвчний эсрэг урьдчилан сэргийлэх тарилга хийх.

Эмнэлгийн үйлчилгээ, тарилга хийх ажлыг малын эмч, эсвэл түүний заавраар зохих дадлага эзэмшсэн маллагч хийнэ. Аврах үйл ажиллагаанд орсон амьтан өвчтэй эсвэл өвчтэй байж болох сэжиг илэрвэл эмчид яаралтай үзүүлнэ. Малын эмч авран хамгаалах үйл ажиллагаанд байгаа амьтдыг байнга үзэж аливаа өвчний илрэл, гадна, дотор шимэгчид, зан төрхийн өөрчлөлт зэргийг цаг алдалгүй илрүүлж, шаардлагатай эмчилгээ хийнэ. Тэрээр амьтны тэжээл, арчилгаа, байр савны талаар удирдлагад зохих зөвлөгөө өгнө.

### 2.9.1. Хорио цээр, тусгаарлах болон дасан зохицох үе

Хорио цээр (карантин) гэдэг нь хүний асрамжид шинээр болон дахин ирсэн амьтдыг тодорхой хугацаанд бусад амьтдаас тусгаарлан байлгах үйл явц юм.

Шинээр ирсэн амьтдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, ямарваа өвчин тархах аюулаас хамгаалахад хорио цээр чухал үүрэгтэй. Хорио цээрийн үргэлжлэх хугацаа нь тухайн амьтны эрүүл мэндийн байдлаас шалтгаалж харилцан адилгүй байх ба үүнийг гагцхүү малын эмч, мэргэжилтний шийдвэр, заавар зөвлөмжийн дагуу тухайн орчинд хэсэгчлэн зохион байгуулна.

Хорио цээр, тусгаарлалт явуулах зорилго нь:

- а. Халдварт өвчний эрсдэлээс бусад амьтдыг хамгаалах
- б. Зоонозын халдвараас хүнийг хамгаалах
- в. Хүний хараа хяналт, асаргаанд орж буй амьтдын дасан зохицох чадварыг дээшлүүлэх зэрэг болно.

Үзлэг, оношилгооны үр дүнд халдварт өвчтэй болох нь тогтоогдсон амьтдыг хорио цээрийн арга хэмжээнд хамруулна.

Тусгаарлалт нь бусад амьтан болон хүн ямар нэг өвчний халдвар авах эрсдэлийг бууруулах ач холбогдолтой. Эрсдэлийн бүлэгт хамаарах магадлалтай амьтдыг заавал тусгаарлах шаардлагатай. Мөн үзлэгээр халдварт өвчтэй болох нь бүрэн гүйцэд тогтоогдоогүй ч сэжигтэй хэмээн үзсэн амьтныг зохих хугацаагаар тусгаарлана. Шинээр ирж байгаа амьтныг хүлээн авахдаа хаанаас гаралтай болохоос хамаарч тусгаарлах, түүнчлэн дасгахад тохиромжтой тайван орчинд байлгана.

Дасан зохицох үе гэдэг бол тээвэрлэлтийн явцад тухайн амьтанд үүссэн мэдрэлийн хямралыг засаж тайвшруулах, амьдралын шинэ орчин нөхцөл, цаашлаад тэднийг асарч халамжилж буй үйл ажиллагаанд дасан зохицоход маш чухал үүрэгтэй зурвас хугацаа юм.

Шинээр ирсэн амьтан харьцангуй эрүүл, сэргэлэн цовоо байсан ч гэсэн дасгах хугацааг заавал дамжуулах шаардлагатай. Харин дасан зохицох үеийн үргэлжлэх хугацаа нь тухайн амьтанд стресс хэр үргэлжилсэн (ер нь стрессийн түвшин нь ихэвчлэн зөөвөрлөлт ямар зайд, хир хугацаанд үргэлжилснээр тодорхойлогддог), цочролын түвшин, тэдний нас, эрүүл мэндийн байдал, амьдрах орчны нөхцөлийн өөрчлөлт гэх зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байна.

### 2.9.2. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх арга, бодис урвалж ба халдвар, хамгааллын хувцасны тухай

Өвчтэй ч онош тодорхой бус зэрлэг амьтдын байр, хэрэглэгдэхүүн, ялгас, хоолны үлдэгдэл зэргийг Мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн зааврын дагуу ариутган халдваргүйжүүлнэ. Боом, ям, хулгана яр, дуут хавдар, зогсоо, үхрийн мялзан, шүлхий зэрэг өвчний үед зэрлэг амьтдын арьс, шир, үс ноос, эвэр туурайг авч ашиглахыг хориглох бөгөөд шууд устгана. Боомын сэжигтэйгээр үхсэн зэрлэг амьтны хүүрийг задлахыг хатуу хориглоно.

**Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх үндсэн арга.** Тухайн нян, вирусийн тэсвэрт чанар, онцлог, халдваргүйжүүлэлт хийх объектын шинж байдлаас шалтгаалж харилцан адилгүй аргаар ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийнэ. Мал, амьтны эмнэлгийн байгууллагаас хэрэгжүүлэх халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ нь үндсэн зорилгын хувьд хүн эмнэлэгтэй ижил төсөөтэй боловч технологийн бага зэргийн ялгаатайгаар доорх хэд хэдэн аргыг хэрэглэнэ. Үүнд:

**Механик цэвэрлэгээ.** Энэ нь халдваргүйжүүлэлтийн өмнөх бэлтгэл үе бөгөөд амьтны хэвтэр, хашаа хороо, тэжээлийн хог хаягдал, хашаа, байр, оромжийн шал, хана, тааз, орох, гарах хаалга зэрэгт наалдсан болон бусад хэлбэрээр бохирдсон өвчин үүсгэгчийг механик аргаар цэвэрлэж, эмгэг төрүүлэгчдэд халдваргүйжүүлэгч бодисын үзүүлэх үйлчилгээ, нөлөөг сайжруулах ач холбогдолтой.

**Химийн арга.** Аливаа нян, вирусээр бохирлогдсон объектыг химийн янз бүрийн бодис, бэлдмэлүүдийг тохирох хэмжээ, хувиар бэлтгэн, тодорхой хугацаагаар үйлчлүүлж халдварыг аюулгүй болгох арга юм.

Химийн халдваргүйжүүлэлтийг ихэвчлэн уусмал байдлаар хийхийн зэрэгцээ мананцаржуулах эсвэл нунтаг хэлбэрийг ч бас ашиглана. Химийн аргыг мал амьтны хашаа байр, хэвтэр бууц, дэвсгэр, өвс тэжээл, газрын хөрс, бэлчээр, багаж хэрэгсэл, хог хаягдлыг халдваргүйжүүлэхэд өргөн хэрэглэнэ.

Химийн бодисоор хийх халдваргүйжүүлэлтийг уг үйл ажиллагаанд хэрэглэх бодис, урвалжаас шалтгаалан дараах байдлаар ангилна. Үүнд: шүлтийн, хүчлийн, хлорт нэгдлийн, фенолын, хүнд металын, формальдегидийн халдваргүйжүүлэлт гэх мэт.

Хэдийгээр халдваргүйжүүлэлтэд дээр дурдсан олон төрлийн бодис, бэлдмэлийг ашиглах боломжтой ч амьтны байр оромж, өрөө тасалгааны шал, хаалганы бариул, ширээ, сандал зэрэг бүх гадаргууг 250-500 мг/л хлор агуулсан хлорын бодис эсвэл 100 мг/л хлорын давхар ислийг агуулсан халдваргүйтгэлийн бодисыг түгээмэл ашиглаж ариутгана. Хлор агуулсан халдваргүйжүүлэгч уусмалаар арчиж 15-30 минутын турш халдваргүйтгэнэ. Угаалгын өрөөний шал, ханыг 15-30 минутын турш 500 мг/л хлор байхаар тооцож бэлдсэн халдваргүйтгэлийн уусмалаар шүрших эсхүл арчина. Бохирдуулагч ихтэй цус, бөөлжис, ялгадас зэрэг биологийн шингэнийг халдваргүйжүүлэхдээ халдваргүйжүүлэх бодисын тунг зохих хэмжээгээр нэмэгдүүлж болно.

Халдваргүйжүүлэх бодисын уусмал бэлтгэхдээ аюулгүй байдлыг хангах үүднээс бээлий, хормогч, нүдний шил болон зааварт тусгагдсан бусад хэрэгслийг ашиглана.

Өвчтэй, сэжигтэй амьтан байгаа байр, хашааны үүдэнд халдваргүйжүүлэх уусмал бүхий дэвсгэр эсвэл хөл онгоц байрлуулсан байна. Хүйтний улиралд халдваргүйжүүлэх уусмал дээр хоолны давс 10%-аар тооцож нэмнэ.

Амьтантай ажилласны дараа гараа сайн савандаж угаах ба гарын ариутгалд 0.5% иодын уусмал, 70% спиртийг ашиглана. Уусмалаар 1-3 минутаар 2 удаа арчих, мөн хлор, устөрөгчийн хэт исэл агуулсан нэг удаагийн гар ариутгагч бодис хэрэглэж, өөрөөр нь хатаана.

**Физикийн арга.** Энэ нь нарны гэрэл, галын дөл, буцалсан ус, усны уур, хэт ягаан туяа, хатаалт, өндөр нам температур, өндөр давтамжит цахилгаан гүйдэл, хэт богино долгион зэрэг физик хүчин зүйлийг ашиглаж явуулах арга юм. Амьтан аврах, асран хамгаалах байр, оромжийн

ариутгалыг хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэх бол хүчин чадал нь 1.5 ватт/м<sup>2</sup>-аас багагүй, өндөр нь 1.8-2.2 м, хугацаа доод тал нь 30 минут байна.

**Биологийн арга.** Энэ арга нь байгалийн юмс үзэгдлийн өөрийн дотоод чанарыг ашиглан халдварт өвчин үүсгэгчийг гадаад орчны хүрээлэл дотор устгахыг хэлнэ. Тухайлбал, аливаа өвчний үүсгэгчийн эсрэг үйлчлэх антигонист бичил биетнүүд болон байгалийн үзэгдлийг ашиглаж болно. Үүнд: биотермийн, фитонцидийн зэргийг дурдаж болно.

**Ариутгал халдваргүйжүүлэлтэд ашиглах бодис, урвалж.** Халдваргүйжүүлэлтэд Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн дараах төрлийн химийн бодис, бэлдмэлийг ашиглана.

Хлорлог бодис:

- Хлорамин хуурай ба уусмалаар 0.2% - 10%
- Хлорын шохой хуурай ба уусмалаар 3% - 10%
- Гипохлорид кальц хуурай ба уусмалаар 3% - 7%
- Гипохлорид натри хуурай ба уусмалаар 0.1% - 2%
- Жамелион уусмалаар 0.015% - 0.5%

Спирт:

- Этилийн спирт уусмалаар 60%-96%
- Изопропилийн спирт 60%

Иодлог бодис:

- Иод форм
- Иодинал усмал (Химодин – 0.1%, калиид – 0.9%)
- Поливидон иодын усмал 10%
- Иодинат, тамелин

Альдигед5

- Формалин уусмалаар 5-10%
- Глютаральдегид 2%
- Салидекс 2%

Фенолийн бүлгийн бодисууд:

- Фенол, Тимол, Крезол, Хлорфенол, Гексахлорфен зэрэг

Бусад бодис:

- Устөрөгчийн хэт исэл 1% -6%
- Виркон (Персульфит кали) 2%
- Идэмхий натри, идэмхий кали
- Килса, түүхий шохой.

**Ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажилтан нэг бүрийн хэрэглэх халдвар, хамгааллын хувцас болон хөдөлмөр аюулгүй байдал хангах хувцасны тухай.** Халдвар хамгааллын хувцас хэрэглэх нь халдвартай болон халдварын сэжигтэй эмгэгт материал, амьтантай харьцах, лабораторид ажиллах үед малын эмч, шинжээч, туслах ажилтныг халдварт өртөх эрсдэлээс хамгаалах өндөр ач холбогдолтой. Хүн нэг бүрийн халдвар, хамгааллын хувцасны иж бүрдэлд дор дурдсан зүйлс багтах ба эдгээрийг ойролцоогоор 20 см х 25 см хэмжээтэй гялгар уутанд нэгтгэн багцалж урьдчилан бэлдсэн байна.

Багц тус бүр 0.5-0.7 кг жинтэй байна. Халдвар, хамгааллын хувцасны иж бүрдэл нь амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үед зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэг удаа 2 цагийн турш өмсөж хэрэглэх зориулалттай бөгөөд дараах зүйлүүдээс бүрдсэн байна. Үүнд:

- Амны хаалт (маск) N-95, эсвэл амьсгалын хошуувч. Энэ нь амьсгалын замаар халдвар авахаас хамгаална.
- Арьс хамгаалах зориулалттай, нэг удаа ашиглах өмд, цамц, гутал. Эдгээрийг комбинезонтой хослон хэрэглэнэ. Комбинезон нь ажиллагч хүний биеийн арьс, ажлын хувцсыг биологийн бохирдлоос хамгаална. Комбинезоныг усанд тэсвэртэй материалаар хийсэн байна. Комбинезоны дотуур нэг удаа ашиглах өмд, цамцыг өмсөнө.
- Дотор талд өмсдөг винил бээлий (4 мм)
- Гадна талд өмсдөг нитрил бээлий (4-11 мм). Энэ 2 төрлийн бээлийг дэс дараагаар нь давхарлан өмсөнө. Энэ 2 төрлийн бээлийг хатгалтад тэсвэртэй тусгай технологийн дагуу үйлдвэрлэсэн байдаг.
- Гутлын гадуур өмсдөг нэг удаагийн углааш. Комбинезон өмссөний дараа гутлын гадуур углаашийг давхар углаж өмсөнө.
- Ус үл шингээгч хормогч. Үүнийг комбинезон дээрээ өмсөх бөгөөд комбинезоныг гаднын элдэв бохирдлоос хамгаалах үүрэгтэй.
- Хамгаалалт бүхий нүдний шил. Энэ нь үсэрсэн эмгэгт материал, шингэн зэргээс нүд, нүүрийг хамгаална. Нүдний шил нь нүдний тойронд нягт сууж яг таарсан байх ёстой. Ердийн нүдний шилийг хамгаалалтын шилний оронд хэрэглэхийг хориглоно. Хамгаалалтын шилийг нүдний харааны шилэн дээр давхар зүүж болно.
- Гар ариутгах зориулалт бүхий изопропилын спирт шингээсэн тампон юм уу цаасан алчуур. Гадна талын бээлийг тайлахын өмнө эдгээрээр арчиж бохирдлоос цэвэрлэнэ.
- Хатуу гадаргуутай хэсгийг арчиж, халдваргүйжүүлэх зориулалт бүхий нойтон цаасан алчуур. Эмгэгт материал, шингэнээр бохирдсон байж болох арьс, хувцсыг тайлсны дараа дотор талын бээлийг халдваргүйжүүлж цэвэрлэхэд ашиглана.
- Хог хаягдал хийх уут. Ашигласан халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг энэ уутанд хийж устгах арга хэмжээ авна.
- Халдвар, хамгааллын хувцасны багцыг ашиглах зааварчилгаа зэрэг болно.

### 2.9.3. Амьтан аврах, асран хамгаалах байранд өвчин тархахаас хамгаалж, сэргийлэх нь

Мэргэжлийн ажилтан, амьтан маллагч нь цэвэр хувцаслаж аль болохоор олон удаа хувцсаа сольж, тогтмол угаах цэвэрлэнэ. Ажлын гутал нь ариутгах боломжтой байх бөгөөд байнга цэвэрлэнэ. Амьтны өрөө цэвэрлэх, дээж авах, задалгаа хийх үед нэг удаагийн бээлий, маск хэрэглэнэ. Ажлын байр нь гар угаах ба ариутгах нөхцөлийг хангасан байна. Ажиллагсдын цайлах, хооллох, тамхи татах зориулалтын байр нь амьтны гаралтай хог хаягдалгүй, цэвэр ариун нөхцөлийг хангасан байна.

Амьтан маллагчид, ажиллагсдад зооноз өвчний талаар сургалт явуулж, хувийн ариун цэвэр сахих дүрмийг тогтооно. Ажиллагсад татран ба галзуугийн (хөхтөн амьтадтай ажилладаг бол) вакцин заавал хийлгэсэн байна. Жирэмсэн ажилтан нар эмчийн зөвлөгөө авч ажиллана. Зэрлэг амьтдын аврах, асран хамгаалах байранд ялангуяа, өвчтэй амьтдын байранд хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, дархлаа суларсан хүмүүс нэвтрэхийг хориглоно. Махчид, сарьсан далавчтан зэрэг галзуу өвчний дамжуулагч амьтдыг асран хамгаалагч нар нь сургалтад хамрагдаж зохих мэдлэг, чадвар эзэмшсэн байна.

Задалгааны өрөөнд ажлын халат, мэс заслын маск, бээлийтэй (зарим тохиолдолд нүдний хамгаалалттай) ажиллах бөгөөд хэрэглэсэн багаж, ширээ савыг ариутгаж, гарсан хогийг зохих дүрэм журмын дагуу устгалд оруулна. Амьтны гаралтай дээж, сорьцыг хоол хүнсний зориулалтаас тусдаа хөлдөөгч юм уу хөргөгчид хадгална. Эмч, мэргэжлийн ажилтан зэрлэг амьтны сэг зэмийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг удирдан зохион байгуулна.

**Устгал.** Зориуд устгаж унтуулсан эсвэл үхсэн амьтны хүүр, сэг, зэм, халдвартай материалыг сайтар битүүмжилж, зөөвөрлөхдөө ариун цэврийг чанд мөрдөж булшлах газарт хүргэсний дараа ашигласан машин техникээ цэвэрлэн ариутгана.

Булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ орон нутгийн төрийн захиргаа, хууль хүчний, онцгой байдлын болон мал, хүн эмнэлгийн мэргэжлийн байгууллага, байгаль орчны албадтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр устгах арга, булшлах газрыг сонгох ба устгах, булшлах, халдваргүйжүүлэх арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлнэ.

Булшлах газрыг сонгохдоо хөрсний ус, нуур, голын эргээс хол зайтай, улсын болон орон нутгийн чанартай авто болон төмөр зам, нутгийн шүтлэгтэй уул, овооноос зайдуу, мал, хүний суурьшил сийрэг, үерийн усанд автахааргүй, өндөрлөг, хуурай хөрстэй, зонхилох салхины чиглэлийн эсрэг талд байрлах зэрэг шалгуурыг харгалзана.

Булах ажлыг гүйцэтгэж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг сайтар хангах, хүн, мал, амьтан, шувуунд халдвар дамжихаас сэргийлэн булшлах ажлыг богино хугацаанд түргэн шуурхай гүйцэтгэх ба байгаль орчинд ямар нэгэн хор, аюулгүй байх нөхцөлийг урьдчилан тооцсон байвал зохино.

**Аюултай амьтантай харьцахад юуг анхаарах вэ?** Зэрлэг амьтан адуулахад хүнд элдэв эрсдэл, аюул учруулахгүй байх нөхцөлийг хангасан байх ёстой. Биеийн хэмжээ, хүч чадал, ялгаруулах хор, өөрийгөө хамгаалах хэрэгсэл (хурц соёо, эвэр, туурай, хорт шүд г.м), зан төрх нь хүнд эрсдэл үүсгэхээр бол аюултай гэж үзнэ.

Ийм нөхцөлд амьтан бүрд зориулсан аюулгүй ажиллагааны арга хэмжээг хангаж мөрдөнө. Сахин хэрэгжүүлэх аюулгүй ажиллагааны зааврыг удирдах хүмүүс хариуцна боловсруулж, ажиллагсдад зааж сургана.

Аюултай амьтдыг барих багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж (тор, бариултай тор, унтуулах багаж, буу, хамгаалах зааварчилгаа г.м)-ийг шаардлагатай хэмжээгээр урьдчилан бэлдэж, бэлэн байлгана. Аюултай амьтантай харьцах заавар, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө гаргасан байна. Төлөвлөгөөг холбогдох байгууллагатай зөвшилцсөн байна. Хор ялгаруулах амьтан адуулах нөхцөлд тухайн чиглэлээр мэргэшсэн эмчийн оролцоотойгоор аюулын үед дагаж мөрдөх арга хэмжээг төлөвлөсөн байна. Хорны эсрэг үйлчлэлтэй бодис бэлэн байх ёстой.

## 2.10 ЗЭРЛЭГ АМЬТНЫ АНГИЛАЛ ЗҮЙН БҮЛЭГ БҮРИЙН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ АЖЛЫН ОНЦЛОГ

Эрсдэлд орж хүний тусламж шаардлагатай болсон амьтантай хэрхэн харьцах талаар гарсан дэлгэрэнгүй гарын авлага бий. Энэ хэсэгт газрын сээртнийг аврах, асран хамгаалах ажил ангилал зүйл бүлэг бүрд (хөхтөн, шувуу, хоёр нутагтан, мөлхөгч) чухам ямар онцлогтой болохыг цухас танилцуулах болно.

### 2.10.1. Хөхтөн амьтадтай зөв харьцах онцлог

Хөхтөн амьтад нь түүхэн хөгжлийн явцад олон янзын амьдрах орчныг эзэмшин тархсан өндөр хөгжилтэй бүлэг амьтад билээ. Хөхтөн амьтад нь амьдрах орчин, идэш тэжээлийн онцлог, бусад амьтадтай харилцах чадвар, мэдрэлийн систем, мэдрэхүйн эрхтний нарийн хөгжил зэрэг олон хүчин зүйлээс хамааран олон янзын зан төрхтэй болон хөгжсөөр иржээ. Тухайлбал, довтлох, зугтах, нуугдах, түрэмгийлэх зэрэг олон янзын зан төрхтэй бөгөөд эдгээр шинжид тохируулан харьцах шаардлагатай.

Орчин үед хүний үйл ажиллагааны шууд ба дам нөлөөгөөр Монгол орны зэрлэг хөхтөн амьтдын тархац, байршил, амьдрах орчин өөрчлөгдсөөр байна. Түүгээр ч барахгүй хөхтөн амьтад хүний нөлөө, хууль бус агнуурын нөлөөгөөр гэмтэх, шархдах, өнчрөх зэргээр эрсдэлд орохын зэрэгцээ байгалийн ган, зуд, түймэр зэрэг гэнэтийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр эрсдэлд орох нь нэмэгдсээр байна. Эдгээр амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу эрхлэхийн тулд тухайн амьтны зан төрхийн онцлогийг сайн мэдэж харьцах нь чухал.

Асаргаанд буй гэмтсэн, өвдсөн, шархадсан амьтад стресс ихтэй байдаг тул дараах дүрмийг баримтлан харьцана. Үүнд:

- Амьтан маллагч болон мал амьтны эмч нар хөхтөн амьтантай харьцах дүрмийг баримтлан ажиллана. Тухайн амьтны зан төрхөд тохируулан харьцах аргыг эзэмшсэн байна.
- Шавж идэштэн, сарьсан багваахай, мэрэгч амьтад нь хурц жижиг шүдтэй тул хазуулахаас болгоомжилно. Эдгээр амьтад нян, вирусийн халдвар тарааж болзошгүйг анхаарах
- Мах идэшт амьтад хүчирхэг хурц, бахим шүдтэй тул хазах, довтлох, ярдаглах зан төрхтэй тул хувийн хамгаалах хэрэгсэлтэйгээр харьцах
- Махчин амьтдын эмчилгээ, тордлогоо хийх үедээ зориулалтын ширэн хошуувч өмсүүлэх, нүдийг далдлах, зориулалтын зузаан бээлий ашиглах зэргээр болгоомжтой харьцах
- Шархтай махчин амьтад илүү стресстэй байх тул шууд довтлох аюултайг анхаарах
- Эвэр, туруу томтой биеийн жин ихтэй буга, хандгай, цаа буга, бор гөрөөс, аргаль, янгир, бөхөн, зээр зэрэг туруут амьтад мөргүүлэх, тийрүүлэхээс сэргийлэх
- Хулан, тахь, хавтгай зэрэг том туурай, тавхайтай урт хөлийн амьтад өшиглөх, тийрэх, хазах зэргээр олон янзын зан төрхтэйг анхаарч болгоомжтой харьцах
- Эдгээр тураг амьтдын эмчилгээ, үйлчилгээг тусгай зориулалтын хөдөлгөөнийг хязгаарласан өрөө, хашаанд оруулж хийнэ.
- Асаргаа, эмчилгээнд буй хөхтөн амьтадтай харьцахдаа нүдийг шир, даавуу, савхи зэрэг материалаар далдлан боох, зориулалтын уут толгойд нь углах зэрэг аргыг хэрэглэнэ.

Шаардлагатай тохиолдолд тураг амьтад болон махчин амьтадтай харьцахдаа малын эмчийн зөвлөгөөний тусламжтайгаар түр тайвшруулах эм, эмнэлгийн хэрэгсэл ашиглаж болно.

## 2.10.2. Тусламж шаардлагатай болсон шувууг асрах, авран хамгаалах ажлын онцлог

Манай орны нугаламт амьтдын дотор шувуу зүйлийн баялаг, тархалт, хаа сайгүй тохиолдох байдлаар хамгийн түгээмэл амьтанд орно. Энэ үүднээс зэрлэг шувуудад элдэв гэмтэл бэртэл учрах магадлал өндөр, тэр хэмжээгээр тэдэнд хүний зүгээс гараа сунгаж, туслалцаа үзүүлэх шаардлага байгаль хамгааллын салбарын анхаарал хандуулах чухал сэдэв болж байна.

Зэрлэг шувууд гэмтэж, бэртэх шалтгаан үй олон бөгөөд ихэнх нь улам бүр өргөжин тэлэх хандлагатай байна. Гол шалтгаанд:

- Хөдөө аж ахуй, үйлдвэр, уул уурхай, дэд бүтцийн барилга байгууламж нэмэгдэх хэрээр амьдрах орчин сүйдэх, хумигдах нь элбэг болж байна
- Замын нөхцөл сайжирч, сүлжээ өргөсөх бүр шинэ нөхцөл байдалд хурдан хугацаанд дасаж чадаагүйгээс шувууд авто тээврийн осолд өртөж, гэмтэх нь улам бүр нэмэгдэж байна
- Хот суурин газарт бий болж байгаа шилэн барилга, байгууламжийг шувуу мөргөж гэмтэх хандлага нэмэгдэж байна
- Сүүлийн жилүүдэд нарны эрчим хүч ашиглах зориулалтаар том бага оврын салхин сэнс бий болж байгаа нь шувуунд эрсдэл учруулах нэг шинэ нөхцөл болж байна
- Хөдөө аж ахуй, цэцэрлэг, хотын ногоон байгууламжид химийн хорт бодис цацсанаас хордох, идэш тэжээлээр хомсдох
- Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг байгальд ээлтэй байгуулаагүй, тэнд хийх арчилгаа тордлогоо зохистой бус байгаагаас ногоон байгууламжийн мод, сөөг, газар дээр үүрлэдэг шувуудад таагүй нөхцөл бий болгож байна
- Нутгийн уугуул биш атлаа амьдрах чадвартай мод, сөөг ногоон байгууламжид тарих нь нутгийн шувуудад үүрлэх, хоргодох, хооллох орон зайг бүрдүүлж чадахгүй байна
- Нуур, гол мөрний ус бохирдож, эргийн ургамал нөмрөг талхлагдсанаас ус, намгийн шувуудын үүрлэх, хоргодох нөхцөл тохиромжгүй болох
- Хөдөө орон нутгийн уудам орон зайд өндөр хүчдэлийн шугам барьж байгуулахдаа шувуу хамгаалах нэмэлт төхөөрөмжийг орхигдуулах эсвэл уг төхөөрөмжийг буруу технологиор байрлуулснаас махчин шувуу болон бусад олон зүйл шувуу олноор гэмтэх болсон зэрэг үй олон шалтгааныг дурдаж болно.

Хүн хөгжлийн төлөө байгалийн баялгийг эзэмшихдээ зөвхөн эдийн засгийн үр ашгийг гол болгоод байгалийн нэгдмэл байдал алдагдах, амьдрах орчин доройтох, шим мандлын өөрөө өөрийгөө нөхөн сэргээх чадварыг алдагдуулахад чиглэсэн алсын хараагүй харалган бодлого газар авч байгаа нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд харш зүйл юм. Хүн ба зэрлэг амьтдын хооронд зөрчил үүсэх хандлага улам бүр газар авч байгаа нь энэ бүхнийг илтгэх энгийн нэг жишээ, бодит баримт болно. Шархдаж, гэмтсэн шувууд бол бусад бүх амьтны нэгэн адил байгалийн нийлмэл тогтолцооны нэг хэсэг.

Хот, суурин газар үүрлэх шувуудын үүрээ орхисон залуу шувууд хүнээс дайжих нь бага учир амархан баригдана. Зохих бэлтгэлгүй хүн байгаль дээрээ илүү чөлөөтэй, дураараа өсөх боломжтой байсан ийм шувууг “хаягдсан” шувуу хэмээн андуурч гэртээ асарч бойжуулах нь үндсэндээ буруу үйлдэл юм. **Нэгд**, ийм байдалтай байгаа жижиг шувуудын ихэнх нь байгаль дээрээ амьдрах чадвартай. Иймээс “жинхэнэ” хаягдсан эсэхийг нарийн тогтоолгүй шууд гэртээ авч ирэх нь буруу алхам юм. **Хоёрт**, хүний гарт өсөж бойжсон шувууг зөв арчилж, тэжээгээд

зохих бэлтгэл хангаагүй бол байгальдаа зэрлэгээр өсөж бойжсон шувуутай харьцуулахад амьдрах чадварын хувьд ихээхэн ялгаатай. Хүний гарт арчилгаанд байсан залуу шувуудын хөгжилд түлхэц болох гадаад орчны болон ижил зүйлийн амьтны үзүүлэх биет туршлага, нөлөөлөл байхгүйгээс зан үйлийн хувьд суралцах олон зүйлийг орхигдуулна. **Гуравт**, нэг залуу шувууг аврахаас илүүтэй тухайн зүйл шувууны үүрлэх тохиромжтой орон зайг бүхэлд нь хамгаалах арга хэмжээ илүү өргөн хүрээтэй үр дүнд хүрнэ.

Байгальд гараа сунгах хүний тоо олширч, байгаль хамгаалах хөдөлгөөн улам бүр өргөн хүрээтэй болон тэлж байна. Хаягдсан ангаахай, дэгдээхэйг өсгөн бойжуулсан хэн нэг нь байгальд асар их үнэ цэнтэй зүйл хийсэн гэж өөртөө сэтгэл хангалуун байж болно. Амьтан тэжээж байгаа хүн бүрийн мэргэжлийн түвшин, тухайн зүйл шувууны талаарх үндсэн мэдлэг харилцан адилгүй байх тул залуу шувууг буруу арчилж, тэжээснээр хожим байгаль дээрээ чөлөөтэй амьдрах боломж хязгаарлагдах нь элбэг. Гэтэл ийм байдлаар тус болох нь байгаль хамгаалалд үр нөлөө багатай гэдгийг тэр бүр ойлгохгүй байна.

Зарим шувуудыг асарч маллахад тусгай мэргэжлийн бэлтгэл, шаардлага хангахуйц орон байр бэлтгэх хэрэгтэй болно. Ийм шувуудад өдрийн болон шөнийн амьдралтай махчин шувууд, том биетэй ус, намгийн шувууд, шөнийн амьдралтай эргүү бор гэх мэт шувууд, түүнчлэн өвөрмөц орчин шаардах онцлог ништэй шувууд орно. Түүнчлэн нэн ховор, ховор шувуудыг асран хамгаалах ажил заавал мэргэжлийн байгууллага, мэргэжилтний оролцоотой хийгдэх ёстой.

Энэ бүхнээс дүгнэж үзвээс нийт иргэдэд хамаатай зүйл бол зайлшгүй хүний зүгээс тусламж шаардлагатай болсон шувууг олсон даруйд ямар алхам хийвэл зохистой болохыг энэхүү гарын авлагад голлон анхаарсан болно. Анхан шатны арга хэмжээг зөв аваад цаашдын хувь заяаг мал, амьтны эмч, мэргэжлийн бэлтгэл хангасан хүний мэдэлд шилжүүлэх аваас зэрлэг амьтдыг авран хамгаалах ажлын эхлэл зөв болж, сайн үр дүнд хүрнэ. Анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж, улмаар шаардлага хангасан орчинд эмчилж, зөв арчилж маллаж чадах аваас амьтан хамгаалах үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр болно.

Байгаль хамгаалагч хүн гэмтэж бэртсэн шувуутай таарсан үед хийх анхны үзлэг, аврах, асрах чиглэлээр эн тэргүүнд хэрэгжүүлэх боломжтой гол арга хэмжээний талаар авч үзье.

**Шувуунд хийх анхан шатны үзлэг.** Шувуугаа барьж хайрцаг саванд хийсэн, эс бөгөөс зөөлөн даавуугаар ороож хөдөлгөөнийг нь хязгаарлаж тайван болсон үед шувуу чухам ямар шалтгаанаар ийм байдалд орсныг тандах ажил эхэлнэ. Ингэхдээ боломжтой бол илүү найдвартай, тайван орчныг сонгож тэндээ анхны үзлэг хийх нь тохиромжтой. Анхны үзлэгээрээ дараах асуултыг өөртөө тавьж хариулт олохыг хичээ. Үүнд:

- Гадна талд ямар нэг ил шарх, цус хурсан хэсэг байгаа эсэх?
- Яс гэмтсэн эсэх (далавч, хөл)?
- Шувуу гаднын ямарваа нэгэн цочролд хариу үзүүлэх чадвартай байгаа эсэх?
- Ялгаруулах сүв орчим (сүүлний уг орчим, хэвлийн арын хэсэг) бохирдож, норсон эсэх?
- Шувуу хэт туранхай, биеийн жингээ мэдэгдэхүйц алдсан эсэх?
- Шувуу муур юм уу ямар нэг өөр амьтанд хазуулснаас шархдаж, гэмтсэн үү?

Та анхны үзлэг хийж өөртөө зохих дүгнэлт хийснээр дараагийн алхмаа шийдэх болно. Шилэн хаалт мөргөж муужирсан шувуу гаднаа ямар нэг мэдэгдэхүйц гэмтэл, шарх үгүй байдаг. Ийм шувуу олсон бол юуны өмнө тайван орчинд (агаар сайтай битүү цаасан хайрцаг г.м) байлгах шаардлагатай. Ойролцоогоор 4 цаг өнгөрөхөд муужирсан шувуунд ямар нэг онцын өөрчлөлт

гараагүй, сэргээгүй нөхцөлд малын эмч рүү утасдаж зөвлөгөө авах буюу амьтан асрах, аврах байгууллага, мэргэжлийн хүмүүст хандана.

**Анхны тусламж.** Шувуунд ямар нэг өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд яаралтай эмчлэх шаардлагатай. Учир нь шувууны бодисын солилцооны эрчим өндөр учир үхэл ойрхон байдаг. Иймээс юуны өмнө мэргэжлийн эмчид хандаж зохих ёсны эмчилгээнд түргэн хүргэх нь нэн чухал. Гэхдээ эмчид очтолоо гэмтэж бэртсэн, шархтай шувуунд ямар тусламж эн тэргүүнд шаардлагатай вэ гэдгийг мэдэж зохих арга хэмжээ авах нь амьтан аврах үйл ажиллагааны эхний алхам болно. Энэ ажлыг шувуунд элэгтэй хэн бүхэн, тэр тусмаа байгаль хамгаалагч нар мэдэж байх учиртай.

**Даарахаас сэргийлэх.** Эрүүл шувууны биеийн температур зүйл бүрд харилцан адилгүй бөгөөд 40°C- 42°C хооронд хэлбэлзэнэ. Амьтны биед ямар нэг өвчин үүсгэгч орсон, эсвэл гэмтэл бэртлээс үүдэн цус их алдсан тохиолдолд организм гаднын биеийн эсрэг хамгаалалт хийх, шинэ цус үүсгэх зэргээр эрчимтэй ажиллах болно. Энэ нь ихээхэн энерги зарцуулах үйл ажиллагаа тул биеийн дулаанаа тогтмол барьж чадахгүйд хүрнэ.

Үүнээс болж гэмтсэн, өвчтэй шувууны биеийн температур буурна. Хөхтөн амьтан тухайлбал, хүнээс ялгаатай нь өвдсөн үедээ шувуу халуурах биш, харин биеийн температур буурч хөрдөг онцлогтой. Иймээс өвчтэй, бэртсэн шувууг олсон даруйдаа дулаацуулах, дулаан орчинд байлгах нь юу юунаас чухал болно. Энгийн нэг арга бол халуун устай эмнэлгийн бигнүүр (халуун жин) хэрэглэж болно.

Хамгийн амар арга бол дулаан хэвтэр засаад зөөлөн дулаан бүтээлгээр хучих, тэгэхдээ амьсгал чөлөөтэй байх нөхцөл хангагдсан байна. Дулааны нэмэлт эх үүсвэр бий болгохын тулд гэрлийн шил ашиглаж болно. Гэхдээ шувууг доороос нь дулаацуулахыг хичээнэ. Гэрэлд шувууны нүд гялбах тул хэт улаан-бүдэг гэрэл ашиглана. Ямар ч нөхцөлд хэт ягаан гэрэл ашиглаж болохгүй. Харин хэт халуун орчин бүрдүүлж болохгүй. Орчны температур хамгийн ихдээ 35°C-ээс дээш гарч болохгүй. Орчны температурыг хэмжиж байвал зохино.

#### **Анхаар:**

Мөргөлтөөс үүдэлтэй тархины гэмтэл, төв мэдрэлийн системийн гэмтэл, саатлын үед таталт, саажилт өгөх учир дулаанаар үйлчилж болохгүй. Нэмэлт дулааны нөлөөгөөр гэмтсэн тархины цусны даралт ихсэж шувуундаа муугаар нөлөөлнө. Толгой, тархины гэмтэл, бэртэл авсан шувууг харанхуй бөгөөд нам гүм тайван орчинд байлгана.

**Хэт өлсөхөөс сэргийлэх.** Шувууны бодисын солилцоо маш эрчимтэй тул хоол идээгүй нөхцөлд багахан хугацааны дотор жингээ алдаж турна. Биеийн жингээ алдсанаар шувуу улам сульдах, ингэснээр өвчин, гэмтэл бэртэл нь улам даамжрахад хүрнэ. Тайвшруулсны дараа тухайн шувуунд тохирсон тэжээлийг хоолоо идэхэд нь амар хялбар байх аяга, тавагт хийж өгнө. Тодорхой хугацаа өнгөрөхөд шувуу хоолоо идэхгүй байх эсвэл өөрөө хоолоо идэж чадахааргүй байгаа нөхцөлд албадлагаар хооллоно.

Шувуу доройтолдо орж хоолоо идэх, залгих чадваргүй байвал тэр зүйлд тохирсон тэжээлийг нухаж устай хольж өтгөн зуурмаг болгоод тариураар хоолой руу нь шахаж өгнө. Түүнчлэн глюкозын уусмал, витамин, аминин (малд зориулсан шингэн) зэргийг өгвөл шингэний дутагдлаас ангижирч, бага зэрэг энерги нөхөх боломжтой болно.

**Анхаар:**

Сулдаж доройтсон шувууг шууд хооллох гэж оролдож болохгүй. Юуны өмнө шувууны цусны эргэлт тогтвортой хэвийн болж хооллох дуршил, хоол боловсруулах замын ажиллагааг аажим сэргээх учиртай. Маш хүнд байгаа шувуунд эхний ээлжид шилбэний арьсан доогуур шингэн залгах шаардлагатай боловч үүнийг мэргэжлийн эмч, авран хамгаалах төвийн хүмүүс л хийж чадна.

**Толгой гэмтсэн үед анхаарах зүйл.** Шувуу ямар нэг зүйлийг мөргөсөн тохиолдолд (өнөө үед шилэн хаалт г.м) тархи доргих, гэмтэх нь элбэг. Ийм үед шувуу ухаан алдсан, гүн цочролд орсон байдалтай байна. Тийм шувууг зөөлөн даавуугаар жийрэглэж дулаан, тайван нам гүм газар тавина. Шувуу нуруугаараа эсвэл хажуугаараа унасан бол хөл дээрээ босохын тулд дэмжлэг хэрэгтэй болно. Ихэнх тохиолдолд хэсэг хугацаанд тайван байлгах, витамин В-г усаар шингэлж хошууны завсраар дусааж өгөх хэрэгтэй. Шувуу хэвийн байдалд ормогц мэргэжлийн эмч эсвэл зэрлэг шувуудыг асрах, авран хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хүмүүстэй холбоо барина.

**Ил шарх, гэмтлийн үед авах арга хэмжээ.** Ил шархыг халдваргүйжүүлэх арга хэмжээ авна. Эхлээд цэвэр даавуу, эмнэлгийн самбайгаар дарж цэвэрлээд ариутгалын зориулалттай уусмал түрхэх буюу цацлага хийнэ. Хэрвээ шарх ямар нэг хөхтөн амьтанд хазуулснаас үүссэн болох нь илт байвал антибиотик өгөх шаардлагатай. Махчин амьтдын шүлсэнд агуулагдах элдэв бактери шувууны цусанд орох аваас үхүүлэх аюултай. Махчин амьтнаас үүссэн шарх байнга ил мэдэгдэж байх нь ховор. Бага зэргийн хазалт эсвэл арьсанд үүссэн үл ялих шархаар дамжиж халдвар авах боломжтойг анхаарах ёстой. Халдварын эсрэг үйлчилгээтэй эм нь энрофлоксацин агуулсан антибиотик байна.

**Цус алдахыг зогсоох.** Цус алдаж байгаа тохиолдолд цус тогтоох арга хэмжээг цаг алдалгүй хийнэ. Шувуу цус багатай учир гэмтсэн шувуу цус их алдсанаас амархан үхэх эрсдэлтэй. Бага хэмжээний шарх байгаа бол төмөрт хлорын уусмалаар норгосон хөвөн, эмнэлгийн самбайг шарханд тавьж хөнгөн дарна. Хэрвээ ийм боломжгүй бол сонины цаас, ариун цэврийн цаасаар гэмтсэн судас дээр цус зогстол хөнгөн дарна. Харин том хэмжээний шарх үүссэн бол эцэстээ битүүлж оёх шаардлага үүснэ. Цус их алдсан үед шингэний дутагдлаас сэргийлэхийн тулд давс, сахарын уусмал (хоросол) өгнө. Түүнчлэн боломжтой нөхцөлд витамин К өгч болно.

Цус их алдсан үед уух усаар нь төмрийн бэлдмэл өгч болно. Ингэснээр цус бүрэлдэх үйл явцыг дэмжиж өгнө. Бусад төрлийн эмчилгээг мэргэжлийн эмч гүйцэтгэнэ.

**Гэмтэж бэртсэн, өвчтэй шувууг түр зуур хадгалах хайрцаг, сав.** Эхний ээлжид хатуу цаасан хайрцагт агааржуулах нүх сүв гаргаад, дотор нь зөөлөн даавуу, цаасаар жийрэг хийж шувуугаа байрлуулах нь хамгийн зөв алхам.

**Анхаар:**

Витамин К-г өгөхдөө тунг нь зөв тааруулах ёстой. Иймээс тунг хэмжээг зөв тохируулахын тулд эмийн заавраа сайн унших хэрэгтэйг онцгой анхаарна.

Тусламж шаардлагатай шувууг цаашид удаан хугацаагаар арчлах хэрэгцээ үүссэн үед юуны өмнө шувуундаа тохирсон, амьдрах нөхцөл хангахуйц тохиромжтой орчин бүрдүүлэх шаардлагатай болно. Энэ шаардлагын эн тэргүүнд шувуугаа байршуулах оромж, хайрцаг сав, тор, хашлага хамаарна. Гэхдээ тохиромжтой оромж бэлтгэх нь олон хүчин зүйлээс хамааралтай байна. Үүнд:

- Шувууны хэмжээ
- Шувууны зүйл хийгээд түүний зан төрхийн онцлог
- Өвчин болон гэмтэл бэртлийн хэлбэр
- Хүнээс үргэмтгий байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзах хэрэгтэй болно.

Гэнэт дэмжлэг туслалцаа шаардлагатай болсон шувуутай таарсан хүнд амьтнаа хийх бэлэн хайрцаг, сав байхгүй нь мэдээж. Ямар ч болов хатуу цаасан хайрцагт шувуугаа хийх нь хамгийн зөв алхам болно. Хайрцаг битүү байвал агаар оруулах нүх, сүв гаргана. Дээрээ онгорхой бол гэрэл гэгээ, агаар нэвтрэх боломжтой болгохын дээр хамгаалах зорилгоор тороор бүтээнэ. Үүнд янз бүрийн торыг ашиглаж болно. Боломжтой бол нэгэн зэрэг хоёр хайрцаг бэлтгэнэ. Нэг хайрцагт цэвэрлэгээ хийх, шувууныхаа хэвтрийг солих хэрэгтэй болоход нөгөөд нь шилжүүлж тавина. Ийм нөхцөлд цэвэрлэгээ хийх зорилгоор шувуундаа элдэв нэмэлт дарамт, цочрол үүсгэхгүй байх боломжтой болно. Ялангуяа яс нь гэмтсэн шувуунд илүү хөдөлгөөн хийхгүй байхад дэм болно. Шувуугаа эвтэйхэн өргөөд бэлдсэн нөгөө хайрцагтаа шилжүүлэн тавина. Ийм хайрцаг хөөндэйн хэрийн биетэй шувуу хүртэлх жижиг шувуудыг байрлуулахад тохирно.

Боломжит өөр нэг хувилбар бол нохой тээвэрлэх зориулалтын хайрцаг ашиглаж болно. Хувцас болон гэр ахуйн зориулалтаар ашигладаг угсардаг хуванцар хайрцаг бас тохиромжтой байдаг.

Худалдаанд элбэг байдаг шувууны төмөр тор гэмтэж, бэртсэн шувууг байлгахад тохиромж муутай. Учир нь хүнд дасаагүй зэрлэг шувуу нааш цааш үсчиж далавч, өдөө гэмтээх эрсдэлтэй. Нөгөө талаар торны завсраар хошуугаа гаргаж гэмтээх боломжтой. Зайлшгүй шаардлагаар ийм төмөр тор ашиглах нөхцөлд торон дээгүүрээ цайвардуу даавуугаар бүтээнэ. Даавуугаар бүтээхэд шувуу тайван болно.

Шувуутай савны доор олон давхарласан сонины цаасаар хэвтэш хийж болно. Хэвтрийг солих үедээ зөвхөн дээд талын сониныг авахад болох тул шувууг үргээх элдэв үйлдэл хийхгүй амар болно. Сонины цаасан дээрээ гар нүүрийн алчуур зэрэг зүйлээр зөөлөвч хийж өгнө. Гэхдээ зөөлөн хэвтрийг шувууны гэмтэл бэртлээс үүдэн янз бүрээр хэрэглэж болно.

Шилэн хаалт мөргөсөн, машинтай мөргөлдөж муужирсан, эсвэл хөл, далавч нь хүнд гэмтсэн шувуу хөл дээрээ зогсож чадахгүй бөгөөд хажуугаараа юм уу дээш харж хэвтэх нь элбэг. Ийм шувуудыг зөөлөн даавуугаар жийрэглэж хэвийн байдлаар суухад нь тусална. Энэ тохиолдолд гар нүүрийн алчуур хоёр ширхэг шаардагдана. Нэгээр нь хэвтэш бэлтгээд нөгөөг нь уртын дагуу хуйлж эвхээд дундуур нь нугалж, хоёр үзүүрийг нь ойртуулаад ахуйн хэрэглээний резин гоццоо углаж бэхлэх буюу нарийн утсаар холбон уяна. Алчуурынхаа дунд хэсэгт гараараа хоёр тийш тэлж, тавих шувууныхаа хэмжээнд таарсан зай гаргаад үүссэн хонхорт шувуугаа хажуугаар нь хэвтүүлэх юм уу аль эсвэл төв байдлаар суулгана.

Том биетэй хэрээний овгийн шувууд, усны шувуу, тоншуул мэтийг урт хугацаанд битүү хайрцагт байлгах аргагүй байдаг. Мөн сэргээн засварлах, эмчлэх ажил хийгдэж байгаа үед үргэмтгий шувууг том торон хашлаганд байлгах нь зохисгүй.

Зориулалтын торон хашлага байхгүй нөхцөлд ашиглалт багатай өрөө тасалгааг ашиглаж болно. Тэгэхдээ шувууны ялгадсанд бохирдохоос сэргийлж хамгаалалтын будаг, лак түрхэж болно. Тоншуул өрөөний модон хэсэг, ханыг тоншиж цоолох, нүх гаргах эрсдэлтэйг бодолцох ёстой. Тоншуул байлгасан өрөөнд дараа нь засвар хийх шаардлага гарна.

Түр байрны доторх тохижилт дээр өгүүлсэнчлэн шувууны хэмжээ, гэмтэл бэртлийн зэргээс ихээхэн хамаарна. Яс хугарсан, тархи толгойны гэмтэлтэй шувуу илүү тайван байх ёстой бөгөөд хөдөлгөөнийг аль болох хязгаарлах шаардлагатай. Ийм шувууд байгаа байранд элдэв илүүдэл зүйл (суудал гаргах, нуугдах нөхцөл бүрдүүлэх г.м) огт хэрэг болохгүй.

Хоол тэжээл болон усыг тогтвортой саванд хийгээд харагдахуйц бөгөөд амархан хүрэх боломжтой газар байрлуулна. Энэ тохиолдолд тогтвор сайтай шавар таваг тохиромжтой. Харин тэжээлийн саваа шувууны ялгадсаар амархан бохирдохооргүй газар тавихыг хичээнэ. Дорой шувуу усанд орж эрсдэлд орохоос сэргийлэхийн тулд усны савыг шөнийн цагаар гадагш гаргах шаардлагатай.

Дулааны улиралд өвчтэй, бэртэлтэй шувуу асрамжид байгаа ч гэсэн гадаа байлгавал илүү тааламжтай болно. Иймд боломжтой газар зөөврийн хайрцаг, торон саванд байгаа шувууг гадаалуулж байх шаардлагатай.

Усны шувуудын хувьд зүлгэн дээр тавьсан чөлөөтэй торон хашлага зохистой байдаг. Ийм торон хашлагад байгаа шувуу өвс тасалж, усанд сэлж, цэвэр агаараар амьсгалах зэрэг тухайн зүйлд зайлшгүй хэрэгцээг нь хангах боломжтой юм. Түүнчлэн нуугдах нөхцөл ч хангагдсан байвал зохино. Үүнд зөөврийн хайрцаг илүү сайн тохирно. Шөнийн цагаар дотогш оруулахгүй бол муур, махчин шувууны дайралтад өртөж болзошгүй.

Гэмтэл бэртлээ даахаар бол усны шувуудын эмчилгээ, асаргааны үед ч гэсэн усанд сэлэх боломж олгосон нөхцөл шувууддаа илүү таатай болно. Усанд сэлэх жижиг цөөрөм, усан сангийн усыг байнга цэвэрлэж байх ёстой. Бохир усанд элдэв өвчин үүсгэгчид амархан үржиж олширно. Түүгээр ч үл барам усан сан, цөөрөм бүх талаасаа задгай биш, аль нэг талдаа хаалт хамгаалалттай, болбол ногоон ургамал ургасан байх аваас байгалийн нөхцөлтэй адил төсөөтэй болж шувууд илүү чөлөөтэй, тайван байх нөхцөл бүрдэнэ.

*Эмчлэгдэж эдгээрсэн бие гүйцсэн шувууг суллан тавих.* Эмчилгээ хийгдээд эдгээрсэн шувууг суллан тавихын өмнө баталгаажуулах үүднээс малын эмчид дахин нэг удаа хандаж зөвлөгөө авна.

Бие гүйцсэн шувуу урт хугацаагаар эмчлэгдэж байсан бол суллан тавихаас өмнө тодорхой хугацаагаар нисэх дасгал заавал хийлгэнэ. Үүний тулд зориулалтын торон хашлага эсвэл сул чөлөөтэй өрөө хэрэг болно. Өрөөнд нисгэх дасгал хийлээ гэхэд аюулгүй байдлыг хангасан байх ёстой. Тухайлбал, цонх мөргөж гэмтэх, цонх хагарахаас хамгаалж торон хаалт хийсэн байх жишээтэй.

Бие гүйцсэн шувууг суллан тавихдаа анх тэр шувуу олдсон газар, үгйдээ түүний ойролцоох газрыг сонгоно. Өөрийн дассан танил газраа ирсэн шувуу хоол олох, өөрийгөө хамгаалах, унтаж амрах газраа олоход амар болно. Сүргээр амьдардаг шувууг ганцаар нь суллаж байгаа бол тухайн шувууны үүр колони байгаа газрыг бараадуулж тавина. Барьсан, олдсон газар нь тодорхойгүй бол тухайн зүйлд тохиромжтой бөгөөд тухайн зүйлийн шувууд амьдарч байгаа газар суллан тавина.

Зарим тохиолдолд шувуу суллах торон хашлаганы гадна эсвэл тавих газрын ойролцоо түр зуурын тэжээлийн талбай байгуулж болно. Суллан тавьсан шувуу шинэ орчиндоо дасаж, өөрөө хоолоо олж идэх хүртлээ бас багагүй хугацаа шаардагдах тул тэжээл тавьж өгөх нь байгальдаа дасах эмзэг үеийг даван туулахад дэмжлэг болж өгнө. Хэрээний овгийн шувуудыг суллан тавихад тэжээлийн цэгийг өндөрт байрлуулах, дээгүүр эргэлдэн нисэхэд тэр нь харагдахаар байвал суллан тавьсан шувуунд таатай байх болно.

### 2.10.3. Хоёр нутагтан ба мөлхөгчдийг аврах, асран хамгаалах ажлын онцлог

Ангилал зүйн хувьд мөлхөгчид болон хоёр нутагтан нь сээр нуруутны хүрээний бие даасан ангиуд хэдий ч тэднийг аврах, асран хамгаалах үйл ажиллагаа олон талаар тун нийтлэг явдаг байна. Нөгөө талаас хоёр нутагтан, мөлхөгчид амьдрах орчинтойгоо нягт шүтэлцэн амьдардгаараа бусад сээр нуруутан амьтдаас өвөрмөц.

Амьдрах орчин нь устаж үгүй болбол энэ 2 ангийн амьтад дайжин нүүж нутаг сэлгэж чадахгүй тул тухайн орчинтойгоо хамт устана гэсэн үг. Ийм утгаараа хүний асрамж зайлшгүй шаардлагатай болсон хоёр нутагтан, мөлхөгчдийг зохиомол орчинд байлгаж, арчлан тордох нь тэднийг авран хамгаалах, асрах цорын ганц үр дүнтэй арга болж байна.

Энэ бүлэгт хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйл тус бүрийг аврах, асран хамгаалахад тавигдах шаардлагыг нэг бүрчлэн багтаах зорилт тавиагүй болно. Ер нь ийм зорилт дэвшүүлж, ханган хэрэгжүүлэх бодит боломж, судалгаа, шинжилгээний болон практик үйл ажиллагааны үр дүн ч төдийлөн хангалттай бус. Иймээс авран хамгаалах, асрах үйлчилгээ үзүүлэх шаардлагатай хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг түр хугацаагаар барьж тусгаарласан үед эрүүл, тайван, аюулгүй байлгаж, асран тордоход тус дэм болох, хамгийн наад захын арга, боломжийг нэн тэргүүнд авч үзэхийг чухалчлав.

Амьтдыг зохиомол орчинд өсгөн үржүүлэх, судлах зориулалт бүхий байгууламжуудыг вивариум гэнэ. Хоёр нутагтан, мөлхөгчдийг асран сувилахад хамгийн тохиромжтой вивариумын хэлбэр нь террариум болой. Энэ бол тухайн амьтны амьдралын хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай гэрэл, температур, чийгшилт зэрэг экологийн нөхцөлийг бага оврын зориулалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хамгийн боломжит түвшинд иж бүрэн хангах боломжтой, байгалийн дүр төрхийг зохиомлоор үүсгэсэн, овор хэмжээ бага тул зай бага эзэлдэг, амьтан асрахад зориулсан зохиомол үүр, оромжийн үндсэн хэлбэр юм. Террариумыг ямар амьтанд зориулан амьдрах орчин бүрдүүлэхээс хамаарч хуурай террариум, аквариум, акватеррариум, палюдариум гэж ангилж болно.

**Хуурай террариум** (Terra - газар гэсэн латин үгнээс гаралтай). Энэ нь мөлхөгчид, мэрэгчид, шувуу зэрэг жижиг биетэй амьтдыг асран сувилах, өсгөн үржүүлэх, судлах, хамгаалахад зориулагдсан, тухайн амьтны амьдрах орчныг нь бүрдүүлэн тохижуулж, тоноглогсон багахан хэмжээтэй хорго сав юм. Байгалийн ямар төрлийн экосистемийг зохиомлоор үүсгэснээс хамаарч террариумыг цөлийн, ойн, саваны гэх мэтээр ангилна. Хуурай террариумыг ном бүтээлд ихэвчлэн “террариум” хэмээн бичиж заншжээ.

**Аквариум** (Aqua - ус гэсэн латин үгнээс гаралтай). Усны амьтан, ургамалд зориулж бүтээсэн тунгалаг ханатай зохиомол усан орчин. Аквариумын хэмжээ нь өрөө тасалгаанд зориулсан бага хэмжээтэйгээс эхлээд хэдэн арван мянган куб метр эзлэхүүнтэй аварга том хүртэл янз бүр байна. Гиннесийн номд орсон аварга том аквариум Хятадын Гуандун мужид бий. Түүний эзлэхүүн 22.7 мянган м<sup>3</sup>.

Асран хамгаалж буй амьдын амьдралын хэв маягаас хамаарч аквариум болон хуурай террариумын аль алиных нь шинжийг хадгалсан террариумын дараах өвөрмөц хэлбэрүүд байдаг.

**Акватеррариум.** Хуурай газар ба усан орчноос бүрдэх террариумын өвөрмөц хэлбэр. Энэ байгууламжид асран тэжээх амьтны амьдралын хэв маягаас хамаарч усан орчин болон

хуурай газрын хэсгийн талбайн харьцааг тогтооно. Ийм байгууламжид их төлөв хоёр нутагтан болон хагас усны амьдралтай зарим хөхтөн амьтдыг асран сувилна.

**Палюдариум** (palus - намаг гэсэн латин үгнээс үүсэлтэй). Энэ бол бороот ширэнгэн ойн орчныг зохиомлоор бүрдүүлсэн тунгалаг ханатай акватеррариумын нэг хэлбэр. Энд намгийн, эргийн болон чийгсүү ургамлын зэрэгцээ бороожуулах зохиомол хэрэгсэл голлох үүрэгтэй.


**Мөлхөгчдийг барих, тээвэрлэх үед анхаарах зүйлс.** Үзлэг оношилгоо, асаргаа сувилгааны үед мөлхөгчдийг гараар барихдаа хамгаалалтын бээлий хэрэглэхийн зэрэгцээ урт хямсаа, уурга ашиглана. Замба гүрвэлийн овогт хамаарахаас бусад зүйлийн гүрвэлийг зөвхөн их бие, хөлөөс нь барина. Ямар ч тохиолдолд сүүлнээс нь барьж болохгүй, учир нь маш амархан гэмтэж тасарна. Гүрвэлийн тасарсан сүүл аажимдаа нөхөн ургадаг хэдий ч энэ нь байгалиас заяасан сүүлнээс тэс ондоо, өөр гүрвэлийн сүүл залгачихсан мэт таагүй харагддаг. Нохой гүрвэлийн арьс тун эмзэг, маш амархан зулгарч гэмтдэг тул барихдаа үүнийг онцгой анхаарч нэн зөөлөн барих шаардлагатай.

Хүний тусламж шаардлагатай болсон могойг урт хямсаа, уурга, ацалсан үзүүртэй мод юм уу төмөр саваа, галын хайч зэргийн тусламжтайгаар барьж уут, хайрцаг саванд хийнэ. Хямсаа, галын хайчаар хавчих үед амьтдын мөчид, хавиргыг гэмтээхээс цаг ямагт болгоомжлох шаардлагатай. Мөн даавуун уут, хайрцаг саванд оруулан барьж болно. Хортой могойтой харьцахдаа дээд зэргийн анхаарал болгоомжтой байх шаардлагатай.

Үзлэг, оношилгоо, эмчилгээний үед хортой могойг дараах аргаар барьж, үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

1. Үзүүртээ зөөлөвч бүхий жижиг ацтай, урт саваа мод юм уу төмрөөр толгойн дээд хэсэгт газартай наалдуулан дарна. Хэт хүчлэн дарж болохгүй, гэмтээх эрсдэлтэй.
2. Дараа нь доорх зурагт үзүүлсэн хувилбаруудаас аль нэгийг нь сонгон, толгойн хөдөлгөөнийг хязгаарлан барина. Энэ үед нөгөө гараар их биеийг барьж, мушгиран ороохоос сэргийлнэ.

### **Зураг 2.6.** Могойг гараар аюулгүй барих аргачлал



Мөлхөгчдийг хөвөн даавуун уут юм уу агааржуулалтын нүх сүв бүхий жижиг хайрцагт, нэг нэгээр нь хийж тээвэрлэнэ. Савны ёроолд өвс, ургамал эсвэл нягт, сайн чанарын салфетка дэвсэж өгснөөр санамсаргүй доргиох, сэгсрэгдэх үед амьтдыг гэмтэхээс хамгаална. Даавуун уут нь давхар оёотой, амсрын уяа бат бөх байна. Могой уутаа нэвт хазах аюултай тул зөөж тээвэрлэхдээ ямагт анхаарал, болгоомжтой байх шаардлагатай.

Хэд хэдэн амьтан зэрэг зөөх тохиолдолд агаар орохуйц нүхтэй зориулалтын бэлдсэн томхон хайрцагт амьтантай жижиг савнуудаа байрлуулж, завсар зайгаар нь сонини цаасаар хөдөлгөөнгүй чигжиж тээвэрлэнэ. Хайрцаг, сав нь агаарын эргэлт муу, битүү орчин тул нарны гэрэлд амархан халж, тээвэрлэж байгаа амьтдыг үхүүлэх аюултай. Иймд амьтан тээвэрлэж байгаа хайрцаг, савыг нарны гэрэлд гаргах хориотой.

Тээвэрлэх явцдаа амьтдын бохирдуулсан цаасыг солих ба чийгийг сайн хянаж (хэт чийгтэй бол цаасыг солих, чийг бага бол тариур, дусаагуураар чийглэх) байх хэрэгтэй. Чийгийн хэмжээ тохиромжтой байхад тээвэрлэх хугацаанд хүндрэл гарахгүй бөгөөд зөвхөн зайлшгүй, шаардлагатай үед (хол замд) л хооллоно. Хооллохдоо томоохон хуванцар саванд амьтнаа хийж тайвширсны дараад нь устай савыг байршуулж, зохих хоол тэжээлийг өгнө. Зарим гүрвэлүүд савнаас ус уудаггүй тул шүршигчээр цацсан дуслыг гадаргуу дээрээс долоодог.

### Хорт могойд хазуулсан үед үзүүлэх анхны тусламж

Бамбай хоншоорт бол манай оронд хамгийн өргөн тархсан хортой могой юм.

1. Хазуулсан даруйд ямар нэг байдлаар хорыг соруулж гадагшлуулах арга хэмжээ авна. Хугацаа алдаж болохгүй, үүнийг хазуулсны дараах хэдэн секундэд амжиж хийх хэрэгтэй. Хазуулснаас хойш 5 минут өнгөрөхөд энэ арга ямар ч үр дүнгүй болно. Учир нь энэ хугацаанд могойн хор цус, шингэнээр дамжин биеэр тарж амждаг.
2. Могой хазсан шүдний ором гарсан тэр хэсгийн арьсыг хумсаараа маажих маягаар бага зэрэг задлан нээсний дараа хуруугаар чимхэж шахах үед тэнд үүсэн багахан шингэнийг амаар сорж гадагшлуулж болно. Энэ тохиолдолд, шүд эрүүл, амны хөндийд ямар нэг шархгүй байх шаардлагатай.
3. Хамгийн чухал нь хөдөлгөөнийг бүрэн хязгаарлах шаардлагатай. Үүний тулд тухайн хүний толгойг нь гудайлгаж, хөдөлгөөнгүй хэвтүүлнэ. Ялангуяа могойд хазуулж, хор гүйсэн хөл, гарыг ямар ч тохиолдолд хөдөлгөж болохгүй.
4. Бүлээн ус юм уу төдийлөн хандарч өтгөрөөгүй, шингэн, бүлээн хар цайг аль болох их хэмжээгээр уугаарай.
5. Могойн хорыг саармагжуулах үйлчилгээтэй эм, бэлдмэл хэрэглэж болно.
6. Хохирогчийг нэн даруй эмнэлэгт хүргэж, эмчлүүлэх арга хэмжээ авна. Орчин үеийн эмчилгээний практикт могойн хорноос гаргасан эсрэг үйлчилгээтэй ийлдсүүдийг өргөн ашиглаж байна. Могойн хорны эсрэг ийлдэсний зарим нь зөвхөн тодорхой зүйл могойн хорыг саармагжуулах явцуу зориулалттай бол нөгөө зарим нь янз бүрийн зүйл могойн хорыг саармагжуулах түгээмэл үйлчилгээтэй байдаг.



*Хоёр нутагтантай харьцах, тээвэрлэх, байгальд буцаан тавих.* Хоёр нутагтныг асрах, арчлан сувилахдаа, нэн эмзэг арьсыг нь гэмтээхгүйн тулд жижиг торон ховоо ашиглана. Хоёр нутагтны арьсанд байх олон тооны нэг эст булчирхайн шүүрэл арьсны гадаргуу дээр байнга ялгаран гарч байдаг. Эдгээр булчирхайн шүүрэл нь нэг талаас арьсыг чийгшүүлэх, нөгөө талаас элдэв нян гаднаас биед нэвтрэн орохоос хамгаалж, устгах үүрэгтэй. Иймд хоёр нутагтныг зөвхөн хамгаалалтын бээлийтэй тохиолдолд гараар зөөлөн барина.

Хоёр нутагтныг агаарын солилцоо чөлөөтэй явагдах боломжтой (жишээ нь, тагандаа жижиг нүх, сүвтэй байж болно), хатуу ханатай саванд зөөж тээвэрлэнэ. Савны хэмжээ том байх албагүй. Жишээ нь, 20 см x 15 см x 15 см хэмжээтэй таглаатай пластмассан саванд бие гүйцсэн 1-5 толгой хүртэл хоёр нутагтныг тээвэрлэж болно. Энэ саванд усны элдэв зүйлийн ургамал, хөвд зэргийг усаар чийгшүүлэн, нягтруулалгүйгээр хийх ба тээвэрлэлтийн явцад төлөв байдлыг тогтмол шалган боломжит энгийн аргаар үе үе чийглэнэ.

Хоёр нутагтныг хадгалах, тээвэрлэхэд зөвхөн хөвөн даавуун материалаар хийсэн уутыг богино хугацаанд (2 цагаас илүүгүй) ашиглаж болно. Энэ тохиолдолд уутанд тухайн хоёр нутагтныг ус намгийн ургамал, хөвд зэрэгтэй заавал хамт хийж, амыг битүүмжилнэ. Ямар ч тохиолдолд уутыг гаднаас нь чийглэж болохгүй. Учир нь нойтон эд материал тухайн амьтны биед наалдан бүрхсэнээр арьсны амьсгалыг боож үхүүлэх магадлал нэн өндөр.

Хоёр нутагтныг байгальд буцаан тавих үйл ажиллагааг зөвхөн урин дулааны улиралд, тухайн зүйлийн ижил сүрэг нь идээшин амьдарч, өсөн үрждэг тэрхүү уугуул ус намгархаг нутгийг сонгон гүйцэтгэнэ. Эдгэрч, тэнхэрсэн хоёр нутагтныг тухайн зүйл амьдардаггүй нутагт суллан тавьж огт болохгүй. Учир нь цор ганц юм уу цөөн хэдэн бодгалийг ижил сүрэггүй ийм шинэ нутагт суллан тавих нь үндсэндээ тэднийг “үхлийн зам руу шууд үдсэн” үйлдэл болно. Ийм тохиолдолд тухайн амьтныг байгальд буцааж тавилгүйгээр, хүний хараа хяналтын дор байлгаж асран халамжлах нь амьтны эрхийн шаардлагад бүрэн нийцнэ.

### Даалгавар

- Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах аргачлал гарын авлага (2021)-ыг уншиж дэлгэрүүлэн судлах (<https://mongolia.panda.org/publications/?388835/----->)
- Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны багц стандарт (Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага (MNS 6943:2021), Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтдад тавих тусгай шаардлага (MNS 6944:2021), Шувуу аврах, асран хамгаалах тусгай шаардлага (MNS 6945:2021), Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хоёр нутагтан, мөлхөгчдөд тавих тусгай шаардлага (MNS 6946:2021))-уудыг уншиж судлах
- Амьтны тухай хууль (2012) болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль (2017)-ийг унших

## Мэдлэг сорих тест

1. Зэрлэг амьтантай холбоотой дараах тохиолдлуудаас алиныг нь аварч, асран хамгаалах шаардлагатай хэмээн үзэх вэ?

- а. Ороо, хөөцөөнд орж буй ан амьтад
- б. Нутаг сонгон нүүдэллэж яваа ан амьтад
- в. Төрөх дөхсөн ан амьтад
- г. Хөл нь хугарч, турж эцсэн янгир

2. Дараах өгүүлэмжүүдээс аль нь амьтны эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаанд нийцэж байна вэ?

- а. Үхсэн амьтныг тодорхой зан үйлийн дагуу оршуулах
- б. Бүргэдийн баярын үед бизнесийн зорилгоор чонын бэлтрэг хөтлөн, үйлчилгээ үзүүлэх
- в. Чонын ав зохион байгуулж, азарган чоно агнасан үйл явдлыг газар дээрээс нь сурвалжлан, телевизээр шууд дамжуулах
- г. Чоно бол мал сүргийг олноор хороодог, заналт амьтан болохыг цэцэрлэгийн наснаас эхлэн хүүхдэд төлөвшүүлэх

3. Амьтны тухай хуулийн “. . . гэж амьтад идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байхыг ойлгоно” гэсэн заалтад тохирохыг нь нөхөн тэмдэглэнэ үү.

- а. Амьтны амьдрах арга
- б. Амьтны жам ёсны эрх
- в. Байгалийн ан амьтан
- г. Ан амьтныг энэрэх ёс

4. Биологийн төрөл зүйлийг хамгаалахад дагаж мөрдөх ёс зүйн зарчимд аль нь нийцэх вэ?

- а. Хэдийгээр байгалийн ан амьтад оршин тогтнох эрхтэй ч ямагт хүний дараах байр суурийг эзэлнэ
- б. Биологийн зүйл бүрийн үнэ цэнэ нь хүний хэрэгцээгээр тодорхойлогдоно
- в. Зүйл бүр амьд ертөнцийн нэг бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хүний адил амьдрах, оршин тогтнох эрхтэй
- г. Аж ахуйн үйл ажиллагаанд хор хөнөөлтэй биологийн төрөл, зүйлийг хүн устгах эрхтэй

5. Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үед хамгийн анхлан авах арга хэмжээг тэмдэглэнэ үү.

- а. Бүлээн юм уулгах, хөдөлгөж идэвхжүүлэхийг оролдох
- б. Стрессийг багасгахын тулд нүдийг нь дарж боох, битүү зүйл толгойд нь углах зэргээр харах боломжийг хязгаарлах
- в. Шаардлагатай тариа хийх юм уу эм бэлдмэл өгөх
- г. Цус алдаж байгаа болон яс хугаралттай эсэхийг шалгах

6. Ямар тохиолдолд амьтныг зориуд унтуулж, амь хороох вэ?

- а. Ямар нэг хэлбэрээр өвчилсөн амьтан
- б. Нас ахиж хэт хөгширсний улмаас цаашид амьдрах боломжгүй болсон амьтан
- в. Хөл нь хугарсан амьтан
- г. Ижил сүргээсээ салж, төөрөн ганцаардсан амьтан

7. Амьтны амийг зориудаар хороон унтуулах үед ямар аргыг нь хэрэглэх вэ?

- а. Боломжтой гэж үзсэн гэр ахуйн бүтээгдэхүүнээр хордуулах
- б. Эмийн аргаар унтуулах
- в. Амьдаар нь шатаах
- г. Цусыг нь юүлэх

8. Асран хамгаалах шаардлагатай болсон нялх ногоолойг юугаар тэжээх вэ?
- а. Хэрчиж жижиглэсэн махаар
  - б. Амтат жимс, жимсгэнээр
  - в. Сүүгээр
  - г. Гурилан бүтээгдэхүүнээр

9. Өндөг хагарахад өдтэй, нүдээ нээсэн байх боловч ангаахайг бодвол илүү хөдөлгөөнтэй бөгөөд үүрэндээ юм уу үүрнийхээ орчим байж эцэг, эх шувуудаар тодорхой хугацаанд тэжээлгэдэг шувууны төлийг хэрхэн нэрлэдэг вэ?

- а. Ангаахай
- б. Дэгдээхэй
- в. Өдрийн дэгдээхэй
- г. Сөгдөөхэй

10. Амьтан асрах, тэжээх зориулалттай, хуурай газар ба усан орчноос бүрдсэн байрыг юу гэж нэрлэдэг вэ?

- а. Аквариум
- б. Акватеррариум
- в. Палюдариум
- г. Хуурай террариум

11. Террариум хийхэд хамгийн тохиромжтой материалыг сонгоно уу.

- а. Нимгэн төмөр
- б. Зүймэл мод, банз, фанерь
- в. Төрөл бүрийн шахмал хавтан
- г. Шил

12. Асран сувилж буй гүрвэлийн амьдарч буй террариумын хамгийн зохистой дулааныг сонгоно уу.

- а. Ямар тохиолдолд  $10^{\circ}\text{C}$  хэмээс буурч болохгүй
- б. Хамгийн тохиромжтой нь  $25^{\circ}\text{C}$ - $32^{\circ}\text{C}$  хэмийн дулаан болно
- в. Хамгийн тохиромжтой нь  $10^{\circ}\text{C}$ - $25^{\circ}\text{C}$  хэмийн дулаан болно
- г. Хамгийн тохиромжтой нь  $10^{\circ}\text{C}$ - $25^{\circ}\text{C}$  хэмийн дулаан болно

13. Террариумд ашигладаг дараах гэрлүүдээс зөвхөн гэрэлтүүлэх зориулалттайг нь сонгоно уу.

- а. Ердийн улайсдаг гэрэл
- б. Галоген гэрэл
- в. ЛЕД гэрэл
- г. Өдрийн гэрэл

14. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.15-д зааснаар “Амьтныг арчлах, тэжээх, болзошгүй аюулаас хамгаалах, хашаа, байр, нөмөр, хорго, хэвтрийг цэвэрлэх үүрэгтэй иргэн”-ийг юу гэж нэрлэдэг вэ?

- а. Амьтан авран хамгаалагч
- б. Мэргэжлийн ажилтан
- в. Амьтан асрагч
- г. Амьтан маллагч

15. “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага (MNS 6943:2021)” стандартад зааснаар “шинээр ирсэн амьтдыг аврах, асран хамгаалах байгууламжид байгаа бусад амьтдаас тодорхой хугацаанд тусгаарлан байгуулах үе шат”-ыг юу гэж нэрлэдэг вэ?

- а. Амьтныг дасгах үе шат
- б. Үзлэг, оношилгооны үе шат
- в. Хяналт тавих үе
- г. Хорио цээрийн дэглэм

16. “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага (MNS 6943:2021)” стандартад “хүний тусламж, үйлчилгээ шаардлагатай болсон амьтдыг амьтан аврах, асран хамгаалах байранд хүргэж, хүлээлгэн өгөх, эсхүл энэ талын мэдээлэл дамжуулж буй байгууллага, иргэн”-ийг ямар нэр томъёогоор илэрхийлсэн вэ?

- а. Мэдээлэгч
- б. Тусламж дуудагч
- в. Мэдээлэл дамжуулагч
- г. Амьтан нийлүүлэгч

17. Амьтан аврах, асран хамгаалах байр савны экологийн нөхцөлийг Зэрлэг амьтан аврах, асрах хамгаалах багц стандартад юу гэж нэрлэсэн вэ?

- а. Тусгай зориулалтын байр
- б. Зохиомол амьдрах орчин
- в. Амьтдын амьдрах тохиромжтой нөхцөл
- г. Амьтдын хэвийн амьдрах нөхцөл

18. Эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах зорилгоор мэргэжлийн ажилтны зүгээс амьтанд үзүүлж буй үзлэг, оношилгоо, сувилгаа, унтуулга, устгал зэрэг бүх төрлийн үйлчилгээг дээрх стандартад юу гэж нэрлэдэг вэ.

- а. Амьтны сувилгаа
- б. Амьтны үзлэг, эмчилгээ
- в. Амьтдын сувилгаа, асаргаа, эмчилгээ
- г. Амьтны үзлэг, оношилгоо, эмчилгээ

19. “Шувууг асран хамгаалах тусгай шаардлага. MNS 6945:2021” стандартад шувуу чөлөөтэй нисэж буух боломжтой, нэг буюу хэд хэдэн тал нь битүү, урдуураа болон дээгүүрээ торон хаалт бүхий байрыг хэрхэн нэрлэсэн вэ?

- а. Хамгаалах байр
- б. Шувуун асрах байр
- в. Торон хашлага
- г. Шувуу дасгах байр

20. Жилийн дөрвөн улиралд манай орны нутаг дэвсгэрт амьдардаг шувуудыг юу гэж нэрлэдэг вэ?

- а. Уугуул шувууд
- б. Нутгийн шувууд
- в. Суурин шувууд
- г. Орогномол шувууд

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫГ СМАРТ ПРОГРАММААР  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙ




### 3.1 SMART ПРОГРАММЫН ТУХАЙ

SMART/SMART (Spatial Monitoring and Reporting Tool) программ гэдэг нь тусгай хамгаалалттай газар нутаг болон хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэртээ байгаль хамгаалагчид хяналт шалгалтыг тодорхой орон зайд хийх, мэдээ, баримт цуглуулах, түүнийгээ программд оруулж нэгтгэн, дүн шинжилгээ хийх, дараагийн хяналт шалгалтын зорилтыг тодорхойлох, түүнийгээ тайлагнах, байгаль хамгаалах практикт өргөн хүрээний хэрэглээ бүхий гар утас, суурин компьютер, онлайн платформд суулгасан хяналт шалгалтын удирдлагын цогц систем юм.

Мөн биологийн олон янз байдлыг үр дүнтэй хамгаалахын тулд байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, олон нийт, эрх баригчид зэрэг бүх оролцогч талуудад эрх мэдлийг адил тэгш олгодог хэрэглээний программ.


**Зураг 3.1.** SMART программын бүтэц



2021 оны байдлаар SMART хөтөлбөрийг дэлхийн 80 гаруй улсын 1000 орчим газар нутагт хэрэгжүүлж байна. Үүнээс 18 улс нь албан ёсоор эрх зүйн баримт бичигтээ уялдуулж, тусгасан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Зураг 3.2. SMART программыг хэрэгжүүлж буй дэлхийн бүс нутаг



*Жишээ нь, хамгаалах үнэт зүйлд хулан хамгаалахаар сонгосон байвал түүнтэй хамааралтай бүхий л мэдээллийг цуглуулах боломжийг SMART программд оруулж өгнө. Хулантай холбоотой үүсдэг хэрэг зөрчлүүдийг үүсгэнэ. Үүнд, хулгайн ан байж болно. Мөн мониторингийн мэдээлэл буюу популяцийн байршил, тоо толгойн өгөгдөл цуглуулахаар байж болно. Тухайлбал, хээрийн ажиглалтын явцад тохиолдсон хулангийн тоо, хүйсийн харьцаа, байршиж буй газар нутгийн экосистем, амьдрах орчны хэлбэр гэх мэт мэдээллийг программчлан цуглуулахаар оруулна.*

Ийнхүү Ази, Африк, Өмнөд Америкийн зарим бүс нутагт хэрэгжиж, үр дүнтэй болох нь тогтоогдсон энэхүү SMART хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулах, тусгай хамгаалалттай газар нутагт хуулийн хэрэгжилт, хяналт шалгалтыг энэ программаар зохион байгуулах боломжийг бүрдүүлэх үндсэн дээр уг программыг Монголын нөхцөлд нийцүүлэх, турши ажлыг Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар тэргүүлэн Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Ирвэс хамгаалах сан, Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэг (ZSL)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Дэ Нэйче Консерванси (TNC)-ын Монгол дахь төлөөлөгчийн газар зэрэг олон улсын байгууллагууд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран хэрэгжүүлж иржээ.


Уг ажлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэмжиж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/219 дүгээр тушаалаар “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хуулийн хэрэгжилт, хяналт шалгалтыг SMART программаар зохион байгуулах арга зүй”-г баталж, түүнийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж ажиллахыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нарт үүрэг болгосон байна.

Энэ дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-т SMART программын сургалтыг 16 цагийн багтаамжтай зохион байгуулахаар тусгасны дагуу энэхүү гарын авлагад дээр дурдсан арга зүйг бүрэн эхээр нь оруулав.

SMART-ын дасан зохицох менежмент нь дараах эргэх холбоотой ажилладаг. Үүнд:

- Байгаль хамгаалагч өөрийн хариуцсан газар нутагтаа эргүүл хяналт, шалгалт хийх, хэрэг зөрчлийн тухай мэдээлэл цуглуулах, эргүүл хяналтын хуудас хөтлөх (Эргүүл хяналтын хуудсыг хавсаргав)
- Цуглуулсан мэдээ, мэдээллийг SMART программ руу оруулах
- Газрын зурагт буулгаж нэгтгэх, нөхцөл байдлыг харах
- Дүгнэх, дараагийн хяналт шалгалтын зорилгыг тодорхойлох
- Тайлагнах
- Менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах, дараагийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зэрэг алхмуудын дагуу хийж гүйцэтгэнэ.

**Зураг 3.3.** SMART программын дасан зохицох менежмент



**Эргүүл хяналт, мониторингийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим.** Эргүүл, хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

- Төрийн үйлчилгээг чанартай, хурдан шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн байх
- Аюулгүй ажиллагааны дүрэм, стандартыг чанд мөрдөх
- Хамтрагч талуудтай ажлын уялдааг хангасан байх
- Эргүүл хяналт, мониторингийн мэдээлэл нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалах үнэт зүйлүүдэд суурилсан байх
- Хэрэглэхэд хялбар, энгийн ойлгомжтой байх
- Цуглуулсан мэдээлэл баримттай, бодит, тодорхой байх
- Арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц, төсөв, санхүүгийн эх үүсвэр тодорхой байх.

**Эргүүл хяналт, мониторингийн ач холбогдол.** Аливаа техник, технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа ашиглах нь хүний хөдөлмөрийг үлэмж хөнгөвчилж, цаг хугацаа хэмнэдгээрээ онцлог юм. Тиймээс байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдийн ажлыг хялбар болгох, мэдээллийг баримттайгаар цуглуулах, тодорхой болгодог зэрэг нь SMART хэрэгслийн давуу тал болно.

- Мониторинг судалгааны мэдээлэл, үр дүн нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын үндсэн зорилгыг хангах, менежментийн үр дүнтэй шийдлийг олох боломж олгодог.
- Хамгаалалтын захиргааны өдөр тутмын болон дунд, урт хугацааны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, тулгамдсан асуудлаа шийдэх, шийдвэр гаргахад тусална.

- Тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааны залгамж чанар, тасралтгүй байдлыг хангаж өгдөг.
- Байгууллагын менежментийн үр ашиг, бүтээмжийг тодорхойлж дэвшүүлсэн зорилтоо хэрхэн хэрэгжүүлсэн байдалдаа үнэлэлт дүгнэлт өгч, өөрчлөх шаардлагатай эсэхийг тодорхойлдог.
- Байгаль хамгааллын зөв стратеги, менежментийг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.
- Санхүү, материаллаг бааз болон хүний нөөцийн зохистой төлөвлөлт хийх, хөрөнгийг зөв төсөвлөж зарцуулах, хяналт тавих боломж олгоно.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, мэргэжилтнүүдтэй хариуцлага тооцох, гүйцэтгэлийн сахилга батыг сахиулах хэрэгсэл болдог.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын ажлын үзүүлэлтийг хянах, бодитоор үнэлэх боломжийг олгоно.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцогч талууд буюу хамгаалалтын захиргаа, нутгийн иргэд, шийдвэр гаргагчдын хамтын ажиллагаанд холбогч гүүр нь болдог.
- Тусгай хамгаалалттай газар нутагт мэдээлэл цуглуулах, хяналт тавихад идэвхтэн байгаль хамгаалагчдын дэмжлэгийг үнэлэх, тодорхойлох боломжийг бий болгоно.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үйл ажиллагааг бусдад тайлагнах, олон нийтэд ойлгуулах, ажлын үзүүлэлтийг ойлгуулахад хялбар болгодог.
- Тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт болон түүний орчмын бүс нутагт үйлдэгдсэн зөрчил мэдээллийг бүртгэх, цаашид хянан шийдвэрлэхэд чухал баримт болно.
- Зарим биологийн төрөл зүйлд мониторинг хийх, өгөгдөл цуглуулах боломжтой болгодог.
- Эргүүл хяналт, шалгалтыг зохион байгуулах явцад орхигдсон газар нутгийг тодорхой болгодог.

**Эргүүл хяналт, мониторингийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага.** Эргүүл, хяналт мониторингийн ажлыг хэрэгжүүлэхэд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- Эргүүл хяналт, мониторингийн мэдээлэл цуглуулах аргачлал нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц нийтлэг зарчмыг агуулсан байх
- Үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, байгаль орчны багц хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журам зэрэгт тусгагдсан үзэл баримтлалыг бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн
- СМАРТ-ыг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, холбогдох чиглэлийн байгууллага, байгаль хамгаалах бүлэг, нөхөрлөлүүдийн оролцоог хангахуйц уялдааг бий болгосон, зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг хангасан
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистем, биологийн төрөл зүйл, байгалийн нөөц баялгийг ашиглах, хамгаалах талаар урьд нь хэрэгжиж ирсэн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх замаар цаашид хийгдэх үйл ажиллагааны оновчтой хувилбарыг гаргах, шийдвэр гаргахад дэмжлэг болох
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хил залгаа болон хилийн дотор байрладаг нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагуудтай тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдмэл чанарыг хангасан
- СМАРТ-ыг хэрэгжүүлснээр уян хатан байдлыг хангаж, орхигдлыг тодорхойлох боломж бүрдэх зэрэг болно.

## 3.2 ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛОХ

Тусгай хамгаалалттай газар нутагт хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, менежментийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур нь тухайн газарт хийгдэж буй эргүүл хяналт, судалгаа мониторингийн ажлын үр дүн юм. Тиймээс тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, менежментийн төлөвлөгөөг үнэлж, дүгнэх, ажлаа сайжруулахад шаардлагатай мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн эргүүл, хяналт шалгалт, мониторингийн мэдээлэл цуглуулах хэсгийг бий болгоно. Үүнд хамгаалахаар сонгон авсан үнэт зүйлүүдэд тулгамдаж буй асуудлууд буюу аюул, дарамтыг багтаасан байх, мөн хээрийн ажлын явцад таарч, тэмдэглэгдсэн мониторингийн мэдээллийг цуглуулах зэрэг орно.

***Жишээ нь,** хамгаалах үнэт зүйлд хулан хамгаалахаар сонгосон байвал түүнтэй хамааралтай бүхий л мэдээллийг цуглуулах боломжийг SMART программд оруулж өгнө. Хулантай холбоотой үүсдэг хэрэг зөрчлүүдийг үүсгэнэ. Үүнд, хулгайн ан байж болно. Мөн мониторингийн мэдээлэл буюу популяцийн байршил, тоо толгойн өгөгдөл цуглуулахаар байж болно. Тухайлбал, хээрийн ажиглалтын явцад тохиолдсон хулангийн тоо, хүйсийн харьцаа, байршиж буй газар нутгийн экосистем, амьдрах орчны хэлбэр гэх мэт мэдээллийг программчлан цуглуулахаар оруулна.*

**Эрүүл хяналт, мониторинг хийх зорилго.** Тусгай хамгаалалттай газар нутагт хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, менежментийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур нь тухайн газарт хийгдэж буй эргүүл хяналт, судалгаа мониторингийн ажлын үр дүнгээр илэрхийлэгдэнэ. Тиймээс SMART программын дагуу мэдээлэл цуглуулах эцсийн зорилго нь хамгаалахаар сонгосон үнэт зүйлүүдийг хамгаалах, байгаль хамгааллын менежментийг бодит мэдээлэл, судалгааны үр дүнд суурилан сайжруулахад оршино.

**Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах.** Хуульд заасны дагуу хяналт, мониторингийн ажлыг хийхдээ тухайн газар нутгийнхаа менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан хийх нь зүйтэй.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах арга зүй”-д хамгаалах үнэт зүйлийг сонгохоор тусгагдсан байдаг. Тиймээс тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд сонгон авсан үнэт зүйлүүдтэй холбоотойгоор тэр газар нутагт хамгаалах шаардлагатай үнэт зүйл буюу биологийн тодорхой төрөл зүйл, экосистемийн төлөөллийг сонгон авна. Хамгаалахаар сонгон авсан үнэт зүйлүүдийн талаарх мэдээллийг цуглуулан сайжирч байгаа, эсвэл доройтож байгаа мэдээллийг цуглуулах нь менежментийн арга хэмжээнд тустай.

**Аюул дарамт.** Тухайн тусгай хамгаалалттай газарт, хамгаалахаар сонгон авсан үнэт зүйлүүдэд учирч буй аюул дарамтын мониторинг хийж, мэдээлэл цуглуулах нь эргүүл хяналтын ажлыг дүгнэх, үр дүнтэй явуулахад хэрэгтэй. Аюул дарамтыг ажиглаж, бүртгэнэ гэдэг нь хулгайн ан, хориотой үед загас барих, ангийн хэрэгсэлтэй явах, хууль бусаар ашигт малтмал хайх, мод огтлох, орчны бохирдол, амьдрах орчныг санаатайгаар өөрчлөх (голын голдирол өөрчлөх) гэх мэт дарамтыг тооцож болно.

### 3.3 ЭРГҮҮЛ, ХЯНАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Эргүүл, хяналтын ажлыг төлөвлөнө гэдэг хэзээ, хэн, хаана, ямар зорилгоор, хэдэн удаа гэсэн асуултад хариулахаас эхэлнэ. Эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэхдээ менежментийн төлөвлөгөө, хамгаалах үнэт зүйлүүдийн төлөв байдал, тусгай хамгаалалттай газар нутагт байнга эсвэл нүүдэллэн оршдог, дамжин өнгөрдөг зүйлүүд зэргийг харгалзан үзнэ.

**Эргүүл хяналтын төлөвлөгөө боловсруулах.** Эргүүл хяналтын ажлын төлөвлөгөөг жил, улирал, сараар нь тооцоолон боловсруулна. Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн онцлогоос хамааран тогтмол болон гэнэтийн эргүүл хяналтыг хийнэ.

Тогтмол хийгддэг эргүүл хяналт гэдэг нь төлөвлөгөөний дагуу сар, өдөр нь тодорхой бөгөөд төлөвлөсөн маршрутын дагуу хийж буй эргүүл хяналтыг хэлнэ. Гэнэтийн гэдэг нь тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран эргүүл, хяналтыг хийх шаардлагатай цаг үед хийгдэж буй хяналт, шалгалтыг хэлнэ (жишээ нь, самар түүх цаг үе, загас барихыг хориглосон хугацаанд г.м).

Эргүүл хяналтын төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлст анхаарна. Үүнд:

- Багийн ахлагч, гишүүдийн нэрс, тоо
- Эргүүл, хяналт шалгалтын тоо
- Чиглэл, маршрут
- Зорилго, зорилт
- Нийт зарцуулагдах шатахуун (литр)
- Нийт туулах зам (км)
- Томилот
- Тээврийн хэрэгслийн төрөл (машин, мотоцикл, морь г.м)
- Яаралтай үед холбоо барих хүний дугаар.

SMART программыг ашиглан эргүүл хяналт хийхээс өмнө хариуцсан мэргэжилтэнтэй зөвлөлдөж төлөвлөгөөний хуудсаа батлуулна.

**Мониторинг мэдээлэл цуглуулах.** Мэдээлэл цуглуулах хэсэг нь эргүүл, хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулахаас эхэлдэг. Үүний тулд урд өмнө хэрэгжүүлсэн мониторинг, эргүүл хяналт хийсэн ажлын үр дүнг шинжлэн, үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр төлөвлөгөөгөө боловсруулна.

SMART программын дагуу эргүүл, хяналтын мэдээллийг цуглуулахаас гадна, биологийн олон янз байдлын мэдээллийг цуглуулна. Мониторингийн дагуу цуглуулагдсан урт хугацааны мэдээлэл нь тухайн биологийн олон янз байдлын хамгааллын ажлыг сайжруулах, төлөвлөх, шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй байдаг. Тиймээс менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хамгаалах үнэт зүйлүүд болон тэдгээртэй холбогдох экологи, биологийн мэдээллийг SMART программд оруулан цуглуулах хэсгийг суулгасан байх шаардлагатай.


### 3.4 ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МОНИТОРИНГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

**Эргүүл хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх багийн бүтэц ба үүрэг.** Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хүний нөөцийн онцлогтой уялдан багийн бүрэлдэхүүн янз бүр байна. Хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх баг болон байгаль хамгаалагч нар нь дараах 4 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:


- **Судалгаа ба мониторинг:** Судалгаа мониторингийн чиглэлээр эргүүл хяналт, шалгалтыг зохион байгуулах
- **Төлөвлөгөөт хяналт, шалгалт:** Байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтнүүд батлагдсан төлөвлөгөөний дагуу дангаар эргүүл, хяналт шалгалтыг гүйцэтгэх
- **Төлөвлөгөөт бус хяналт, шалгалт:** Байгаль хамгаалагч болон тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтэн дуудлагын дагуу эсхүл төлөвлөгөөнд тусгагдаагүй хяналт шалгалтыг дангаар гүйцэтгэх
- **Хамтарсан хяналт шалгалт:** Байгаль хамгаалагчид, захиргааны мэргэжилтнүүд, хамаарал бүхий бусад байгууллагуудтай нэгдэн хяналт шалгалт гүйцэтгэх.

Хамтарсан хяналт, шалгалт хийж буй тохиолдолд бүртгэл хөтлөх үндсэн хоёр арга байдгаас зөвхөн аль нэгийг сонгон хэрэгжүүлнэ. Үүнд:


1. **Зөвхөн багийн ахлагч SMART программ дээр бүртгэл хөтлөх.** Ингэхдээ багийн гишүүд гэсэн хэсэгт зөвхөн байгаль хамгаалагч өөрийгөө сонгож ганцаарчилсан эргүүл, хяналт шалгалт хийх журмаар бүртгэлээ хөтлөн хийнэ (Зураг 3.4). Хяналт шалгалтад явж ирсний дараа багийн гишүүн тус бүр өөрсдийн хийсэн мэдээ бүртгэлийг захиргааны ажилтан руу тус тусдаа илгээнэ
2. **Зөвхөн багийн ахлагч SMART программ дээр бүртгэл хөтлөх.** Ингэхдээ багийн гишүүд гэсэн хэсэгт гишүүдийн нэрсийг оруулж өгөх шаардлагатай бөгөөд багийн ахлагч гэсэн хэсэгт ахлагчийг сонгоно (Зураг 3.5). Хяналт шалгалтад явж ирсний дараа зөвхөн багийн ахлагч мэдээллийг захиргааны ажилтан руу илгээнэ.



**Зураг 3.4.** Багийн гишүүн тус бүр SMART программ дээр бүртгэл хөтлөх



**Зураг 3.5.** Зөвхөн багийн ахлагч SMART программ дээр бүртгэл хөтлөх



**Эргүүл, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх давтамж, хугацаа, зай.** Хууль бус үйлдлийг илрүүлэх магадлал нь эргүүл, хяналт шалгалтын тоотой шууд хамааралтай байдаг. Иймд тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хүчин чадал, газар нутгийн хэмжээнд тохирсон эргүүл, хяналт шалгалтыг аль болох олон давтамжтай явуулах шаардлагатай.

Тогтмол нэг өдөр, нэг цагт эргүүл хяналт, шалгалт хийх нь хууль бус үйл ажиллагааг илрүүлэх явцыг сааруулдаг. Учир нь хууль бус үйл ажиллагаа хийж буй этгээд байгаль хамгаалагч нарын эргүүлийн хэв маягийг урьдчилан таамаглах боломжтой болсноор эдгээр өдөр, цагуудаас зайлсхийдэг. Тиймээс байгаль хамгаалагчид нь гэнэтийн байдлаар тогтмол бус, урьдчилан таамаглах боломжгүйгээр өдөр цагийг тохируулах нь зүйтэй юм.

- Төлөвлөгөөт эргүүл ,хяналт шалгалтыг сард хоёроос доошгүй удаа хийх нь тохиромжтой.
- Нэг удаагийн эргүүл, хяналт шалгалт дунджаар 6-8 цаг, хамгийн ихдээ 2-3 хоног үргэлжилж болно.
- Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн нийт талбай, байгаль хамгаалагчдын тоо, хүчин чадал, нөөц боломж харилцан адилгүй байх тул хамгаалалтын захиргаа энэ бүхнийг нарийн тооцож үнэлэн нэг удаагийн эргүүл, хяналт шалгалтын хамрах талбай, туулах зайг төлөвлөнө.

**Жишээ нь,** Говийн Бага дархан цаазат газар нь нийт 19 байгаль хамгаалагчтай бөгөөд нийт нутаг дэвсгэрийн хэмжээ нь 1.8 сая га. Нэг байгаль хамгаалагч дунджаар 100,000-110,000 га талбайг хариуцаж ажилладаг. Нэг байгаль хамгаалагч сард 2 удаа төлөвлөгөөт хяналт шалгалтыг нийт 400 км зам туулан хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байдаг. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг, хэрэг, зөрчил гарсан, энэ талаар дуудлага ирсэн, эсвэл сэжигтэй гэж үзсэн тохиолдолд хэдэн ч удаа хийх боломжтой.

Судалгаа, мониторингийн зорилготой эргүүлийг тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө болон хамгаалахаар сонгон авсан үнэт зүйлтэй уялдуулан зохион байгуулна. Тэгэхдээ тухайн газар нутагт амьдарч буй зэрлэг амьтад, ховор ургамлын шинж чанарт тохируулан сонгох нь зүйтэй. Энэ тохиолдолд байгаль хамгаалагчид нь биотехникийн арга хэмжээ, сургалт сурталчилгааны чиглэлээр SMART программ дээр бүртгэл мэдээлэл хөтлөн, захиргааны мэргэжилтэнд мэдээлэх үүрэгтэй.

**Бэлтгэл ажил, хэрэгцээт багаж, техник хэрэгслүүд.** SMART программ ашиглан эргүүл, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд дараах техник, тоног төхөөрөмжийг урьдчилсан бэлтгэх нь зүйтэй. Үүнд:


- SMART программ суулгасан ухаалаг гар утас болон бусад төхөөрөмж
- Маршрутыг газрын зурагт урьдчилан бэлдэх
- Нэмэлт батарейтай гар чийдэн
- Тухайн цаг агаарт тохирсон ажлын хувцас
- Нэгээс дээш хоногоор эргүүл хийх бол аяны хөнжил, гудас
- Мотоцикл, машин, хөнгөн идэж уух зүйлсийг өөрт тохируулан авч явах
- Бусад хэрэгтэй зүйлс зэргийн заавал тооцон бэлдэх шаардлагатай.

Анхаарах зүйлс:


- SMART программ суулгасан ухаалаг гар утас болон бусад төхөөрөмжийн цэнэгийг 100% байлгах

- Эргүүл саатсан болон төлөвлөсөн маршрутаас гадуур хууль бус үйл ажиллагааны мэдээлэл хүлээн авсан тохиолдолд хэрэглэх 20%-ийн нэмэгдэл шатахуун бэлдсэн байх
- Зөөврийн цэнэглэгч авах
- Машин, мотоциклийн бүрэн бүтэн байдлыг шалгасан байх
- Анхны тусламжийн хайрцаг
- Бусад хэрэгцээтэй зүйлс.


**Эргүүл хяналтын мэдээллийг цуглуулах.** Байгаль хамгаалагч нь (1) Хүний үйл ажиллагаа, (2) Зэрлэг амьтдын ажиглалт, (3) Байгалийн тогтоц гэсэн үндсэн 3 төрлийн бүртгэл мэдээллийг хөтөлнө.



**Зураг 3.6.** Үндсэн цэс



**Зураг 3.7.** Байршил авах



**Зураг 3.8.** Заавал бөглөх талбар


Эргүүл, хяналт шалгалтын бүртгэлийг байгаль хамгаалагч зөвхөн Монгол хэл дээр бөглөнө. Эргүүл эхлүүлэх үед байршлын солбицлыг (координатыг) программын **байршил** хэсэгт автоматаар уншиж дууссаны дараа эргүүл эхлэхэд бэлэн болно (Зураг 3.7).

Бүртгэлийн өмнө (\*) тэмдэг байвал тухайн бүртгэлийг зайлшгүй бөглөснөөр цааш ажиглалт хэвийн үргэлжилнэ. Хэрэв (\*) тэмдэг бүхий бүртгэлийг бөглөөгүй тохиолдолд улаан өнгөтэй болж анхааруулна (Зураг 3.8). Мөн тухай шинж тэмдэг, нотлох эд мөрийн баримтыг өргөн өнцгөөс харж гэрэл зураг авах шаардлагатай. SMART программ ашиглан видео бичлэг хийх, гэрч болон тухайн зөрчил, гэмт хэрэг үйлдэгч этгээдтэй газар дээр нь тааралдаж байгаа тохиолдолд дуу хураах боломжтой байдаг.


Эргүүл хяналт, шалгалтыг 1-ээс дээш хоногоор зохион байгуулах үед эхний өдрийн ажиглалтыг хадгалж программын эргүүл цэсээс **эргүүлийг түр зогсоох** сонголтыг дарж идэвхжүүлснээр тухайн эргүүл түр зогсох горимд шилжинэ (Зураг 3.9). Маргааш өдөр нь программыг үргэлжлүүлэн эхлүүлэх сонголтыг дарснаар цааш үргэлжлүүлж болно. Мөн эргүүл, хяналт шалгалт хийж байх хугацаанд гэнэтийн хувийн асуудал гарсан, нэг газраа ажлын бус шалтгаанаар удаан зогсох эсвэл техник хэрэгсэл авдрэх зэргээр хяналт шалгалтыг түр хугацаанд хийх боломжгүй болсон үед ашиглаж болно.



**Зураг 3.9.** Эргүүлийг түр зогсоох



**Зураг 3.10.** Эргүүлийг дуусгах



**Зураг 3.11.** Туулсан зайг (км) харах

Эргүүл, хяналт шалгалтыг дуусгах үед эргүүл цэсээс **эргүүлийг дуусгах** сонголтыг дарж эргүүлийг дуусгана (Зураг 3.10). Энэ сонголтыг дараагүй тохиолдолд программ хэвийн ажилласаар байх болно.

Эргүүл хяналт, шалгалтын нийт туулсан зай, явсан хурд, бусад мэдээллийг харахыг хүсвэл **статистик** гэсэн сонголтыг дарж харна (Зураг 3.11).

**Хүний үйл ажиллагаа.** Энэ бүртгэлд хүний үйл ажиллагаатай холбоотой ажиглалтуудын мэдээ баримтыг оруулна. Нийт 14 дэд ажиглалтуудаас бүрддэг бөгөөд тэдгээрийн утгын дэлгэрэнгүйг хүснэгт 3.1-д оруулав.

**Хүснэгт 3.1. Хүний үйл ажиллагаатай холбоотой бүртгэл**

Дугаар	Ажиглалтын нэр	Бүртгэл
1.1	Хүн - шууд ажиглалт	Зөрчил
		Авсан арга хэмжээ
		Хүний тоо
		Нэр
		Хүйс
		Нас
		Иргэншил
		Регистрийн дугаар
		Оршин суугаа хаяг
		Зэвсэгтэй эсэх
		Галт зэвсэг, тоног төхөөрөмжийн төрөл
		Сумны төрөл
		Галт зэвсгийн сериал тоо
		Холбоо барих дугаар
1.2	Хүн-ул мөр ажиглалт	Тайлбар
		Ул мөрийн төрөл
		Ул мөрийн насжилт
		Зөрчил
1.3	Кемп / Отог	Авсан арга хэмжээ
		Үйл ажиллагаа
		Зөрчил
		Төлөв
		Нэр
		Зөвшөөрөлтэй эсэх
		Хөрсөнд нэвчилттэй жорлонгийн тоо
		Хөрсөнд нэвчилтгүй жорлонгийн тоо
		Авсан арга хэмжээ
		Торгууль
Тайлбар		
1.4	Байгалийн дагалдах баялаг (БДБ)	Зөрчил
		БДБ-ын төрөл
		Нэгж
		Хэмжээ
		Авсан арга хэмжээ
		Торгууль

Дугаар	Ажиглалтын нэр	Бүртгэл
1.5	Түймэр	Зөрчил
		Галын шалтгаан
		Түймэрт өртсөн талбай (га)
		Амьтны төрөл, зүйл
		Үхэл хорогдлын тоо
		Авсан арга хэмжээ
		Торгууль
1.6	Мод бэлтгэл	
	1.6.1 Гуалин	Зөрчил
	1.6.2 Түлшний мод	Модны төрөл
	1.6.3 Хожуул	Хэмжээ
	1.6.4 Банз	Авсан арга хэмжээ
	1.6.5 Мод шилжүүлэн суулгах	Торгууль
1.7	Тээврийн хэрэгсэл	Зөрчил
		Тээврийн хэрэгслийн төрөл
		Улсын дугаар
		Гэрчилгээний дугаар
		Эзэмшигчийн нэр
		Жолоочийн нэр
		Авсан арга хэмжээ
Торгууль		
1.8	Мал аж ахуй	Өрхийн эзний нэр
		Амьтны төрөл
		Амьтны тоо
1.9	Уул уурхай	Төрөл
		Төлөв
		Байршил
		Байгууламжийн хэмжээ
		Ашигт малтмалын төрөл
		Талбайн хэмжээ /га/
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч
1.10	Эрдэс баялаг	Зөрчил
		Эрдэс, баялгийн төрөл
		Нэгж
		Хэмжээ
		Авсан арга хэмжээ
		Торгууль

Дугаар	Ажиглалтын нэр	Бүртгэл
1.11	Бохирдол	Бохирдлын төлөв
		Хуулийн этгээд
		Ангилал
		Талбайн хэмжээ /га/
		Хог хаягдлын төрөл
		Зөвшөөрөлтэй эсэх
		Авсан арга хэмжээ
		Торгууль
		Тайлбар
1.12	Аялал жуулчлал	Иргэншил
		Насны ангилал
		Хүйс
		Хүний тоо
		Тайлбар
1.13	Айлын мэдээлэл	Овог
		Өрхийн эзний нэр
		Хүйс
		Ам бүлийн эмэгтэйн тоо
		Ам бүлийн эрэгтэйн тоо
		Хүүхдийн тоо
		Ачааны машин/тоо
		Суудлын машин/тоо
		Мотоциклийн тоо
		Төрөл
		Газар, усны нэр
		Багийн нэр
		Утасны дугаар
Худгийн нэр		
1.14	Сургалт, сурталчилгаа	Сургалтын төрөл хэлбэр
		Байршил
		Оролцсон иргэдийн тоо
		Сэдэв
		Тараах материал өгсөн эсэх
		Тараасан материалын тоо

**Зэрлэг амьтдын ажиглалт.** Тусгай хамгаалалттай газар нутгийн дэвсгэр нутаг дахь зэрлэг амьтантай хамаарал бүхий ажиглалтын мэдээ, баримтыг энэ хэсэгт бүртгэнэ. Зэрлэг амьтдын ажиглалтын мэдээ, бүртгэл нь 4 дэд хэсгээс бүрдэнэ. Зэрлэг амьтдын ажиглалтаар Монгол Улсын Улаан ном (2013) болон Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN, 2006)-ны Улаан дансанд ховордлын өндөр зэрэглэлээр орсон биологийн төрөл зүйл, ховор, нэн ховор амьтан, ургамлын зүйлүүдэд тулгарч буй аюул дарамт, зөрчлийг бүртгэлжүүлэх, мониторинг мэдээлэл цуглуулах нь энэ хэсгийн нэн тэргүүний зорилго болно.

### Хүснэгт 3.2. Зэрлэг амьтдын ажиглалт

Дугаар	Ажиглалтын нэр	Бүртгэл
2.1	Зэрлэг амьтан-шууд ажиглалт	Зөрчил
		Амьтны төрөл зүйл
		Амьтдын тоо /эр/
		Амьтдын тоо /эм/
		Амьтдын тоо /үр төл/
		Амьтдын тоо /нас, хүйс тодорхойгүй/
		Өвчлөлийн шинж тэмдэг илэрсэн эсэх
2.2	Зэрлэг амьтан-ул мөр	Зөрчил Амьтны төрөл зүйл Ул мөрийн насжилт
	2.2.1 Ул мөр	
	2.2.2 Хоргол	
	2.2.3 Дуу чимээ	
	2.2.4 Үүр	
	2.2.5 Идэш тэжээл	
	2.2.6 Хумсны мөр	
	2.2.7 Үнэр	
2.3	Сэг зэм	Зөрчил
		Амьтны төрөл зүйл
		Хорогдлын шалтгаан
		Сэг зэмийн насжилт
		Амьтны нас
		Хүйс
		Олзворын төрөл
		Авсан арга хэмжээ
2.4	Олзвор	Тайлбар
		Зөрчил
		Амьтны төрөл зүйл
		Олзвор
		Олзворын тоо
		Жин кг
		Урт см
Авсан арга хэмжээ		

**Байгалийн тогтоц.** Энэ хэсэг нь байгалийн тогтоц бүхий дурсгалт газрууд, уст цэгүүд, ой болон ургамал гэх зэрэг нийт 8 дэд ажиглалтаас бүрдэнэ (Хүснэгт 3.3).

**Хүснэгт 3.3. Байгалийн тогтоцын талаарх ажиглалт**

Дугаар	Ажиглалтын нэр	Бүртгэл
3.1	Дурсгалт газар	Зөрчил
		Төрөл
		Нэр
		Төлөв
		Тайлбар
3.3	Газар, газрын хэвлий	Газар усны нэр
		Газрын төрөл
		Талбайн хэмжээ /га/
		Гүйцэтгэгчийн нэр
3.4	Уст цэг	
	3.4.1 Байгалийн уст цэг	Усны төрөл
		Нэр
		Устай эсэх
		Тайлбар
	3.4.2 Худаг	Хийц
		Тоолууртай эсэх
		Зориулалт
		Эзэмшигч
	3.5	Ойн сан
3.5.1 Байгалийн ой		Ойн төрөл
		Талбайн хэмжээ /га/
		Доройтсон эсэх
		Хортонд нэрвэгдсэн эсэх
		Тайлбар
3.5.2 Бусад ой		Ойжуулалтын хэлбэр
		Тарьсан модны төрөл
		Тарьсан модны тоо
		Талбайн хэмжээ /га/
		Ойжуулалт хийсэн он
		Усалгааны төлөв
		Хашаатай эсэх
	Хортонд нэрвэгдсэн эсэх	
Тайлбар		

Дугаар	Ажиглалтын нэр	Бүртгэл
3.6	Ургамал	Төрөл зүйл
		Ургамлын төлөв
		Ашиглалтын төрөл
		Талбайн хэмжээ /га/
		Ашиглалтын нөөц /тн/
		Зөрчил
		Торгууль
3.7	Биотехник	Газар усны нэр Хэмжээ Тайлбар
	3.7.1 Ус мөс	
	3.7.2 Өвс тэжээл	
	3.7.3 Хужир, долооц	
	3.7.4 Нөхөн сэргээсэн талбай	
	3.7.5 Цэвэрлэсэн талбай	
	3.7.6 Будаа, тэжээл	
	3.7.7 Булаг шанд хаших	
	3.7.8 Хөв цөөрөм байгуулах	
	3.7.9 Махан идэш	
3.8	Судалгааны төхөөрөмж суурилуулалт	Төхөөрөмжийн төрөл
		Төхөөрөмжийн төлөв
		Төхөөрөмжийн дугаар
		Газар, усны нэр
		Зориулалт

## 3.5 SMART МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН МЕНЕЖМЕНТ

**Хэрэглэгчийн түвшний зөвшөөрөх болон хориглох үйлдлүүд.** Компьютерт суулгасан SMART программд нэвтрэх олон төрлийн хандалтын эрх байдаг. Энэ нь хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүд, бусад ажилчдад тохирох хэрэглэгчийн түвшнийг тогтоох боломжийг олгодог.

SMART программ нь уян хатан бөгөөд ажилтны ажлын үүрэгт гарсан өөрчлөлтийг харгалзан хэрэглэгчийн бүртгэлийг шинэчлэх боломжтой. Одоогоор үндсэн 3 төрлийн хандалтын эрхийг ашиглан SMART программд нэвтэрч байна.

**SMART программыг ашиглах хэрэглэгчийн эрхүүд.** SMART программд буюу компьютерт суулгасан үндсэн программ дээр мэдээлэл оруулах, засварлах үндсэн 3 эрхээр программыг ашиглана. Үүнд:

- Мэдээ оруулах
- Менежер
- Админ гэсэн гурван эрх байна.

**Мэдээ оруулах эрх.** Энэ нь тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэл SMART холбоост холбогдсон эсэхээс хамааран хоёр төрөл байна.

- SMART Холбоост холбогдоогүй тохиолдолд мэдээг программ руу оруулах хэсэг нь гар буюу механик аргаар хийгдэнэ. Байгаль хамгаалагч эргүүл, хяналт шалгалт (ЭХШ)-ын мэдээг хамгаалалтын захиргааны мэргэжилтэн рүү цахим шуудан ашиглан илгээх боломжтой, эсвэл SMART программд суусан утасны дотоод санах ойгоос (internal storage) хуулж аваад программ уруу зөөвөрлөн оруулж болно. Энэ хэсгийг мэргэжилтэн хийж гүйцэтгэнэ.
- SMART Холбоост холбогдсон тохиолдолд ЭХШ-ын мэдээ нь автоматаар серверт байрших бөгөөд программд нэвтэрсэн админ эрхтэй мэргэжилтнүүд серверээс татан авч байршуулна.

**Админ эрх.** Админ бүртгэл нь SMART программын бүх функц болон сонголтуудад бүрэн хандах эрхтэй.

(а) Байгаль хамгаалагчаас илгээсэн эргүүлийг SMART программд оруулах, (б) эргүүлийн бүх мэдээллийн чанарыг шалгах, (в) Эргүүл, хяналт шалгалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуулга, хураангуйг боловсруулж гаргах, (г) Гаргасан хураангуй асуулгын үр дүнд тулгуурлан тайлан гаргах.

Энэ арга зүйн 3.6-д заасан тайлангийн форматыг ашиглан 7-14 хоногийн эргүүл бүрд SMART эргүүлийн тайлангийн төслийг бэлтгэх ба сар бүрийн тайланг тусгай хамгаалалттай газар нутгийн даргад илгээж дараагийн сард хийх эргүүлийн зөвлөмжийг багцлан хүргэнэ.

Эргүүл, хяналт шалгалтын сарын тайланг архивлаж, өгөгдөл, тайланг алдахаас сэргийлэхийн тулд бүх файлыг компьютерын хатуу санах ойд “Мэдээллийн сангийн мэдээллийг нэгтгэх байгууллага болон стандарт” хэсэгт заасны дагуу нөөцөлж, хадгална.

**Мэдээллийн сангийн мэдээллийг нэгтгэх байгууллага болон стандарт.** Хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, тухайн тусгай хамгаалалттай газар нутаг SMART холбоост холбогдсон эсэхээс үл хамааран байгаль хамгаалагч нарын хийж гүйцэтгэж буй бүртгэлийн мэдээллийг өөрийн тусгай хамгаалалттай газар нутгийн архивд нэгтгэж хадгалах үүрэгтэй.

Захиргааны мэргэжилтэн сар бүрийн мэдээ бүртгэлийг SMART программ дээр татан авч байршуулан, зохих засвар, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг шалган тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн онцлогт тохируулан эргүүл, хяналт шалгалт, судалгаа мониторингийн мэдээнд нэр өгөн хадгалж, хатуу диск (hard drive) буюу компьютерын санах ойд мэдээллийн сан бий болгоно.

Байгаль хамгаалагчийн сар бүрийн төлөвлөгөөт хяналт шалгалт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт, судалгаа мониторинг гэх мэтчилэн үндсэн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэж буй бүртгэлийг нэр өгч хадгалах стандарт байдаг. Гэхдээ үүнийг тусгай хамгаалалттай газар нутаг өөрийн онцлогт тааруулан дурын байдлаар өөрчлөх боломжтой.

Нэр өгч хадгалах стандарт: **Байгаль хамгаалагчийн нэр\_сар\_өдөр\_он**

Жишээ нь, байгаль хамгаалагч Батын 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр хийсэн эргүүл хяналт шалгалтын мэдээ SMART программд татан байршуулсан гэж үзье. Тухайн эргүүлийн мэдээний нэрийг дараах хэлбэрээр хадгална: **Бам\_01032023**

SMART программ дээр байршуулсан бүртгэлийн мэдээг компьютерын санах ойд экспортлон гаргаж хадгалах шаардлагатай байдаг. Ингэснээр тухайн SMART программд ямар нэгэн байдлаар алдаа гарах, программ устах гэх мэтчилэн асуудал тулгарсан үед нөөц мэдээллийн сан хатуу диск дээр үлдэх ач тусгай юм.

Хатуу диск дээр бүртгэлийн мэдээг хадгалахдаа мөн адил стандартын дагуу эмх цэгцтэй байршуулах нь чухал. Тухайн тусгай хамгаалалттай газар мэдээллийн сангаа үүсгэхдээ он, сар тус бүрд нь хавтас нээн хадгална (Зураг 3.12).

### Зураг 3.12. Мэдээллийг хадгалах газвар

The screenshot displays the Windows File Explorer interface. The main window shows the path: This PC > DATA (D:) > Говийн бага ДЦГ. Below this, a list of folders for the years 2016 through 2020 is shown, with their respective modification dates and types (File folder). The 2020 folder is selected and expanded, revealing a list of monthly folders: 1p сар, 2p сар, 3p сар, 4p сар, 5p сар, 6p сар, and 7p сар, all with modification dates of 2/17/2023. A second window shows the 2022 > 11p сар folder expanded, displaying a list of compressed files (zip files) with names like Азжаргал\_11112022, Азжаргал\_11232022, Батдэлгэр\_11042022, Батдэлгэр\_11132022, Батсүх\_11012022, and Батсүх\_11022022, all with modification dates of 2/17/2023.

## 3.6 ТАЙЛАГНАХ

СМАРТ нь зөвхөн байгаль хамгаалагчдын эргүүл, хяналт шалгалт хийж байх үед цуглуулсан мэдээллийг хадгалах газар биш юм. Энэ бол эргүүл, хяналт шалгалтын өнөөгийн чиг хандлага, хэв маягт дүн шинжилгээ хийх, тайлагнах хэрэгсэл болдог.

Тайлан нь захиргааны мэргэжилтэнд өгөгдлийг дүрслэн харуулах, эргүүлийн орон зайн хуваарилалтыг харуулсан газрын зургийг үзэх, хүний үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, зэрлэг ан амьтдын бүртгэл, мөн өгөгдлийг нэгтгэсэн хүснэгтүүдийг харах боломжийг олгодог.

Ямар зорилгоор ашиглахаас хамаараад тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад тайланг өөрийн онцлогт тааруулан үүсгэж болно. Жишээ нь, хулгайн антай тэмцэх ажлын үр дүнг сар бүр тогтмол мэдээлэх зорилготой тайлан бэлдэж болно. Эсвэл эргүүл, хяналт шалгалтын өдөр тутмын мэдээг нэгтгэн харуулдаг өдөр бүрийн тайлан гаргах боломжтой.

Тайланг сар дутам, улирлаар эсвэл жилийн эцэст нэг гаргах нь тохиромжтой. Үүнийг захиргааны мэргэжилтэн гаргаж тусгай хамгаалалттай газар нутгийн даргад танилцуулж, цааш Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газарт тайлагнана.

Тайлангийн загвар бэлэн болгоход түүнд орох өгөгдлийн үр дүнг харуулах асуулга (Query) СМАРТ программд бэлэн болсон байх шаардлагатай. Үүний дараа асуулгын үр дүнг тайлангийн хэлбэрээр хэрхэн танилцуулах талаар мэргэжилтэн сурч эзэмшсэн байх ёстой. Асуулга бичих анхан шатны хичээл Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн (WCS) youtube хуудсанд нээлттэй байршсан байгаа. СМАРТ программ дээрх тайлангуудыг янз бүрийн форматаар (Word, PDF г.м) экспортлох, тайлангийн тодорхойлолтыг бусадтай хуваалцах боломжтой.

Тайланд дараах мэдээллүүд зайлшгүй орсон байх шаардлагатай. Үүнд:

- Байгаль хамгаагчийн хийж гүйцэтгэсэн эргүүл, хяналт шалгалтын мэдээлэл
  - i. Эргүүл, хяналт шалгалтын тоо
  - ii. Эргүүл, хяналт шалгалт хийсэн өдрийн тоо
  - iii. Туулсан зам (км)
- Илрүүлсэн зөрчлийн мэдээ (тусгай хамгаалалттай газар нутаг бүр өөр өөрийн онцлогтой тул илрүүлсэн зөрчлийн мэдээ нь харилцан адилгүй байна). Үндсэн 5 төрлөөр авч үзэж зөрчлийн мэдээг тайлагнана.
  - i. Нэн ховор, ховор амьтдыг агнасан, худалдаалсан
  - ii. Нэн ховор, ховор ургамал түүсэн, худалдаалсан
  - iii. Хууль бус ашигт малтмал олборлогч, хайгуул
  - iv. Зөвшөөрөлгүй байгалийн дагалдах баялаг ашиглах
  - v. Зөвшөөрөлгүй үйлдсэн зөрчлүүд (нэвтрэх, галт зэвсэг авч явах, барилга байгууламж барих г.м)
- Ажигласан зэрлэг амьтдын мэдээлэл (газрын зургийн хамт). Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд заасан гол үнэт зүйлийн амьтныг төрөл, зүйлээр нь гаргаж харуулах.
  - i. Эр, эм, үр төл, нийт тоогоор
  - ii. Өвчлөлийн мэдээлэл байгаа эсэх
  - iii. Амьтдын зүйл тус бүрээр тархацыг харуулсан газрын зураг

- Хууль бусаар агнасан амьтдын сэг зэмийн мэдээлэл. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд заасан гол үнэт зүйлийн амьтны төрөл зүйлээр гаргаж харуулах. Газрын зургийн хамт гаргах.
  - i. Амьтны төрөл
  - ii. Амьтны тоо
  - iii. Байршил
- Биотехникийн арга хэмжээ.
  - i. Ус, мөс байршуулсан хэмжээ
  - ii. Хужир долооц байршуулсан хэмжээ
  - iii. Өвс тэжээл тавьсан хэмжээ
  - iv. Цэвэрлэгээ хийсэн талбайн хэмжээ
  - v. Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ
- Сургалт сурталчилгааны ажил хийсэн мэдээлэл
  - i. Сургалт сурталчилгаанд хамрагдсна иргэдийн тоо
  - ii. Тараасан материалын тоо

Бусад мэдээллийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа дурын байдлаар сонгон тайлагнах юм.

### 3.7 ХОЛБООС (CONNECT)

SMART — Холбоос бол SMART программын дараагийн үе шатны дэвшилтэт технологийн аргачлал юм. SMART нь одоогоор дэлхийн хэмжээнд 1000 гаруй тусгай хамгаалалттай газарт хэрэгжиж, SMART хэрэглэгчийн нийгэмлэг нь улам бүр тэлсээр байна.


SMART Холбоос нь цахим орчинд тусгай хамгаалалттай газар нутгийн бүртгэл мэдээллийг холбох, нэгтгэх үйл явцыг хөнгөвчлөх нэмэлт хэрэгсэл болон бүтээгдсэн үйлдлийн сүлжээ (сервер) юм. SMART Холбоос нь дараах давуу талуудыг бий болгодог. Үүнд:

- SMART хэрэглэгчдэд веб-д суурилсан мэдээллийн санд өгөгдлийг хадгалах, удирдах боломжийг олгодог.
- Тухайн тусгай хамгаалалттай газар нутагт хийгдэж буй эргүүл, хяналт шалгалтын мэдээг бодит цаг хугацаанд цуглуулах, хуваалцах, илүү үр дүнтэй, хурдан шуурхай хариу арга хэмжээ авна.
- Олон тусгай хамгаалалттай газар нутгийг SMART Холбоосоор дамжуулан нэгдсэн байдлаар удирдана.
- Өгөгдөл дамжуулах хурдыг нэмэгдүүлнэ.
- Бусад системтэй нэгтгэх замаар шийдвэр гаргахад шаардлагатай эргүүл, хяналт шалгалтын мэдээнд дүн шинжилгээ хийж, дүрслэл, үр дүнг сайжруулна.
- Гар утасны мэдээлэл цуглуулах нэмэлт хэрэгслийг дэмждэг (UHF/VHF дижитал радио).
- SMART өгөгдлийг I2 эсвэл ArcGIS зэрэг бусад системд шилжүүлэн дүн шинжилгээ хийнэ.

Шаардагдах тоног төхөөрөмж:

- Интернет (хурдны доод хязгаар 10mb)
- Суурин болон зөөврийн компьютер (хамгийн багадаа 16GB RAM-тай байх)

**Зураг 3.13. SMART-ын хэрэглэгчдийн сүлжээ**



**Холбоосыг ашиглах эрхүүд.** Холбоос нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс серверт нэвтрэх эрхүүдийг хандах хандалтаар нь тусгайлан сонгох, өөрчлөх боломжийг олгодог. Ингэснээр мэдээллийн аюулгүй байдал, нууцлал үлэмж сайжирна.

СМАРТ-ын хувьд холбоосыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны серверт байршуулж, хандах эрхийг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар хариуцан ажиллана. Холбоос серверт байршсаны дараа тусгай хамгаалалттай газар нутаг тус бүрд серверийн хаягийг илгээж хандах эрхтэйгээр бүртгэлжүүлнэ.

Хандах эрхийн төрлүүд:

- Administrator/Админ: СМАРТ холбоос доторх бүх тусгай хамгаалалттай газар нутгийн функц, мэдээлэл, тайлан, бусад хандах эрхүүд, тэдгээрийг засах, өөрчлөх, устгах болон нэмэх эрхтэй.
- CA Administrator/ТХГ-ын админ: Зөвхөн сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутгийн бүх функц, мэдээлэл, тайлан, бусад хандах эрхүүдийг засах, өөрчлөх, устгах болон нэмэх эрхтэй.
- Add Conservation area/ТХГ нэмэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийг шинээр нэмэх эрхтэй.
- View Conservation area/ТХГ-ын мэдээллийг үзэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг харах эрхтэй.
- Update Conservation area/ТХГ-ын мэдээллийг шинэчлэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг засах, шинэчлэх эрхтэй.
- Delete Conservation area/ТХГ-ыг устгах: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг устгах эрхтэй.
- View alerts in CA/ТХГ-ын анхааруулгыг үзэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн эргүүл, хяналт шалгалтын анхааруулах мэдээг үзэх эрхтэй.
- Create alerts in CA/ТХГ-д анхааруулах мэдээг үүсгэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн анхааруулах мэдээг шинээр үүсгэх эрхтэй.
- Update alerts in CA/ТХГ-ын анхааруулах мэдээг шинэчлэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн анхааруулах мэдээг шинэчлэх эрхтэй.
- Delete alerts in CA/ТХГ-ын анхааруулах мэдээг устгах: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн анхааруулах мэдээг устгах эрхтэй.
- Run query/Асуулгыг ажиллуулах: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн асуулгыг ажиллуулан үр дүнг гаргаж авах, харах эрхтэй.
- Run profile query/Хавтаст хэргийн асуулгыг ажиллуулах: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн хавтаст хэргийн асуулгыг ажиллуулан үр дүнг гаргаж авах, харах эрхтэй.
- View profile data (Entities & records)/Хавтаст хэргийн мэдээг үзэх: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн хавтаст хэргийн мэдээллийг үзэх эрхтэй.
- View data queue items/ЭХШ-ын өгөгдлийн дарааллыг серверээс харах: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн хийж гүйцэтгэсэн эргүүл, хяналт шалгалтын мэдээллийг серверт байршсан дарааллын мэдээллийг үзэх эрхтэй.
- Delete data queue items/ЭХШ-ын өгөгдлийн дарааллыг устгах: СМАРТ холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн аль хамгаалагчийн хийж гүйцэтгэсэн эргүүл, хяналт шалгалтын мэдээллийг серверт байршсан дарааллыг устгах эрхтэй.

- Process (and Update) data queue items/ЭХШ-ын өгөгдлийн дарааллыг боловсруулах болон шинэчлэх: SMART холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн хийж гүйцэтгэсэн эргүүл, хяналт шалгалтын мэдээллийн серверт байршсан дарааллыг шинэчлэх эрхтэй.
- Add/Upload files to data queue/ЭХШ-ын өгөгдлийн дараалал руу мэдээ нэмэх: SMART холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн хийж гүйцэтгэсэн эргүүл, хяналт шалгалтын мэдээллийн серверт байршсан дараалалд нэмж мэдээ оруулах эрхтэй.
- Run report/Тайлан гүйлгэх: SMART холбоост зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн тайланг ажиллуулж, үр дүнг харах, татаж авах эрхтэй.
- SMART mobile API/SMART гар утасны багц.

Эдгээр эрхүүдийг харгалзан Administrator/Админ эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар хариуцан хандах эрхийг үүсгэнэ. Цаашлаад тусгай хамгаалалттай газар нутгийн тус бүрд CA Administrator/ТХГ-ын админ эрхээр нэг бүртгэл нээж нэвтрэх нэр, нууц үг олгоно.

View Conservation area/ТХГ-ын мэдээллийг үзэх, View alerts in CA/ТХГ-ын анхааруулгыг үзэх, Run report/Тайлан үзэх гэх зэрэг эрхүүдийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны зохих мэргэжилтнүүд болон бусад албан тушаалтанд олгон бүртгэлжүүлнэ.

**Холбоосыг ашиглах нь.** Хамгийн энгийнээр авч үзвэл суурин компьютер дээрх SMART программд тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэл байх ба давхар интернэт орчинд (үүлэн дээр суурилсан сервер) тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэл адилхан байх ёстой. Байгаль хамгаалагч нарын оруулсан эргүүл, хяналт шалгалтын мэдээлэл интернэт орчны тусламжтайгаар серверт байршиж буй тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан руу автоматаар очих юм.


Ингэснээр захиргааны ажилтан серверээс байгаль хамгаалагч нарын эргүүл, хяналт шалгалтын мэдээллийг цаг алдалгүй татан авах боломжтой болно. Мөн тухайн суурин компьютер дээр суусан SMART-ын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг дэлхийн өнцөг булан бүрд байрлан ажиллаж буй захиргааны мэргэжилтэн болон удирдах албан тушаалтан хянах, дүн шинжилгээ хийх зэргээр тогтмол мэдээллийг авах боломжтой юм. Үндсэн серверийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар нэгдсэн байдлаар авч явна. Үүнд:

- Серверт хандах эрх
- Серверийн хэвийн үйл ажиллагааг хариуцах
- Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг тогтмол хянах, дүн шинжилгээ хийх.


Сервер шинээр үүсгэх болон сервертэй холбоотой асуудал тулгарсан үед Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS Mongolia)-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт хандана уу <https://mongolia.wcs.org/>.

Үндсэн серверт тухайн тусгай хамгаалалттай газар нутгийг холбох шаардлагатай тул программын холбоос цэсэд серверийн тохируулгыг хийнэ (Зураг 3.14). Үүний дараа мэдээллийг серверт байршуулна (Зураг 3.15).

### Зураг 3.14. Серверийн тохируулга хийх байдал




### Зураг 3.15. Серверт тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг байршуулах нь



Тухайн тусгай хамгаалалттай газар нутаг холбоосыг ашиглаж байгаа бол мэдээллийг шинэчлэх (update/sync) хэсгийг зайлшгүй хийх шаардлагатай. Ингэснээр суурин компьютер дээр суулгасан SMART программ болон сервер дээр байрлах SMART дахь тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллүүд нэг ижил байх нөхцөл бүрддэг.

Үүний тулд тухайн захиргааны мэргэжилтэн суурин компьютер дээр суулгасан SMART программ дээр өөрчлөлт, шинэчлэлт хийсэн болон байгаль хамгаалагч нарын мэдээллийг татан авах бүрдээ энэхүү шинэчлэлийг сервер дээр байрлах хувилбар руу хуулснаар нэг ижил байх боломж хангагдана (Зураг 3.16).


### Зураг 3.16. Шинэчлэлийг нэгтгэх, хуулах нь



Холбоос дээр байрлах газрын зураг цэсээс тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч нарын хийж гүйцэтгэсэн эргүүл, хяналт шалгалтын явцыг харах боломжтой. Ингэхдээ, бүх мэдээллийг бус, харин нэн тэргүүний, зайлшгүй шаардлагатай зөрчил болон амьтдын талаарх ажиглалтыг тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн онцлогоос хамааран харилцан өөр өөрөөр тохируулж болдог (Зураг 3.17).

Үүнийг анхааруулах мэдээ (alerts) гэх ба холбоос дээрээс шинээр үүсгэх болон устгах үйлдлүүдийг хийнэ. Бүртгэлүүд бэлэн болсон тохиолдолд газрын зураг цэсээс байгаль хамгаалагч нарын эргүүл, хяналт шалгалтын мэдээллийг цаг тухай бүрд нь хянах боломжтой.

**Зураг 3.17.** SMART холбоосны газрын зураг



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

**ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР БА  
ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ**



## 4.1 ХАРИЛЦААНЫ ҮНДЭС БА СОЁЛ

### 4.1.1. Харилцааны ур чадвар гэж юу вэ?

**Энэ бол** хүн өөрийн бодол, санаа, мэдээлэл, мэдрэмжийг бусадтай тодорхой, ойлгомжтой бөгөөд үр дүнтэй байдлаар солилцох, бусдын мэдээллийг хүлээн авч ойлгох, мөн харилцааны зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх чадвар юм. Энэ нь аман, бичгийн, биеийн хэлэмж болон сонсох чадварыг багтаасан олон талт ур чадвар бөгөөд хувь хүн, баг, байгууллагын түвшинд харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих үндсэн суурь болдог.

*Энэхүү чадвар нь орчин үеийн бусадтай харилцах чадвар буюу EQ (Emotional Quotient)-ийн гол бүрэлдэхүүн хэсэгт тооцогддог бөгөөд хувь хүний амжилт, мэргэжлийн өсөлтөд чухал нөлөө үзүүлдэг.*

### 4.1.2. Харилцаа гэж юу вэ?

Монгол хэлний их тайлбар тольд “Харилцаа” гэдгийг “харилцах үйлийн нэр буюу хэлхээ холбоо тогтоох ажиллагаа” хэмээн тайлбарласан байдаг. Харилцах гэдэг нь хүмүүс хоорондоо холбоо барих, уулзах, бие биедээ юм өгөх, авах зэрэг өргөн хүрээний утгатай (Монгол хэлний их тайлбар толь). Жишээ нь:

- Биеэр харилцах (биеэр уулзах)
- Бөмбөг харилцах (бөмбөгийг бие биедээ дамжуулах)
- Захидлаар харилцах (бие биедээ захидал бичилцэх)
- Шуудангаар харилцах (шуудангаар холбогдох)
- Харилцах данс ашиглах (банкнаас мөнгө авах, хадгаламж хийх) гэх мэт.

Дээрх олон төрлийн харилцах үйлдлүүд дундаас хүмүүс хоорондоо биеэр болон бусад хэрэгслээр харилцах үйл хамгийн их ур чадвар шаарддаг. Олон улсад үүнийг EQ (Emotional Quotient) буюу сэтгэл хөдлөлийн чадамж, сэтгэл хөдлөлийн оюун ухаан эсвэл хамгийн энгийнээр харилцааны ур чадварын үзүүлэлт гэж тодорхойлох оролдлого хийх ба энэ нь бусдын мэдрэмжийг ойлгох, өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах, бусадтай үр дүнтэй харилцах чадварыг хамааруулдаг. Өнөө цагт мэргэжлийн болон оюуны чадамж (IQ)-аас илүүтэйгээр таны EQ буюу бусадтай харилцах чадвар илүү чухалд тооцогдох болсон (Бат-Эрдэнэ, 2002).

### 4.1.3. Харилцааны ач холбогдол

Харилцаа нь хувь хүн, баг, байгууллага, нийгмийн түвшинд олон талын ач холбогдолтой бөгөөд эдгээрт шууд болон дам нөлөөллийг үзүүлдэг. Үр дүнтэй харилцаа нь хувь хүний хөгжил, багийн ажиллагаа, манлайлал, нийгмийн эв нэгдэл, хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хувь хүний хувьд харилцааны ур чадвар нь өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох, шинэ мэдлэг, мэдээлэл олж авахад гол нөлөөтэй. Түүнчлэн сэтгэл хөдлөлийн чадамж буюу EQ-ийг хөгжүүлж, өөрийгөө болон бусдыг удирдах чадварыг сайжруулах үндэс болдог. Тодорхой, хүндэтгэлтэй харилцаа нь бусадтай үр дүнтэй ойлголцох боломжийг нэмэгдүүлж, эрүүл, найдвартай харилцааг бүрдүүлдэг.

Ажлын байрны түвшинд харилцаа нь ажлын уур амьсгалыг сайжруулж, багийн гишүүдийн хамтын ажиллагааг дэмждэг. Үр дүнтэй харилцааны ур чадвар нь мэдээллийг цаг алдалгүй, тодорхой, оновчтойгоор солилцох боломжийг бүрдүүлж, шийдвэр гаргах үйл явцад голлох үүрэгтэй. Сайн удирдагчид харилцааны ур чадвараа ашиглан багийн гишүүдэд урам зориг өгч, бүтээмжийг нэмэгдүүлдэг.

Нийгмийн түвшинд харилцааны ур чадвар нь зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, эв нэгдлийг хангах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй. Харилцаа нь мэдлэг, инноваци, хамтын ажиллагааг дэмжих замаар эдийн засаг, соёлын хөгжилд хувь нэмэр оруулдаг.

Үүнээс гадна, харилцаа нь хүмүүсийн аз жаргал, сэтгэл ханамжид шууд нөлөөлж, сайн харилцаатай хүмүүс илүү аз жаргалтай, урт удаан амьдардаг болохыг судалгаагаар тогтоожээ. Жишээлбэл, хувь хүний түвшинд сайн сонсогч байж, бусдын санаа бодлыг ойлгох нь харилцааг гүнзгийрүүлдэг. Менежер ажилчдынхаа санал бодлыг сонсож, шийдвэр гаргахдаа тусгаснаар итгэлцлийг бий болгодог. Байгууллагын түвшинд, Google компани харилцааны ур чадварыг хөгжүүлэх сургалтаар багийн гишүүдийн хоорондын итгэлцлийг нэмэгдүүлснээр ажлын бүтээмжийг 37%-аар өсгөсөн байна.

Шинжлэх ухааны судалгаанууд ч харилцааны ач холбогдлыг нотолдог. Жишээ нь, Albert Mehrabian-ийн судалгаагаар (1971), харилцаанд үгийн агуулга 7%, дууны өнгө 38%, биеийн хэлэмж 55%-ийг эзэлдэг болохыг харуулсан бөгөөд энэ нь харилцааны олон талт байдлыг ойлгох шаардлагатайг нотолж байна. Мөн Daniel Goleman-ийн судалгаа (1995), EQ нь амьдралын амжилтын 80%-ийг тодорхойлдог болохыг баталсан нь харилцааны ур чадварын чухлыг дахин нотолж байна. Иймд харилцааны ур чадварыг хөгжүүлэх нь хувь хүн, баг, байгууллага, нийгмийн хөгжлийн салшгүй хэсэг гэдгийг ойлгож, энэхүү ур чадварыг байнга ахиулж байх нь зүйтэй.

#### 4.1.4. Өөрийгөө таних тухай

Амжилттай харилцааны суурь нь өөрийгөө танин мэдэх тухай асуудал байдаг. Харилцаа нь эхэндээ өөрийгөө ойлгож, өөртэйгөө зөв харилцахаас эхэлдэг гэж үздэг. Хүн өөрийгөө таньж мэдэх тусмаа бусадтай илүү гүн гүнзгий ойлголцол, харилцаа үүсгэх боломжтой болдог. Энэ нь хувь хүний хөгжлийн үндэс бөгөөд олон эх сурвалжид “Өөрийгөө таних”, “Өөртэйгөө амьдарч сурах”, “Өөрийгөө хүлээн зөвшөөрөх”, “Өөрийгөө байгаа чигээр нь харах”, “Өөрийгөө үгүйсгэхгүй” гэх мэт чухал агуулгыг онцолдог (Буяндэлгэр, 2012; Казүо, 2016; Рюшүн, 2024).

Өөрийгөө бодитоор харах нь бусдыг ойлгож, бусдаар ойлгогдох харилцааны үндэс болдог. Харин өөрийгөө таньж чадаагүй, өөртөө итгэлгүй хүмүүс бусдын үзэл бодлоор өөрийгөө тодорхойлох хандлагатай байдаг. Тэд ганцаараа үлдэхээс эмээж, өөртэйгөө байхыг зовлон мэтээр хүлээн авдаг нь амьдралын олон боломжийг алдахад хүргэдэг. Харин өөрийгөө таньж, өөртэйгөө эвлэрсэн хүмүүс бусадтай харилцахдаа илүү итгэлтэй, тайван байдаг. Нар ганцаарддаггүй шиг, өөрийгөө жинхэнэ утгаар нь хүлээн зөвшөөрсөн хүн бусдаар хүрээлүүлж, амьдралдаа баяр баяслыг мэдэрдэг.



Өөрийгөө таних нь зөвхөн өөртөө итгэлтэй байхад бус, өөрийгөө хүлээн зөвшөөрч, өөрийнхөө үнэ цэнийг ойлгоход чухал. Өөрийн сул болон давуу талаа зөв таньж мэдсэнээр хүн өөрийгөө илүү амархан хөгжүүлж, бусдын санаа бодол, шүүмжлэлд хэт авталгүйгээр зорилгодоо тууштай байх боломжтой болно. Сократын “*Өөрийгөө тань. Энэ нь амьдралын хамгийн чухал мэдлэг юм*” гэсэн алдартай сургаал бий.

Өөрийгөө таних нь дотооддоо гүнзгий эрэл хайгуул хийхээс гадна, өөрийгөө сорьж, шинэ зүйл туршиж үзэхийг шаарддаг.

Жишээ нь, өөрийгөө сорих сорилтуудыг даван туулах замаар бид өөрийн хязгаарыг ойлгож, өөртөө илүү итгэлтэй болдог. Өөрийгөө таних нь зөвхөн харилцааны суурь бус, амжилт, аз жаргал, амар тайван амьдралын үндэс юм.

#### 4.1.5. Харилцааны үндсэн ойлголтууд

*Харилцаа бол үүнд хичээл зүтгэл гаргаж буй хүмүүст л үр дүнгээ өгдөг.  
Жон Пауэлл*

Харилцаа нь “communus” буюу “хуваалцах” гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд хамгийн энгийнээр хүн хооронд солилцож буй “утга” гэж сэтгэл судлал дахь харилцааны тухай ойлголтуудад дурдсан байна (Уянга, 2018). Харилцааг хэл зүй, зан үйл, танин мэдэхүй, нийгэм зэрэг олон талаас нь судалдаг. Аль ч талаас нь харсан харилцааны талаар дараах үндсэн ойлголтуудыг бид зайлшгүй мэдэх ёстой. Үүнд:

**Харилцаа бол утга солилцоо.** Харилцаа гэдэг нь мэдээлэл, үзэл бодол, утга агуулгыг хүмүүс хоорондоо солилцох үйл явц бөгөөд үүний зорилго нь харилцан ойлголцол бий болгоход оршино.

**Харилцаа бол процесс.** Цаг хугацааны явцад харилцаа нь тодорхой үе шатуудтайгаар өрнөдөг. Үүнд, илгээгч мэдээллийг үүсгээд илгээнэ. Харин хүлээн авагч мэдээллийг хүлээн авч, ойлгоод, хариу үйлдэл үзүүлж, ойлголцол бий болгоно. Харилцааны процесс нь харилцан үйлчлэлээр дамжин тасралтгүй хувьсаж, илүү гүн гүнзгий ойлголцол бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг.

**Харилцааны элементүүд.** Харилцаа тодорхой элементүүдээс бүрдэнэ. Эдгээр нь харилцааны үр дүнтэй байдалд шууд нөлөөлдөг.

Илгээгч	Мессеж	Хүлээн авагч	Суваг	Хариу үйлдэл	Хүрээлэн буй орчин
Мэдээллийг эхлэн боловсруулж, дамжуулагч	Харилцааны гол утга агуулга	Мэдээллийг хүлээн авч, ойлгогч	Мэдээллийг дамжуулах арга зам (жишээ нь, үг хэлэх, бичих, дохио зангаа г.м)	Мэдээллийн үр дүнд бий болсон ойлголт, үйлдэл	Харилцааны нөхцөл, нөлөөлөл

**Харилцаа бол харилцан үйлдэл.** Харилцаа нь хоёр ба түүнээс дээш хүний хоорондох харилцан үйлчлэлээр тодорхойлогдоно. Энэ нь зөвхөн мэдээлэл дамжуулахаас гадна, ойлголцол, хүлээн зөвшөөрөлт, уялдаа холбоо үүсгэх явц юм.

**Харилцаа бол дохио тэмдгийн солилцоо.** Харилцаа нь үгийн болон үгсээс бусад хэлбэрээр (биеийн хэл, дууны өнгө, дохио зангаа г.м) дамждаг. Өмнө дурдсанчлан Albert Mehrabian (1971)-ийн судалгаагаар, харилцаанд үгийн утга 7%, дууны өнгө 38%, биеийн хэлэмж 55%-ийг эзэлдэг гэж тогтоосон нь харилцаанд дохио тэмдэг ямар өндөр ач холбогдолтой болохыг илэрхийлнэ.

**Харилцаа бол нийгмийн үйл явц.** Харилцаа нь нийгмийн харилцан ойлголцлыг хангаж, хамтын зорилгод хүрэх нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь хүмүүсийн хооронд итгэлцэл, хамтын ажиллагааг бий болгож, нийгмийн эв нэгдэлд хувь нэмэр оруулдаг.

**Харилцааны зорилго.** Харилцааны гол зорилго нь мэдээлэл дамжуулах, харилцан ойлголцол бий болгох, асуудал шийдвэрлэх, хамтын ажиллагааг сайжруулах зэрэг өргөн хүрээнд илэрдэг.

Эдгээр үндсэн ойлголтууд нь харилцааг бүхэлд нь тодорхойлох бөгөөд түүний процесс, элементүүд болон олон талт үүргийг тайлбарлахад тусална. Харилцааг зөв ойлгож, ашиглах нь хувь хүн, баг, байгууллагын амжилтын үндэс суурь болдог.


#### 4.1.6. Харилцааны үүрэг

Харилцаа нь хувь хүн, баг, байгууллага, нийгмийн түвшинд тодорхой үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- **Мэдээлэл дамжуулах.** Харилцаа нь мэдээллийг зөв дамжуулж, ойлголцол бий болгох үндсэн үүрэгтэй.
- **Харилцан ойлголцол бий болгох.** Харилцааны явцад хүмүүсийн хооронд итгэлцэл, ойлголцол үүсч, хамтын ажиллагаа сайжирдаг.
- **Сэтгэл хөдлөлийг илэрхийлэх.** Харилцаа нь сэтгэл хөдлөл, санаа бодлыг бусдад илэрхийлэх, хуваалцах хэрэгсэл болдог.
- **Хамтын ажиллагааг зохицуулах.** Баг, байгууллагын хүрээнд хүмүүсийн үйл ажиллагааг уялдуулах, зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.
- **Нийгмийн дүрэм, үнэт зүйлийг батжуулах.** Харилцаа нь нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлийг түгээж, хадгалахад чухал үүрэгтэй.
- **Бүтээлч санаачилга дэмжих.** Харилцааны явцад шинэ санаа, бүтээлч санаачилга үүсч, хөгжих боломжтой.

Эдгээр үүргүүд нь харилцааг хувь хүн, баг, байгууллага болон нийгмийн түвшинд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл болгодог. Харилцаа нь зөвхөн мэдээлэл дамжуулах хэрэгсэл бус, мөн хүмүүсийн харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, нийгмийн үнэт зүйлсийг хадгалах, бүтээлч санаачилгыг хөгжүүлэх үндсэн суурь юм. Иймд харилцааны чанар, үр дүн нь тухайн орчин, нөхцөл байдлаас шууд хамааралтай байдаг бөгөөд амжилттай харилцаа нь хувь хүн болон байгууллагын зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой.

**Зураг 4.1.** Харилцааны процесс буюу үйл явц, тайлбар (Шеннон-Виверийн харилцааны загвар)



**Мэдээллийг үүсгэгч (Sender).** Харилцааны процесс эхлэхийн тулд мэдээллийг үүсгэгч нь тодорхой санаа, зорилгыг бий болгодог. Энэ нь тухайн мэдээлэл дамжуулахыг хүсч буй гол зорилт юм. Жишээлбэл, багш нь байгаль хамгаалагчдад шинэ мэдлэг хүргэх санааг бий болгоно.

**Шифрлэлт (Encoding).** Илгээгч нь өөрийн санааг үг, дүрс, дохио эсвэл бичгийн хэлбэрт оруулж, хүлээн авагчид ойлгомжтой байхаар боловсруулна. Жишээ нь, багш байгаль хамгаалагчдад хичээл заахдаа зураг, текст, яриа ашиглан ойлгомжтой болгоно.

**Мэдээлэл (Message).** Энэ нь илгээгчийн боловсруулсан, хүлээн авагчид хүрэх ёстой санаа, агуулга юм. Жишээ нь, багшийн байгаль хамгаалагчдад зааж буй хичээлийн агуулга.

**Суваг (Channel).** Мэдээллийг дамжуулах хэрэгсэл эсвэл арга зам юм. Жишээ нь, нүүр тулсан уулзалт, имэйл, видео хурал эсвэл утасны яриа.

**Хүлээн авах (Receiving).** Хүлээн авагч нь мэдээллийг сонсох, унших, харах эсвэл бусад мэдрэхүйгээр дамжуулан хүлээн авна. Жишээ нь, сурагч багшийн яриаг сонсох.

**Тайлалт (Decoding).** Хүлээн авагч мэдээллийг ойлгож, илгээгчийн санааг хүлээн авахад төвлөрдөг. Жишээ нь, сургалтаар байгаль хамгаалагчид хичээлийн агуулгыг ойлгоно.

**Хариу үйлдэл (Feedback).** Хүлээн авагч ойлгосон мэдээлэлдээ үндэслэн хариу өгдөг. Жишээ нь, сургалтад хамрагдсан байгаль хамгаалагч асуулт асуух эсвэл хичээлд хариулах.

**Дуу, чимээ (Noise).** Харилцааны явцад үүсэж болох саад. Жишээ нь, сургалтын танхмын гаднах дуу чимээ эсвэл ойлгомжгүй үгс.

Эдгээр үе шатууд нь харилцааны үйл явцыг бүрэн илэрхийлж, илгээгч болон хүлээн авагчийн хооронд мэдээлэл солилцох динамикийг тодорхойлдог. Харилцаа нь зөвхөн мэдээлэл дамжуулах төдийгүй ойлголцол, хариу үйлдэл, хамтын ажиллагаа үүсгэх үндсэн механизм юм.

Процесс бүрийн үр дүн нь шифрлэлт, суваг, мэдээллийн тодорхой байдал, мөн дуу чимээ зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Иймээс амжилттай харилцаа нь зөв суваг сонгох, ойлгомжтой шифрлэлт хийх, дуу чимээний саад бэрхшээлийг багасгах, мөн хариу үйлдлийг үр дүнтэй зохицуулах замаар хэрэгжинэ.

## 4.2 ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙ, ЗАРЧИМ

*Таны өндөрт хүрэх эсэхийг ур чадвар бус, таны хандлага шийднэ.  
Бизнесийн нэрт зөвлөх Зиг Зиглар (1926-2012)*

Харилцаа нь хүн төрөлхтний хамгийн чухал үйл явц бөгөөд зөвхөн мэдээлэл солилцох төдийгүй харилцан ойлголцол, итгэлцэл, эв нэгдэл, хамтын ажиллагааны үндэс суурь болдог. Гэвч харилцаа нь зөвхөн хэл, дохио зангаа гэх мэт техникийн хэрэгсэл биш, харин түүний ард орших соёл, ёс зүй, зарчмууд нь харилцааны үр дүн, чанарт ихээхэн нөлөөлдөг.

Харилцааны соёл нь хүний илэрхийлж буй үг, үйлдэл, хандлагын илэрхийлэл бөгөөд бусдыг хүндэтгэх, харилцааг үр дүнтэй, зохистой байлгах зарчмыг баримтлахыг шаарддаг. Ёс зүй нь харилцаанд оролцогчдын зан төлөв, үйлдэлд удирдамж болж, хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг тогтоодог бол зарчим нь харилцааг амжилттай өрнүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг.

Эдгээр элементүүд нь харилцааны чанартай бөгөөд урт хугацааны эерэг нөлөөг бий болгодог. Жишээлбэл, хэн нэгэн хүн харилцан ойлголцлыг дээдэлж, ёс зүйтэй, соёлтой харилцаж чадвал бусдын итгэлийг хүлээх, баг, хамт олондоо үнэ цэнтэй хувь нэмэр оруулах боломжтой болдог. Харин харилцааны соёл, ёс зүй, зарчмыг үл тоомсорловол зөрчилдөөн, үл ойлголцол, итгэл алдрал зэрэг сөрөг үр дүн гарч болзошгүй. Иймд харилцааны соёл, ёс зүй, зарчмуудыг гүнзгий ойлгож, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх нь хувь хүн, баг, байгууллага, нийгэмд харилцан ойлголцол, эв нэгдэл, амжилтыг бий болгох чухал хүчин зүйл юм.

### 4.2.1. Харилцааны соёл

Харилцааны соёл гэдэг нь хүн хоорондын харилцаанд хүндлэл, эелдэг байдал, найрсаг хандлага, зохистой зан төлөвийг хэвшүүлэх үйл явц юм. Энэ нь зөвхөн үг, үйлдэлд хамааралтай бус, тухайн хүний үнэт зүйлс, зан төлөв, хандлагын илэрхийлэл болдог. Харилцааны соёл нь хүмүүсийн харилцааг илүү үр дүнтэй, эвсэг, зохистой болгож, харилцан ойлголцлыг нэмэгдүүлдэг.

#### *Харилцааны соёлын үндсэн шинжүүд*

- *Эелдэг байдал.* Эелдэг, найрсаг хандлага нь харилцаанд итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлнэ. Инээмсэглэл, найрсаг үг, хүндэтгэлтэй үйлдэл нь харилцааг зөөллөж, хамтын ажиллагааг дэмжинэ.
- *Үг, үйлдлийн зохицол.* Үг хэл, үйлдэл хоёр хоорондоо нийцэж байх нь харилцааны соёлд чухал үүрэгтэй. Жишээлбэл, эерэг үг хэлж байгаад хүйтэн хандлага үзүүлэх нь харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг.
- *Биеийн хэлэмж.* Харилцааны ихэнх хэсэг нь биеийн хэлэмжээр илэрхийлэгдэх тул нүүрний хувирал, дохио зангаа, биеийн байрлалд анхаарах нь соёлын нэг хэсэг юм.
- *Хүндэтгэлтэй харилцаа.* Бусдын үзэл бодол, соёлын ялгааг хүлээн зөвшөөрч, тэднийг сонсох нь харилцааны соёлын чухал элемент юм. Хүндэтгэлтэй харилцаа нь эвсэг, урт хугацааны харилцааны үндэс болдог.
- *Цаг баримтлах.* Харилцааны соёлд цаг баримтлах нь үнэнч, хариуцлагатай байдлыг илтгэнэ. Уулзалт, амлалт, хэлэлцээр зэрэгт цаг баримталж, бусдын цагийг хүндэтгэх нь соёлын илэрхийлэл юм.
- *Итгэлцлийг бэхжүүлэх.* Хүмүүсийн хоорондын итгэлцэл нь харилцан нэгнийгээ ойлгож, хамтын ажиллагааг үр дүнд хүргэхэд чухал нөлөө үзүүлдэг харилцааны соёлын онцгой чухал шинж болно.

Харилцааны соёл нь хувь хүн, баг, байгууллага, нийгэмд эерэг уур амьсгал үүсгэж, амжилт, бүтээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Түүнчлэн, харилцааны соёлтой хандлага нь зөрчилдөөн, маргаан гарах эрсдэлийг бууруулж, талуудын хооронд хүндэтгэл, харилцан ойлголцлыг бий болгоно. Соёлтой харилцааны суурь нь зөв ойлголцол, харилцан хүндэтгэл, хамтын ажиллагаанд тулгуурладаг.

#### *Харилцааны соёлыг хэрхэн хөгжүүлэх вэ?*

- *Өөрийгөө хөгжүүлэх.* Харилцааны соёлыг хөгжүүлэхийн тулд хүн өөрийн мэдлэг, ур чадвар, хандлагыг тасралтгүй сайжруулах хэрэгтэй. Өөрийгөө хянах, бусдыг ойлгох, харилцааны арга барилаа уян хатан болгох нь чухал.
- *Сонсох ур чадварыг хөгжүүлэх.* Сонсох нь харилцааны хамгийн чухал хэсэг. Бусдыг анхааралтай сонсож, тэдний үзэл бодлыг ойлгох нь харилцааны соёлыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.
- *Бусдын ялгааг хүлээн зөвшөөрөх.* Хүмүүсийн үзэл бодол, соёл, хандлага ялгаатай байдаг. Эдгээрийг хүндэтгэн үзэж, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нь харилцааны соёлын нэгэн илрэл юм.
- *Ёс зүйг баримтлах.* Харилцааны соёл нь ёс зүйтэй салшгүй холбоотой. Шударга, хариуцлагатай байдал, бусдын эрх, үзэл бодлыг хүндэтгэх нь харилцааны соёлын үндэс юм.

Харилцааны соёл нь зөвхөн харилцааны техник, ур чадвар биш, харилцан ойлголцол, итгэлцлийг бүрдүүлж, хамтын ажиллагааг сайжруулах амин чухал хүчин зүйл юм. Үүнийг хөгжүүлснээр хувь хүн, баг, байгууллага, нийгмийн түвшинд зөв, үр дүнтэй харилцааг бий болгох боломжтой болно. Харилцааны соёлыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлснээр хүн зөвхөн өөрийгөө төдийгүй бусдыг хөгжүүлэх чухал алхмыг хийж байдаг.

#### **4.2.2. Харилцааны ёс зүй**

Харилцааны ёс зүй гэдэг нь хүн хоорондын харилцаанд ёс суртахуун, хариуцлага, шударга байдал зэрэг үнэт зүйлсийг баримтлах явдал юм. Энэ нь зөвхөн харилцан мэдээлэл солилцох төдийгүй харилцан итгэлцэл, хүндэтгэл, эв нэгдэл, зохистой хамтын ажиллагааг бий болгоход чиглэгдэнэ. Харилцааны ёс зүй нь хувь хүнээс эхлээд баг, байгууллага, нийгэмд хүртэл харилцааны чанарыг сайжруулах, илүү эерэг уур амьсгал бүрдүүлэхэд тусалдаг.

Харилцааны ёс зүйг хэрэгжүүлэх нь зөвхөн бусдын итгэлийг хүлээх арга биш, мөн хувь хүний үнэт зүйлс, хандлагын илэрхийлэл юм. Жишээ нь, шударга байдал, хариуцлагатай хандлага, хүндлэлтэй харилцаа нь ёс зүйн зан үйлийн үндсэн илрэлүүд бөгөөд эдгээр нь харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, хүмүүсийн хоорондын итгэлцлийг бэхжүүлдэг.

#### *Харилцааны ёс зүйн үндсэн зарчмууд*

- *Шударга байдал.* Үнэнч, ил тод байх нь харилцааны хамгийн чухал зарчим юм. Шударга байдал нь харилцаанд итгэлцлийг нэмэгдүүлж, урт хугацааны хамтын ажиллагааг бэхжүүлдэг.
- *Хүндэтгэл.* Харилцаанд оролцогчдын үзэл бодол, итгэл үнэмшил, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх нь ёс зүйн гол илэрхийлэл юм.
- *Хариуцлага.* Харилцааны явцад хэлсэн үг, хийсэн үйлдэлдээ хариуцлагатай хандах нь ёс зүйн үндэс суурь болдог. Амласан амлалтаа биелүүлэх нь харилцан итгэлцлийг нэмэгдүүлдэг.
- *Нууцлалыг хадгалах.* Харилцаанд олж авсан хувийн болон мэргэжлийн мэдээллийг хамгаалах, зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх нь ёс зүйн чухал элемент юм.

Харилцааны ёс зүй нь итгэлцлийг бэхжүүлж, хамтын ажиллагааг үр дүнтэй болгодог. Ёс зүйн зарчмыг дагаж мөрдөх нь үл ойлголцол, маргаан, зөрчилдөөнөөс сэргийлэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь хувь хүнээс эхлээд баг, байгууллага, нийгмийн түвшинд эв нэгдлийг хангахад чухал нөлөө үзүүлдэг.

#### Харилцааны ёс зүйг хэрэгжүүлэх арга замууд

- *Анхааралтай сонсох.* Бусдын үзэл бодлыг хүндэтгэж сонсох нь харилцааны ёс зүйн чухал илэрхийлэл юм.
- *Тунгалаг, ил тод байх.* Харилцаанд оролцогчид өөрийн үзэл бодол, шийдвэрийг ойлгомжтой, ил тод илэрхийлэх ёстой.
- *Эерэг хандлага баримтлах.* Харилцаанд үргэлж эерэг, найрсаг хандлага баримтлах нь ёс зүйн чухал хэсэг юм.

Шударга, хариуцлагатай, хүндэтгэлтэй, нээлттэй харилцааг хэвшүүлэх нь итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлж, эерэг орчин бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймд харилцааны ёс зүйг өдөр тутмын харилцаандаа мөрдлөг болгож, зөв хэвшүүлэх нь бүх түвшинд амжилт, хөгжил, эв нэгдлийн үндэс болно.

#### 4.2.3. Харилцааны үндсэн зарчмууд

Харилцааны зарчим гэдэг нь хүн хоорондын харилцааг илүү үр дүнтэй, эерэг болгох удирдамж, үндсэн хэм хэмжээг тодорхойлох үйл явц юм. Энэ нь харилцагч талуудын хоорондын ойлголцлыг нэмэгдүүлж, харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэнэ.

##### Харилцааны зарчмууд

- *Тодорхой байдал.* Үг, үйлдэл, санаагаа ойлгомжтой, тодорхой илэрхийлэх нь харилцааны гол зарчим юм. Тодорхойгүй харилцаа нь үл ойлголцол, маргаан үүсгэх магадлалтай.
- *Ил тод байдал.* Мэдээллийг нээлттэй, шударгаар солилцох нь харилцааг ойлгомжтой, найдвартай болгодог.
- *Харилцан хүндэтгэл.* Оролцогчид нэгнийхээ үзэл бодол, соёлын ялгааг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх ёстой.
- *Сонсох чадвар.* Анхааралтай сонсох нь харилцааны амжилтын үндэс юм. Энэ нь бусдыг хүндэтгэх, ойлгох нөхцөлийг бүрдүүлдэг.
- *Хариуцлагатай байдал.* Хэлсэн үг, хийсэн үйлдэлдээ хариуцлагатай байх нь харилцааг урт хугацааны турш үр дүнтэй байлгах үндэс болдог.

Харилцааны зарчмууд нь итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ил тод, тодорхой харилцаа нь үл ойлголцол, маргаанаас сэргийлж, аливаа асуудлыг зохистойгоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Эдгээр зарчмыг дагаж мөрдөх нь хувь хүнээс эхлээд баг, байгууллага, нийгмийн түвшинд хүртэл эерэг, үр дүнтэй харилцааны үндэс суурийг тавьдаг.

Харилцааны соёл, ёс зүй, зарчим гурав хоорондоо нягт уялдаа холбоотой боловч тус бүртээ өвөрмөц онцлогтой бас ач холбогдолтой. Зарчмуудыг бодит амьдралд хэрэгжүүлснээр харилцаа нь илүү итгэлцэлд тулгуурласан, эерэг, үр ашигтай болох төдийгүй нийгмийн бүх түвшинд зохистой харилцааны соёл төлөвшихөд хувь нэмэр оруулна.

## 4.2.4. Харилцааны хэлбэрүүд

Өнөөдрийн үг маргаашийн үйлдэл болно.

Харилцааны хэлбэр гэдэг нь хүмүүсийн хоорондын харилцааг илэрхийлэх, дамжуулах арга зам, арга хэлбэрийг хэлдэг. Үүнийг харилцан ярианы зорилго, оролцогчдын хоорондын харилцааны суурь нөхцөл болон хэрэглэж буй хэрэгсэл, хэлбэрийн онцлогт тулгуурлан авч үздэг.

### Хүснэгт 4.1. Харилцааны хэлбэр

Харилцааны хэлбэр	Тайлбар	Жишээ	Давуу тал	Хамрах зүйлс
Аман харилцаа (Verbal Communication)	Ярианы хэлбэрээр дамжуулан санаа, мэдрэмж, мэдээллийг илэрхийлэх.	Уулзалт, хурал, ярилцлага, энгийн яриа.	Шууд ойлголцол, уян хатан байдал, хариу үйлдлийн боломж.	- Албан харилцаа (хурал, уулзалт, илтгэл) - Албан бус харилцаа (найз нөхдийн яриа, энгийн харилцаа)
Бичгийн харилцаа (Written Communication)	Үг, өгүүлбэрийн тусламжтайгаар мэдээллийг бичгээр илэрхийлэх.	Имэйл, албан бичиг, тайлан, илтгэл, ном.	Баримтжуулах боломж, мэдээллийг нарийн зохион байгуулах.	- Албан харилцааны бичиг баримт - Албан бус харилцааны тэмдэглэл, захиа
Биеийн хэлэмж, дохио зангаа (Non-verbal Communication)	Үг хэлээр бус дохио зангаа, нүүрний хувирал, биеийн байрлал, хөдөлгөөнөөр харилцах.	Инээмсэглэл, толгой дохих, гараар дохих	Үгийг нөхөх, мэдрэмжийг шууд илэрхийлэх.	- Үзэл бодол, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх. - Аман харилцааг нөхөх, бэхжүүлэх
Дижитал буюу цахим харилцаа (Digital Communication)	Технологийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл солилцох.	Чат, мессеж, цахим хурал, цахим шуудан.	Цаг хугацаа, орон зай хэмнэх, олон хүнд нэг дор хүргэх.	- Видео хуралд оролцохдоо аман яриа, дохио зангаа, бичгийн тайлбар ашиглах

**Аман харилцаа.** Ярианы хэлээр дамжуулан мэдээлэл солилцох, санаа бодлоо илэрхийлэх үйл явцыг аман харилцаа гэнэ. Энэ нь харилцааны хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд хүн төрөлхтний нийгмийн амьдралд онцгой үүрэг гүйцэтгэнэ. Аман харилцаа нь шууд буюу нүүр тулсан, мөн зайнаас буюу утас, цахим орчны хэрэгслээр дамжин хэрэгжих боломжтой.

#### Аман харилцааны онцлог

- *Шууд хариу үйлдэл.* Аман харилцаанд оролцогчид мэдээлэл солилцохдоо шууд харилцан үйлдэл хийх боломжтой. Энэ нь харилцагч талуудын хоорондын ойлголцлыг хурдасгадаг.
- *Дууны өнгө, хэмнэл.* Үгийн агуулгаас гадна, дууны өнгө, хэмнэл, хурд нь харилцааны утга санааг илүү баяжуулдаг.

- *Уян хатан байдал.* Аман харилцаа нь нөхцөл байдлаас хамаарч агуулга, хэлбэрээ түргэн өөрчлөх боломжтой.
- *Үе, утгын сонголт.* Үг сонголт, илэрхийллийн арга барил нь мэдээллийг ойлгомжтой, тодорхой болгох эсвэл үл ойлголцол үүсгэх гол хүчин зүйл болдог.

Аман харилцааны давуу тал	Аман харилцааны сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Ойлголцол, хариу үйлдэл хурдан байдаг: Шууд харилцаанд оролцогчид бие биенийхээ асуултад түргэн хариу өгч, үл ойлголцлыг засах боломжтой.</li> <li>- Сэтгэл хөдлөлийн илэрхийлэл: Дууны өнгө, нүүрний хувирал, дохио зангаа нь мэдээллийг баяжуулж, илүү ойлгомжтой болгодог.</li> <li>- Хурдан шийдвэр гаргах боломж: Харилцагч талуудын хооронд асуулт, хариулт түргэн солилцогдсоноор шийдвэр гаргалт хялбар болдог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үл ойлголцол үүсэх эрсдэл: Дууны өнгө, хурд, үгийн сонголтоос шалтгаалан мэдээлэл буруу ойлгогдох боломжтой.</li> <li>- Баримтжуулалтгүй: Аман харилцаанд мэдээлэл албан ёсоор баримтжуулагдахгүй учир баталгаажуулахад хүндрэлтэй.</li> <li>- Цаг хугацаа, орон зайнаас хамааралтай: Шууд харилцаанд оролцогчид нэг газар, нэг цагт байх шаардлага гардаг.</li> </ul>

#### Аман харилцааг сайжруулах арга замууд

- *Ярих ур чадвараа хөгжүүлэх.* Үг сонголт, хэл найруулгадаа анхаарах.
- *Эргэх холбоо үүсгэх.* Харилцагчийн хариу үйлдлийг анхаарч, ойлголцол бий болгох.
- *Нөхцөл байдалд тохируулан ярих.* Албан болон албан бус нөхцөлд ярианы хэлбэрийг зохистой ашиглах.
- *Анхааралтай сонсох.* Харилцаанд оролцогчийг ойлгож, хариу үйлдэлдээ анхаарах.

**Бичгийн харилцаа.** Мэдээллийг үг, өгүүлбэр, бичвэрээр дамжуулан солилцох үйл явцыг бичгийн харилцаа гэнэ. Энэ нь тодорхой мэдээллийг баримтжуулж, архивлах, олон хүнд нэгэн зэрэг хүргэх боломжтой харилцааны үндсэн хэлбэр юм.

#### Бичгийн харилцааны онцлог

- *Баримтжуулалт.* Бичгийн харилцаа нь албан ёсны хэлэлцээр, баримт бичиг, тайлан гэх мэт урт хугацаанд хадгалагдах мэдээллийг түгээхэд тохиромжтой.
- *Агуулгын нарийвчлал.* Үг, өгүүлбэрийг анхаарч сонгох замаар мэдээллийг тодорхой, ойлгомжтой хүргэх боломжтой.
- *Цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах.* Бичгийн харилцаа нь оролцогч талуудын нэгэн зэрэг байхыг шаарддаггүй, тиймээс алслагдсан нөхцөлд тохиромжтой.

Бичгийн харилцааны давуу тал	Бичгийн харилцааны сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Баримтжуулалт: Албан ёсны мэдээллийг бүртгэх, архивлах боломжтой.</li> <li>- Нарийвчилсан мэдээлэл дамжуулах: Нарийн төвөгтэй мэдээллийг тодорхой, ойлгомжтой хүргэх боломжтой.</li> <li>- Өөрт тохирсон хэмнэлээр боловсруулах: Хүлээн авагч бичвэрийг өөрийн хурд, цагт тохируулан уншиж ойлгох боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг хугацаа их шаарддаг: Мэдээллийг бичих, боловсруулахад илүү их цаг шаарддаг.</li> <li>- Ойлголцол хязгаарлагдмал: Биеийн хэлэмж, дууны өнгө зэрэг нэмэлт илэрхийлэл байхгүй учир утга ташаа ойлгогдох эрсдэлтэй.</li> <li>- Шуурхай хариу үйлдэл багатай: Бичсэн мэдээлэлд хариу ирэхэд тодорхой цаг хугацаа шаардагдана.</li> </ul>

### Бичгийн харилцааг сайжруулах арга замууд

- *Бичгийн чадвараа хөгжүүлэх.* Үг найруулга, дүрмийн алдаагүй бичих.
- *Товч бөгөөд тодорхой байх:* Илүү үг, утга давхардлыг багасгах.
- *Хүлээн авагчийн хэрэгцээнд тохируулах.* Мэдээллийг унших хүн хэн бэ гэдгийг урьдчилан тооцоолох.
- *Дижитал хэрэгслийг ашиглах.* Имэйл, цахим платформуудыг үр дүнтэй ашиглах.

**Биеийн хэлэмж ба дохио зангаа.** Үг хэлээр бус, нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, байрлал, дохио зангаагаар дамжуулан мэдээлэл солилцох үйл явцыг биеийн хэлэмж буюу дохио зангаа гэнэ. Энэ нь харилцааны 70% гаруйг бүрдүүлдэг гэж үздэг (Mehrabian, 1971).

### Биеийн хэлэмжийн онцлог

- *Нэмэлт мэдээлэл дамжуулах.* Биеийн хэлэмж нь үгсийн утгыг бататгах, баяжуулах үүрэгтэй.
- *Сэтгэл хөдлөлийг илэрхийлэх.* Нүүрний хувирал, гараар дохих, биеийн байрлал зэргээр мэдрэмжийг шууд дамжуулдаг.
- *Нөхцөл байдлыг тодруулах.* Үгийн утга ташаа ойлгогдох үед биеийн хэлэмж нь нөхцөл байдлыг ойлгомжтой болгодог.

### Биеийн хэлэмжийн ач холбогдол

- *Эмоцийг илэрхийлэх.* Баярлах, уурлах, гайхах гэх мэт мэдрэмжийг илүү тод илэрхийлдэг.
- *Ойлголцол нэмэгдүүлэх.* Үг, өгүүлбэрийг баяжуулна.
- *Ойлголцлыг нөхөх.* Аман харилцааны явцад үгсийн утга бүрэн дамжигдахгүй үед биеийн хэлэмж нь харилцааг илүү ойлгомжтой болгон, үг өгүүлбэрийг баяжуулдаг.
- *Итгэлцэл бий болгох.* Үг хэллэг, биеийн хэлэмж хоорондоо нийцтэй байснаар харилцагч талуудын хооронд итгэлцэл үүсдэг.

### Биеийн хэлэмжийн төрлүүд

- *Нүүрний хувирал.* Сэтгэл хөдлөлийг шууд илэрхийлэх хамгийн чухал хэлбэр.
- *Нүдний холбоо.* Итгэлцэл, анхаарал, хүндэтгэлийг илэрхийлэхэд чухал үүрэгтэй.
- *Гарын хөдөлгөөн.* Ярианы утга санааг тодруулах, хүч нэмэгдүүлэх үүрэгтэй.
- *Биеийн байрлал.* Биеийн байрлал нь хүндэтгэлтэй эсвэл үл тоомсорлосон хандлагыг илэрхийлж болно.
- *Хөдөлгөөний зай.* Хүмүүсийн хоорондын харилцааны зай нь ойр дотно эсвэл албан ёсны харилцааг тодорхойлдог.

Биеийн хэлэмжийн давуу тал	Биеийн хэлэмжийн сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Мэдрэмжийг шууд илэрхийлэх: Биеийн хэлэмж нь үгийг орлохгүйгээр мэдрэмж, сэтгэл хөдлөлийг хурдан, тодорхой илэрхийлдэг.</li> <li>- Аман харилцааг нөхөх: Үгийн утгыг тодотгох эсвэл баталгаажуулахад биеийн хэлэмж чухал үүрэгтэй.</li> <li>- Утгагүйдлийг багасгах: Аман харилцаанд ойлгомжгүй байдал үүссэн үед биеийн хэлэмж нь тухайн мэдээллийн утгыг илүү ойлгомжтой болгоход тусална.</li> <li>- Итгэлцэл бий болгох: Эерэг биеийн хэлэмж нь харилцан итгэлцэл, ойлголцлыг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ташаа ойлголт үүсгэх эрсдэл: Биеийн хэлэмжийг хэтрүүлэн илэрхийлэх эсвэл буруу тайлбарлах нь үл ойлголцолд хүргэж болзошгүй.</li> <li>- Соёлын ялгаа: Улс орон, соёлын онцлогоос шалтгаалан нэг дохио зангаа өөр утгаар ойлгогдох магадлалтай.</li> </ul>

**Биеийн хэлэмжийг сайжруулах арга замууд**

- *Өөрийн хөдөлгөөнийг хянах.* Хэт их хөдөлгөөнөөс зайлсхийж, зохистой илэрхийлэл ашиглах.
- *Нөхцөл байдалд тохирсон байдал.* Аман яриатайгаа нийцтэй, зохистой дохио зангаа хэрэглэх.
- *Сонсогчийн соёлын онцлогийг ойлгох.* Соёлын ялгааг анхаарч, харилцагч талдаа тохируулан харилцах.

**Дижитал харилцаа.** Технологийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл солилцох, санаа бодлоо илэрхийлэх үйл явцыг дижитал харилцаа гэнэ. Орчин үеийн харилцааны хамгийн түгээмэл хэлбэрийн нэг болсон харилцааны энэ хэлбэр нь нийгмийн сүлжээ, цахим шуудан, видео дуудлага зэрэг олон төрлийн платформоор дамждаг.

**Дижитал харилцааны онцлог**

- *Цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах.* Дижитал харилцаа нь мэдээлэл солилцоходоо оролцогч талуудын биечлэн уулзахыг шаарддаггүй бөгөөд хэзээ, хаанаас ч харилцах боломжийг олгодог.
- *Хурдтай, хүртээмжтэй.* Нэг товч даралтаар олон хүнд нэгэн зэрэг мэдээлэл хүргэх боломжтой.
- *Баримтжуулалт.* Цахим шуудан, мессеж, бичлэг зэрэг дижитал хэлбэрийн харилцаа нь мэдээллийг хадгалах, хянах боломжийг бүрдүүлдэг.
- *Олон төрлийн илэрхийлэл.* Зурвас, зураг, бичлэг, GIF, дууны хураангуй зэрэг олон хэлбэрээр мэдээлэл илэрхийлэх боломжтой.

Дижитал харилцааны давуу тал	Дижитал харилцааны сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Цаг хугацаа хэмнэнэ: Олон оролцогчтой харилцаа хурдан хэрэгжиж, үр дүнгээ өгдөг.</li> <li>- Хүртээмж нэмэгдэнэ: Дэлхийн аль ч хэсэгт оршиж буй хүмүүст мэдээлэл шууд хүргэх боломжтой.</li> <li>- Архивлагдах боломж: Бүх мэдээлэл цахим орчинд хадгалагддаг тул мэдээллийг хянах, эргэн санахад дөхөмтэй.</li> <li>- Олон төрлийн хэрэгслийн тусламж: Цахим шуудан, видео дуудлага, чатбот зэрэг хэрэгслүүдийг ашиглан харилцааны уян хатан байдлыг хангадаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Технологийн хамаарал: Төхөөрөмж, интернетээс хамааралтай учир саатал үүсэх эрсдэлтэй.</li> <li>- Эргэх холбоо багатай: Зарим нөхцөлд хариу үйлдэл удаашрах буюу бүр хүлээн авагдахгүй байх магадлалтай.</li> <li>- Мэдээллийн аюулгүй байдал: Хакердах, мэдээлэл алдагдах зэрэг эрсдэл дагалддаг.</li> <li>- Сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд хязгаарлагдмал: Биеийн хэлэмж, дууны өнгө дутагдах нь мэдээллийг бүрэн гүйцэд дамжуулахад саад болдог.</li> </ul>

**Дижитал харилцааг сайжруулах арга замууд**

- *Цахим харилцааны соёл баримтлах.* Албан болон албан бус цахим харилцаанд найрсаг, ойлгомжтой, хүндэтгэлтэй байх.
- *Эргэх холбоог баталгаажуулах.* Оролцогч талуудын хооронд ойлголцлыг нэмэгдүүлэхийн тулд тодорхой хариу үйлдэл хүлээх эсвэл өгөх.
- *Нууцлал, аюулгүй байдлыг хангах.* Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс нууц үг ашиглах, өгөгдлийг шифрлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх.
- *Олон төрлийн хэрэгслийг оноочтой хослуулах.* Имэйл, видео дуудлага, чат, дижитал баримт бичиг зэрэг хэрэгслүүдийг нөхцөл байдалд тохируулан ашиглах.

Дижитал харилцаа нь орчин үеийн мэдээлэл солилцооны хамгийн үр дүнтэй хэлбэрүүдийн нэг бөгөөд хүмүүсийн хоорондын харилцааг хялбаршуулж, илүү хүртээмжтэй болгодог. Гэсэн хэдий ч үүнийг зөв зохистой ашиглах, соёл, ёс зүйг сахих нь харилцааны үр дүнг сайжруулах үндэс болдог. Дижитал харилцааны технологиос хамааралтай эрсдэл, дутагдлыг шийдвэрлэхийн тулд зохих арга хэмжээг авч, харилцааны чанарт анхаарах нь чухал юм.

**Холимог харилцаа.** Аман, бичгийн болон биеийн хэлэмж, дижитал харилцааг хослуулан ашиглах үйл явцыг холимог харилцаа гэдэг. Энэ нь орчин үеийн харилцаанд өргөнөөр ашиглагддаг ялангуяа, бизнес, боловсрол, олон нийтийн харилцаанд чухал ач холбогдолтой.

**Холимог харилцааны онцлог**

- *Хэд хэдэн хэрэгслийг ашиглах.* Уулзалт, имэйл, видео дуудлага гэх мэт олон хэрэгслийг хослуулан ашиглах боломжтой.
- *Уян хатан байдал.* Хэрэгцээ шаардлагаас хамааран янз бүрийн харилцааны хэлбэрийг сонгох боломжтой.
- *Өндөр үр ашигтай.* Оролцогч талуудын хооронд мэдээллийг илүү тодорхой, олон түвшинд хүргэх боломжийг бүрдүүлдэг.

Холимог харилцааны давуу тал	Холимог харилцааны сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Цаг хугацаа хэмнэнэ: Дижитал хэрэгслийг ашиглан хурдан мэдээлэл солилцох.</li> <li>- Ойлголцол нэмэгдэнэ: Аман яриа, бичвэр, биеийн хэлэмжийг хослуулан илэрхийлэх боломжтой.</li> <li>- Уян хатан: Орон зай, цаг хугацааны хязгаарлалтад баригдалгүй харилцах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Технологийн хамаарал: Интернет, төхөөрөмжөөс шалтгаалан мэдээлэл хүргэхэд хүндрэл учирч болзошгүй.</li> <li>- Илүү их үр чадвар шаарддаг: Холимог харилцаанд оролцогчид олон төрлийн хэрэгслийг ашиглах чадвартай байх шаардлагатай.</li> </ul>

**Холимог харилцааг сайжруулах арга замууд**

- *Технологийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах.* Имэйл, видео дуудлага зэрэг хэрэгслүүдийг зохистой хослуулах.
- *Албан ба албан бус харилцааг ялгах.* Зорилгоос хамааран харилцааны хэлбэрийг оновчтой сонгох.
- *Эргэх холбоог баталгаажуулах.* Мэдээлэлд хариу үйлдэл авах замаар ойлголцлыг сайжруулах.

Аман, бичгийн, биеийн хэлэмж, холимог харилцаа нь тус бүрийн онцлогтойн зэрэгцээ давуу ба сул талтай байх тул тодорхой нөхцөл байдалд өөр өөр хэлбэрийг сонгож хэрэглэх нь зүйтэй. Эдгээрийг үр дүнтэй хэрэглэх нь харилцагч талуудын ойлголцлыг сайжруулж, харилцааны чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## 4.3 ГЭР БҮЛ БОЛОН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ХАРИЛЦАА

*Амьдралын алтан үндэс нь эв эе, харилцааны мөн чанар нь итгэл.*

Харилцах үйлийг бид төрсөн цагаасаа л хийж эхэлсэн байдаг. Харилцааны “мэдлэг”-тэй байх гэхээсээ “ур чадвартай” байх гэж ярих нь зүйтэй юм. Юу ярихаа мэдэх нь таны мэдлэгээс шалтгаалж, хэзээ ярихаа мэдэх нь таны туршлагатай холбоотой. Харин хэрхэн ярих вэ? гэдэг нь харилцааны ур чадвараа хөгжүүлсэн эсэхээс тань ихээхэн шалтгаалах юм (Уянга, 2018). Тэгвэл бидний амьдралынхаа ихэнх хугацаанд хамтдаа байдаг гэр бүлийн болон ажлын хамт олонтойгоо харилцах харилцааны талаар хэдий чинээ мэдлэг, туршлагатай байна, та бидний амьдралын чанар төдий чинээ өндөр байна. Хоёр хүний ялгаа нь бусадтай харилцаж байгаа харилцааны ур чадвар, техникт л байна.

### 4.3.1. Гэр бүлийн харилцаа

Гэр бүлийн харилцаа нь хүн бүрийн амьдралын тулгуур, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангадаг хамгийн чухал харилцааны хэлбэр юм. Энэ нь итгэлцэл, хайр, хүндэтгэл, харилцан ойлголцлоор дамжин гэр бүлийн бүх гишүүдийн амьдралын чанарыг тодорхойлдог.

#### Гэр бүлийн харилцааны онцлог

- *Эмоцийн холбоо.* Гэр бүлийн харилцаа нь хайр, итгэл, халамжаар гүнзгий батжиж, гишүүдийн хоорондын бие биенээ дэмжих сэтгэл зүйг бий болгодог.
- *Үүрэг, хариуцлага.* Гэр бүлийн гишүүд тус бүр тодорхой үүрэг, хариуцлагыг хуваалцаж, харилцан дэмжлэг үзүүлснээр харилцаа тогтвортой байдаг.
- *Урт хугацааны харилцаа.* Гэр бүлийн харилцаа нь үргэлжид оршин тогтнодог тул аливаа асуудал, зөрчлийг урт хугацааны хамтын ажиллагаагаар шийдвэрлэх шаардлагатай.

Гэр бүлийн харилцаа нь хайр, итгэлцэл, халамжаар батжиж, гишүүдийн хоорондын ойлголцол, дэмжлэгийг нэмэгдүүлдэг урт хугацааны гүнзгий холбоо юм. Гэр бүлд эмоцийн холбоо гол байр суурь эзэлдэг бөгөөд хайр, халамж дээр суурилсан энэ харилцаа нь амьдралын стресс, сорилтыг даван туулах хүч болдог. Үүрэг, хариуцлагыг харилцан хуваалцсанаар гэр бүлийн дотоод зохион байгуулалт сайжирч, тогтвортой байдал хангагдана.

Гэр бүлийн харилцаа нь урт хугацаанд үргэлжлэх онцлогтой тул аливаа маргаан, зөрчлийг хамтын ажиллагаа, ойлголцлоор шийдвэрлэх шаардлагатай бөгөөд энэ нь харилцааг улам бататгахад хувь нэмэр оруулдаг. Ийм харилцааны хүрээнд бүрдсэн итгэлцэл, халуун дулаан уур амьсгал нь хувь хүний сэтгэл зүй, нийгмийн харилцааны суурь болж, аз жаргалтай амьдралын үндэс болдог.

#### Гэр бүлийн харилцааны төрлүүд

- *Эцэг эх, хүүхдийн харилцаа.* Халамж, хайр, ойлголцол дээр суурилсан энэ харилцаа нь хүүхдийн өөртөө итгэх итгэл, хувь хүний хөгжилд шууд нөлөөлдөг.
- *Ах эгч, дүүгийн харилцаа.* Харилцан хүндлэл, хамтын ажиллагаа нь гэр бүлийн нэгдмэл байдлыг бэхжүүлдэг.
- *Хань ижил хоорондын харилцаа.* Хайр, итгэлцэл, хамтран шийдвэр гаргах чадвар нь харилцааны тогтвортой байдлыг хангадаг.

### *Гэр бүлийн харилцааг сайжруулах арга замууд*

- *Эерэг харилцааг хөгжүүлэх.* Гэр бүлийн гишүүд хоорондоо хүндэтгэлтэй, ойлгомжтой, найрсаг харилцах нь харилцааг гүнзгийрүүлдэг.
- *Итгэлцлийг бэхжүүлэх.* Бусдын алдааг уучилж, харилцан итгэх нь сэтгэл зүйн эрүүл байдлыг бий болгоно.
- *Нээлттэй байдал.* Асуудлаа хамтдаа ярилцаж, хамтран шийдвэрлэх нь зөрчил маргааныг багасгана.

## **4.3.2. Ажлын байрны харилцаа**

Ажлын байрны харилцаа нь ажилчдын хоорондын ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих, байгууллагын зорилгод хүрэх үндсэн хэрэгсэл юм. Энэ нь албан ёсны болон албан бус хэлбэрээр илэрдэг бөгөөд үр дүнтэй харилцаа байгууллагын амжилтыг тодорхойлно.

### *Ажлын байрны харилцааны онцлоо*

- *Мэргэжлийн харилцаа.* Ажлын байрны харилцаа нь ажил үүргийн гүйцэтгэлд чиглэгддэг тул тодорхой зорилго, дүрэм журамтай байдаг.
- *Албан ба албан бус харилцаа.* Албан харилцаа нь албан ёсны арга замаар мэдээлэл солилцдог бол албан бус харилцаа нь ажлын уур амьсгалыг нөхөрсөг болгодог.
- *Шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх.* Үр дүнтэй харилцаа нь мэдээллийг зөв дамжуулж, оновчтой шийдвэр гаргахад нөлөөлдөг.

Ажлын байрны харилцаа нь хамт олны уур амьсгалыг эерэг байлгаж, харилцан ойлголцол, найрсаг хандлагыг бүрдүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, стрессийг бууруулахад чухал үүрэгтэй. Багийн дотоод харилцаа нь хамтын зорилгод хүрэхэд тулгуур болдог бөгөөд санал, санаачилгыг чөлөөтэй солилцох орчин нь оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг. Иймд ажлын байранд харилцааг оновчтой зохицуулж, эерэг уур амьсгалыг бий болгох нь байгууллагын амжилтад шууд нөлөөлнө.

### *Ажлын байран дахь харилцааны төрөл*

*Дотоод харилцаа (Өөрөө өөртэйгээ).* Энэ нь хувь хүний дотоод бодол, сэтгэл хөдлөл, зорилгоо тодорхойлох үйл явцтай холбоотой. Дотоод харилцаа нь ажилтны өөрийгөө ойлгох, удирдах, шийдвэр гаргах чадварт нөлөөлдөг. Жишээ нь, ажлын байрны стрессийг удирдах, сэтгэл зүйн тэнцвэрийг хангах.

*Бизнесийн буюу ажил хэргийн харилцаа.* Ажил хэрэгтэй холбоотой харилцаа бөгөөд албан бичиг, гэрээ хэлэлцээр, уулзалт, түншлэлд илэрдэг. Энэ төрлийн харилцаа нь ажлын үр дүн, зорилгод шууд нөлөөлдөг. Жишээ нь, байгууллагын удирдлагаас ажилтнуудад үүрэг даалгавар өгөх, харилцагчтай хэлэлцээр хийх.

*Хүмүүс хоорондын буюу гадаад харилцаа.* Энэ төрлийн харилцаа нь байгууллагын ажилтнуудын хооронд, удирдлага ба ажилтнуудын хооронд эсвэл байгууллага ба харилцагчдын хооронд явагддаг. Жишээ нь, хамт ажиллагсдын хоорондын нөхөрсөг харилцаа эсвэл харилцагчтай харилцах үед итгэлцэл үүсгэх.

*Бүлгийн харилцаа.* Багийн дотоод харилцаа, хамтын ажиллагаа, зорилгоо тодорхойлох, шийдвэр гаргах үйл явц юм. Энэ төрлийн харилцаа нь багийн уур амьсгал, бүтээмжид ихээхэн нөлөөтэй. Жишээ нь, багийн уулзалт зохион байгуулах, багийн гишүүдийн үүргийг тодорхойлох.

**Үгэн харилцаа буюу аман ба бичгийн харилцаа.** Үгэн харилцаа нь албан болон албан бус харилцаагаар дамжин хэрэгждэг. Аман харилцаанд үгийн өнгө аяс, илэрхийлэл чухал бол бичгийн харилцаа нь албан ёсны баримт бичиг, имэйл зэрэгт суурилдаг. Жишээ нь, удирдлагаас бичгээр зааварчилгаа өгөх эсвэл уулзалтын үеэр аман яриа өрнүүлэх.

**Олон нийттэй харилцах харилцаа.** Байгууллага нь олон нийт, харилцагчидтай үр дүнтэй харилцаа үүсгэх үйл явц. Энэ нь байгууллагын нэр хүндийг хамгаалах, нийгэмд эерэг дүр төрх бүрдүүлэхэд чиглэнэ. Жишээ нь, хэвлэлийн мэдээ гаргах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах.

**Ёс зүйтэй харилцаа.** Ажлын байрны ёс зүйг сахих, шударга, хүндэтгэлтэй, хариуцлагатай харилцааг хэлнэ. Ёс зүйтэй харилцаа нь итгэлцлийг нэмэгдүүлж, байгууллагын амжилтад эерэгээр нөлөөлдөг. Жишээ нь, ажилтнуудын алдаа дутагдлыг шударгаар хэлэлцэх, бусдыг хүндэтгэх.

Ажлын байран дахь харилцааны төрөл бүр нь байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын уур амьсгалд өөр өөрийн онцлогоор нөлөөлдөг. Эдгээр төрлийг оновчтой ашигласнаар байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын хооронд итгэлцэл, ойлголцол бий болгох боломжтой. Тиймээс байгууллагын удирдлага эдгээр төрлийг зохистой хослуулж, харилцааны соёл, ёс зүйг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

#### **Ажлын байрны харилцааг сайжруулах арга замууд**

- *Итгэлцлийг нэмэгдүүлэх.* Багийн гишүүдийн хоорондын итгэлцлийг бэхжүүлэх нь хамтын ажиллагааг сайжруулна.
- *Нээлттэй харилцаа үүсгэх.* Ажилчид хоорондоо чөлөөтэй ярилцах орчныг бүрдүүлэх.
- *Хариуцлагыг тодорхой болгох.* Харилцааны тодорхой дүрэм журам хэрэгжүүлж, хариуцлагыг тодорхой болгох.
- *Эргэх холбоо бий болгох.* Удирдлага, ажилчдын хооронд мэдээлэл солилцохыг идэвхжүүлэх.

Гэр бүлийн болон ажлын байрны харилцаа нь тус бүрийн онцлогтой ч хоёулаа харилцан ойлголцол, итгэлцэл, хамтын ажиллагаагаар баяжиж, хүн бүрийн амьдралд чухал нөлөө үзүүлнэ.

**Албан ба албан бус харилцаа.** Ажлын байрны харилцаа нь албан ба албан бус гэсэн хоёр үндсэн хэлбэрээр илэрдэг. Энэ хоёр хэлбэр нь байгууллагын зорилго, уур амьсгал, ажилтнуудын хоорондын ойлголцолд чухал үүрэгтэй.

**Албан харилцаа.** Албан харилцаа гэдэг нь тодорхой дүрэм, журам, бүтэц зохион байгуулалт, шатлалд тулгуурлан хэрэгждэг харилцааны хэлбэр юм. Энэ нь ажлын байрны албан үүрэг, хариуцлагыг тодорхойлж, байгууллагын зорилгод хүрэхэд чиглэгддэг.

#### **Албан харилцааны онцлог**

- *Тодорхой зохион байгуулалттай.* Албан харилцаа нь тодорхой дүрэм журам, бодлого, албан ёсны хэлбэрээр явагддаг.
- *Эрх мэдлийн шатлалд тулгуурласан.* Удирдлагаас доод шатны ажилтнуудад эсвэл ажилтнууд хоорондоо заавар, мэдээлэл солилцох зохион байгуулалттай бүтэцтэй.
- *Баримтжуулалттай.* Албан харилцаа ихэвчлэн баримт бичгээр (имэйл, тайлан, тушаал г.м) хийгддэг тул мэдээлэл хадгалах боломжтой.
- *Зорилготой.* Албан харилцаа нь тодорхой зорилго, үр дүнд чиглэсэн байдаг.

Албан харилцааны давуу тал	Албан харилцааны сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийг ойлгомжтой, тодорхой хүргэх: Тодорхой заавар, дүрэм журам, албан бичиг нь буруу ойлголцлоос сэргийлдэг.</li> <li>- Хариуцлага нэмэгдүүлэх: Албан харилцаа нь баримтжуулалт дээр тулгуурладаг тул хариуцлагыг тодорхой болгодог.</li> <li>- Зохион байгуулалтыг дэмжих: Бүтэцтэй харилцаа нь ажилтнуудын хоорондын харилцан үйл ажиллагааг хөнгөвчилдөг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Уян хатан бус байдал: Албан харилцаа нь хэтэрхий дүрэм журамд баригдсанаар уян хатан байдал дутмаг байдаг.</li> <li>- Хэт албан ёсны байдал: Ажилтнуудын хооронд нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэхэд саад болж болзошгүй.</li> <li>- Цаг их шаарддаг: Баримтжуулалт болон албан бичгийн процесс нь цаг их шаарддаг.</li> </ul>

**Албан бус харилцаа.** Албан бус харилцаа гэдэг нь ажилтнуудын хооронд үүссэн хувийн болон нөхөрсөг хэлбэрийн харилцааг хэлнэ. Энэ нь албан ёсны дүрэм журамд баригдалгүй, харилцан ойлголцол, нөхөрсөг уур амьсгалыг бий болгодог.

#### Албан бус харилцааны онцлог

- *Чөлөөт байдал.* Албан бус харилцаа нь дүрэм журамд баригддаггүй бөгөөд нөхцөл байдлаас хамааран өрнөдөг.
- *Харилцааны уян хатан байдал.* Ажилтнуудын хооронд өөрийн санаа бодол, мэдрэмжээ чөлөөтэй хуваалцах боломжийг олгодог.
- *Эмоцийн холбоо.* Итгэлцэл, нөхөрлөлийг дэмжиж, ажилтнуудын хооронд эерэг сэтгэл зүйг бий болгодог.
- *Хурдтай мэдээлэл солилцоо.* Албан бус харилцаа нь аман яриа, шууд хэлэлцүүлгийн замаар хурдан өрнөдөг.

Албан бус харилцааны давуу тал	Албан бус харилцааны сул тал
<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын уур амьсгалыг сайжруулах: Нөхөрсөг харилцаа нь ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.</li> <li>- Итгэлцлийг нэмэгдүүлэх: Чөлөөтэй яриа нь ажилтнуудын хоорондын итгэлцлийг бэхжүүлдэг.</li> <li>- Шийдвэр гаргалтад туслах: Албан бус яриа хэлэлцүүлэг нь шинэ санаа, шийдлийг хурдан гаргахад тустай.</li> <li>- Харилцааны хурд: Шууд, энгийн харилцаа нь мэдээллийг хурдан солилцох боломжийг олгодог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийн буруу дамжуулалт: Албан бус яриа нь алдаатай мэдээлэл дамжих эрсдэлтэй.</li> <li>- Хэтэрхий хувийн шинжтэй байдал: Ажлын орчинд шаардлагагүй хувийн харилцаа нь ажлын бүтээмжийг бууруулах магадлалтай.</li> <li>- Эрх мэдэл, зохион байгуулалтад нөлөөлөх: Албан бус харилцаа нь албан ёсны эрх мэдэл, зохион байгуулалтыг сулруулах талтай.</li> </ul>

Албан ба албан бус харилцаа нь бие биенээ нөхөх шинж чанартай бөгөөд зөв зохистой хослуулснаар ажлын байрны үр дүнг нэмэгдүүлдэг. Албан харилцаа нь зохион байгуулалт, тодорхой үр дүнг баталгаажуулахад тустай бол албан бус харилцаа нь ажлын уур амьсгалыг сайжруулж, бүтээлч байдал, итгэлцлийг нэмэгдүүлдэг. Тиймээс байгууллагын удирдлага эдгээрийг оновчтой ашиглах замаар ажилтнуудын бүтээмж, ажлын чанарыг дээшлүүлэх боломжтой.

Харилцаа бол хүмүүсийн хоорондын ойлголцол, хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг бий болгох гол түлхүүр юм. Бид энэ хичээлээр харилцааны үндэс суурь, хэлбэр, зарчмуудыг судалж, аливаа харилцааны онол, соёлын ач холбогдлыг ойлгож, анхны шатны ур чадварыг

эзэмших боломжийг олгов. Гэвч харилцаа бол зөвхөн ойлголтоор хязгаарлагдахгүй, харин практик дээр хэрхэн амжилттай хэрэгжүүлэхээс илүү их шалтгаалдаг. Тиймээс, цаашид бид харилцааны ур чадварыг илүү тодорхой нөхцөлд, бодит орчинд хэрхэн ашиглах, үр дүнтэй харилцааг хэрхэн өрнүүлэх талаар илүү нарийвчилсан арга замуудыг судлах болно. Тухайлбал, удирдан манлайлах, багаар ажиллах, эерэг харилцааны уур амьсгал бүрдүүлэх зэрэг ажлын орчинд зайлшгүй шаардлагатай ур чадваруудаас эхлээд, хувь хүний ёс зүй, стресс удирдах, дасан зохицох чадварыг гүнзгийрүүлэхийг зорьж байна.

## Бүлгийн дүгнэлт

Харилцаа нь хүмүүсийн хоорондын ойлголцол, хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг бүрдүүлэх гол механизм юм. Энэхүү бүлгээр бид харилцааны үндсэн ойлголт, хэлбэрүүд, ёс зүй, соёл, зарчмуудыг судалж, хувь хүн, баг, байгууллага, нийгмийн түвшинд харилцааны ач холбогдлыг ойлгох боломжийг олголоо. Үр дүнтэй харилцаа нь мэдээллийг дамжуулах, зөрчилдөөнийг зохицуулах, хамтын ажиллагааг зохицуулж, итгэлцлийг нэмэгдүүлэхэд голлох үүрэгтэй.

Харилцааны хэлбэрүүд болох аман, бичгийн, биеийн хэлэмж, дижитал харилцаа нь тус бүрдээ онцлог, давуу ба сул талтай бөгөөд нөхцөл байдалд тохируулан зөв хослуулж хэрэглэх нь чухал. Үүний зэрэгцээ харилцааны соёл, ёс зүй, зарчмуудыг баримтлах нь харилцан итгэлцэл, ойлголцол, эв нэгдлийг хангах үндэс болдог. Харилцааны соёлтой хүн бусдыг хүндэтгэж, өөрийн үг, үйлдэлд хариуцлагатай хандаж, нөхцөл байдалд нийцсэн харилцааг үр дүнтэй зохион байгуулдаг.

Хувь хүний түвшинд харилцааны ур чадвар нь өөрийгөө таньж мэдэх, бусдыг ойлгож, хамтын ажиллагааг сайжруулахад тусалдаг. Үр дүнтэй харилцаа нь гэр бүлийн хүрээнд итгэлцэл, халамжийг нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлдэг бол ажлын байранд хамт олны уур амьсгалыг эерэг байлгаж, байгууллагын бүтээмжид чухал хувь нэмэр оруулдаг.

Эцэст нь, харилцааны ур чадвар нь тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай ур чадвар бөгөөд бидний амжилт, аз жаргал, сэтгэл ханамжид чухал нөлөө үзүүлдэг. Бид энэхүү бүлгээр харилцааны үндсийг судалж, бодит орчинд хэрэгжүүлэх анхан шатны мэдлэг, ур чадварыг олж авлаа. Цаашид харилцааны нарийвчилсан ур чадваруудыг судалж, үр дүнтэй харилцааг хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.

## 4.4 МАНЛАЙЛАЛ БА ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦААНЫ АРГА БАРИЛ

- 1.
- 2.

### 4.4.1. Удирдан манлайлах чадвар

*Манлайлал гэдэг нь бусдыг зорилгодоо хүрэхэд чиглүүлэх ур чадвар юм. John Kotter (Өөрчлөлтийн удирдлага, Бизнесийн манлайллын тэргүүлэх мэргэжилтэн)*

Удирдан манлайлах чадвар нь аливаа баг, байгууллага, хамт олны амжилт, хөгжил дэвшлийн үндэс суурь болдог. Энэ чадвар нь зөвхөн удирдах бус, бусдыг урамшуулж, ухаалгаар чиглүүлэн хамтдаа амжилтад хүрэх урлаг юм. Удирдан манлайлагч нь зөвхөн тушаал өгөгч бус, харилцааны хүчтэй холбоосыг бий болгож, багийн гишүүдийг нэгтгэж, хамтын зорилгод чиглүүлдэг.

#### Удирдан манлайлагч гэж хэн бэ?

*Сайн удирдагч бол замыг заагч бус, хамтдаа урагшлагч хүн юм. Жон Максвелл*

Удирдан манлайлагч нь зөвхөн өөрийн авьяас, ур чадвараар бус, бусдад нөлөөлөх, тэдний дунд эерэг өөрчлөлт авчрах чадвараараа тодорхойлогдоно. Жинхэнэ удирдагчийн хувьд дараах үндсэн чанаруудыг нэрлэж болно.

*Алсын хараатай байх* – Удирдагч нь ирээдүйг урьдчилан харж, алсын зорилгоо тодорхойлж, түүнийгээ бусдад ойлгомжтойгоор хүргэх чадвартай байна.

*Харилцааны ур чадвартай байх* – Бусдыг сонсох, ойлгох, зөв мэдээлэл өгөх, зөв шийдвэрт хөтлөх чадвар нь удирдагчийн гол шинж чанар юм.

*Хариуцлага хүлээх чадвар* – Зөвхөн өөрийнхөө үйлдэлд бус, багийнхаа амжилт, алдаа, дутагдалд ч бүрэн хариуцлага хүлээх ёстой.

*Уян хатан байдал* – Төрөл бүрийн нөхцөл байдалд дасан зохицож, оновчтой шийдвэр гаргах чадвартай байх нь удирдагчийг бусдаас ялгадаг.

**Удирдан манлайлах ур чадвар яагаад чухал вэ?** Ажлын байр, хамтын ажиллагааны орчинд удирдан манлайлагч нь хамт олны гишүүдийн урам зоригийг нэмэгдүүлж, тэднийг илүү бүтээмжтэй ажиллахад чиглүүлдэг. Манлайлагчийн эерэг хандлага, түүний үлгэр дууриал нь багийн гишүүдэд урам зориг өгөхөөс гадна, тэднийг өөрийнхөө чадамжийг ашиглаж, илүү ихийг хийхэд түлхэц болдог.

*Багийн зохион байгуулалт* – Удирдан манлайлагч нь багийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг зөв тодорхойлж, ажлыг үр дүнтэй зохион байгуулах замаар амжилтанд хүрэхэд чухал үүрэгтэй.

*Урам зориг өгөх* – Хамт олонд эерэг сэтгэлзүйн орчин бүрдүүлэх, зорилгоо хамтдаа биелүүлэх эрмэлзэл төрүүлэх нь удирдагчийн гол үүрэг юм.

*Шийдвэр гаргах* – Удирдан манлайлагч нь мэдээллийг нарийн шинжилж, багийнхаа оролцоог ханган, оновчтой шийдвэр гаргах чадвартай байх ёстой.

**Хэрхэн удирдан манлайлагч болох вэ?** Удирдан манлайлах чадвар нь зөвхөн төрөлхийн зүйл бус, суралцаж хөгжүүлэх боломжтой ур чадвар юм. Энэ чадварыг хөгжүүлэхийн тулд дараах арга замыг хэрэгжүүлж болно. Үүнд:

*Өөрийгөө таньж мэдэх* – Өөрийнхөө давуу болон сул талыг тодорхойлж, байнга өөрийгөө хөгжүүлэхэд анхаарах.

*Суралцагч байх* – Манлайлагчийн сайн жишээнүүдийг судалж, тэднээс тогтмол суралц. Үүний зэрэгцээ, алдаа дутагдлаасаа суралцаж, өөрийгөө байнга сайжруулахыг эрмэлзэх.

*Харилцааны ур чадвараа хөгжүүлэх* – Бусдыг сонсох, ойлгох, харилцан зөв шийдвэр гаргахын тулд харилцааны ур чадвараа байнга сайжруулах шаардлагатай.

*Хамтын ажиллагааг дэмжих* – Багийн гишүүдийн санал бодлыг хүндэтгэж, хамтдаа шийдэлд хүрэх орчныг бүрдүүлж ажиллана.

*Шийдэмгий байдал* – Хэцүү нөхцөл байдалд зөв шийдвэр гаргаж, бусдыг итгэлтэйгээр удирдан жолоодохыг эрмэлзэнэ.

Удирдан манлайлах чадвар нь зөвхөн удирдагчийн үүрэг төдийгүй аливаа хамт олны амжилт, эв нэгдлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ чадвар нь зөвхөн өөрийгөө хөгжүүлэх замаар төдийгүй бусдын хүч чадал, авьяасыг нээж, тэдэнд өөрийгөө илэрхийлэх боломж олгосноор илүү үнэ цэнтэй болдог. Жинхэнэ удирдагч бусдыг өөрийн алсын хараатай нэгтгэж, хамтын зорилгод хүрэх замд хөтлөгч байх ёстой.

#### 4.4.2. Ухаалаг манлайлал ба дотоод итгэл



Манлайлагч нь зоригтой бөгөөд ухаалаг шийдвэр гаргагч байх ёстой. Казүо Инамори “Амжилтад хүрэх гал эрмэлзэл” (2016) номдоо манлайллын суурь зарчмыг тодорхойлсон бөгөөд манлайлагчид зоригтой удирдаж, багийнхаа гишүүдийг урамшуулах нь чухал болохыг онцолсон. Мөн итгэлцлийг дотроос эхлэн бий болгож, багийн уур амьсгал, харилцааг эерэг байлгах нь удирдагчийн ур чадварын салшгүй хэсэг болохыг тэмдэглэсэн.

Манлайллын явцад туйлширсан хандлагаас зайлсхийж, харилцааг ухаалгаар зохицуулж, уян хатан, бодлоготой шийдвэр гаргах нь чухал. Туйлшрал, хийрхлийн төлбөр ямагт өндөр тусдаг. Харин аливаа нөхцөл байдалд зохицох чадварыг чухалчилж, харилцааны тэнцвэрийг хадгалах нь удирдагчийн эрхэм үүрэг хариуцлага болой. Мөн нэгдмэл байдлыг хүлээн зөвшөөрч, хамтын зорилгын төлөө хамтран ажиллах нь манлайлагчийн гол үүрэг байдаг (Наминчимэд, 2019).

Манлайлагчид багийн доторх харилцааг удирдан зохицуулахдаа хамтын зорилгыг тодорхойлох, эв нэгдэлтэй уур амьсгалыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Мөн багийн харилцааг үр дүнтэй удирдахын тулд удирдагчийн хүртэхүй, мэдрэхүй, сэргэг байдлыг ашиглах нь чухал гэж зөвлөдөг (Туул, 2010). Эцэст нь, ухаалаг манлайлал нь дотоод итгэл, зориг, уян хатан байдал, мэдрэмжийг хослуулан хамтын ажиллагааг чиглүүлэх чадварт тулгуурлах бөгөөд энэ нь байгууллага, хамт олны хөгжлийг хангах хамгийн хүчтэй арга хэрэгсэл болдог.

**Имидж бүрдүүлэлт.** Хүнийг удирдан, манлайлах чадвар нь зөвхөн үйл хөдлөл, үгийн сонголтоор хязгаарлагдахгүй, харин тухайн хүний дотоод мөн чанар, итгэл үнэмшил, гадаад төрх зэрэг олон хүчин зүйлээс бүрддэг. Ухаалаг манлайлал нь хамт олныг урамшуулж, хамтын зорилгын төлөө нэгдмэл байдлыг бий болгодог бол тухайн манлайлагчийн имидж нь энэ зорилгын бэлгэ тэмдэг болдог. Имидж бүрдүүлэлт нь манлайлагчийн өөрийгөө таних, өөртөө итгэх итгэлийг бататгаж, бусдад хэрхэн нөлөөлөх чадварыг нэмэгдүүлдэг.

Имидж бүрдүүлэлт нь зөвхөн хувцаслалтаас хамаарах зүйл биш. Энэ нь дотоод мөн чанар, зан чанар, үзэл бодолтой нягт уялдаатай. Дотоод итгэл үнэмшил, хандлага нь гадаад төрхөд шууд тусгалаа олж, хамт олон болон нийгэмд эерэг эсвэл сөрөг сэтгэгдэл төрүүлэх үндэс болдог. Хүн өөрийгөө таньж, өөрийн давуу болон сул талаа зөв үнэлэн, түүнийгээ гадаад төрхөөрөө илэрхийлэх чадвартай байх нь үр дүнтэй манлайллын гол суурь юм.

Энэ хичээлээр бид дотоод сэтгэл, итгэл үнэмшил болон гадаад имиджийн уялдааг хэрхэн удирдан манлайлахад ашиглах талаар судалж, имидж бүрдүүлэлтийн арга замуудыг илүү дэлгэрэнгүй авч үзэх болно. Энэ нь зөвхөн таны гадаад дүр төрхийг тодорхойлохоос гадна, таны манлайллын хүчийг нэмэгдүүлэх чухал алхам байх болно.

Хамгийн сайхан хоол бол таны биед тохирсон хоол, хамгийн сайхан хувцас бол таны стиль, биеийн онцлогт тохирсон хувцас, хамгийн их аз жаргал бол таны өөрийн замаар, өөрийн өгөгдөлдөө нийцүүлэн амьдрах явдал юм (Урангоо, 2019).

И.Урангоо “Хувцаслалтын эрх чөлөө” (2019) номоороо дамжуулан хувь хүний дотоод сэтгэл хөдлөлийг гадаад имиджтэй хэрхэн уялдуулж, өөрийгөө илэрхийлэх онцгой боломжийг олгосон юм. Энэ ном нь зөвхөн хувцаслалтын тухай бус, өөрийгөө таньж мэдэх, өөртөө итгэх, имиджээ бүрдүүлэх алхмуудыг эх хэл дээрээ авах боломжийг нээж өгсөн практикийн өндөр ач холбогдолтой гарын авлага бөгөөд онцлог үйлийг хураангуйлан тодорхойлж байна. Учир нь өөрийгөө бодитоор таньж, өөрт тохирсон стиль, гадаад төрхийг бүрдүүлэх нь таны харилцаанд итгэл төрүүлэх, бусдад эерэг сэтгэгдэл үлдээх чухал хүчин зүйл юм.

### **Имидж бүрдүүлэх алхмууд**

**Алхам 1:** Давуу болон сул талаа таньж хүлээн зөвшөөрөх. Өөрийн онцгой шинж чанаруудыг давуу тал гэж харах нь өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Энэ алхамд өөрийн давуу болон сул талуудыг жагсаан бичиж, сул талаа засах эсвэл өөлөх гэж оролдохын оронд байгаагаар нь хүлээн авах боломжийг хайх хэрэгтэй. Өөрийгөө хүлээн зөвшөөрөх нь дотоод тайвшрал, өөрийгөө таних эхний алхам юм.

**Алхам 2:** Загварын чиг хандлага ба мэдрэмжийг хөгжүүлэх. Загварын чиг хандлагыг ойлгох нь гадаад имидж бүрдүүлэхэд чухал. Өөрийн мэдрэмж, мэдлэгээ цаг үеийн загварын мэдээлэлтэй хослуулан хөгжүүлж байх хэрэгтэй. Үүний тулд:

- Орчин үеийн загварын мэдээ, мэдээллийг унших
- Өөрт сонирхолтой чиг хандлагыг сонжих
- Өөрт тохирох болон тохиромжгүй хэв маягийг ялган таних.

**Алхам 3:** Өөрт тохирсон дүрийг тодорхойлж, имидж бүрдүүлэх. Өөрийн сонирхол, амьдралын зорилго дээр тулгуурлан дүр төрх буюу стилийг бий болгох нь чухал. Үүний тулд:

- Өөрийн сонирхлыг ойлгож, өөрөөсөө асуулт асууж өөртэйгөө ярилц.
- Өөрт тохирсон өнгө, материал, загварын талаар судал.
- Боломжтой бол мэргэжлийн стилистээс зөвлөгөө авч, илүү оновчтой дүр төрхийг тодорхойл.

Эдгээр алхмуудыг хэрэгжүүлснээр Та өөрийн имиджийг зөвхөн гаднах төрхөөр бус, дотоод сэтгэлтэйгээ нийцсэн, илүү итгэлтэй, хүчирхэг өөрийгөө бүтээх боломжтой болно.

#### 4.4.3. Дотоод, гадаадын түншүүдтэй харилцах арга хэлбэр, зарчим

*Итгэлцэл бол харилцааны зүрх нь. Стивен Кови  
(Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн манлайллын нэртэй зөвлөх, багш)*

Орчин үеийн байгууллагын үйл ажиллагаа, амжилт нь дотоод, гадаад түншүүдтэй тогтоосон харилцааны чанараас шууд хамааралтай. Түншүүдтэй харилцах харилцаа нь зөвхөн мэдээлэл солилцох төдийгүй харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэнэ. Энэхүү харилцаа нь хэлэлцээр хийх, зөвшилцөх, мэдээллийг тодорхой арга хэлбэрээр солилцох үйл явц юм.

##### *Түншүүдтэй харилцах арга хэлбэрүүд*

**Аман харилцаа.** Уулзалт, хэлэлцээр, зөвлөгөөн зэрэг нүүр тулсан харилцааг багтаана. Энэ нь харилцааны шууд эргэх холбоог хангаж, илүү хурдан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг.

**Бичгийн харилцаа.** Имэйл, албан захидал, тайлан зэрэг бичгийн харилцааг ашиглах нь мэдээллийг албан ёсны байдлаар хадгалах, түншүүдтэй урт хугацааны итгэлцэл бий болгоход чухал үүрэгтэй.

**Дижитал харилцаа.** Виртуал уулзалт, чат, мессеж зэрэг харилцааны шинэ хэлбэрүүдийг ашиглан түншүүдтэй алсаас харилцах боломжтой болсон. Энэ нь цаг хугацаа, орон зайг хэмнэх давуу талтай.

##### *Түншүүдтэй харилцах харилцааны зарчим*

- **Итгэлцэл бий болгох.** Түншүүд хоорондын харилцааны хамгийн чухал суурь нь итгэлцэл. Үүнийг бий болгоход үнэнч байдал, хариуцлагатай хандлага чухал.
- **Соёлын ялгааг хүндэтгэх.** Дотоод болон гадаад түншүүдийн соёлын ялгааг ойлгож, хүндэтгэх нь харилцааны үр дүнг нэмэгдүүлнэ. Жишээ нь, олон улсын түншүүдтэй харилцахдаа тэдний хэл яриа, зан үйлд тохирсон арга барил хэрэглэх.
- **Тодорхой, ойлгомжтой харилцаа.** Мэдээллийг тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлэх нь зөрчил, буруу ойлголцлоос урьдчилан сэргийлнэ.
- **Уян хатан байх.** Бусдын санал бодлыг хүлээн зөвшөөрч, нөхцөл байдлаас хамааран өөрчлөлт хийхэд бэлэн байх нь амжилтын үндэс болно.

- *Урт хугацааны харилцааг эрхэмлэх.* Харилцааг зөвхөн богино хугацааны үр дүнгээр хязгаарлах бус, урт хугацаанд тогтвортой хамтын ажиллагаа бий болгоход анхаарах.
- *Харьцаж буй хүнээ “Анх уулзаж буй хүн” гэж харах.* Харилцаанд тустай нэгэн арга барил нь “шинэ хүн” гэж харах хандлага юм. Энэ хандлага нь буддизмийн сургаалд үндэслэсэн бөгөөд хүн, сэтгэл хоёр үргэлж өөрчлөгдөж байдаг гэж үздэг. Бусдыг шинэ өнцгөөр харах нь илүү нээлттэй, ойлголцол дүүрэн харилцааг үүсгэхэд тустай (Рюшүн, 2024).
- *Чин сэтгэлээсээ харилцах.* Энэ зарчмын дагуу түнштэй харилцахдаа эхлээд тэдний хэрэгцээ, хүсэлтийг ойлгож, дараа нь өөрийн санаагаа илэрхийлэх нь харилцан итгэлцэл, тогтвортой хамтын ажиллагааг бий болгоно. Бусадтай чин сэтгэлээсээ харилцах нь харилцааг илүү үр дүнтэй, бат бөх болгодог (Казүо, 2016).

Дотоод болон гадаад түншүүдтэй үр дүнтэй харилцах нь байгууллагын амжилтын үндэс суурь болдог. Энэхүү харилцааг итгэлцэл, соёлын ялгааг хүндэтгэх, тодорхой, ойлгомжтой байдалд тулгуурлан хөгжүүлснээр байгууллагын зорилгод нийцсэн тогтвортой хамтын ажиллагаа бий болдог.

Түншүүдтэй харилцааг үр дүнтэй хөгжүүлэхийн тулд дараах аргачлалуудыг ашиглаж болно. Үүнд:

- *Албан ёсны имэйл бичих, утга тодорхой дамжуулах дасгал.* Имэйл харилцаанд мэргэжлийн хандлага, тодорхой мэдээлэл, найрсаг үгийг хослуулан бичих нь итгэлцлийг нэмэгдүүлнэ. Жишээ нь, имэйл бичихдээ албан ёсны мэндчилгээ, гол мэдээлэл, эцсийн найрсаг төгсгөлийг багтаах.
- *Соёл хоорондын харилцааны кейс судалгаа.* Жишээлбэл, олон улсын түнштэй хэлэлцээр хийхдээ тухайн улсын хэл ярианы хэв маяг, зан заншил, ажлын арга барилыг хэрхэн ашиглах тухай кейсийг судалж, шийдэл боловсруулах.
- *“Win-Win” зарчмыг ашиглан хэлэлцээр хийх симуляц.* Хоёр талын хэрэгцээ, зорилгыг ойлгож, хамтдаа ялалт байгуулдаг шийдлийг олохыг зорьсон бодит хэлэлцээрийг дуурайлган хийх дасгал.



Эдгээр арга барил, зарчмуудыг хэрэгжүүлснээр дотоод болон гадаад түншүүдтэй харилцах харилцаа нь зөвхөн мэргэжлийн төдийгүй эерэг, итгэлцэл дүүрэн, урт хугацааны хамтын ажиллагааны үндэс болно.

#### 4.4.4. Нутгийн иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг бэлтгэж хүргэх, танилцуулах

*Мэдээлэл нь зөв өгсөн тохиолдолд зам заагч, буруу өгсөн тохиолдолд төөрөгдүүлэгч болдог.*

Нутгийн иргэдтэй харилцах нь байгаль орчин, нийгмийн хариуцлагатай холбоотой үйл ажиллагааны нэг чухал хэсэг юм. Тэдэнд хэрэгцээтэй мэдээллийг бэлтгэж хүргэх нь зөвхөн мэдээлэл дамжуулах бус, мөн хамтын ажиллагааг дэмжих, итгэлцэл бий болгох үйл явц билээ.

### 1. Мэдээллийг бэлтгэх арга

- *Хэрэгцээг тодорхойлох.* Нутгийн иргэдийн шаардлага, хэрэгцээг ойлгохын тулд судалгаа, ярилцлага хийх.
- *Мэдээллийг оновчтой болгох.* Иргэдийн ойлгож чадах хэл, хэлбэрээр мэдээллийг бэлтгэх. Жишээ нь, энгийн үг хэллэг, дүрслэл ашиглах.
- *Шалгаж, баталгаажуулах.* Хүргэх мэдээллийг үнэн зөв эсэхийг баталгаажуулж, мэргэжлийн эх сурвалжаас зөвлөгөө авах.

### 2. Мэдээллийг хүргэх арга

- *Нийтийн уулзалт зохион байгуулах.* Нийтийн уулзалтаар дамжуулан иргэдтэй харилцан ярилцах боломж олгох.
- *Сурталчилгааны материал ашиглах.* Зурагт хуудас, сонин, цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл хүргэх.
- *Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах.* Нутгийн захиргаа, иргэдийн бүлгүүдтэй хамтран мэдээлэл түгээх.

### 3. Танилцуулах арга

- *Хэл ярианы энгийн байдал.* Ойлгомжтой, хялбар үг хэллэг ашиглах.
- *Дүрслэл ашиглах.* Зураг, график, видео бичлэг ашиглан мэдээллийг сонирхолтой байдлаар танилцуулах.
- *Иргэдийн оролцоог хангах.* Асуулт хариулт, санал хүсэлт хүлээн авах замаар иргэдийг идэвхтэй оролцуулах.

Нутгийн иргэдтэй харилцах нь зөвхөн мэдээлэл хүргэх явц биш, хамтын итгэлцэл, ойлголцол бий болгоход чиглэгддэг. Мэдээллийг оновчтой бэлтгэж, энгийн, ойлгомжтой хэлбэрээр хүргэх нь амжилттай харилцааны түлхүүр болдог. Үүний тулд тодорхой нөхцөл байдлыг урьдчилан тооцоолох, түүнд тохирох хариу үйлдлийг үзүүлж, зөв арга хэмжээг авах нь чухал. Энэ утгаараа нөхцөл байдлыг тодорхойлох SPAM арга, мэдээлэл түгээх ИЛТГЭЛ, удирдан зохион байгуулах ХУРАЛ зэргийг хэрхэн хийх аргуудыг товч дурдаж байна.

**SPAM.** SPAM гэх ойлголт нь аливаа харилцааны нөхцөл байдлыг урьдчилан төсөөлж, дүн шинжилгээ хийхэд ашиглагддаг арга зүй юм. Энэ нь харилцааны явцад гарч болох хүндрэлүүд болон үр дүнг урьдчилан тооцоолох боломжийг бүрдүүлдэг. SPAM гэдэг нь дараах дөрвөн үндсэн ойлголтын товчлол юм:

1. *Situation (Нөхцөл байдал).* Энэ нь тухайн харилцааны орчин, цаг хугацаа, оролцогч талуудын үүрэг, зорилгыг тодорхойлохтой холбоотой. Нөхцөл байдлыг үнэлэхдээ дараах асуултуудыг авч үзнэ:
  - Хэнтэй харилцаж байна вэ?
  - Ямар орчинд харилцаа явагдаж байна вэ?
  - Энэ харилцаа ямар зорилготой вэ?
2. *People (Хүмүүс).* Харилцаанд оролцож буй хүмүүсийн үүрэг, хандлага, туршлага, сэтгэл зүйн онцлогийг шинжлэхэд анхаарна. Үүнд:
  - Тухайн хүмүүсийн хоорондын харилцааны түвшин
  - Тэдний итгэлцэл, нөлөөлөл, эсвэл өрсөлдөөний байдал
  - Хүмүүсийн соёлын болон үнэт зүйлсийн ялгаа.
3. *Action (Үйлдэл).* Харилцааны явцад хэн юу хийх эсвэл ямар үйлдэл хийхээр төлөвлөж байгааг тодорхойлох. Үүнд:

- Тухайн харилцааны үйлдлийн дараалал
- Оролцогч талуудын хариу үйлдэл
- Аливаа шийдвэр гаргах эсвэл хариуцлага хүлээх механизм.

4. *Message (Мэдээлэл)*. Харилцааны гол агуулга, мэдээлэл дамжуулалтын арга зам, мессежийн тодорхой байдал, хүлээн авахад үзүүлэх нөлөөг авч үзнэ. Үүнд:

- Харилцааны гол санаа, зорилго
- Мессежийг ямар сувгаар дамжуулах (бичгээр, амаар эсвэл цахимаар)
- Мессежийн ойлгомжтой, үр дүнтэй байдал.

#### *SPAM-ийн ач холбогдол*

- *Зохион байгуулалттай харилцаа*. Харилцагч талуудын хоорондын харилцааг үр дүнтэй төлөвлөх, удирдах боломжийг олгодог.
- *Эрсдэлийг багасгах*. Болзошгүй асуудлыг урьдчилан тооцоолсноор сөрөг үр дагавраас зайлсхийхэд тусална.
- *Төлөвлөлтийг сайжруулах*. Харилцааны илүү үр дүнтэй стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Энэ аргыг бизнес, боловсрол, гэр бүлийн харилцаа зэрэг олон төрлийн нөхцөл байдалд ашиглах боломжтой.

*Илтгэл*. Илтгэл бол мэдээлэл дамжуулах, үзэл бодлоо хуваалцах, сонсогчдод нөлөөлөх хамгийн үр дүнтэй арга зам юм. Амжилттай илтгэл бэлтгэж, хүргэхэд илтгэл бичих аргачлал болон илтгэх ур чадварын тэнцвэрт байдал чухал үүрэгтэй. Доор илтгэлийг бичих болон илтгэхэд анхаарах гол зарчмуудыг тайлбарлав.

#### *Илтгэл бичих*

Тодорхой зорилго тавих: Илтгэлийн гол зорилгоо тодорхойлж, сонсогчдод ямар санаа хүргэхийг хүсэж байгаагаа тодорхой болго. Жишээ нь, мэдээлэл өгөх, урам зориг өгөх, үзэл бодлыг нь өөрчлөх гэх мэт.

Сонсогчдоо таних: Хэнд зориулж илтгэж байгаагаа мэдэх нь чухал. Тэдний мэдлэг, сонирхол, хэрэгцээг ойлгож, тэдэнд тохирсон үг хэллэг, жишээг ашиглах ба дараах энгийн бүтэцтэй байна. Үүнд:

- Оршил: Сонирхолтой эхлэл, гол санааны товч танилцуулга
- Гол хэсэг: Логик дараалалтай, жишээ баримтаар баялаг үндсэн мэдээлэл
- Дүгнэлт: Товч бөгөөд хүчтэй төгсгөл, сонсогчдод өгөх уриалга эсвэл гол санааны давтамж.

Товч, тодорхой бичих: Сүүлийн үеийн судалгаагаар илтгэлийн хамгийн үр дүнтэй хугацаа 10-15 минут байдаг тул агуулгыг оновчтой хураангуйлах. Гол санаагаа тодорхой илэрхийлж, урт өгүүлбэрээс зайлсхий.

*Баяжуулах материал бэлтгэх*. Зураг, график, жишээ, статистик зэрэг агуулгыг дэмжих материалуудыг ашиглах нь илтгэлийн агуулгыг ойлгомжтой, сонирхолтой болгодог.

#### *Илтгэх*

- *Өөртөө итгэлтэй байдал*. Бэлтгэл сайн байх тусам өөртөө итгэлтэй байдлыг нэмэгдүүлдэг. Илтгэлээ хэд хэдэн удаа давтаж, дуу хоолой, биеийн хэлэмжээ туршиж үзэх.

- *Сонсогчидтойгоо харилцах.* Нүдээр харилцах, асуулт асуух, инээмсэглэх зэрэг нь сонсогчдын анхаарлыг татаж, харилцааг илүү ойртуулдаг.
- *Биеийн хэлэмж ашиглах.* Хөдөлгөөн, дохио зангаа, дуу хоолойны өнгөний өөрчлөлт нь илтгэлийн сэтгэл хөдлөлийг нэмэгдүүлж, сонсогчдод хүчтэй сэтгэгдэл үлдээдэг.
- *Төвлөрсөн сэдэвтэй байх.* Илтгэлийнхээ гол санаанд анхаарч, сэдвээс хазайхгүй байх. Товч бөгөөд тодорхой хэлэхийг эрмэлзэх.
- *Харилцан үйлчлэл хийх.* Асуултанд хариулах, санал солилцох боломж олгох нь илтгэлийг илүү үр дүнтэй, сонирхолтой болгодог.

Илтгэл бичих, илтгэх ур чадвар нь зөвхөн өөрийгөө илэрхийлэх төдийгүй сонсогчдод эерэг нөлөө үзүүлэх, мэргэжлийн болон хувь хүний харилцааг сайжруулах хүчтэй хэрэгсэл юм. Хичээнгүй бэлтгэл, сонсогчдод чиглэсэн хандлага, урам зоригтой илэрхийлэл нь таны илтгэлийг амжилттай болгох гол түлхүүр билээ. Сайн удирдагч уран илтгэгч байх ёстой гэж үздэг (Уянга, 2018).

**Хурал зохион байгуулах.** Хурал нь аливаа байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, зорилгыг тодорхойлж, хамтын шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай арга хэрэгсэл юм. Үр дүнтэй хурал нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- *Зорилго тодорхойлох.* Хурлын үеэр оролцогчид байгууллагын зорилго, тодорхой үйл ажиллагааны чиглэл, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг хамтдаа хэлэлцэж тодорхой болгодог. Энэ нь зорилгыг нэг мөр ойлгож, үр дүнтэй биелүүлэхэд тусалдаг.
- *Хамтын шийдвэр гаргах.* Хурлаар асуудлыг олон талаас нь авч үзэж, хамтын санал, шийдвэр гаргах боломж бүрддэг. Хамтран шийдвэр гаргах нь оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлж, ажлын үр өгөөжийг сайжруулдаг.
- *Харилцааг сайжруулах.* Хурал нь оролцогчдын хоорондын харилцаа холбоо бэхжүүлж, санал бодлоо чөлөөтэй солилцох, бие биенээ илүү сайн ойлгох боломжийг олгодог.

**Хурлын зохион байгуулалт.** Хурлын зохион байгуулалтын амжилт нь урьдчилсан сайн төлөвлөлтөөс хамаарна. Үүнд дараах үндсэн үе шат багтана.

1. Урьдчилан төлөвлөх:
  - Хуралдах хугацаа: Хурлын огноо, цагийг тодорхойлж, оролцогчдод урьдчилан мэдэгдэнэ. Энэ нь оролцогчдод бэлтгэл хангахад тусална.
  - Оролцогчдыг тодорхойлох: Хуралд оролцох хүмүүсийн нэрсийг гаргаж, үүрэг хариуцлагыг нь урьдчилан ойлгуулах.
  - Хөтөлбөр бэлтгэх: Хуралд хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг гаргаж, хөтөлбөрийн бүтэц, дарааллыг тодорхойлох.
2. Хурал удирдах
  - Илтгэгчдийг зохион байгуулах: Хэлэлцэх асуудлыг танилцуулах, шийдвэрлэх хүмүүсийг сонгон, тэдэнд үүрэг даалгавар өгнө.
  - Цаг ашиглалт: Хурал бүрийн хугацааг оновчтой тодорхойлж, хэлэлцэх асуудалд төвлөрч, хөтөлбөрийн дагуу үргэлжлэхэд анхаарна.
3. Хурлын үр дүнг дүгнэх
  - Хурлын төгсгөлд гол шийдвэрүүдийг нэгтгэн дүгнэж, хэн юу хийхийг тодорхой болгож, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргана.
  - Дүгнэлт, мэдээллийг оролцогчдод хуваалцаж, хэрэгжилтийн явцыг хянах ажлыг зохион байгуулах.

**Хурлын үеийн харилцааны үр чадвар.** Хурлын үр дүн нь оролцогчдын харилцааны үр чадвараас ихээхэн шалтгаалдаг. Үүнд:

- *Идэвхтэй сонсох.* Бусдын ярьж буй зүйлийг анхааралтай сонсож, шаардлагатай үед асуулт тавих. Энэ нь харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, үр дүнтэй санал, шийдвэр гаргахад тусална.
- *Асуулт тавих.* Оролцогчидтой илүү ойлгомжтой, үр дүнтэй харилцахын тулд тодорхой асуулт тавих нь хурлын гол асуудлыг гүнзгийрүүлэн ойлгоход дэмжлэг үзүүлнэ.
- *Санал солилцох.* Өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын үзэл бодлыг хүндэтгэн, баримт, үндэслэлтэйгээр хэлэлцэх.

Үр дүнтэй хурал зохион байгуулах нь байгууллагын амжилтын нэг үндэс суурь юм. Урьдчилан төлөвлөж, үр ашигтай удирдан зохион байгуулж, харилцааны үр чадвараа зөв ашиглаж чадвал аливаа хурал хамтын зорилгодоо хүрэх томоохон алхам болно.

#### **Дадлага ажил. “Байгаль хамгаалах ажлын хурал”**

Байгаль хамгаалагчид хуралдаж, нутаг дэвсгэрийн зэрлэг ан амьтдын тооллогын тайланг хэлэлцэхийн зэрэгцээ, хөдөө аж ахуйн байгууллагуудтай хамтын ажиллагааны шинэ арга хэмжээг тодорхойлж байна. Хурлын үеэр:

- Багийн ахлагч хөтөлбөрийг танилцуулж, илтгэгчдэд тодорхой үүрэг хуваарилав.
- Оролцогчид идэвхтэй сонсож, санал солилцсон.
- Хурлын төгсгөлд мэдээллийг нэгтгэж, шийдвэрийг бичгэн хэлбэрээр баримтжуулсан.

Энэ жишээ нь хурал амжилттай зохион байгуулахад зорилго тодорхойлох, идэвхтэй оролцох, үр дүнг нэгтгэхийн чухлыг харуулна.

#### **4.4.5. Аман судалгаагаар мэдээлэл цуглуулж, боловсруулах арга техник**

*Асуугаагүй бол мэдэхгүй, мэдээгүй бол шийдэхгүй*

Аман судалгаа нь мэдээлэл цуглуулах хамгийн шууд бөгөөд үр дүнтэй арга юм. Түүнчлэн байгаль хамгаалагчийн мэргэжлийн онцлогтой аман судалгаа нь нягт уялддаг. Энэ нь тухайн орон нутгийн иргэд, мэргэжилтнүүд болон бусад холбогдох талуудтай харилцан яриа өрнүүлж, шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах үр чадварыг шаарддаг. Үр дүнтэй аман судалгаа явуулахад зөв асуулт тавих, анхааралтай сонсох, тэмдэглэл хөтлөх зэрэг чадварууд зайлшгүй чухал бөгөөд эдгээр нь зөвхөн мэдээлэл цуглуулах төдийгүй харилцагч талуудтай итгэлцэл бий болгоход чиглэдэг.

##### **Аман судалгааны ач холбогдол**

- *Шууд харилцаа ба итгэлцэл бий болох.* Аман судалгаа нь оролцогч талуудтай нүүр тулж харилцах боломжийг олгодог. Ингэснээр зөвхөн мэдээлэл авах төдийгүй харилцан итгэлцэл, ойлголцол бий болдог.
- *Ойлгомжтой, нарийвчилсан мэдээлэл авах.* Ярилцлагын үеэр асуултаа тодорхойлж, шаардлагатай нэмэлт мэдээллийг шууд авч болдог.
- *Субъектив мэдрэмжийг таних.* Судалгаанд оролцогчдын сэтгэл хөдлөл, хандлага, үзэл бодлыг ойлгох боломжийг олгодог.
- *Мэдээллийн чанар сайжруулах.* Судалгааны явцад тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, баталгаажуулах боломжийг олгодог.

### Аман судалгааны үе шат

1. *Судалгааны зорилгоо тодорхойлох.* Аман судалгааны хүрээнд ямар мэдээлэл олж авахыг тодорхойлох. Жишээ нь, нутгийн иргэдийн байгаль орчны асуудалд хандах хандлага.
2. *Асуулт боловсруулах.* Логик дараалалтай, ойлгомжтой, нээлттэй асуултуудыг урьдчилан боловсруулах. Жишээ нь “Танай орон нутагт ховордсон амьтдын хамгаалалд ямар асуудал тулгарч байна вэ?”
3. *Судалгаанд оролцогчдыг сонгох.* Судалгааны зорилгод тохирох бүлэг эсвэл хувь хүмүүсийг сонгон авах.
4. *Судалгааг гүйцэтгэх.* Судалгаанд оролцогчдод асуулт тавьж, тэдний хариултыг анхааралтай сонсох. Биеийн хэлэмж, дохио зангааг анхаарах замаар мэдээллийн утгыг илүү сайн ойлгох.
5. *Мэдээллийг тэмдэглэх, баталгаажуулах.* Хариултыг тэмдэглэл эсвэл аудио бичлэгийн аргаар хадгалах, агуулгыг эргэж нягтлан, зөв ойлгосон эсэхийг шалгах.
6. *Мэдээллийг боловсруулах.* Цуглуулсан мэдээллээ нэгтгэн, ангилах, дүгнэлт гаргах.

### Аман судалгааны арга техник

- *Нэг удаагийн ярилцлага.* Нэг оролцогчоос тодорхой асуултад хариулт авах.
- *Фокус бүлгийн ярилцлага.* Бүлэг хүмүүсийг хамруулан тодорхой сэдвээр мэдээлэл авах. Энэ нь илүү олон өнцгөөс мэдээллийг харах боломж олгоно.
- *Тэмдэглэл ба бичлэг ашиглах.* Ярилцлагыг тэмдэглэх, аудио эсвэл видео бичлэг хийх замаар мэдээллийг хадгалах.
- *Санамсаргүй асуулт тавих.* Судалгаанд оролцогчдын хариултыг илүү шударга, бодит байлгахын тулд асуултуудыг урьдчилан мэдэгдэхгүй тавих.

### Асуулт боловсруулах зарчим

- *Тодорхой, энгийн байх.* Оролцогчдод ойлгомжтой, хялбар асуулт тавих. Жишээ нь “Байгаль хамгаалах энэ төслөөс таны хүлээлт юу вэ?”
- *Нээлттэй асуулт ашиглах.* Оролцогчид бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох. Жишээ нь “Энэ асуудал танай амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?”
- *Шалтгаан тодруулах.* Хариултын уг шалтгааныг тодруулж, илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах. Жишээ нь “Энэ асуудал яагаад хамгийн чухал гэж үзэж байна вэ?”
- *Эргэх холбоо тогтоох.* Асуултаар харилцагчийн санаа бодлыг тусгах, баталгаажуулах.

### Мэдээллийг боловсруулах

1. *Мэдээллийг ангилах.* Бодит, субъектив мэдээллийг тусад нь ялгах.
2. *Анализ хийх.* Цуглуулсан мэдээллийн хандлага, ерөнхий дүр төрхийг тодорхойлох.
3. *Дүгнэлт гаргах.* Судалгааны зорилгод нийцсэн мэдээллийг нэгтгэн, тайлан бэлтгэх.

Аман судалгаа нь мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, харилцаа хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Зөв асуулт тавих, анхааралтай сонсох, мэдээллийг зохих ёсоор тэмдэглэх нь амжилттай судалгааны үндэс болдог. Байгаль хамгаалагчид харилцааны энэхүү аргыг үр дүнтэй ашигласнаар мэргэжлийн зорилгодоо хүрч, байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам хийнэ.

## Бүлгийн дүгнэлт

Манлайлал бол хувь хүн, баг, байгууллага, хамт олны хөгжлийг хангах үндсэн суурь бөгөөд үр дүнтэй харилцаа нь түүний салшгүй хэсэг юм. Энэ хичээл нь удирдан манлайлах ур чадвар болон харилцааны арга барилыг эзэмшихэд чиглэсэн бөгөөд багийн зохион байгуулалт, мэдээлэл солилцоо, итгэлцлийг нэмэгдүүлэх чухал арга хэрэгслүүдийг судалсан. Манлайллын онцлог нь зөвхөн удирдах биш, бусдыг урамшуулан хамтын зорилгод чиглүүлэх урлагт оршдогийг тэмдэглэх нь зүйтэй.

Удирдан манлайлагчийн хувьд алсын хараатай байж, багийн гишүүдийн оролцоог дэмжих, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оновчтой шийдвэр гаргах нь нэн чухал. Түүнчлэн, харилцааны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, соёлын ялгааг хүндэтгэх, нөхцөл байдалд уян хатан хандах зэрэг нь үр дүнтэй харилцааны үндэс болдог. Хамтын ажиллагааны уур амьсгалыг бүрдүүлснээр багийн гишүүдийн итгэлцэл нэмэгдэж, бүтээмж, ажлын чанар сайжирдаг.

Дотоод болон гадаад түншүүдтэй харилцах харилцаа нь зөвхөн мэдээлэл солилцоо биш, харилцан итгэлцэл, урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэдэг. Мөн нутгийн иргэдтэй үр дүнтэй харилцахын тулд мэдээллийг тодорхой, ойлгомжтой, энгийн байдлаар хүргэж, тэдний хэрэгцээ, онцлогийг хүндэтгэх нь амжилтын түлхүүр юм. Аман судалгаа нь бодит мэдээлэл цуглуулж, оролцогч талуудын хэрэгцээ, саналыг ойлгох чухал арга замыг бүрдүүлдэг.

Эцэст нь, удирдан манлайлах болон харилцааны ур чадваруудыг эзэмшсэнээр хувь хүн өөрийн нөлөөллийг нэмэгдүүлж, хамт олон, байгууллагынхаа амжилтад бодит хувь нэмэр оруулдаг. Энэ бүхэн нь зөвхөн хувь хүний төдийгүй нийгэмд эерэг өөрчлөлт авчрах суурь болдог. Иймд манлайлал, харилцааны ур чадварыг хөгжүүлэх нь өнөөдрийн нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хамтдаа амжилтад хүрэх замыг тодорхойлогч хүчин зүйл болохыг энэ хичээлээр онцоллоо.

## 4.5 ЗЭРЭГ ХАНДЛАГА БА ХУВЬ ХҮНИЙ МАНЛАЙЛАЛ

### 4.5.1. Эерэг хандлага ба үлгэрлэх хүч

*Нүүрээ үргэлж нар луу харуул, сүүдэрүүд ард чинь үлдэнэ.  
Уолт Уитман*

Эерэг хандлага гэдэг нь аливаа нөхцөл байдалд өөдрөгөөр хандаж, боломжийг олж харах, сорилтуудыг даван туулах итгэл, хүчийг дотооддоо бий болгох чадвар юм. Энэ нь хувь хүний дотоод ертөнцөөс эхэлж, бусдад нөлөөлөх хүч болж илэрдэг. Америкийн сэтгэл судлаач Мартин Селигманы “Өөдрөг хандлагын онол”-оор эерэг хандлага нь аз жаргал, амжилтад хэрхэн нөлөөлдөг талаар судалсан байдаг (YOLO, н.г.). Судалгаагаар, эерэг хандлагатай хүмүүс асуудлыг шийдвэрлэхдээ илүү бүтээлч бөгөөд сэтгэл зүйн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлдөг болохыг баталсан.

Эерэг хандлага нь зөвхөн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлээд зогсохгүй бусдад нөлөөлж, хамтын ажиллагаанд урам зориг өгдөг. Өндөр бүтээмжтэй хүний 7 дадлын нэгт “Идэвх санаачилгатай байдал (Proactive)”-ийг оруулсан нь нөхцөл байдлыг хяналтдаа авч, бусдад зөв үлгэр дууриал үзүүлэх нь чухал ур чадвар болохыг илтгэнэ (Кови, 1989). Өдөр тутмын амьдралдаа эерэг үйлдэл хийж хэвших, өөдрөг хандлагыг өөрийн бодол, үйл хөдлөлд шингээх нь бусдад эерэгээр нөлөөлдөг. Бусдад үлгэр дууриал болгох нь хамтын зорилгод хүрэх гол түлхүүр болдог. Үлгэрлэх хүчийг тодорхойлбол зөвхөн үгээр бус, бодит үйлдэл, хандлагаар бусдад нөлөөлөх ур чадвар юм. Гэвч энэ чадвар өөрөө автоматаар бий болдог зүйл биш. Харин ухамсартай хүчин чармайлтаар хөгжүүлдэг ур чадвар юм. Тиймээс дараах хөгжүүлэх арга замыг хуваалцаж байна.

#### *Эерэг хандлага ба үлгэрлэх хүчийг хөгжүүлэх арга зам*

##### *1. Өөрөөсөө эхэлье: Эерэг хандлагыг хөгжүүлэх*

Бидний хандлага амьдралынх нь чанарыг тодорхойлдог. Хүнд хэцүү нөхцөлд ч боломжийг олж харах чадварыг хэрхэн хөгжүүлэх вэ?

- *Талархалын дэвтэр хөтөл.* Өдөр бүр өөрт тохиолдсон гурван эерэг зүйлийг тэмдэглэх дадал өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, өөдрөг байдлыг хэвшүүлнэ.
- *Сөрөг бодлыг “шүүлтүүрдэх”:* Та сөрөг бодолдоо шууд захирагдахгүйгээр, оронд нь “Энэ бодол надад хэрхэн ашигтай байж болох вэ?” гэж асуу.

##### *2. Үйлдлээрээ үлгэрлэ: Хандлага бол халдвар*

Зөвхөн ярих биш, зөв зүйл хийх нь бусдад эерэг нөлөө үзүүлдэг. Таны жижиг үйлдэл ч бусдын сэтгэлд үлгэр жишээ болох хүчтэй.

- *Бусдыг урамшуул.* Ажил дээрээ хэн нэгний сайхан үйлдлийг магтаж, сайшаах нь багийн уур амьсгалыг сайжруулна.
- *Эерэг зан үйл.* Бага зүйлд ч хариуцлагатай хандаж, бусдад итгэл хүлээлгэхэд анхаар.

##### *3. Харилцааны шидэт хүч: Бусдыг урамшуулах урлаг*

Казүо Инаморийн онцолсончлон, өөрийн эерэг эрч хүчээ бусдад түгээж, тэдний сэтгэл санааг дэмжих нь эерэг хандлагыг амьдралд хэрэгжүүлэх арга юм. Жишээ нь, өдөр тутмын ажлын үедээ бусдад чин сэтгэлээсээ талархах нь зөвхөн таныг биш, таны багийг ч хөгжүүлнэ. Тиймээс талархалын үгийг бусдад харамгүй хэлж байгаарай (Казүо, 2016).

#### 4. Төлөвлөгөөний хүч: Зорилго тодорхойлох

Эерэг хандлага бол зорилгоо тодорхойлж, түүндээ төвлөрөх чадвараар бэхжинэ. Аливаа зүйлийг “Эцсийн үр дүнгээр төсөөлөх” дадлыг хэрэгжүүлэн, богино болон урт хугацааны зорилтуудаа жагсаан бичих дадлыг хэвшүүл (Кови, 1989).

#### 5. Үгийн ид шид: Үг амьдралд нөлөөлдөг

Монголчууд үгээр хүнийг аварч ч, үхүүлж ч болдог хэмээн сэтгэж “Амны бэлгээс, ашдын бэлэг”, “Ерөөлөөр болог” зэргээр үргэлж сайн сайхныг хэлж ярихыг хичээдэг (Наминчимэд, 2019). Үг зөвхөн мэдээлэл дамжуулах бус, харилцагчийн урам зоригийг сэргээх шидтэй. Хүмүүсийн сэтгэлд хүрэх дулаан үгсийг байнга ашиглаарай.

#### Ганцаараа хийх дасгал:

- *Эерэг үйл явдлыг тэмдэглэх.* Өдөр бүр амьдралд тохиосон сайхан зүйлсийг бичих дасгал.
- *Зорилго тодорхойлох.* Ажил болон амьдралдаа хүрэхийг хүссэн богино болон урт хугацааны зорилгоо тодорхойлж бичих.

#### Багийн дасгал:

- Хамт олныг эерэг хандлагатай болгох зорилгоор харилцан магтах дасгал хийх.

Эерэг хандлага, үлгэрлэх хүч нь зөвхөн хувь хүний төдийгүй хамт олны амжилтын түлхүүр юм. Үүнийг хөгжүүлж, өөртөө болон бусдад урам зориг өгөхөд идэвхтэй оролцдог хүн бүхэн амжилтын замд илүү хурдан хүрдэг.

### 4.5.2. Ёс зүй ба хариуцлагатай байдал

*Өөрөө зөв бай, бусдын зөвийг хүндэл*

Ёс зүй гэдэг нь хувь хүн, байгууллага, хамт олны үйлдэл, харилцаанд баримтлах үнэт зүйлс, хэм хэмжээний цогц юм. Энэ нь зөвхөн нийгмийн хүлээлт бус, хувь хүний хариуцлагатай үйл хөдлөл, хандлагыг тодорхойлох чухал хүчин зүйл болж өгдөг. Мэргэжлийн ёс зүй бол ажил, үүргийн хүрээнд үнэнч, хариуцлагатай, шударга байдлыг хангах үзэл санаа юм.

Мэргэжлийн ёс зүй нь хариуцлагатай байдлын үндэс суурь юм. Энэ нь зөвхөн хууль, дүрэм журмыг баримтлах төдийгүй шударга, хүндэтгэлтэй хандах, өөрийн болон бусдын үйлдлийн үр дагаврыг ухамсарлах явдал юм. Хариуцлага хүлээх нь хувь хүний ёс зүйн амлалт бөгөөд энэ нь зөв шийдвэр гаргах, шударга үйл ажиллагааг хангахад чиглэнэ.

Хариуцлага гэдэг нь хувь хүн болон байгууллага өөрсдийн үйлдэл, шийдвэр, үүрэг хариуцлагаа ухамсарлаж, түүндээ нийцсэн зан үйл гаргах чадвар юм. Энэ нь алдаа гаргах үед зөвхөн уучлал хүсэхээр хязгаарлагдахгүй, харин аливаа үйл ажиллагаа, шийдвэрийн эерэг болон сөрөг үр дагаврыг ухамсарлан хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.

Хариуцлага нь дараах үндсэн элементүүдийг агуулдаг:

- *Өөрийн үйлдлийг ухамсарлах.* Хүн өөрийн хийж буй үйлдлийн утга учир, нөлөөллийг таньж мэдэх чадвартай байх.
- *Үр дагаврыг хүлээн зөвшөөрөх.* Ямар нэгэн шийдвэр, үйлдлийн үр дүн нь хэн нэгэнд хэрхэн нөлөөлөхийг ойлгож, шаардлагатай үед хариу үйлдэл үзүүлэх.

- *Хүлээлтийг биелүүлэх.* Өөрт ногдсон үүргийг цаг тухайд нь гүйцэтгэж, бусдын итгэлийг хүлээх.
- *Хариу арга хэмжээ авах.* Үүссэн нөхцөл байдалд зохицож, шаардлагатай өөрчлөлт хийх, алдаагаа засах.

**Мэргэжлийн ёс зүй ба хариуцлагатай байдлын зарчмууд.** Дараах зарчмуудыг олон улсын болон мэргэжлийн байгууллагуудын баримт бичгүүдээс сонгож, хураангуйлав. Эдгээр нь ёс зүйн хэм хэмжээг сахих, хариуцлагатай ажиллахад зайлшгүй шаардлагатай агуулгуудыг багтаасан болно. Үүнд:

- *Үнэнч шударга байдал (Integrity)* - Ажлын байр болон мэргэжлийн орчинд үнэнч байж, ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлах.
- *Ил тод байдал (Transparency)* - Үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, мэдээлэл солилцооны ил тод байдлыг хангах.
- *Хариуцлага хүлээх (Accountability)* - Хийсэн үйлдэл, гаргасан шийдвэр, хүрсэн үр дүнгийн хариуцлагыг бүрэн хүлээх.
- *Хүндэтгэл (Respect)* - Бусдын эрх, үзэл бодол, соёлын ялгааг хүлээн зөвшөөрөх.
- *Үүрэг биелүүлэх (Duty Fulfillment)* - Хамтын зорилгод нийцсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх.
- *Мэргэшлийн өндөр түвшинд ажиллах (Competence)* - Мэргэжлийн ур чадварыг байнга сайжруулж, чанартай үйлчилгээ үзүүлэх.
- *Тэгш байдал (Equity)* - Хүмүүсийн тэгш эрхийг хүндэтгэж, аливаа ялгаварлан гадуурхалтыг хориглох.
- *Хувийн мэдээллийг нууцлах (Confidentiality)* - Хувийн болон байгууллагын мэдээллийг зөвшөөрөлгүй тараахаас зайлсхийх.
- *Мэргэжлийн хил хязгаарыг дагах (Professional Boundaries)* - Хувийн болон мэргэжлийн харилцааг ялгаж, зохистой хэмжээнд барих.
- *Сурч хөгжих эрмэлзэл (Commitment to Learning)* - Мэргэжлийн ёс зүйн талаар суралцаж, өөрийгөө байнга хөгжүүлэх.

### Дадлага ажил. “Ёс зүйн кейс шийдвэрлэх”

Доорх кейсийг уншаад, асуултад хариулна уу.

Кейс: Таны хамт ажилладаг хүн чухал төслийн хугацааг хэтрүүлж, тайлагнахдаа бусад багийн гишүүдийн оролцоог дутуу үнэлсэн.

- Энэ нөхцөлд ёс зүйн ямар зарчмыг зөрчсөн байна вэ?
- Та энэ асуудлыг шийдвэрлэхэд ямар арга хэмжээ авах вэ?

Энэхүү хөнгөн кейс нь оролцогчдыг бодит нөхцөл байдалд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх, ёс зүйн хэм хэмжээг баримтлахад сургах зорилготой.

### 4.5.3. Асуудал шийдвэрлэх ба санаачилга гаргах

*Би ухаантайдаа биш, зүгээр л асуудалтай удаан ажиллах чадвартай.  
Альберт Эйнштейн*

Асуудал шийдвэрлэх чадвар гэдэг нь аливаа сорилт, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, оновчтой шийдэл боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц юм. Энэ чадвар нь хувь хүнээс гүнзгий бодлого, асуудлыг оновчтой тодорхойлох, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх дарааллыг төлөвлөхийг шаарддаг. Энэ нь XXI зуунд шаардагдаж буй чухал ур чадваруудын нэгд орно.

Санаачилга гаргах гэдэг нь ямар нэг зүйлийг сайжруулах, шинэ санаа гаргах, асуудлыг идэвх санаачилгатайгаар шийдвэрлэх оролдлого хийхийг хэлнэ. Санаачилга гаргах нь зөвхөн шийдлийг боловсруулах биш, бусдыг идэвхжүүлж, үйл ажиллагааны шинэ арга барилыг бий болгох явдал юм.

#### Асуудал шийдвэрлэхэд баримтлах үе шатууд

1. *Асуудлыг тодорхойлох.* Асуудлын гол шалтгааныг олж тогтоох, тухайн нөхцөл байдлыг ойлгох.
2. *Мэдээлэл цуглуулах.* Нөхцөл байдлыг дүгнэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах.
3. *Шийдвэрийн хувилбар боловсруулах.* Боломжит шийдлүүдийг гаргаж, үр дүнг нь урьдчилан тооцоолох.
4. *Шийдвэр гаргах.* Шийдвэрийн хувилбаруудаас оновчтойг сонгох.
5. *Хэрэгжүүлэх.* Сонгосон шийдлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэх.
6. *Үр дүнг үнэлэх.* Шийдвэрийн үр дүнг шинжилж, ирээдүйд суралцах туршлага болгох.

#### Асуудал шийдвэрлэхэд ашиглах арга хэрэгсэл

- *SWOT шинжилгээ.* Нөхцөл байдлын давуу болон сул тал, боломж, аюул заналыг үнэлэх.
- *Шийдвэрийн мод.* Боломжит хувилбаруудыг графикаар дүрслэн дүн шинжилгээ хийх.
- *Кейс судалгаа.* Бодит асуудалд тулгуурлан шийдвэр гаргах дасгал.

#### Санаачилга гаргах зарчмууд

- *Идэвхтэй байдал.* Бусдын санаачилгыг хүлээх биш, өөрөө эхлэн удирдах.
- *Тогтмол сайжруулалт.* Байгууллагын үйл ажиллагаанд шинэ санаачилгуудыг байнга нэвтрүүлэх.
- *Багийн оролцоо.* Шийдвэр гаргах үйл явцад бусадтай хамтран ажиллах.
- *Хариуцлага хүлээх.* Гарах үр дүн, алдаанд өөрийн хариуцлагыг ухамсарлах.

Асуудал шийдвэрлэх болон санаачилга гаргах чадвар нь хувь хүний дотоод ур чадварыг хөгжүүлж, бүтээлч үйл ажиллагааг дэмжихээс гадна, хамт олны уур амьсгал, байгууллагын бүтээмжийг сайжруулахад чухал нөлөөтэй. Энэ чадварыг эзэмшсэнээр хувь хүн аливаа нөхцөлд уян хатан хандаж, оновчтой шийдвэр гаргах, шинэ санаачилгыг хэрэгжүүлэх замаар хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах боломжтой.

Удирдагчийн хувьд шийдвэр гаргах болон санаачилгыг зөв зүгт чиглүүлэх нь хамт олны итгэлцлийг нэмэгдүүлж, зорилгодоо төвлөрөхөд түлхэц болдог. Санаачилга нь зөвхөн байгууллагын орчинг сайжруулах төдийгүй шинэ арга барилаар бусдыг манлайлах, үр дүнг нэмэгдүүлэх чухал түлхүүр юм.

**Дадлага ажил. “Шийдвэрийн мод” бүтээх**

Зорилго: Асуудлыг шийдвэрлэх үе шатуудыг бодитоор турших, багийн дотоод харилцааг сайжруулан, санаачилгатай хамтын ажиллагааг дэмжих.

**Дадлагын явц:**

1. Асуудлыг тодорхойлох: Жижиг багуудад хуваагдаж, баг тус бүр өөрийн салбар эсвэл өдөр тутмын ажлын жишээнээс нэг асуудал тодорхойлно (Жишээ нь “Багийн гишүүдийн хооронд харилцаа муу байгаа нь ажлын бүтээмжийг бууруулж байна”).
2. Шийдвэрийн хувилбар боловсруулах: Баг тус бүр асуудлаа шийдвэрлэх 3-5 хувилбар гаргаж, тус бүрийн давуу болон сул талыг товч бичнэ.
3. Шийдвэр гаргах: Багууд өөрсдийн гаргасан шийдвэрийн хувилбаруудаас хамгийн оновчтойг сонгон авна (Жишээ нь “Харилцааны сургалт зохион байгуулах”).
4. Шийдвэрийн мод бүтээх: Сонгосон шийдлийг хэрэгжүүлэх үе шатуудыг харуулсан “шийдвэрийн мод” бүтээж, алхам бүрийг дүрсэлнэ (Жишээ нь “Хэн сургалтыг зохион байгуулах, ямар хэлбэрээр, хэзээ” г.м).
5. Үр дүнг хуваалцах: Багууд өөрсдийн “шийдвэрийн мод”-ыг багийн гишүүдэд танилцуулж, тэдний санал, шүүмжийг хүлээн авна.

**4.5.4. Бусдыг дэмжих ба урамшуулах**

*Манлайлал гэдэг нь удирдахаас илүү хариуцаж буй хүмүүстээ анхаарал тавих тухай юм.  
Саймон Синек*

Бусдыг дэмжих гэдэг нь хамтран ажиллаж буй хүмүүстээ тусалж, тэдний ур чадвар, чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл явц юм. Энэ нь зөвхөн бусдын хэрэгцээг ойлгох төдийгүй тэднийг урамшуулж, хамтдаа зорилгодоо хүрэхэд түлхэц өгөхийг хэлнэ. Бусдыг дэмжих харилцаа нь итгэлцлийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны соёл бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.

Урамшуулах гэдэг нь бусдын эрч хүч, идэвх, хичээл зүтгэлийг өдөөж, амжилтад хүрэхэд нь урам зориг өгөх үйл явц юм. Урамшуулал нь хүмүүсийн сэтгэл санааны байдалд эерэг нөлөө үзүүлж, тэднийг илүү ихийг хийх эрмэлзэлтэй болгодог.

Бусдыг дэмжих, урамшуулах үйлдэл нь хувь хүний хөгжил, ажлын орчин, манлайллын үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой. Энэ нь хувь хүнийг өөрийн ур чадвараа хөгжүүлж, бусадтай эерэг харилцаа тогтооход тусалдаг бол ажлын байранд хамтын ажиллагааг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Манлайлагчийн хувьд дэмжлэг, урамшуулал нь зөвхөн зорилгод хүрэхэд бус, багийн гишүүдийн нөөц боломжийг нээн илрүүлж, тэднийг хөгжүүлж, амжилтанд хүргэх гол арга зам болдог.

## Дадлага ажил. “Сэтгэлээ хуваалцаж, дэмжлэг үзүүлэх нь”

*Хүмүүс үргэлж зөвлөгөө шаарддаггүй. Заримдаа тэдэнд гараа бариулах, яриаг нь сонсуулах, ойлгох сэтгэл л хэрэгтэй байдаг.*

Зорилго: Эмпати буюу бусдын сэтгэл хөдлөлийг ойлгож, дэмжлэг үзүүлэх ур чадварыг хөгжүүлэх.

Заавар:

1. Дадлага ажлын зорилгоо уншина уу (2 минут):

Эмпати гэж юу вэ? Энэ нь бусдын мэдрэмжийг ойлгож, тэдэнд дэмжлэг үзүүлэх чадвар юм. Эмпати нь итгэлцэл бий болгох, харилцааг сайжруулах үндэс болно.

Үйл ажиллагааны алхмуудыг дагана уу (30 минут):

а. Хосын дасгал: 2 хүн хос болж, нэг нь “түүх яригч,” нөгөө нь “сонсогч” болно.

Түүх яригч дараах нөхцөлийг ашиглан 1-2 минутын турш өөрт тохиолдсон эсвэл төсөөлсөн жишээг хуваалцана: “Би нэг удаа маш их стресстэй байсан...”, “Намайг хэн ч ойлгоогүй юм шиг санагдсан...”

Сонсогчийн үүрэг:

- Анхааралтай сонсох
- Бусдын мэдрэмжийг хүндэтгэн ойлгохыг хичээх
- Дараах асуултаар хариу өгнө: “Энэ үед та ямар мэдрэмжийг хамгийн их мэдэрч байсан бэ?”, “Та ийм мэдрэмж төрсөндөө өөрийгөө буруутгаж байсан уу?”

б. Солилцоо: Түүх яригч, сонсогчийн үүргийг солилцож дасгалаа үргэлжлүүлнэ.

2. Дүгнэх: Дараах асуултад өөртөө хариулаарай

- Хосын ярианаас та ямар мэдрэмжийг ойлгож, дэмжлэг үзүүлсэн гэж бодож байна вэ?
- Хүнд нөхцөлд бусдыг сонсох нь ямар мэдрэмж төрүүлэв?
- Энэ дасгал танд өөрийн амьдралд эмпатыг ашиглах ямар санаа өгч байна вэ?

3. Хуваалцах:

Дадлага ажлын дүгнэлтээ 2-3 өгүүлбэрээр бичиж баг хамт олноороо хуваалцана уу.

### Бусдыг дэмжих ба урамшуулах аргууд

- *Харилцааны хүч ашиглах.* Үнэнч, тодорхой харилцаа нь итгэлцлийг нэмэгдүүлж, хүмүүсийн сэтгэл санааг өөдрөг болгодог.
- *Сэтгэл хөдлөлийг ойлгож, дэмжлэг үзүүлэх.* Эмпатыг ашиглан бусдын нөхцөл байдлыг ойлгож, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх.
- *Эерэг хандлага, урам зориг өгөх.* Бусдын сайн талыг олж харан, тэднийг урамшуулан дэмжих нь хамтын ажиллагааг бататгадаг.
- *Ур чадварыг хөгжүүлэх.* Бусдын чадамжийг сайжруулах сургалт, дадлага, шинэ ур чадвар эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- *Бусдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх аргуудыг ойлгох.* Хүмүүсийн өөр өөр хэлбэрээр дэмжлэг авах байдлыг хүлээн зөвшөөрөх. Тухайлбал, үгсээр магтах (Words of Affirmation), үйлдлээр харуулах (Acts of Service), чанартай цаг өнгөрүүлэх (Quality Time), бэлэг өгч урамшуулах (Gifts), биеийн дохио зангаагаар дэмжих (Physical Touch) (Чапмен, 1992).

### Итгэлцлийн данс

*Итгэлцэл бол амьдралын цавуу юм. Энэ нь үр дүнтэй харилцааны хамгийн чухал найрлага.*  
Стивен Кови

“Өндөр бүтээмжтэй хүмүүсийн 7 дадал”-д өгүүлсэн “итгэлцлийн данс” хэмээх ойлголт нь хүмүүс хоорондын харилцаанд итгэлцлийг бий болгон уламжлан хадгалахыг санхүүгийн данстай зүйрлэн тайлбарладаг. Санхүүгийн дансанд мөнгө хадгалж, зарлага гаргадагтай адил, итгэлцлийн дансанд бидний үйлдэл, үг яриа нь “орлого” буюу итгэлцлийг нэмэгдүүлэх эсвэл “зарлага” буюу итгэлцлийг бууруулах нөлөөтэй байдаг (Кови, 1989).

Стивен Р. Кови итгэлцлийн дансанд орлого нэмэх зургаан гол арга замыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. *Хувь хүнийг ойлгох.* Бусдын хэрэгцээ, хүсэл, мэдрэмжийг ойлгож, тэдэнд анхаарал хандуулах нь итгэлцлийг нэмэгдүүлдэг. Энэ нь бусдыг үнэлж, хүндэтгэж буйг илэрхийлдэг.
2. *Ялихгүй зүйлийг ч бүү орхигдуул.* Өдөр тутмын жижиг үйлдлүүд, эелдэг үгс, талархал илэрхийлэх зэрэг нь итгэлцлийг бэхжүүлдэг. Эдгээр жижиг зүйлс нь харилцаанд чухал нөлөөтэй.
3. *Амлалтаа биелүүлэх.* Өгсөн амлалтаа цаг тухайд нь биелүүлэх нь бусдын итгэлийг олж авахад чухал. Амлалтаа зөрчих нь итгэлцлийг бууруулдаг.
4. *Хүлцэнгүй байдал.* Өөрийн алдаа, дутагдлыг хүлээн зөвшөөрч, уучлал гуйх нь итгэлцлийг нэмэгдүүлдэг. Энэ нь бусдад үнэнч, шударга байдлыг харуулдаг.
5. *Хувийн нууцыг хадгалах.* Бусдын итгэж хэлсэн зүйлсийг нууцалж, задруулахгүй байх нь итгэлцлийг бэхжүүлдэг. Нууцыг задруулах нь итгэлцлийг алдагдуулдаг.
6. *Хүлээлтийг тодорхой болгох.* Харилцаанд оролцогч талуудын хүлээлт, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, ойлголцлыг нэмэгдүүлэх нь итгэлцлийг сайжруулдаг.

Эдгээр зургаан арга замыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлснээр хүмүүс хоорондын харилцаа бэхжиж, итгэлцэл нэмэгдэж, хамтын ажиллагаа сайжирдаг. Итгэлцлийн дансанд байнга “орлого” нэмэх үйлдлүүдийг хийснээр хүмүүс хоорондын харилцаа бэхжиж, хамтын ажиллагаа, ойлголцол сайжирдаг. Энэ нь хувь хүн болон байгууллагын амжилтад чухал нөлөөтэй.

### 4.5.5. Дасан зохицох ба тодорхойгүй нөхцөлд орших ур чадвар

*Ганцаараа бид бага зүйл хийж чадна, харин хамтдаа ихийг бүтээж чадна.*  
Хелен Келлер

Тодорхойгүй нөхцөлд хэрхэн үр дүнтэй оршиж, ажиллаж, амьдрах ухааны тод илэрхийлэл нь монголчуудын дасан зохицох чадвар юм. Уур амьсгалын өөрчлөлт, газар зүйн өргөн уудам нутаг, улирлын эрс өөрчлөлттэй нөхцөл дэх амьдрал нь нүүдэлчдэд хязгаарлагдмал нөөцтэй үед уян хатан шийдвэр гаргах, нөхцөл байдалд зохицон өөрчлөгдөх хосгүй чадварыг суулгажээ.

#### Нүүдэлчдийн дасан зохицох ур чадварын гол шинжүүд

- *Төлөвлөлтөөс илүү хариу үйлдэл.* Нүүдэлчид байгалийн эрсдэл, цаг агаарын таагүй нөхцөлд урьдчилан төлөвлөлт хийхээс илүү тухайн нөхцөлд хурдан хариу үйлдэл үзүүлэх замаар амьдрал ахуйгаа зохицуулж ирсэн.

- *Нөөцийг үр ашигтай ашиглах.* Хязгаарлагдмал нөөцтэй нөхцөлд байгаль орчны боломжуудыг бүрэн ашиглаж, эд зүйлсийг дахин хэрэглэж, гамнах ухаан суулгасан.
- *Нийгмийн харилцаанд тулгуурлах.* Нүүдэлчдийн амьдрал, оршин тогтнолд хамтын ажиллагаа, харилцан тусламжид суурилсан харилцаа нь дасан зохицох чухал хүчин зүйл болдог.

Орчин үеийн ажил, бизнесийн орчинд тодорхойгүй нөхцөл байдал нь түгээмэл тулгарах сорилт болжээ. Монголчуудын нүүдэлчин соёлын дасан зохицох онцлогууд нь энэ нөхцөлд ажилтнуудад уян хатан хандах, багийн уур амьсгалыг эерэгээр бүрдүүлэх, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөд суралцах үлгэр жишээ болдог.

#### *Дасан зохицох үр чадварыг хөгжүүлэх арга замууд*

*Хувь хүний түвшинд:*

- Өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх, өөдрөг хандлагаа хадгалах
- Мэдээллийг хурдан хүлээн авч, шинэ нөхцөлд хариу үйлдэл хийх дадлага хийх.

*Багийн түвшинд:*

- Тодорхойгүй нөхцөлд ажиллах туршлагаа багийнхантай хуваалцаж, хамтдаа оновчтой шийдэл олох.
- Зөвлөлдөх, санал солилцох хэлэлцүүлэг явуулж, хамтын шийдвэр гаргах.

*Байгууллагын түвшинд:*

- Уян хатан ажлын цагийн хуваарь гаргах.
- Өөрчлөлтийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах.

#### **Дадлага ажил. Тодорхойгүй нөхцөлд шийдвэр гаргах үр чадвар**

Зорилго: Оролцогчдыг тодорхойгүй нөхцөлд дасан зохицох, шийдвэр гаргах чадварыг бодит байдлаар хөгжүүлэх.

*Заавар:*

1. Нөхцөл байдлыг танилцуулах: Та бүхэн аялалд явж байна. Цаг агаар муудсан тул зам хаагдаж, сонголт хийх шаардлагатай:
  - Тойруу замаар явах
  - Цаг агаар сайжрахыг хүлээх
  - Ойролцоох сум, сууринд байрлаж, шинэ төлөвлөгөө гаргах.
2. Багаар ажиллах: 3-4 хүний багт хуваагдан, нөхцөл байдлыг 10 минут ярилцаж шийдвэр гаргах.
  - Сонголт хийхэд юу нөлөөлсөн бэ?
  - Багийн харилцаа, хамтын ажиллагаа ямар байв?
  - Тодорхойгүй нөхцөлд хэрхэн дасан зохицсон талаар ярилцана.
3. Нийтэд хуваалцах: Хэрхэн шийдвэр гаргаснаа 2 минутанд багтаан танилцуулна.

Үр дүн: Нөхцөл байдалд дасан зохицохдоо уян хатан, хамтын ажиллагаанд тулгуурлах нь чухал. Ганц мод гал болдоггүйтэй адил, багийн гишүүд хамт байж, хамтын шийдвэр гаргалтын хүчийг харуулна.

## Бүлгийн дүгнэлт

Эерэг хандлага ба хувь хүний манлайлал нь хувь хүний дотоод ур чадвар, ёс зүй, хариуцлагыг хөгжүүлж, хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ хичээлээр эерэг хандлага нь аливаа нөхцөл байдалд боломжийг олж харах, өөрчлөлтөд дасан зохицох, бусдад үлгэр дууриалал болох явдлыг тодорхойлох үндэс суурь гэдгийг ойлгож авсан. Эерэг хандлага нь хувь хүний амьдралд зөвхөн аз жаргал төдийгүй ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны амжилтад хүрэх үндэс болдог.

Хувь хүний манлайлал нь зөвхөн өөрийгөө удирдах чадвараар хязгаарлагдахгүй, бусдыг урамшуулж, хамт олны зорилго руу чиглүүлэх үйл явц юм. Үүний тулд хувь хүн өөртөө итгэлтэй байх, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, шинэ санаачилга гаргах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай.

Ёс зүй, хариуцлагатай байдал нь хувь хүнээс шударга, нээлттэй хандлагыг шаардаж, байгууллага, хамт олны итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ нь хувь хүний үйлдэл бүрийг ухамсарлах, бусдын хүлээлтэд нийцсэн шийдвэр гаргахыг дэмждэг.

Амжилттай харилцааг бий болгохын тулд бусдыг дэмжих, тэдний санаа бодлыг сонсох, хамтран ажиллах нь хамтын зорилгод хүрэх хамгийн үр дүнтэй арга гэдгийг энэ хичээлээр онцолжээ. Бусдыг дэмжих, урамшуулах замаар хамт олны сэтгэлзүйн уур амьсгалыг эерэг байлгаж, ур чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой.

Түүнчлэн, тодорхойгүй нөхцөл байдалд дасан зохицох чадвар нь хувь хүнээс уян хатан байдал, хурдтай хариу үйлдэл, хүндрэлийг даван туулах ур чадварыг шаарддаг. Энэ чадварыг хөгжүүлснээр хувь хүн, байгууллага өөрчлөлтийн үед тогтвортой байдлыг хадгалах, шинэ боломжуудыг олж харах, сорилтуудыг амжилтад шилжүүлэх чадвартай болдог.

Эцэст нь, эерэг хандлага ба хувь хүний манлайллыг хөгжүүлснээр хувь хүн зөвхөн өөрийн амжилтад хүрэх төдийгүй бусдын амжилтад нөлөөлж, хамтдаа өсөн дэвжих замыг нээж өгдөг. Энэ хичээл нь хувь хүн, хамт олон, байгууллагын амжилтын үндсийг ойлгуулах, хэрэгжүүлэхэд чухал хөтөч болно.

## 4.6 СТРЕССИЙН УДИРДЛАГА БА БАГААР АЖИЛЛАХ УР ЧАДВАР

### 4.6.1. Ажлын байрны стресс, түүнийг даван туулах арга техник

*Ажлын орчинд харилцан хүндлэлтэй байх нь бүтээмжийг нэмэгдүүлэх түлхүүр юм.  
Мишель Обама (АНУ-ын Тэргүүн хатагтай, 2009-2017 он).*

Ажлын байрны стресс нь хүн бүрд тулгарч болох ч хэрхэн зохицуулж, даван туулж байгаагаас хамаарч амжилт, бүтээмжид ихээхэн нөлөөлдөг. Ажлын байрны стресс гэдэг нь ажлын ачаалал, хамт олны харилцаа, удирдлагын шаардлага, ажил, амьдралын тэнцвэр алдагдах гэх мэтээс үүдэлтэй сэтгэлзүйн болон бие махбодийн дарамт юм.

Судалгаагаар, ажлын байрны стрессийн урт хугацааны нөлөө нь ажилчдын эрүүл мэнд, ажлын бүтээмж, байгууллагын уур амьсгалд сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг.

#### Ажлын байрны стрессийн шалтгаан

- *Ачаалал ихтэй ажил.* Ажлын хэт их ачаалал, богино хугацаанд их хэмжээний ажил гүйцэтгэх шаардлага стрессийг үүсгэдэг.
- *Үл ойлголцол.* Хамт олны дундах харилцааны зөрчил, удирдлага болон ажилчдын хоорондын ойлголцолгүй байдал.
- *Ажлын орчин.* Шуугиантай, дарамттай эсвэл тохиромжгүй орчинд ажиллах.
- *Тодорхой бус үүрэг.* Ажлын тодорхой бус үүрэг хариуцлага, зорилго тодорхойгүй байх.

#### Ажлын байрны стрессийн нөлөө

- *Бие махбодийн нөлөө.* Ядрал, толгой өвдөх, нойргүйдэл, дархлаа буурах.
- *Сэтгэлзүйн нөлөө.* Сэтгэл түгшилт, уур бухимдал, ажлын сэдэл буурах.
- *Байгууллагын нөлөө.* Ажлын бүтээмж буурах, алдаа гаргах магадлал нэмэгдэх, ажилчдын сэлгэн ажиллах эрсдэл өсөх.

#### Стрессийг даван туулах арга техник

1. *Стрессийн шалтгааныг таних:* Стрессийн эх үүсвэрийг тодорхойлох нь асуудлыг шийдвэрлэх эхний алхам юм. Ажлын ачаалал, ажлын байрны нөхцөл байдлыг судалж, ямар хүчин зүйлүүд стрессийг үүсгэж байгааг олж тогтоох хэрэгтэй.
2. *Ажлын төлөвлөлт хийх:*
  - Ажил үүргийг төлөвлөж, өдрийн ажлын чухал зорилтуудад төвлөрөх
  - “Эхлээд хамгийн чухлыг хий” зарчмыг баримталж, ажлуудаа эрэмбэлэх
  - Хугацааны менежментийн аргуудыг ашиглах (Жишээ нь Гантын график, Pomodoro техник г.м).
3. *Амралт, тайвшрах арга:*
  - Завсарлага авах, ажлын завсар сэтгэлзүйн болон биеийн амралт хийх
  - Йог, бясалгал зэрэг стресс тайлах дасгалуудыг хийх
  - Өөртөө эерэг сэдэл өгөх үгс хэлэх, өөртөө амрах цаг гаргах.
4. *Эрүүл амьдралын хэв маяг:*
  - Эрүүл хооллолт, тогтмол дасгал хөдөлгөөн хийх
  - Нойрыг хангалттай авч, амралтаа зохицуулах
  - Согтууруулах ундаа, тамхи зэрэг сөрөг зуршлаас зайлсхийх.
5. *Харилцаагаа сайжруулах:*
  - Асуудлыг шийдвэрлэхдээ хамт олонтойгоо илэн далангүй ярилцаж, хамтын шийдлийг эрэлхийлэх

- Харилцааны эерэг, бүтээлч хэлбэрийг баримтлах (Жишээ нь ухамсарлан сонсох, асуулт асуух г.м).
  - Зөрчилдөөнөөс зайлсхийх, зөрчлийг эв зүйгээр зохицуулах.
6. *Мэргэжлийн тусламж авах:*
- Стрессийн түвшин өндөр байгаа тохиолдолд мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авах.
  - Байгууллагын сургалт, зөвлөгөөнд хамрагдах замаар асуудлыг шийдвэрлэх.

Стрессийг үр дүнтэй даван туулах чадвар нь зөвхөн хувь хүний амжилтанд хүрэхэд төдийгүй байгууллагын бүтээмж, хамт олны уур амьсгалыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Хамгийн чухал нь стрессийг удирдаж сурсан хүн аливаа бэрхшээлийг боломж болгон хувиргах хүчтэй болдог.

#### Дадлага ажил. “Стрессийг даван туулах дасгал”

1. Стрессээ тодорхойлох: Сүүлийн үед танд стресс үүсгэсэн нөхцөл байдлыг нэг өгүүлбэрээр бичнэ үү.
2. Гүнзгий амьсгалах: 4 секунд амьсгал авч, 4 секунд барьж, 4 секунд гаргах дасгалыг 3 удаа хийнэ.
3. Эерэг бодол бичих: Тухайн нөхцөл байдлаас суралцсан эерэг зүйлийг нэг өгүүлбэрээр бичнэ үү.
4. Даван туулах төлөвлөгөө: Ирээдүйд ийм нөхцөл байдалд хэрхэн зөв хариу үйлдэл хийхээ 1-2 өгүүлбэрээр бичнэ.

#### Шинэ зүйлд шуурхай дасан зохицох ба 30-60-90 өдрийн төлөвлөгөө

*30-60-90 өдрийн төлөвлөгөө гэж юу вэ?* Шинэ орчинд ажиллахдаа хурдан дасан зохицож, бүтээмжээ нэмэгдүүлэх арга замыг тодорхойлсон төлөвлөгөөг 30-60-90 өдрийн төлөвлөгөө гэж нэрлэдэг. Энэ төлөвлөгөө нь шинэ ажилд эсвэл шинэ үүрэгт шуурхай дасах, зорилгоо тодорхойлох, өөрийгөө илэрхийлэх, удирдлага болон хамт олны итгэлийг олох үр дүнтэй аргачлал юм.

#### *30-60-90 өдрийн төлөвлөгөөний бүтэц*

1. Эхний 30 хоног:
  - Байгууллагын соёл, ажил үүргийн хуваарь, хамт олны харилцааны хэв маягийг ойлгох
  - Удирдлага болон хамт ажиллагсадтай эхний харилцааг амжилттай эхлүүлэх
  - Өөрийн үүрэг, зорилтыг тодорхойлж, ойлголттой болох.
2. 60 дахь хоног хүртэл:
  - Хариуцаж буй үүрэгтээ илүү нягт төвлөрч, ажлын процессийг гүнзгий ойлгох
  - Багаар ажиллахад идэвхтэй оролцож, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх
  - Анхны амжилтуудыг хуримтлуулж, удирдлагадаа тайлагнах.
3. 90 дахь хоног хүртэл:
  - Ажлын орчиндоо бүрэн дасан зохицож, өөрийн хариуцлагыг үр дүнтэй биелүүлэх
  - Ур чадвар, бүтээмжээрээ ялгарч, удирдлага болон багийн итгэлийг олж авах
  - Шинэ санаачилга гаргаж, ажлын байран дахь стрессийг багасгахад хувь нэмэр оруулах.

### 30-60-90 өдрийн төлөвлөгөөний давуу талууд

- *Стрессийг бууруулах.* Төлөвлөгөөтэй ажиллах нь тодорхойгүй байдлыг багасгаж, ажлын ачааллыг хуваарилахад тусалдаг.
- *Харилцааг сайжруулах.* Хамт олонтой үр дүнтэй харилцаж, хамтын ажиллагааг бататгана.
- *Өөрийгөө хөгжүүлэх.* Бодлоготой, бүтээлч хандлагаар өөрийн ур чадвар, ажлын бүтээмжээ тасралтгүй сайжруулах боломж олгодог.

#### Дадлага ажил

1. Өөрийн төлөвлөгөө боловсруулах:  
Суралцагчид шинэ орчинд (жишээ нь, шинэ ажилд орох эсхүл шинэ төсөл дээр ажиллах) 30-60-90 өдрийн төлөвлөгөө гаргана. Төлөвлөгөөнд:
  - Эхний 30 хоногт юу сурах, хэндтэй харилцах, ямар зорилгод хүрэх талаар тодорхой зорилт тавих
  - 60 болон 90 хоногт ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, харилцааг сайжруулах, шинэ санаачилга гаргах алхмуудыг тусгах.
2. Хэлэлцүүлэг зохион байгуулах:  
Баг бүр өөрсдийн төлөвлөгөөг танилцуулж, хамт олонтойгоо хэрхэн дасан зохицох, стрессийг хэрхэн бууруулах тухай ярилцана.

## 4.6.2. Багаар ажиллах ур чадвар

*Эвт шаазгай буга барина.*

Багаар ажиллах чадвар нь орчин үеийн ажил мэргэжлийн хамгийн чухал ур чадваруудын нэг юм. Багийн хүрээнд үр дүнтэй хамтран ажиллах нь зөвхөн тухайн байгууллагын амжилтад төдийгүй хувь хүний хөгжлийн гол хүчин зүйл болдог. Багаар ажиллах нь зөвхөн ажлын даалгаврыг хуваалцах төдийгүй харилцааны чанарыг сайжруулж, хамтын зорилгодоо хүрэх үйл явц юм.

Судалгаагаар, багийн гишүүдийн хоорондын итгэлцэл, уялдаа холбоо сайн байх нь бүтээмжийг 20%-аар нэмэгдүүлдэг. Энэ нь хамтран ажиллах, харилцах чадварын чухлыг харуулж байна.

### Багаар ажиллах ур чадвар

- *Харилцааны чадвар:* Багийн гишүүдтэй ил тод, эерэгээр харилцах
- *Хариуцлага:* Өөрт оноогдсон үүргээ цаг тухайд нь чанартай биелүүлэх
- *Итгэлцэл:* Бусдын санаа бодол, шийдвэрт хүндэтгэлтэй хандах
- Уян хатан байдал: Шинэ нөхцөл байдалд хурдан дасан зохицож, хамтын шийдэл гаргах
- *Хамтын ажиллагаа:* Бусадтай зөвлөлдөж, хамтдаа шийдвэр гаргах.

Эелдэг харилцах гэдэг нь бусдын сэтгэл санааг хүндэтгэж, харилцааны эерэг уур амьсгал бүрдүүлэхийг хэлнэ. Энэ нь багийн уур амьсгалыг сайжруулах, хамт олны итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Анхаарал халамж тавих нь багийн гишүүдийн харилцааг гүнзгийрүүлж, ажилдаа хандах хандлагыг эерэг болгодог.

### Багаар ажиллах, хамтран ажиллах зарчим

- *Итгэлцэл бий болгох.* Багийн гишүүдийн харилцааны үндэс нь итгэлцэл юм. Итгэлцэл нь нээлттэй байдал, үнэнч харилцаагаар бий болдог.
- *Хамтын зорилго тавих.* Багийн бүх гишүүдийн оролцоог хангаж, хамтдаа зорилгоо тодорхойлох нь чухал.
- *Харилцан туслах.* Бусад гишүүдэд тусалж, дэмжлэг үзүүлэх нь багийн амжилтад эерэгээр нөлөөлдөг.
- *Зөрчилдөөнөөс зайлсхийх.* Багаар ажиллах үед санал зөрөлдөөн гарч болох ч үүнийг эерэг, бүтээлч аргаар зохицуулах нь чухал.
- *Харилцааны уялдаа холбоо.* Мэдээллийг цаг тухайд нь, ойлгомжтой дамжуулах нь багийн амжилтын үндэс.

Багаар ажиллах, хамтран ажиллах чадвар нь орчин үеийн ажлын орчинд зайлшгүй шаардлагатай бөгөөд эелдэг харилцах, анхаарал халамж тавих нь хамт олны эв нэгдлийг бататгах гол хүчин зүйл юм. Энэ чадварыг хөгжүүлснээр хувь хүн өөрийн нөөц бололцоог бүрэн дайчлан ажиллаж, багийн зорилгодоо амжилттай хүрэх боломжтой болно.

### 4.6.3. Маргаан шийдвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чадвар

*Хүмүүсийг хайрлаж, эд зүйлсийг ашигла. Үүний эсрэгээр бүү бай.  
Далай лам*

Хэрүүл маргаан нь хүмүүсийн хоорондын харилцааны үл ойлголцол, зөрчилдөөнөөс үүдэлтэй асуудал бөгөөд зөв зохицуулж чадахгүй бол хамтын ажиллагааг тасалдуулах аюултай. Гэвч хэрүүл маргаан бүрийг эерэг үр дүнтэй шийдвэрлэгдэх боломжтой. Үүнийг зохицуулах нь зөвхөн зөрчилдөөнийг багасгаад зогсохгүй хүмүүсийн харилцааг сайжруулах, хамтын ойлголцлыг нэмэгдүүлэх арга болдог.

#### Хэрүүл маргаанаас зайлсхийх арга зам

- *Өөрийгөө хянах.* Эмоциональ буюу сэтгэл хөдлөлийг удирдаж, тайван хандах нь зөрчилдөөнийг хурцатгахгүй байх үндэс суурь юм.
- *Итгэлцэл бий болгох.* Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхийн тулд харилцан итгэлцлийг нэмэгдүүлж, аливаа асуудлыг шууд хэлэлцэх орчин бүрдүүлэх хэрэгтэй.
- *Ил тод байдал.* Бусдад өөрийн бодол, санааг ил тод, ойлгомжтой илэрхийлэх нь буруу ойлголтоос сэргийлдэг.
- *Эерэг хандлагыг хадгалах.* Бусдын үзэл бодлыг хүндэтгэж, эерэг шийдлийг эрэлхийлэх.

#### Маргааныг шийдвэрлэх зарчим

- *Сонсох чадвар.* Маргаан гарсан нөхцөлд аль аль талын үзэл бодлыг сонсож, асуудлын жинхэнэ үндсийг тодорхойлох хэрэгтэй.
- *Бодит байдлыг үнэлэх.* Зөрчилдөөнийг үнэлж, аливаа шийдлийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн гаргах.
- *Харилцан зөвшилцөх.* Зөрчилдөөнд оролцогч талуудтай хамтран хэлэлцэж, аль аль талд нийцэх шийдэл олох.
- *Хүндэтгэлтэй харилцах.* Зөрчилдөөний үед ч хүндэтгэлтэй хандлага нь харилцааг эерэг байлгах үндэс болдог.

#### Маргаан шийдвэрлэх стратегиуд

- *Зөв харилцааны арга барил ашиглах.* Тайван, ойлгомжтой ярих, тодорхой мэдээлэл дамжуулах.

- *Зөрчилдөөнийг эрт илрүүлэх.* Маргаан гарч эхлэх үед нь шууд зохицуулж, томоохон хямралд хүрэхээс зайлсхийх.
- *Шийдвэрлэх арга зам сонгох.* Уян хатан байж, нөхцөл байдалд тохирсон шийдлийг хамтдаа олох.
- *Хамтын шийдвэр гаргах.* Бүх талуудын оролцоог хангаж, шударга шийдэл гаргах.

Хэрүүл маргаанаас зайлсхийх, маргааныг шийдвэрлэх ур чадвар нь хувь хүний харилцаанд төдийгүй хамтын ажиллагаа, байгууллагын амжилтад чухал үүрэгтэй. Энэ чадварыг хөгжүүлснээр хүмүүсийн хоорондын зөрчилдөөнийг багасгаж, эерэг, бүтээлч орчин бүрдүүлэх боломжтой юм.

## Маргаанаас урьдчилан сэргийлэх

*Ойлголцол, хүндлэл хоёрын дунд маргаанд орогнох орон зай олддоггүй.  
Далай лам*

Орчин үеийн ажлын орчинд хамтын ажиллагаа нь байгууллагын амжилтын гол түлхүүр юм. Хамт олны уур амьсгал, үр дүнтэй харилцаа нь зөрчил, маргаанаас зайлсхийж, хамтын зорилгодоо хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс хамтран ажиллагсадтай маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх ур чадвар нь багийн амжилтыг хангах, ажлын орчны бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

*Маргаанаас урьдчилан сэргийлэх арга, стратеги.* Маргаанаас урьдчилан сэргийлэхийн тулд багийн гишүүдийн хоорондын харилцааг сайжруулж, хамтын ажиллагааг дэмжих нь чухал. Үүнд идэвхтэй сонсох, зөв ойлголцох, нэгдмэл зорилгыг тодорхойлох зэрэг арга барилуудыг ашиглах нь үр дүнтэй байдаг.

1. *Идэвхтэй сонсох ба зөв ойлголцох.* Багийн гишүүдийн санал бодлыг анхааралтай сонсож, харилцан буруу ойлголцлоос сэргийлэхийн тулд мэдээллийг тодорхой өгч байх шаардлагатай. Сонсох дадлыг хөгжүүлснээр итгэлцлийг нэмэгдүүлж, маргааныг эхлэхээс нь өмнө зогсоох боломжтой.
2. *Нэгдмэл зорилгыг тодорхойлох.* Багийн нийтлэг зорилгыг тодорхойлох нь зөрчил үүсэх магадлалыг бууруулж, бүх гишүүдийг хамтран ажиллахад чиглүүлдэг. Зорилгын тодорхой байдал нь хүлээлт болон үүрэг хариуцлагыг ойлгомжтой болгодог.
3. *Эерэг харилцааг хөгжүүлэх ба итгэлцлийг бий болгох.* Эерэг уур амьсгалыг бүрдүүлэхийн тулд багийн гишүүдийн харилцаанд харилцан хүндэтгэл, ил тод байдал чухал. Итгэлцэл нь зөрчлийг бууруулж, хамтын ажиллагааг дэмжих үндэс суурь болдог.
4. *Бүтээлч шийдэл эрэлхийлэх.* Үүсэж болох маргааны эх үүсвэрийг урьдчилан тодорхойлж, бүтээлч шийдлүүдийг хайх нь зөрчил үүсэхээс сэргийлэх чухал алхам юм. Энэ нь багийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг.
5. *Өөрийгөө хянах.* Эмоциональ буюу сэтгэл хөдлөлийг удирдаж, тайван хандах нь зөрчилдөөнийг хурцатгахгүй байх үндэс суурь юм.
6. *Итгэлцэл бий болгох.* Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхийн тулд харилцан итгэлцлийг нэмэгдүүлж, аливаа асуудлыг шууд хэлэлцэх орчин бүрдүүлэх хэрэгтэй.
7. *Ил тод байдал.* Бусдад өөрийн бодол, санааг ил тод, ойлгомжтой илэрхийлэх нь буруу ойлголтоос сэргийлдэг.

Маргаанаас урьдчилан сэргийлэх эдгээр арга замууд нь зөвхөн багийн уур амьсгалыг сайжруулаад зогсохгүй, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, хамтын зорилгод хүрэх үйл явцыг илүү үр дүнтэй болгодог.

#### Маргаан үүсэх шалтгаанууд

- *Мэдээлэл хуваалцахгүй байх.* Албан болон албан бус харилцааны дутагдал нь зөрчилдөөн үүсгэх эрсдэлтэй.
- *Хүлээлт тодорхойгүй байх.* Багийн гишүүдийн үүрэг, хариуцлага тодорхойгүй байвал маргаан үүсэх магадлал нэмэгддэг.
- *Харилцааны хэв маяг зөрчилдөх.* Хүмүүсийн харилцааны арга барил зөрчилдөх нь үл ойлголцол, маргааны эх үүсвэр болдог.
- *Эрх мэдлийн зөрчил.* Байгууллагын бүтэц дэх эрх мэдлийн үл ойлголцол нь хамт олны дотор маргаан үүсгэх эрсдэлтэй.

Хамтран ажиллагсадтай маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх нь хамтын ажиллагааны чанарыг нэмэгдүүлж, байгууллагын зорилго, зорилгод хүрэх замыг хөнгөвчилдөг. Энэхүү ур чадвар нь хамт олны эв нэгдлийг хангах, ажлын байрны бүтээмжийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

#### 4.6.4. Сөргөлдөөн, түүнийг намжаах арга техник

*Хэрэв бид сонсож чадвал, сөргөлдөөн бол ойлголцолд хүрэх эхлэл байж болно.  
Далай лам*

Сөргөлдөөн (зөрчилдөөн) нь хэдийгээр эсэргүүцэн маргахтай ижил төстэй боловч нөхцөл байдлын хувьд илүү хурцадмал буюу хүмүүсийн ашиг сонирхол, үнэт зүйлс, үзэл бодол зөрчилдөх үед үүсдэг нийгмийн үзэгдэл юм.

Байгаль хамгаалах салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд олон талын сонирхлын бүлгүүдтэй (орон нутгийн иргэд, төрийн байгууллагууд, хувийн хэвшил, судлаачид г.м) харилцаж ажиллах шаардлагатай тул зөрчилдөөн үүсэх магадлал өндөр байдаг. Иймээс сөргөлдөөний шалтгааныг зөв тодорхойлж, зохицуулах чадвартай байх нь чухал юм. Энэ утгаараа тухайн салбарт хамаарах сөргөлдөөн үүсч болох нөхцөл байдлыг урьдчилан тооцох, нэгэнт үүссэн тохиолдолд түүнийг хурцадмал байдалд хүргэлгүй шийдвэрлэх шаардлага үүсэж байна.

#### Байгаль хамгаалах салбарт үүсдэг сөргөлдөөний үндсэн шалтгаанууд

- *Нөөцийн хуваарилалт.* Байгалийн нөөцийг ашиглах эрхийн талаар иргэд, компаниуд, төрийн байгууллагуудын хооронд маргаан үүсэж, улмаар талууд өөрсдийн ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьснаар сөргөлдөөн гүнзгийрэх нөхцөл бүрдэнэ. Ялангуяа усны нөөц, бэлчээр, ой модны ашиглалт зэрэг асуудал голлох маргааны эх үүсвэр болдог.
- *Байгаль орчны хууль, журам.* Зарим талууд хууль тогтоомжийг өөр өөрөөр ойлгох эсвэл хуулийн хэрэгжилтэд сэтгэл хангалуун бус байх тохиолдол гарна. Түүнчлэн хууль, журмын хэрэгжилтийг үл тоомсорлох, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл дутмаг байх зэрэг нь асуудлыг улам хүндрүүлдэг.
- *Эдийн засаг ба байгаль хамгаалал.* Эдийн засгийн өсөлтөд байгаль хамгаалах бодлого хэрхэн нөлөөлөх тухай асуудал дээр бизнес эрхлэгчид болон байгаль хамгаалагчдын дунд зөрчилдөөн хамгийн ихээр гарч болзошгүй. Ашигт малтмалын олборлолт, үйлдвэржилт, аялал жуулчлал зэрэг салбарууд байгаль орчинд ихээхэн нөлөө үзүүлдэг тул эдгээртэй холбоотой сөргөлдөөн олонтоо тохиолддог.

- *Орон нутгийн оролцоо.* Иргэд байгаль хамгаалах бодлогод өөрсдийн оролцоог хангалтгүй гэж үзэж, бодлого боловсруулагчдын шийдвэрийг эсэргүүцэх магадлалтай. Мөн тэдний уламжлалт аж ахуй, зан заншил, өмчлөх эрхтэй холбоотой асуудлууд нь зөрчил үүсэхэд нөлөөлдөг.
- *Мэдээллийн зөрүү.* Талуудын мэдлэг, мэдээлэл харилцан адилгүй байх нь сэргэлдөөн үүсэх нэг гол шалтгаан болдог. Байгаль хамгааллын асуудлаар олон нийт, бизнесийн байгууллагууд, төрийн байгууллагуудын дунд мэдээллийн хангалтгүй байдал нь ойлголцлын бэрхшээл үүсгэж, маргаан хурцдах нөхцөл бүрдүүлдэг.

*Сэргэлдөөнийг намжаах арга техникүүд.* Сэргэлдөөн гарч болзошгүй олон нөхцөл байдал бий ч үүнийг зөв удирдан зохицуулснаар илүү үр дүнтэй, тогтвортой шийдэлд хүрэх боломжтой. Урьдчилан сэргийлэх, тохиролцох, хэлэлцээр хийх арга техникийг ашигласнаар талуудын хоорондын харилцааг сайжруулж, байгаль хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлж болно.

#### *Урьдчилан сэргийлэх, дайсангалгүй орчин бүрдүүлэх арга*

- *Ил тод байдал.* Хамааралтай бүх талуудын хооронд мэдээлэл солилцоог чөлөөтэй, үнэн зөв байлгаж, үл ойлголцлоос сэргийлэх.
- *Оролцооны механизмууд.* Орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудыг шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцуулах.
- *Хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтууд.* Талуудын байр суурийг ойлгож, дундын шийдэл олоход чиглэсэн байнгын уулзалт зохион байгуулах.
- *Боловсрол, сургалт.* Байгаль хамгаалах бодлогын ач холбогдол, үр дагаврын талаар олон нийтийг мэдлэгжүүлэх, оролцоог нь нэмэгдүүлэх.
- *Итгэлцлийг бий болгох.* Талуудын хооронд харилцан итгэлцэл үүсгэж, удаан хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар сэргэлдөөнөөс зайлсхийх.
- *Харилцааны үр чадварыг хөгжүүлэх.* Байгаль хамгаалагчид хүндэтгэлтэй, үр дүнтэй харилцах чадвараа сайжруулж, зөрчлийг даамжруулахгүй байх.
- *Стратегийн хамтын ажиллагаа.* Төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хувийн хэвшил, орон нутгийн иргэдтэй хамтын ажиллагааны механизмуудыг хөгжүүлэх.
- *Олон нийтийн хүлээн зөвшөөрөхүйц шийдлүүдийг дэмжих.* Байгаль хамгааллын асуудлыг зөвхөн нэг талд ашигтайгаар бус, бүх талуудад үр өгөөжтэй байдлаар шийдэх, нийтлэг эрх ашгийг онцлох.

Энэхүү арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр сэргэлдөөнийг хурцдахаас сэргийлж, тогтвортой, үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох боломжтой.

*Сэргэлдөөнийг шийдвэрлэх арга.* Сэргэлдөөн нэгэнт үүссэн тохиолдолд талуудын байр суурийг сонсох, нийтлэг ашиг сонирхлыг тодорхойлох, зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь чухал. Үүний тулд дараах арга техникүүдийг ашиглаж болно. Үүнд:

- *Зуучлал.* Хөндлөнгийн этгээд оролцуулж, маргалдагч талуудын хооронд харилцан зөвшилцөлд хүрэх нөхцлийг бүрдүүлэх арга.
- *Хэлэлцээр.* Хоёр болон түүнээс дээш тал өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалж, харилцан буулт хийж, бодит шийдэлд хүрэх.
- *Амарлингүй байдлыг хадгалах техник.* Сэргэлдөөн хурцдахаас сэргийлж, зөөлөн, тайван харилцаа үүсгэн асуудлыг намжаах.
- *Зохицуулалтын зөвлөл.* Тухайн салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн, сэргэлдөөнийг дүгнэж, тохиролцолд хүргэх чиглэлтэй зөвлөл ажиллуулах.

Дээрх аргуудаас гадна, асуудлыг бие даан шийдвэрлэхийг хүсвэл “Шийдвэр гаргах нэгдсэн арга”-ыг ашиглаж болох бөгөөд алхам нь дараах байдалтай:

1. *Санал, байр суурийг сонсох.* Талуудын байр суурийг анхааралтай сонсож, дэмжих болох гол санаануудыг тодорхойлох.
2. *Эерэг хандлага баримтлах.* Яриагаа дэмжих зүйлсээс эхэлж, зөрүүтэй байр суурь дээр өөр ямар боломжит хувилбар байгааг асуух. Жишээ нь “Таны хэлснээс энэ хэсэгтэй санал нийлж байна, харин зарим зүйл дээр өөр хувилбар байж болох уу?” г.м.
3. *Эсэргүүцлийг хүлээцтэй сонсох.* Маргалдагч талын эсэргүүцлийг дуустал нь сонсож, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх.
4. *Шийдэл боловсруулах.* Санал нийлж буй гол асуудлуудыг онцлон тэмдэглэж, дундын тохиролцоонд хүрэхээр байр сууриа тодорхойлох.

Ямар ч үед яриаг нь анхааралтай сонсож байгаагаа харуулснаар таагүй үр дагавар гарах асуудал байсан ч эерэг сэтгэгдлийг үлдээх, дараа дараагийн нөхцөл байдал дээрдэх боломж бүрддэг.

Сөргөлдөөнийг удирдах, зохицуулах нь ур чадвар шаардсан нарийн үйл явц юм. Байгаль хамгаалах салбарт үүсэх сөргөлдөөнийг зөв шийдвэрлэхийн тулд оролцогч талуудын ашиг сонирхлыг ойлгож, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Хэлэлцээр, зуучлал, нээлттэй харилцаа, мэдээлэл солилцоо нь сөргөлдөөнөөс зайлсхийх, түүнийг намжаах улмаар байгаль хамгааллын бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх гол түлхүүрүүд юм.

## Бүлгийн дүгнэлт

Стрессийн удирдлага ба багаар ажиллах ур чадвар нь хувь хүнээс ажлын байрны ачаалал, зөрчилдөөн, тодорхойгүй нөхцөл байдлыг үр дүнтэй удирдаж, багийн хамтын ажиллагааг сайжруулахад шаардлагатай ур чадваруудыг хөгжүүлэхийг шаарддаг. Энэхүү хичээлээр суралцагчид стрессийн үндсэн шалтгаан, үр нөлөө, түүнийг даван туулах аргуудыг тодорхойлж, багийн дотоод харилцааг бэхжүүлэх арга замын талаар үндсэн ойлголттой болно.

Ажлын байрны стресс нь хувь хүний сэтгэлзүй, эрүүл мэнд, ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлөх ч стрессийг зөв удирдсанаар бэрхшээлийг боломж болгон хувиргаж, ажлын орчинд эерэг өөрчлөлт авчирч болдог.

Багаар ажиллах ур чадвар нь багийн зорилгодоо хүрэхэд хамт олны итгэлцэл, харилцан ойлголцлыг чухалчилдаг. Эв эеийг эрхэмлэж, үүргээ тодорхой биелүүлэх, нээлттэй харилцаж, зөрчилдөөнийг эв зүйгээр шийдвэрлэх нь багийн амжилтыг бататгадаг. Хамтын ажиллагааг оновчтой зохион байгуулах нь зөвхөн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна, багийн гишүүдийн харилцааг сайжруулж, нийтлэг зорилгод төвлөрөхөд тусалдаг.

Маргаан шийдвэрлэх чадвар нь зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргааныг бүтээлч байдлаар шийдвэрлэх ур чадвар юм. Зөрчилдөөн нь зөв зохицуулж чадвал эерэг үр дүн авчрах, хамтын ойлголцлыг нэмэгдүүлэх боломжтой.

Эцэст нь, стрессийн удирдлага ба багаар ажиллах ур чадвар нь хувь хүн болон байгууллагын түвшинд зайлшгүй шаардлагатай. Стрессийг зохицуулж, багийн эв нэгдлийг хадгалан, маргаанаас зайлсхийж, үр дүнтэй шийдвэрлэх чадварт суралцсанаар суралцагчид ажлын бүтээмж, хамтын ажиллагааны чанарыг сайжруулж, ажлын орчинд эерэг уур амьсгал бүрдүүлэх боломжтой болно.

## Даалгавар

### Харилцааны үндэс ба соёл

1. *Харилцааны ур чадвар гэж юу вэ?*  
Харилцааны ур чадварын ач холбогдлын талаар 300-400 үгтэй эссэ бичнэ үү. Эссэндээ өөрийн харилцааны ур чадвар хэрхэн хөгжсөн эсвэл хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар бодлоо хуваалцаарай.
2. *Харилцааны үндсэн ойлголтууд*  
Харилцааны элементүүдийг тодорхойлж, Shannon-Weaver загварыг ашиглан 5 минутын богино яриа эсвэл мессежний харилцааны явцыг диаграммаар үзүүлнэ үү.
3. *Харилцааны соёл*  
Өдөр тутмын амьдралдаа харилцааны соёлд хамаарах үйлдлүүдийг анхаарч ажигла. 3 жишээ сонгож, тухайн жишээн дээр гарсан харилцааны соёлын нөлөөллийг тайлбарлаж, 150-200 үгтэй тайлан бичнэ үү.
4. *Харилцааны ёс зүй*  
Дараах кейсийг уншаад, ёс зүйн асуудлыг тодорхойлж, харилцааны ёс зүйд нийцэх шийдлийг санал болго.  
Кейс: Танай багийн гишүүн нэгэн төслийн ажлын явцад мэдээллийг санаатай болон санамсаргүйгээр буруу дамжуулсан тохиолдол гарлаа. Үүнийг хэрхэн зохицуулах вэ?
5. *Харилцааны зарчим*  
Харилцааны үндсэн зарчмуудыг ашиглан багийн гишүүдийн хооронд үүссэн ойлголцлын асуудлыг шийдвэрлэх 3 алхамт зөвлөмж бич.
6. Хичээл удирдан зохион байгуулж буй багш нарын сонсогчидтой харилцаж буй байдлыг ажиглах, харилцааг хэрхэн удирдан зохион байгуулж буйд эргэцүүлэмж хийх.
7. Ажил хэргийн харилцаанд хэрхэн шургуу харилцах харилцааны стратеги өөртөө зориулан боловсруулах.

### Манлайлал ба үр дүнтэй харилцааны арга барил

1. *Удирдан манлайлах чадварын шинж чанарыг судал.*  
Өөрийн ажлын байранд удирдагчийн үүрэг хариуцлага ямар байдаг талаар судалж, өөрийн бодлыг бичих.
2. *Дотоод, гадаад харилцааны харьцуулалт*  
Байгууллагын дотоод болон гадаад харилцааны ялгааг тайлбарлаж, практик жишээ дээр тайлбарлах.
3. *Нутгийн иргэдтэй харилцах практик дасгал*  
Нутгийн иргэдэд зориулсан мэдээллийг хэрхэн ойлгомжтой хүргэх талаар дасгал хийж, богино илтгэл бэлтгэх.
4. *Аман судалгааны асуулт боловсруулах*  
Аман судалгаанд ашиглах 10 асуулт боловсруулж, түүнийгээ хэрхэн ашиглах талаар тайлбар бичих.
5. *Манлайлагчийн жишээнүүдийг шинжлэх.*  
Алдартай удирдагчдын намтар, жишээг судалж, тэдний амжилтын шалтгааныг тайлбарлах.

*Эерэг хандлага ба хувь хүний манлайлал*

1. Нэг долоо хоногийн турш өдөр бүр өөрт тохиолдсон эерэг үйл явдлуудыг тэмдэглэж, тэдгээр нь таны хандлагад хэрхэн нөлөөлснийг бичнэ үү.
2. Хичээл дээр дурдсан мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг ашиглан багийн гишүүдэд тулгарсан бодит эсвэл төсөөлсөн ёс зүйн зөрчлийн жишээг авч судалж, хэрхэн шийдвэрлэх талаар тайлан бичнэ.
3. Өөрийн орчинд (сургууль, ажил, амьдрал) тулгарч буй нэг асуудлыг тодорхойлж, уг асуудлыг шийдвэрлэх санаачилгыг боловсруулж, хэрэгжүүлэх алхмуудыг гарган бичнэ.
4. Хамт олондоо итгэлцлийг нэмэгдүүлэх 3-5 энгийн үйлдлийг тодорхойлж, тэдгээрийг яагаад үр дүнтэй гэж үзэж байгаагаа тайлбарлана.
5. Нэг хүн эсвэл багийг урамшуулан дэмжих төлөвлөгөө боловсруулж, урамшууллын тодорхой хэлбэрүүдийг (жишээ нь, магтаал, урамшууллын үг, багийн үйл ажиллагаа) тодорхойлж бичнэ.

*Стрессийн удирдлага ба багаар ажиллах ур чадвар*

1. Маргаан үүсгэх нөхцөл байдлын жишээг судалж, зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар тайлбар бичих. Жишээ: Хоёр багийн хооронд үүссэн үл ойлголцлыг хэрхэн шийдэж болох вэ?
2. Багийн харилцаанд итгэлцлийг бий болгох 5 стратеги боловсруулж, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэхээ тайлбарла.
3. Зөрчлийг шийдвэрлэхэд зориулсан симуляци зохион байгуулж, өөрийн хандлагыг тайлбарлах. Жишээ: Багийн гишүүнтэй санал зөрөх үед хэрхэн шийдвэрлэх вэ?
4. Багийн дотоод харилцаанд гарч болох эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрийг багасгах арга замыг гаргах.
5. Багийн уур амьсгалыг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, өөрийн санал, хэрэгжүүлэх арга замыг тайлбарлах.

**Бие даалт**

*Сэдэв: “Харилцааны үндсэн ойлголтуудыг өдөр тутмын амьдралд хэрэглэх нь”*

Даалгаврын удирдамж: Өөрийн өдөр тутмын амьдралд тулгардаг харилцааны асуудал (гэр бүл, ажлын байр, найзуудтай г.м)-ыг сонгон авч, дараах бүтэцтэйгээр эссэ бичнэ:

- Тулгарсан асуудал (150 үг)
- Харилцааны соёл, ёс зүй, зарчмыг ашиглан шийдвэрлэх арга (200-300 үг)
- Үр дүн ба сургамж (150 үг)
- Дуусгах хугацаа: 5-7 хоногийн дотор бичиж, багшид танилцуулна.

*Сэдэв: “Манлайлагчийн үүрэг ба харилцааны үр нөлөө”*

Зорилго: Манлайлагчийн үүрэг, харилцааны үр нөлөөг танин мэдэж, багийн амжилтанд хэрхэн нөлөөлдгийг судлах.

Хийх зүйл: Удирдан манлайлах ур чадварын ач холбогдлыг танилцуулан, багийн харилцаанд хэрхэн нөлөөлдөг талаар судалгаа хийж бичих.

1. Онолын хэсэг:
  - Манлайллын үндсэн ойлголт, ач холбогдлыг тайлбарлах
  - Манлайлагчийн үүрэг ба багийн харилцаанд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох.

2. Практик хэсэг: Багийн харилцаанд манлайллын нөлөөллийн талаар судалгаа хийх (жишээ нь ярилцлага, асуулга эсвэл кейс судалгаа).
3. Дүгнэлт: Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, багийн харилцааг сайжруулах, манлайлагчийн үүргийг тодорхой болгох зөвлөмж гаргах.

Хэмжээ: А4 хэмжээтэй 2-3 хуудас

*Сэдэв: “Итгэлцэл, ил тод харилцаа ба зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх стратеги”*

1. Итгэлцэл, ил тод харилцааны ач холбогдлыг онолын талаас тайлбарлах.
2. Өөрийн ажлын орчинд тулгарч байсан зөрчлийг жишээ болгон дурдаж, хэрхэн шийдвэрлэж болохыг шинжлэх.
3. Багийн харилцааг сайжруулахад зориулсан стратеги боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг гаргах.

Хэмжээ: 3-4 нүүр

*Сэдэв: Насан туршийн суралцахуйг судлах*

Зорилго: Насан туршийн суралцахуйн ач холбогдлыг ойлгож, хувь хүний болон мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх шаардлагыг ухамсарлан, түүнийг амьдралдаа хэрэгжүүлэх тодорхой алхмуудыг төлөвлөхөд оршино.

#### *Заавар*

1. Ойлголтыг судлах
  - Насан туршийн суралцахуй гэж юу болохыг тодорхойлно уу.
  - Энэ нь хувь хүний хөгжил, мэргэжлийн манлайлалд хэрхэн нөлөөлдөг талаар эх сурвалжуудыг (судалгааны өгүүлэл, ном, нийтлэл) ашиглан судалгаа хий.
  - Жишээ болгон нэг амжилттай хүний (удирдагч, шинжлэх ухаанч, уран бүтээлч г.м) насан турш суралцахуйд суурилсан хөгжлийн түүхийг судалж оруул.
2. Өөрийн төлөвлөгөө гаргах
  - Та ирээдүйн карьер эсвэл хувийн амьдралдаа ямар мэдлэг, чадварыг суралцах хэрэгтэйг жагсаан бичнэ үү.
  - Эдгээр чадваруудыг хэрхэн эзэмших, ямар эх сурвалж ашиглах, хэр хугацаанд хэрэгжүүлэх талаар тодорхой төлөвлөгөө боловсруулна уу.
3. Багийн хэлэлцүүлэг хийх
  - Баг болж, өөр өөр мэргэжлийн болон амьдралын нөхцөлд насан турш суралцахуйн ач холбогдлыг хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилцана уу.
  - Баг бүр насан турш суралцахуйн дадлыг үр дүнтэй хөгжүүлэх арга замыг бусад багуудад танилцуулна уу.
4. Дүгнэлт бичих

Судалсан болон хэлэлцсэнээсээ үндэслэн “Насан турш суралцахуй миний амьдралд” сэдвээр 300-500 үгтэй эсээ бичнэ үү.

## Мэдлэг сорих тест

### Харилцааны үндэс ба соёл

1. Харилцааны ур чадвар гэж юуг хэлэх вэ?
  - а. Хэл зүйн мэдлэг
  - б. Бусадтай үр дүнтэй харилцах чадвар
  - в. Мэдээллийг дамжуулах технологи
  - г. Үг цээжлэх чадвар
2. Харилцаа гэдэг үгийн гарал үүсэл юу вэ?
  - а. Англи хэлний “communication”
  - б. Латин хэлний “communus”
  - в. Грек хэлний “koinos”
  - г. Франц хэлний “commune”
3. Харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд юу хамгийн чухал вэ?
  - а. Хурдан хариу өгөх
  - б. Харилцааны соёл
  - в. Мэдээллийн хурд
  - г. Бичгийн харилцааны ур чадвар
4. Харилцааны соёлын үндсэн шинж чанарт аль нь багтах вэ?
  - а. Зөвшилцөл, хүндэтгэл
  - б. Ухаалаг үг хэллэг
  - в. Биеийн хэлэмжийн дутагдал
  - г. Өөрийн санаагаа тулгах
5. Ёс зүйтэй харилцааны үндэс юу вэ?
  - а. Мэдээллийн тодорхой байдал
  - б. Шударга байдал, хүндэтгэл
  - в. Албан ёсны дүрэм мөрдөх
  - г. Багийн шийдвэр гаргах чадвар
6. Харилцааны хэлбэрт аль нь хамаарах вэ?
  - а. Ажлын байрны зохион байгуулалт
  - б. Аман, бичгийн, биеийн хэлэмж
  - в. Дотоод харилцаа
  - г. Бүлгийн удирдлага
7. Биеийн хэлэмжийн аль нь зөв жишээ вэ?
  - а. Захидал бичих
  - б. Гар өргөх, толгой дохиx
  - в. Илэрхий үг хэллэг ашиглах
  - г. Хурдтай ярих
8. Гэр бүлийн харилцааны онцлогт юу багтах вэ?
  - а. Эмоцийн холбоо, хүндэтгэл
  - б. Албан ёсны дүрэм мөрдөх
  - в. Зөвхөн бичгийн харилцаа
  - г. Ажлын байранд хэрэглэх ур чадвар
9. Ажлын байрны харилцааг ямар зарчмаар зохицуулах вэ?
  - а. Харилцааны дүрэм, ёс зүйг сахих
  - б. Хурдтай мэдээлэл солилцох
  - в. Багийн уур амьсгалыг орхих
  - г. Бичгээр мэдээлэл хязгаарлах
10. Харилцааны үр дүнг үнэлэхэд юу шаардлагатай вэ?
  - а. Хурдан шийдвэр гаргах
  - б. Эерэг эргэх холбоо
  - в. Мэдээллийн нууцлал
  - г. Үгэн харилцааны техник

### Манлайлал ба үр дүнтэй харилцааны арга барил

1. Удирдан манлайлагчийн гол чанаруудыг сонго.
  - а. Алсын хараатай байх
  - б. Туйлшралтай хандах
  - в. Харилцааны ур чадваргүй байх
  - г. Уян хатан байх
2. Казүо Инамори (2016) манлайлагчийн ямар үндсэн шинж чанарыг онцолсон вэ?
  - а. Зоригтой удирдах
  - б. Шийдвэр гаргахад бусдын оролцоог хязгаарлах
  - в. Туйлширсан үзэл баримтлах
  - г. Алдаа гаргахаас зайлсхийх

3. Багийн доторх харилцааны ач холбогдол юу вэ?  
а. Ганцаарчилсан шийдвэр гаргах  
в. Тушаал өгөх  
б. Багийн эв нэгдлийг нэмэгдүүлэх  
г. Мэдээлэл дамжуулахыг зогсоох
4. Аман судалгаанд ямар асуулт ашиглах нь илүү тохиромжтой вэ?  
а. Нээлттэй асуулт  
в. Хэцүү асуулт  
б. Хаалттай асуулт  
г. Хоёрдмол утгатай асуулт
5. “Туйлшрал хийрхлийн төлбөр өндөр” гэсэн санаа юу илэрхийлдэг вэ?  
а. Шийдвэр гаргахдаа уян хатан байхын чухлыг  
б. Багийн зорилгыг орхихын ач холбогдлыг  
в. Зөрчилдөөн үүсгэхийг  
г. Тушаал өгөхийг
6. Багийн харилцаанд хамгийн чухал хүчин зүйл юу вэ?  
а. Тодорхой зорилго  
в. Хувийн амжилт  
б. Зөрчилдөөн  
г. Удирдагчийн үг сонсох чадваргүй байдал
7. Харилцаанд итгэлцлийг хэрхэн бий болгох вэ?  
а. Бусдын үзэл бодлыг сонсох  
в. Зөвхөн өөрийнхөө үзэл санааг илэрхийлэх  
б. Тушаал өгөх  
г. Харилцааг орхих
8. Багийн харилцаанд удирдагчийн хамгийн чухал үүрэг юу вэ?  
а. Зорилгоо тодорхойлох  
в. Багийн гишүүдийг тусгаарлах  
б. Бусдын санаа бодлыг үл тоох  
г. Шийдвэр гаргахаас зайлсхийх
9. Аман судалгаанд мэдээлэл цуглуулах хамгийн үр дүнтэй арга юу вэ?  
а. Нээлттэй асуулт  
в. Тодорхойгүй асуулт  
б. Урт ярилцлага  
г. Хэцүү асуулт
10. Манлайлагчийн хувьд хамгийн чухал үнэт зүйл юу вэ?  
а. Итгэлцэл  
в. Зөрчилдөөн үүсгэх  
б. Хурдан шийдвэр гаргах  
г. Хувийн эрх ашгийг хамгаалах

*Эерэг хандлага ба хувь хүний манлайлал*

1. Эерэг хандлага гэж юу вэ?  
а. Бусдын үзэл бодлыг ойлгох  
б. Боломжийг олж харах, өөдрөгөөр хандах чадвар  
в. Асуудлыг хүлээн зөвшөөрөх  
г. Удирдах ур чадвар
2. Эерэг хандлага ямар ач холбогдолтой вэ?  
а. Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг  
в. Амжилт, аз жаргалыг нэмэгдүүлдэг  
б. Хамтын ажиллагааг сайжруулдаг  
г. Бүгд зөв
3. Эерэг хандлагыг хэрхэн хөгжүүлэх вэ?  
а. Талархлын дэвтэр хөтлөх  
в. Харилцаанаас зайлсхийх  
б. Сөрөг бодлыг хүлээн зөвшөөрөх  
г. Бусдад итгэл хүлээлгэхгүй байх
4. Ёс зүйтэй байх гэдэг нь юу гэсэн үг вэ?  
а. Зөвхөн дүрмийг баримтлах  
в. Асуудлыг хурдан шийдвэрлэх  
б. Шударга, хариуцлагатай байдал  
г. Багийн уур амьсгалыг нэмэгдүүлэх

5. “Хариуцлага хүлээх” гэдэг нь юу вэ?  
 а. Алдаагаа хүлээн зөвшөөрөх  
 б. Бусдад бурууг тохох  
 в. Үр дагаврыг анхаарахгүй байх  
 г. Зөвхөн өөрт ашигтай шийдвэр гаргах
6. Асуудлыг шийдвэрлэхэд баримтлах эхний алхам юу вэ?  
 а. Шийдвэр гаргах  
 б. Мэдээлэл цуглуулах  
 в. Асуудлыг тодорхойлох  
 г. Үр дүнг үнэлэх
7. Дасан зохицох чадварын гол шинжүүд юу вэ?  
 а. Уян хатан байдал, нөхцөл байдалд хурдан хариу өгөх  
 б. Багийн уур амьсгалыг сайжруулах  
 в. Тодорхойгүй нөхцөлд итгэлтэй байх  
 г. Бүгд зөв
8. Бусдыг дэмжихийн ач холбогдол юу вэ?  
 а. Хамтын ажиллагааг дэмжих  
 б. Итгэлцлийг нэмэгдүүлэх  
 в. Багийн бүтээмжийг сайжруулах  
 г. Бүгд зөв
9. Эерэг хандлагын талаар юу хэлж болох вэ?  
 а. Боломж олж харах чадвар  
 б. Сөрөг бодолд захирагдах  
 в. Зөвхөн өөрт төвлөрөх  
 г. Бусадтай харилцахаас зайлсхийх
10. Бусдад урам зориг өгөхөд юу чухал вэ?  
 а. Үйлдлээрээ харуулах  
 б. Магтаал, талархал илэрхийлэх  
 в. Эерэг үгс хэрэглэх  
 г. Бүгд зөв

### *Стрессийн удирдлага ба багаар ажиллах ур чадвар*

1. Итгэлцлийг нэмэгдүүлэх хамгийн үр дүнтэй арга юу вэ?  
 а. Шүүмжлэх  
 б. Ил тод харилцах  
 в. Бусдыг үл тоомсорлох  
 г. Мэдээллийг нуух
2. Маргаан үүсэх гол шалтгаан юу вэ?  
 а. Ил тод мэдээлэл  
 б. Үүрэг, хариуцлагын тодорхой бус байдал  
 в. Эерэг хандлага  
 г. Урамшуулал
3. Зөв шийдвэр гаргахын тулд хамгийн түрүүнд юу хийх ёстой вэ?  
 а. Бүх саналыг үл тоомсорлох  
 б. Эрх мэдлээ нэмэгдүүлэх  
 в. Нөхцөл байдлыг нарийвчлан шинжлэх  
 г. Эсэргүүцлийг шууд үгүйсгэх
4. Маргааныг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй арга юу вэ?  
 а. Ил тод харилцах, хамтран ажиллах  
 б. Саналыг үл тоомсорлох  
 в. Хэрүүл маргаан хийх  
 г. Мэдээллийг нуух
5. Итгэлцэл ямар нөхцөлд нэмэгддэг вэ?  
 а. Нууцлалтай нөхцөлд  
 б. Харилцан хүндэтгэлтэй байдалд  
 в. Шүүмжлэл давамгайлах үед  
 г. Багаар ажиллахгүй үед
6. Маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх гол зарчим юу вэ?  
 а. Саналыг үл хүлээн зөвшөөрөх  
 б. Бусдын үзэл бодлыг хүндэтгэх  
 в. Мэдээллийг нуух  
 г. Эрх мэдлээр дарамтлах

7. Итгэлцлийг бий болгоход юу нөлөөлдөг вэ?
- а. Хэлэлцээр хийх чадвар
  - б. Сөрөг хандлага
  - в. Мэдээллийн тодорхой бус байдал
  - г. Харилцан буруутгал
8. Зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал хүчин зүйл юу вэ?
- а. Удирдлагын зүгээс тасралтгүй хяналт
  - б. Багийн зорилгыг тодорхой болгох
  - в. Зөрчлийг үл тоомсорлох
  - г. Шийдвэр гаргахаас зайлсхийх
9. Маргаан үүсгэхгүйгээр санал бодлыг хуваалцах хамгийн сайн арга юу вэ?
- а. Шууд зөрчилдөөн рүү хөтлөх
  - б. Бусдын санааг хүндэтгэн сонсох
  - в. Саналаа хүчээр тулгах
  - г. Бусдыг буруутгах
10. Багийн уур амьсгалыг сайжруулахад аль нь хамгийн их нөлөөлдөг вэ?
- а. Итгэлцэлтэй харилцаа
  - б. Үргэлж шүүмжлэх
  - в. Мэдээллийг хязгаарлах
  - г. Маргаан өдөөх

## Ашигласан болон гүнзгийрүүлэн сонирхож унших материал

Бат-Эрдэнэ, О. (2022). *EQ боловсрол буюу харилцааны ур чадварын боловсрол*. Mbook. Улаанбаатар

Буюндэлгэр, П. (2012). *Нар хүнээс манддаг*. Selengepress. Улаанбаатар

Казүо, И. (2016). *Амжилтад хүрэх гал эрмэлзэл*. Пресс. Улаанбаатар

Кови, С. (1989). *Өндөр бүтээмжтэй хүний 7 дадал*. Улаанбаатар

Монгол хэлний их тайлбар толь

Наминчимэд, Б. (2019). *Шинж: үзэл бодол, үзэл баримтлал*. Мөнхийн үсэг. Улаанбаатар

Рюшүн, К. (2024). *Хариу үйлдэхгүй дадал*. Гарүна. Улаанбаатар

Туул, Ч. (2010). *Удирдлагын сэтгэл зүй*. ХИС-ийн хэвлэх. Улаанбаатар

Урангоо, И. (2019). *Хувцаслалтын эрх чөлөө*. Адмон. Улаанбаатар

Уянга, Г. (2018). *Бид нэг хэлээр харилцдаг уу: Үр ашигтай харилцааг бүтээх нь*. Mbook. Улаанбаатар

Чэпмен, Г. (1992). *Хайрын 5 хэл*. Улаанбаатар

Defacto, J. (2018). *Хувь хүний эрх чөлөө, нийгэм, хувь хүний тухай нийтлэлүүд*. Мөнхийн үсэг. Улаанбаатар

YOLO: <https://www.yolo.mn/z/6134?utm>

# ТАВДУГААР БҮЛЭГ

ХӨТӨЧ, ТАЙЛБАРЛАГЧ



## 5.1 ОРОН НУТГИЙН ТҮҮХ, СОЁЛ, УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШИЛ

### 5.1.1. Соёлын тухай ойлголт, түүний тодорхойлолт

Соёл гэдэг бол хүний байнгын, идэвхтэй, чөлөөт үйл ажиллагааны үр дүнд бий болж уламжлагдаж байдаг хэм хэмжээ, итгэл үнэмшил, бэлгэ тэмдэг, үнэт зүйлсийн цогц, хүний хөгжсөн түвшин юм. Товчоор, соёл нь хүний ололт амжилтын цогц юм (Буян, 2006).

Соёл нь хүний нийгэм дэх нийтийн зан үйл, хэм хэмжээний цогц нийлэмж болно. Нөгөө талаас соёл нь хүний нийгэмд суралцах замаар дамжин тархдаг үзэгдлийн цар хүрээг хамарсан антропологийн үндсэн ойлголт юм. Соёлын ертөнцийг бүх хүн төрөлхтөн хамтдаа бүтээнэ. Үүнд багаж хэрэгсэл, хөгжим, зан заншил, шашин шүтлэг, технологийг ашиглах, хоол хийх, орон байр, хувцас гэх мэт таашаал авах хэлбэрүүд багтдаг. Материаллаг соёлын үзэл баримтлал нь технологи, архитектур, уран зураг гэх мэт соёлын биет илэрхийллийг хамардаг бол нийгмийн байгууллагын зарчмууд (улс төрийн зохион байгуулалт, нийгмийн институциональ үйл ажиллагаа г.м), домог, философи, уран зохиол (бичгээр болон амаар), шинжлэх ухаан нь нийгмийн биет бус соёлын өв юм (Мөнхсайхан, 2006).

**Соёлын үнэлэмж:** Соёлын хувьд үнэлэмж бол суурь ойлголтын нэг бөгөөд үнэлэмж нь аливаа соёлын цөмийг бүрдүүлдэг гэж үзнэ. Тийм ч учраас өнөөгийн ертөнцөд үнэлэмжийн асуудлыг мэдлэгийн нэн өргөн хүрээнд ялангуяа, хүмүүнлэгийн чиглэлийн олон салбарт идэвхтэй шинжлэн судалж, сургалтад нэвтрүүлсээр байгаа билээ. Германы философич Рудольф Лотце (1817-1881) үнэлэмжийн тухай онолыг философи эргэцүүллийн талбар болгох эх суурийг тавьсан гэж тооцогддог. Энд түүний “Практик философийн үндэслэгээнүүд”, “Бичил орчин” хэмээх бүтээлүүд нь чухал үүрэг гүйцэтгэжээ.

Манайд үнэлэмжийн асуудлыг харьцангуй хожуу авч үзсэн байдаг хэдий ч үндэсний эрдэмтэн мэргэд түүнийг судалсан нь цөөнгүй (Лувсанцэрэн, 1999). Тухайлбал, Цэцэнбилэг (2017) “Үнэлэмж бол хувь хүн өөртэйгөө адилтгадаг (харьцуулдаг) нийгэмлэгт болон өөрт нь ач холбогдол (утга) бүхий зан үйлийн эрхэмлэх зорилго хийгээд аргын тухай түүний төсөөллүүд юм”, Гомбосүрэн (2008) “Үнэлэмж гэдэг нь субъектээс байгалийн юм уу, тухайн нийгмийн тодорхой үзэгдэлд бурхан тэнгэрлэгээр юм уу, бурхан тэнгэрлэг бишээр төсөөлөгддөг, ямар нэг далдлаг хүчинд өгч буй үнэлгээ мөн”, Чулуунбаатар (2001) “Байгаль, амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч субъектийн зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл ажиллагааны нийлбэр цогцсыг хамгийн ерөнхий байдлаар нь үнэлэмж хэмээх ойлголтоор илэрхийлж болно”, Одонтуяа (2004) “Үнэлэмж нь субъектийн оюуны үйл ажиллагаа мөн бөгөөд түүний хүсэл хийгээд үл хүсэхүйн утгыг илэрхийлэх үнэлгээ” хэмээн тус тус тодорхойлжээ.

**Соёлын хэм хэмжээ.** Соёлын хэм хэмжээ нь хүмүүсийн зан үйлийг зохицуулах чухал хэрэгсэл байдаг билээ. Харин төрөөс тогтоосон хэм хэмжээ бол соёлын хэм хэмжээний албан ёсны илэрхийлэл болно. Гэхдээ эрхийн хэм хэмжээ нь нийгэмд үйлчилж байгаа бүх хэм хэмжээг нийтэд нь хамарч чадахгүй юм. Соёлын хэм хэмжээ бол хүний түүхэн хөгжлийн хамгийн эрт үе шатнаас үүсэн хөгжжээ. Тэрээр соёлын тэмдгийн тогтолцооны тусламжтайгаар үеэс үед дамжин өвлөгдөж, зан заншил, уламжлал болон хувирсан байна. Янз бүрийн соёлууд өөр өөрийн өвөрмөц хэм хэмжээтэй байдаг.

Соёлын хэм хэмжээ нь хүмүүсийн зан үйлийг жигдрүүлж, нэгдмэл төрх болон тэдний хамтач үйлийн зөвшилцлийг хангадаг байна. Соёлын хэм хэмжээг мөрдсөнөөр хүмүүсийн хамтын амьдрал, үйл ажиллагааг зохион байгуулах зайлшгүй нөхцөлийг хангаж, нийгмийн хэв журмыг

бүрдүүлэх бололцоотой. Энд дүрэм, арга, үйл ажиллагааны хөтөлбөр, хүссэн үр дүндээ хүрэх үйлдвэрлэл-техникийн зорилтот хөтөлбөр, мэргэжлийн ур чадварын нууцлал, үйл ажиллагааны арга барил зэргийг оруулан үзэж болно.

**Ардын соёл.** Ардын соёл бол соёлын хамгийн эртний төлөөлөл мөн бөгөөд түүнээс хожим нь соёлын бусад төрлүүд үүсэн салбарласан байна. Ардын соёл нь нэргүй зохиогчтой, мэргэжлийн тодорхой бэлтгэл шаарддаггүйгээрээ шилмэл бөгөөд нийтийн соёлоос ялгаатай байдаг. Ардын соёлыг мөн сонирхогчдын эсвэл хамтлагийн гэж нэрлэх нь бий. Ардын соёл нь бичмэл хэлбэрээр уламжлагдан хадгалагдаж ирээгүй ба дуу эсвэл тууль хайлах хэлбэрээр өөр өөр хүмүүс олон удаа гүйцэтгэхэд ямар нэгэн байдлаар байнга хувирч өөрчлөгдөж байдаг ажээ. Мөн шашин хийгээд домгийн төсөөлөлтэй нягт холбоотой байдаг нь түүний нэг онцлог юм. Ардын соёлд шидэт домог, домог, хууч үг, тууль, үлгэр, дуу, бүжиг зэргийг хамруулна. Ардын соёлын элементийг гүйцэтгэх бүрэлдэхүүний байдлаар нь ганцаарчилсан (үлгэр хэлэх, домог ярих), бүлгийн (тууль хайлах, дуу дуулах, бүжиг бүжиглэх), нийтийн (багт наадам зохион байгуулах) гэж ялган үзэж болно.

Ардын соёл нь тухайн орон нутгийнхаа уламжлалтай уялдан тархцын тодорхой хүрээтэй байдгаас гадна, хүссэн хүн бүхэн түүнд оролцож болдог учраас илүү ардчилсан шинжтэй юм. Ардын соёлыг хүртэн хүлээж авах нь уламжлалт болоод аж үйлдвэржсэн нийгэмд хэвийн төдийгүй хүн амын дийлэнх олонхын хэрэгцээ байлаа. Харин аж үйлдвэржсэний дараах нийгэмд байдал нэлээд өөрчлөгдөж ирсэн байна. Чухам тийм учраас өнөөдөр хүн төрөлхтний буй болгосон соёлын түүхэн өвийг хадгалж хамгаалах талаар дэлхийн олон нийт санаа нэгдэн чармайн тэмцэх болов.

Ардын соёлыг эрх зүйн зарим баримт бичиг, судалгааны бүтээлүүдэд “Биет бус соёлын өв”, “Утга соёлын өв” гэх мэт нэр томъёогоор илэрхийлсэн нь цөөнгүй. Эдгээрт ардын уртын болон богинын дуу, хөөмий, исгэрээ, морин хуур, цуур, аман хуур, бий биелгээ, цам бүжиг, нийгмийн уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам, байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, газар, ус, тэнгэрийн байдал, цаг агаарыг шинжих, тахилгат газар, байгаль хамгаалах уламжлал зэрэгтэй холбоотой өв гэх мэт маш олон зүйлийг хамруулж үздэг.

Ардын гар урлал, уламжлалт арга ухааны өв, монгол дархан, мужаан, модон эдлэлийн урлал, оёдол, хатгамал, эсгий ширмэл, арьс ширэн урлал, малын ашиг шимийг боловсруулах уламжлалт арга, ан агнуурын уламжлалт арга ухаан (технологи) гэх мэтийг ч мөн оруулж болно (Зураг 5.1). НҮБ-ын Соёл, шинжлэх ухааны төрөлжсөн байгууллага (ЮНЕСКО) 2001 оноос эхлэн хүн төрөлхтний биет бус соёлын өвийн шилдэг дээжийг дэлхий дахинд зарлан тунхагладаг болсон бөгөөд Монгол үндэстний бүтээж бий болгосон морин хуур хөгжмийн уламжлалт урлагийг 2003 онд, монгол ардын уртын дууг 2005 онд, монгол ардын язгуур урлаг болох бий биелгээ, цуур, тууль, хөөмийг 2009 онд хүн төрөлхтний биет бус соёлын өвийн шилдэг дээжээр өргөмжлөн тунхагласан болно. Энэ бол монгол соёлын үнэ цэнийг олон улсын хэмжээнд үнэлж, түүний хүмүүнлэг чанарыг дэлхий дахинаа тунхагласны нэгэн илрэл юм.

### Зураг 5.1. Соёлын өвийн ангилал (Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2014)

#### Биет бус

1. Эх хэл, бичиг, түүний хүрээний соёл
2. Аман зохиолын уламжлал түүнийг илэрхийлэх хэлбэр
3. Урлагийн тоглолт, үзүүлбэр
4. Үндэсний хөгжмийн зэмсэг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил
5. Ардын ёс заншил, зан үйл
6. Уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил
7. Ардын уламжлалт мэдлэг, арга ухаан
8. Ардын бэлгэдэх ёсны уламжлал
9. Үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл
10. Ардын уламжлалт, технологи
11. Угийн бичиг хөтлөх, өвлүүлэх уламжлал
12. Гэрийн дэг сургуулийн өв уламжлал
13. Уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл
14. Газар усны уламжлалт нэр

#### Биет

##### Түүх соёлын үл хөдлөх дурсгал

1. Эртний ургамал амьтны чулуужсан олдворт газар
2. Эртний хүн оршин сууж байсан үл мөр бүхий давхарга
3. Чулуун зэвсгийн олдворт газар
4. Хадны зураг, бичээс
5. Булш, хиргисүүр, оршуулга, тахилгын байгууламж
6. Эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл
7. Хөшөө дурсгал
8. Тахилгат газар
9. Түүхэн үйл явдал болсон дурсгалт газар
10. Эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулах үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар
11. Бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал

##### Түүх, соёлын хөдлөх дурсгал

1. Ховор эрдэс
2. Эрдэнийн чулуун ховор олдвор
3. Солир
4. Ховор болон ховордсон ургамлын хатаамал, цуглуулга, амьтны чихмэл
5. Эртний ургамал, амьтны олдвор
6. Археологийн олдвор
7. Угсаатны хувцас, чимэглэл
8. Уламжлалт ахуй, тоног, хэрэгсэл, хөдөлмөрийн багаж хэрэгсэл
9. Уламжлалт тоглоом, наадгай
10. Угсаатан ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл
11. Уламжлалт шашин шүтлэгийн холбоотой эд өлгийн зүйл
12. Бичгийн дурсгалт зүйл

### 5.1.2. Монголчуудын уламжлалт зан заншил

Аливаа үндэстэн угсаатны бусдаас ялгарах нэг шинж нь тэдний зан заншил байдаг. Бүр ураг төрлийн байгууллын үед ч овог бүр өөр өөрийн зан заншилтай байжээ. Монголчуудын зан заншил нь өөрийн гэсэн онцлог, өвөрмөц шинж төрхтэй. Угсаатан үндэстний зан заншилд олон хүчин зүйл нөлөөлдөг. Тухайлбал, оршин амьдардаг газар зүйн орчин, цаг уур зэрэг байгалийн хүчин зүйл, эрхлэх аж ахуй, соёл, шашин шүтлэг, оюун сэтгэлгээний онцлог, ертөнцийг үзэх үзэл баримтлал, түүхэн хөгжлийн уламжлал, гадаад харилцааны нөхцөл зэрэг нийгмийн болон улс төрийн олон хүчин зүйлүүд чухал нөлөө үзүүлдэг байна.

Зан заншил харьцангуй тогтвортой шинжтэй агаад өмнөх үеэс хойч үедээ уламжлагдан дамждаг. Ингэхдээ үеэ өнгөрөөсөн зан үйл нь орхигдон, шинэ агуулга хэлбэрээр баяжин хөгжих нь бий. Тэрчлэн дотоодын төдийгүй гадаад хүчин зүйлийн нөлөөллөөр өөрчлөгдөн



сургадаг байсан байна. Үүнд мөр суга-аав, тохойн үе-өвөг, бугуйн үе-өндөр өвөг, алганы үе-элэнц өвөг, хурууны дунд үе-хуланц эцэг, хуруун үзүүр-хуланц, суга-хүү, тохойн үе-ач, бугуйн үе-жич, алганы үе-гуч, хурууны үе-дөч, өндөгний үе гич, хурууны үзүүр-жилийх, талийх гэжээ.

Дээрхтэй уялдаж гал голомтыг амьдралын үндэс, хамгийн нандин зүйл хэмээн эрхэмлэсээр иржээ. Эртний заншлаар хамгийн бага хүү нь гал голомтоо сахиж, эд хөрөнгөө өмчилдөг байна. Гэр бүлээрээ туг тойрон сууж, илч гэрэлд нь дулаацаж, хоол ундаа болгож, эцэг эхийнхээ үгийг сонсож, “бяр сэтгэлийн тэнхээг өгөгч, амьдрал тэтгэгч эх булаг” хэмээн гал голомтоо эрхэмлэсээр иржээ. Галыг шүтэх заншил эртний уламжлалтай билээ. Төрсөн эцгийн гал голомтоос жигүүр ургаж, хүч чадалтай болоод зүг бүр мордож, өөр өөрийн гал голомтыг асаадаг. Хамгийн отгон нь гэртээ үлдэж гал голомтоо залгамжилна.

Отчигин хэмээх Чингис хааны отгон дүүгийн нэр гал голомт сахигч, галын эзэн гэсэн утгатай. Чингис хаан нэг удаа авга ах Даридай Отчигинийг урван тэрсэлсэн учир цаазаар аваачих гэсэн боловч ойрын шадар Боорчи: “Төрөл саднаа хороох гэгч гал голомтоо хөнөөхтэй адил буюу. Ургийн чинь удмаас энэ авга ах чинь л үлдсэн. Чи үүнийг хороохоор шийдэж зүрхлэх гэж үү” хэмээн сануулахад андын үгийг зөвшөөрч авга ахаа өршөөжээ. Сайхь Даридай Отчигин нь Чингис хааны эцэг Есүхэй баатрын отгон дүү аж.

Айл өрх бүр өөрсдийн угийн бичгийг хөтлөн, уг удмаа уламжлуулан тогтоолгодог заншил байжээ. Монголчууд ураг төрлийн баялаг нэрстэй бөгөөд түүнд хэсэг бүлэг хүмүүсийг нэрийдсэн авга, нагац, ач, зээ гэх мэт ерөнхий нэр, төрсөн эцэг, эх гэх мэт бодгалийг илэрхийлсэн тухайлсан нэр гэж хоёр ангилдаг. Түүнчлэн тухайн ураг, элгэн садны хүмүүсийг хүндэтгэн нэрлэсэн хүндэтгэл нэр байдаг. Өрх гэр бүлийн ёс заншилд гал голомтоо амьдралын үндэс, хамгийн нандин зүйл хэмээн эрхэмлэнэ. Монгол гэрийн зохицтой уялдан хүмүүсийн суух суудлын жаяг дэг, өрх тусгаарлах заншил, сүй тавих болон хуримлах ёс, талийгаач оршуулах зан үйл, тогтдоггүй хүүхэдтэй холбоотой заншил, үрчлэх ёс, хүүхдийн даахь авах, хүүхдийн угаалга хийх, энгэр зөрөх ёс зэрэг арвин ёс заншил багтдаг.

Хүмүүсийн өөр хоорондын харилцаа, мэндлэх ёс нарийн дэгтэй. Монголчуудын дүү нь ахмад хүний амар мэндийг эхлэн эрдэг. Гэхдээ эрдэмтэн мэргэд, алдар цуутай гавьяатан, баатар цолтныг эгэл хүн эхэлж амар амгаланг эрнэ. Монгол хүн амар мэндээ цаг хугацааны байдлаас хамаарч хэлэлцдэг. Энэ бүхнээс үзвэл, хүмүүсийн хоорондын харилцааны ёс заншилд монголчууд өвөг дээдэс ахмад хүмүүсээ хүндэтгэх, хүнийг хүлээж хүндлэхийн эрхэм үйл болох зочлох ёс, сайхан учралын бэлгэдэл болсон бэлэг барих ёс, буянт үйл хэмээн үздэг өглөгийн ёс, хүж барилцах, анд бололцох зэрэг олон ёс заншил буй.

Эдгээрийн дотроос “Багшийг хүндэтгэх ёс”-ны тухай товч дурдъя. Манай ард түмэн багшийг хүний дээд манлай болгон “хүндэт” их хүн гэж үздэг учраас багшийг шинжин таних ухааныг бий болгожээ. Багшийн эрхэмлэн хүндэтгэх ёс бол шашны шавилах ёсонтой холбогдсон талтай боловч өнө эртний үеэс овгийн ахлагч, удирдан манлайлагч, алив эрдэм заан сургагч зэрэг тэргүүнүүдээ сонгож ихэд хүндэтгэдэг байсан түүхэн уламжлалаас гаралтай. АНУ-ын монголч эрдэмтэн О.Латиморийн хэлсэнчлэн Монголчууд үр хүүхдүүддээ “Нүүдэлчний эв ёс”-ыг заан сургадаг байжээ. Энэ ёсонд эсгий хийх, хонь мал хариулах, нүүх суух зэрэг нийтлэг чанартай ёс заншилд сургах бүхий л үйл, аж төрөхийн бүхий л арга ухаан орж байсан. Ингэж залуу үеэ манай, танай гэхгүй багшлан зааж хүмүүжүүлдэг нэгдмэл арга барилтай байжээ. Монголчууд үр хүүхдээ сурган хүмүүжүүлэхдээ:

- Хүнийг хайрлах, хүндэтгэх ёс
- Аж төрөх арга ухаан

- Цэргийн эрдэм боловсрол
- Гал голомт, газар усаа дээдлэх
- Эрдэм номын ухааныг сургахад анхаарч байв.

Зонхов богдын зохиосон “Бодь мөрийн арван зэрэгт” багш хүний эрхэмлэн эзэмшвэл зохих зарчмыг зааж тэрхүү арван зүйлийг эзэмшсэн хүнийг багш хэмээн нэрлэж байжээ. Үүнд, багш хүн номхон дөлгөөн, зөөлөн, эрдэмтэй, тэсвэртэй, баялаг хэлтэй, хэлэмгий, олон авьяастай, энэрэнгүй, тэвчээртэй, уйтгаргүй байх тухай заасан байдаг. Мөн шавь хүний жигшвэл зохих сударт “сав”-аар зүйрлэн хэлсэн байдаг.

- Ёроол нь цоорхой сав
- Дотроо хар буртагтай сав
- Ам нь эмтэрхий сав хэмээжээ.

Төрөл биш хүмүүс төрсөн эцэг эх, ах дүү, элгэн садан лугаа адил бие биедээ чин үнэнч эрхэм шударга явах явдлыг ах дүүгийн барилдлага гэдгийн адил шавь багшдаа төрсөн ах дүү, эцэг эх мэт элэгсэг дотно, үнэнч шударга, эрхэм сайн байх ёсноос “барилдлага” үүсжээ. Шавь хүн учир барилдсан багшийнхаа өмнө зүүн гарынхаа алгыг баруун гарынхаа алган дор тавин сөгдөн сууж эрдэм сургаал, хичээнгүйлэн сонсдог байсан нь багшийг эрхэмлэн санаж хүндэтгэхээс гадна, заалгаж байгаа номоо сүсэглэн хүндэтгэж байгаагийн илрэл байжээ. Багш өөрийн “гарын шавь”-тай байжээ. “...Эцэг эх багш тэргүүтний ачийг эрх биш хариулан бодож тусыг ихэтгэх эзэн дээдийн албанд гавьяа зүтгэлээр хичээ. ... Эх болсон хамаг амьтныг энэ тэр гэлгүй энэр. ...аелдэг зөөлөн зангаас, этгээд гажуу ааш занг эгнэгт тэвч. ... эс мэдвээс битгий мэдэнгүйрэх, эрдэм сурахыг үйлдэвч уйдалгүй авьяас шавь. ... Эрдэмтэй боловч омгорхохын хэрэггүй, эргүү тэнэг болбоос өөрийн хирийг мэдэж авбаас сайн. ... Эрдэмтэй болоод эвтэй болбоос сайн...” гэх зэргээр шавь нарын эзэмшвээс зохих, номхон дөлгөөн аясыг Ноён хутагт “Орчлонгийн алтан товч”-доо шавь хүний таван эрдэмд тулгуурлан бичжээ.

## Бүлгийн дүгнэлт

Ардын соёл бол соёлын хамгийн эртний төлөөлөл мөн бөгөөд түүнээс хожим нь соёлын бусад төрлүүд үүсэн гарчээ. Ардын соёл нь нэргүй зохиогчтой, мэргэжлийн тодорхой бэлтгэл шаарддаггүйгээрээ шилмэл болоод нийтийн соёлоос ялгаатай байдаг. Дотор нь биет болон биет бус гэсэн 2 үндсэн хэсэгт ангилж үзэх бөгөөд биет өвийг түүх соёлын үл хөдлөх ба хөдлөх соёлын дурсгал гэж ангилдаг. Манай улсын хувьд олон мянган жилийн туршид хуримтлагдан бий болж хөгжиж ирсэн арвин их соёлын дурсгалтай төдийгүй дэлхий өөр аль ч улсад үзэж харах боломжгүй гэдгээрээ их онцлог юм.

Зан заншил харьцангуй тогтвортой шинжтэй агаад өмнөх үеэс хойч үедээ уламжлагдан дамждаг. Ингэхдээ үеэ өнгөрөөсөн зан үйл нь орхигдон, шинэ агуулга хэлбэрээр баяжин хөгжих нь бий. Тэрчлэн дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөллөөр өөрчлөгдөн хувирдаг бөгөөд энэ нь ямар ч улс түмний заншил бусдынхаас салангид тусдаа, тасархай байдаггүйтэй холбоотой. Монголчуудын зан заншлын язгуур шинжийг тодорхойлж буй ой тулгуур нь шударга чанар, нинжин сэтгэл, нигүүлсэнгүй үзэл юм. Манай ёс заншил нь гүн утга санаа, өвөрмөц сэтгэмж, түүнийгээ уран яруу тод илэрхийлсэн байдгаараа онцлог билээ.

## 5.2 ЧУЛУУН ЗЭВСЭГ, ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ҮЕИЙН ОНЦЛОХ ДУРСГАЛУУД, БУЛШ БУНХАН, АРХЕОЛОГИЙН ОЛДВОРУУД

### 5.2.1. Чулуун зэвсгийн үеийн онцлог, дурсгалууд

Монголын эртний түүхийн үе нь чулуун зэвсгийн үеэс эхлэх ба дотор нь 3 ангилдаг. Үүнд:

1. Палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үе нь одоогоос 800,000-12,000 жил
2. Мезолит буюу дунд чулуун зэвсгийн үе 12,000 – 7,000 жил
3. Неолит буюу шинэ чулуун зэвсгийн үе 7,000 – 3000 жилийн өмнөх үеийг хамарна (Цэвээндорж нар, 2002).

**Хуучин чулуун зэвсгийн үе.** Археологичдын сүүлийн үеийн судалгаагаар, Төв Азийн хөрс шорооноос одоогоос 800,000 жилийн тэртээд холбогдох эртний хүний ул мөр бүхий бууц Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Цагаан агуйгаас олдсон байна. Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн явцад чулуун зэвсгийн хэлбэр хийц, хийх арга нь улам боловсронгуй болж байсныг үндэслэн, судлаачид хуучин чулуун зэвсгийн үеийг дотор нь дараах байдлаар ангилан тогтоосон байна.

**а) Хуучин чулуун зэвсгийн доод үе.** 800,000-100,000 жилийг хамарна гэж үзжээ. Энэ үеийн гол олдворуудаас дурдвал, Өвөрхангай аймгийн Богд сумын нутагт орших Их газар, Арц Богдын уулын зүүн суга, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Ярх уул, Дорноговь аймгийн Сайншанд хотын орчмоос олддог цахиурлаг чулуугаар хийсэн залтас, болхи зассан чулуу, хусуур зэрэг болно. Энэ үеийн эртний хүмүүс нь агуйд аж төрж байжээ. АНУ-ын эрдэмтэн Г. Ф. Осборн, Ч. Андерс, ОХУ-ын эрдэмтэн А. П. Быстров нар Төв Ази тухайлбал, Монголын элсэн говьд хүн анх үүссэн гэдэг таамаглал дэвшүүлжээ. Жич: 1920 онд олдсон эртний хүний үлдэц, ясыг “Ордос хүн” гэж нэрлэжээ.

**Зураг 5.3.** Эртний хүн амьдарч байсан ул мөр бүхий Цагаан агуй, Баянхонгор аймаг, Баянлиг сум (Бат-Эрдэнэ)



**б) Хуучин чулуун зэвсгийн дунд үе.** 100,000 – 40,000 жилийн өмнөх үеийг хамарна. Энэ үеийн олдворууд Эрдэнэ зуу хийдийн ойрхон Орхон голд цутгах Мойлтын рашааны зүүн дэнж, Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг, Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Дух зэрэг газраас олджээ. Энэ үед дэлхийн цаг агаарт ихээхэн өөрчлөлт орж, Европ, Ази тивийн хойд

зүгээс хүйтэрч, мөстлөг явагджээ. Энэ мөстлөгийн урд хил Туул голын хөндий, Улаанбаатар хотын орчим хүрч байжээ. Мөстлөгийн улмаас амьтан, ургамлын амьдралд ихээхэн өөрчлөлт гарч, зарим нь устан үгүй болж, үлдсэн хэсэг нь дулаан уур амьсгалтай өмнө зүг рүү нүүдэллэн, аж төрөх болжээ. Эртний хүмүүсийн уураг тархинд өөрчлөлт орж, “гал” гаргаж, ашиглаж сурчээ. Эхлээд галыг манадаг байснаа, сүүлдээ “үрэлтийн хүчээр” гал гаргаж сурснаар дулаацах төдийгүй ангийн түүхий махыг шарж, идэх болсон нь эртний хүмүүсийн хөгжлийн түүхэнд том дэвшил болсон байна.

Чулууг олон дахин засаж, улам боловсронгуй болгож, анд хэрэглэдэг байжээ. Ан агнуур ихэд хөгжиж байсан нь багаж зэвсэгтэй холбоотой. Ангийн үслэг арьсаар хувцас, нөмрөг хийж, өмсөх болсон нь бас л дэвшил. Цаг агаар хүйтэрсэнтэй холбоотой агуй хонгилд эртний хүмүүс аж төрж байсан нь энэ үеийн гол онцлог юм.

**е) Хуучин чулуун зэвсгийн дээд үе.** Одоогоос 40,000 – 12,000 жилийн өмнөх үе багтах бөгөөд мөстлөгийн дараах үетэй холбогдож байгаа болно. Энэ үеийн дурсгал Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам, Туул голын сав газар, Ховд аймгийн Манхан сумын Цэнхэрийн агуй зэргээс олджээ. Хөдөлмөрийн багаж зэвсгийн тухайд гэвэл боловсронгуй болж, чулуугаар цоолох, огтлох багаж хийх, түүнчлэн яс, эврээр хийсэн зүү, шөвөг хүртэл хийж сурчээ. Агуйг амьдран суух оромж гэр болгосон. Эмэгтэйчүүд нийгмийн амьдралд голлох үүрэг гүйцэтгэж, эхийн талыг баримтлан овоглох болж, “эхийн эрхт ёс”-ны үндэс тавигдсан. Шинжлэх ухаанд “*матриархат ёс*” гэсэн нэр томъёогоор нэрлэдэг. Түүвэрлэх аж ахуй эрхэлж байсан нь энэ үеийн гол онцлог. Байгалийн элдэв эрхшээлд автагдаж, шашин шүтлэгийн анхны хэлбэрүүд үүсжээ.

Хуучин чулуун зэвсгийн үеийн соёлын дурсгалууд манай оронд элбэг байдаг. Жишээ нь, Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуйгаас олдсон зураг (Зураг 5.4), мөн аймгийн Буянт сумын Чандмань Хар Үзүүрийн зураг, Манхан сумын Ишгэн толгойн хадны зураг, Хэнтий аймгийн Батширээт сумын Хурх бригадын Биндэр уулын Рашаан хадны зурагт археологийн судалгааг нэрт эрдэмтэн Х.Пэрлээ эхлүүлж, цаашид гүнзгийрүүлэн судалсан байна. Хэд хэдэн удаа археологийн малтлага хийж, 1980-аад оны малтлагаас 1500 орчим чулуун эдлэл, олон төрлийн хусуур, хутга, мэс, ирлэсэн залтас, ялтаснууд олджээ. Эрдэмтэн Х.Пэрлээ (1976) Рашаан хаданд сийлсэн олон тамгыг судалж, нэгэн сэдэвт зохиол туурвижээ.

**Зураг 5.4.** Хойд Цэнхэрийн агуй, Ховд аймаг Манхан (Tmatic travel)



**Дунд чулуун зэвсгийн үе.** Хуучин чулуун зэвсгийн дараагийн үеийг дундад чулуун зэвсгийн үе буюу “мезолит” гэж нэрлэдэг ба палеолитоос неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед шилжих шилжилтийн үе болно. Энэ үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдсан гэж үздэг. Учир нь мөстлөг дуусаж уур амьсгал дулаарч, ургамал, амьтны аймагт ихээхэн өөрчлөлт орсон нь хүмүүсийн амьдрал ахуйд өөрчлөлт орох нэг шалтгаан болжээ.

Мезолитийн үед хүний эдийн болон оюуны соёл, аж ахуйд өмнөх үеэс чанарын шинэ өөрчлөлт гарч нум сумыг зохион ашиглах болжээ. Энэ үеийн дурсгалууд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй, Халх гол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын орчим Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам (I үе), Хэнтий аймаг Рашаан хад (II-III үе) Дорноговь аймгийн Дулааны говь, Өмнөговь аймгийн Булган сум Баруун, Зүүн хайрхан уул болон Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар аймгийн зарим газраас илрүүлэн судалжээ.

**Зураг 5.5.** *Мойлтын амны хуучин чулуун зэвсгийн үеийн бууц суурин, дархны газар Өвөрхангай аймаг, Хархорин сум*



Чихэн агуйн дурсгалыг Монгол-Орос-Америкийн судлаачид 1997-2000 онд судалж, ихээхэн хэмжээний чулуун зэвсгийн зүйл, урт удаан хугацаанд гал түлж байсан ором, амьтны яс болон ургамлын үлдэгдэл бүхий хүний амьдралын ул мөрийг хадгалсан 4 соёлт давхаргыг илрүүлсэн байна.

**Шинэ чулуун зэвсгийн үе.** Шинэ чулууны үеийг “неолит” гэж нэрлэдэг. Манай оронд энэ үеийн дурсгалууд элбэг олддог. Булган аймгийн Эгийн голын сав газраас 1990 оны үеэс шинэ чулууны багаж, зэвсгүүд их хэмжээгээр олджээ. Шинэ чулууны үндсэн хэрэглэгдэхүүн нь хаш, хээрийн жонш, хас, мана, төрөл бүрийн цахиур чулуу байсан ба чулууг өрөмдөж цоолох, зүлгэх арга барил үлэмж дэлгэрсэн. Сүхбаатар аймгийн Онгон сумын Бүрд хэмээх газраас үр тариа нухах чулуун самбар, ваарын хагархай, тарианы чулуун нүдүүр олдсон нь газар тариалан эрхэлж байсны нотолгоо юм. Түүнчлэн олслог ургамлаар загасны тор нэхэх, томох, сүлжих, загас агнуур зэргийг эрхэлж байв. Оросын эрдэмтэн А.П.Окладников (1981) “шинэ чулууны үед Азид адуу, үхрийг хүмүүс аж ахуйдаа хэрэглэж байсан” гэж дүгнэжээ.

Энэ үеийн дурсгалуудаас дурдвал, Увс аймгийн Сагил сумын Можоогийн хадны зураг (аргаль, янгир, тэмээ гэх мэт амьтдыг сийлсэн), Дорнод аймгийн Булган сумын Норовлин уулнаас олдсон олдворууд (ан ба аж ахуйн зориулалттай багаж зэвсгүүд) олджээ. “Чулуун онго” гэж нэрлэгдсэн олдвор нь зууван урт, бүтэн баримал хэлбэртэй, хүний царайг зууван хэлбэрээр маш нарийн уран сийлж, зүлгэж, өнгөлсөн, зүүх зориулалттай нүх гаргасныг хожим Чингис хааны үеэс алт, мөнгөн пайз – гэрэгэ болж хөгжиж уламжлагдсан гэж судлаачид үздэг.

Дүрслэх урлагийн үүсэл энэ цаг үед үүсжээ. Өвөрхангай аймгийн Уянга сумын Шурангын бичигт Улаан хад, Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэрийн Рашаан хадны зураг нь улаан зосон будгаар хувцастай бүжиглэж буй хүмүүсийг дүрсэлжээ. Энэ цаг үед багаж зэвсэг сайжирсантай холбоотойгоор эрэгтэйчүүдийн овогт гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, “эцгийн эрхт ёс – патриархат ёс” үүсэж эхэлсэн.

### 5.2.2. Хүрэл зэвсгийн үе

Одоогоос 7,000 жилийн тэртээгээс эхэлсэн гэж археологичид үздэг. Хүрлээр багаж, зэр зэвсэг үйлдэх болсон нь Төв Азид төдийгүй дэлхийн соёл иргэншилд гүнзгий ул мөр үлдээжээ. Хүрлийг гаргаж авахад 90% нь зэс, 10% нь цайрын элементээс бүтдэг байна. Гол олдворууд нь:

- Буган чулуун хөшөө
- Дөрвөлжин булш
- Багаж, зэвсэг
- Хадны зосон ба сийлмэл зургууд.

**Буган чулуун хөшөө.** Евразийн тал нутагт хожуу хүрлийн үе буюу одоогоос 3200 жилийн өмнөөс үүсэн дэлгэрч, нүүдэлчдийн ур ухаанаар бараг 600 шахам жил үргэлжлэн бүтээгдсэн буган хөшөөний утга агуулга нь баялаг хээ чимэглэл, дүр дүрслэлийг ашиглан дайчин баатар эрийг төлөөлүүлэн дүрсэлснээрээ онцлог.



Одоо Евразийн өргөн уудам нутагт нийт 1652 буган хөшөө бүртгэснээс 1318 нь буюу 80% орчим нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа юм. Энэ болон судалгааны бусад баримтаас үзэхэд, буган хөшөөний үүслийн цөм, тархалтын төв нь Монгол нутаг байжээ хэмээн үздэг. Ийнхүү Монгол нутагт анх үүсэн буган хөшөөний соёл Евразийн бусад нутаг тархсан ажээ. Буган хөшөөний уг үндэс нь хиргисүүртэй холбоотой байх тул хамтдаа Хиргисүүр-Буган хөшөөний соёлыг бүрдүүлдэг байна (Төрбат, 2022). Буган чулуун хөшөө нь дунджаар 1-4 м өндөр, 20-40 см зузаан, 30-100 см өргөн хэмжээтэй. Буган чулуун хөшөөнд зураасан зураг, сийлбэр, уран баримлын аль алин хосолсон байдаг. Буган чулуун хөшөөний онцлог нь:

- Чулууны хажуу, нүүрэн талыг тэгшлэн зассан
- Чулууны дээд, оройн хэсэгт нар, сарыг дүрсэлсэн
- Чулууны доод хэсэгт их биеийг тойруулан дээд тэнгэр өөд дүүлж байгаа хэд хэдэн бугуудыг загварчлан сийлсэн
- Хөшөөний доод хэсэгт бүслүүр хийж, нум сум, саадаг, хутга, бамбай зэргийг дүрсэлсэн
- Зориулалт нь бугын ангийн дараа овгийнхон баяр ёслол хийж, хойч үедээ зориулж, буган чулуун хөшөө босгодог уламжлал тогтсон.
- Хүрлийн үеийн хамгийн гол дурсгал юм.

**Дөрвөлжин булш.** Хүрлийн үед нас барагсдыг оршуулах зан үйлийн дурсгал болох “дөрвөлжин булшнууд” Монгол Улсын нутаг өргөн олддог. Яагаад “дөрвөлжин булш” гэдэг нэр авсан бэ гэхээр хонин цагаан хэлбэртэй чулуугаар дөрвөлжилсөн маягтай зассан байдаг аж. Дөрвөлжин булшинд нас барагсдын эдэлж, хэрэглэж байсан морь, мал, зэр зэвсэг, нум сум зэргийг дагалдуулсан байдаг нь “хойд нас”-ны ойлголт, шүтлэгтэй байсныг нотолно. Оршуулах зан үйлийн хүрээнд хэд хэдэн малыг нядлан, хойлго хийж, тусгай булш бунхан барьж, овгийн тэргүүн нарт сүрлэг хөшөө дурсгал босгох нь цөөнгүй ажээ.

**Багаж зэвсэг.** Энэ төрлийн дурсгалыг 3 ангилна. Үүнд:

- Байлдааны багаж зэвсэг
- Ахуйн хэрэгсэл
- Гоёл чимэглэлийн эдлэлүүд.

Дурсгалуудаас дурдвал, Харвадаг сумны хүрэл зэвийг дотор нь онгит, шилбэт, дуут гэж ангилна. Хүрлээр цутгаж хийсэн хутга, ооль, зэв, тогоо, шөвөг, дөрөө, амгай, зуузай, товруу, үсний даруулга, зүүлт, унжлага, ээмэг, бөгж, толь гэх мэт олдворууд болно. 1972 онд Увс аймгийн Улаангом хотын баруун өмнө орших Чандмань уулнаас энэ төрлийн 50 гаруй археологийн дурсгалыг илрүүлж “Чандманийн соёл” гэж нэрлэсэн. Гол онцлог нь амьтны дүрсийг хүрлээр цутгах урлаг гойд хөгжсөнд оршино.

**Хадны зосон зураг.** Улаанбаатар хотын ойролцоо орших Их тэнгэрийн ам, Гачууртын ам, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Бичигт булан зэрэг газраас олджээ. Зосон зургийн гол онцлог нь дөрвөлжин хашлага, дугуй хүрээн дотор олон цэг тавьж, түүний гадна буюу дотор талд хөтлөлцөн зогссон хэд хэдэн хүнийг дүрсэлснийг Оросын эрдэмтэн Н.П. Окладников “хүрээг овог, аймаг гэж, цэг нь маш олон мал сүргийг төлөөлж байж болох юм. Нисэж байгаа шувуу нь овог аймгийн сүлд шүтээн болж байсан” гэж тайлбарлажээ.

**Хадны сийлмэл зураг.** Архангай аймгийн Чулуут сумын хадны зураг, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Модтой толгойн хадны зураг, Булган аймгийн Орхон сумын баруун Могой голын адгийн хадны зураг, Өмнөговь аймгийн Ноён сумын Аравживын хадны зураг, Говь-Алтай аймгийн Цээл сумын Цагаан голын хадны зураг, Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг дахь Ямаан усны хадны зураг зэргийг археологич Д.Цэвээндорж онцлон дурдсан байдаг. Эдгээр сийлмэл зургийн гол онцлог нь зураасаар зам дүрсэлсэн, морь, морин тэрэг, сүйх тэрэг, хүн, ан амьтан, нохой, олон тооны тамга, тэмдгийг сийлсэн байдаг. Хүрлийн үед овгууд хоорондоо газар, ан булаацалдах тэмцэл өрнөх болсон.

**Төмрийн түрүү үе.** Монгол нутагт НТӨ IV-III зууны үеэс “Төмрийн түрүү үе” эхэлсэн гэж үздэг. Төмрийг хэрэглэх болсон нь төмрийн хүдрийг хайлуулах үйл ажиллагаатай холбоотой. Тухайлбал, “бух дарх” гэсэн арга байжээ. Энэ арга нь үргэлж салхитай байдаг уулын орой, онь хөтөл дээр галлах амыг салхи өөд харуулан, зуух барьж, зууханд илч ихтэй түлш хийж, төмрийн хүдэр овоолоод, гал оруулж, орхих замаар төмөр хайлуулах арга юм.

Яваандаа төмөр хайлах, улайтгах арга ажиллагаа улам нарийсаж, хиймэл үлээгүүр “тулман хөөрөг” ашиглах болжээ. Энэ үед хамаарах дурсгал Монгол нутгаас ховор олддог. Төмрийн түрүү үеэс овгийн тэгш бус байдал алдагдаж, хүчирхэг овгууд нь сул дорой овгуудыг эзлэн түрэмгийлж, аймаг, улс үүсэх эхлэл тавигджээ.

## Бүлгийн дүгнэлт

Чулуун зэвсгийн үе нь хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн үе юм. Энэ үеийн хүмүүс хөдөлмөрийн багаж зэвсгээ чулуугаар хийж байсан учир чулуун зэвсгийн үе хэмээн нэрлэх болжээ. Энэ үе нь дотроо 3 үед хуваагдах ба түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид эртний хүмүүсийн чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил, хүрээлэн буй орчин, байгальтай харьцах харьцаанд ихээхэн өөрчлөлт гарч байсныг Монгол орны нутаг дэвсгэрт байрлах чулуун зэвсгийн үеийн дурсгалт газрууд, тэндээс олдож буй дурсгалуудаас харж болох юм. Чулуун зэвсгийн үеийн төгсгөлд хүн төрөлхтөн үйлдвэрлэлийн аргын хувьд хувьсгал хийж мал аж ахуй, газар тариалан эрхлэх болсон байна.

Хүрэл зэвсгийн үед зэсийг бусад металлтай хольж шинэ металл болох хүрлийг гарган авах болсноор аж ахуй, нийгмийн харилцаанд өмнө нь байгаагүй дэвшлийг бий болгожээ. Хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсны дурсгал болох хүдэр авдаг уурхай, хүрэл хайлуулдаг байсан зуух, хүрэл эдлэл цутгадаг байсан хэв зэрэг нь Монгол орны нутаг дэвсгэрээс нэлээд тоогоор олдсон нь Монгол Улс тухайн үеийн Төв Азийн хүрлийн үеийн нэг төв байсныг илтгэнэ.

## 5.3 МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛЬ, ГАЗАРЗҮЙН ТОГТОЦ, БҮС БҮСЛҮҮРИЙН ОНЦЛОГ

### 5.3.1. Бүс ба бүслүүрийн ялгаа, нөлөөлөх хүчин зүйл


Байгалийн бүс, бүслүүр нь газрын бүрхэвчийн үндсэн зүй тогтлын нэг юм. Агаарын даралт, температур, тунадас зэрэг уур амьсгалын элементүүдийн газарзүйн хуваарилалт нь ерөнхийдөө дэлхийн бөмбөрцгийн “ороосон” бүслүүрлэг шинжтэй. Үүнээс үүдэн экваторын бүслүүр, тропикийн бүслүүр, сэрүүн бүслүүр, туйлын бүслүүр зэрэг өргөрөг дагасан ялгаралт үүсэх ба энэ нь хуурай газар, далайн аль алиныг хамарсан газарзүйн бүслүүр юм. Өргөрөг дагасан энэ бүслүүрлэг зүй тогтлын хуурай газрын хүрээнд илэрч буй ялгаралт нь “газарзүйн бүс” буюу байгалийн бүс юм.

Байгалийн бүс нь бүрэлдэхүүн хэсгүүдийн өргөргийн хуваарилалтаас хамаардаг тул тундрийн, тайгын, ойн гэхчлэн ургамалжилтын байдлаар ялган нэрлэнэ. Учир нь байгалийн төрх байдлыг шууд илэрхийлэх “нүдэнд харагдахуйц” ялгаралт бол ургамалжилт юм. Гэвч үнэн хэрэгтээ байгалийн бүс нь зөвхөн ургамалжилтын тархалтад илэрч буй ялгаа төдий биш, температур, тунадас, гэрэл, дулаан, хөрс зэрэг байгалийн бүхий л бүрэлдэхүүн хэсгээс хамаардаг цогцолбор шинжтэй юм.

Дээр дурдсан өргөргийн ялгаанаас гадна, өндөр уулын бэлээс орой хүртэл мөн байгалийн төрх байдал өөрчлөгдөнө. Үүнийг газарзүйн ухаанд “босоо бүслүүр” гэж нэрлэдэг. Ууланд илрэх босоо бүслүүрийн тоо, хэв шинж нь оршиж буй өргөрөг (газарзүйн байрлал) болон тухайн уулын өндрөөс хамаарна. Өөрөөр хэлбэл, экваторт орших өндөр уулын бэлээс орой хүртэл ялгарах босоо бүслүүр нь экватораас туйл хүртэл ялгарч буй өргөргийн бүстэй адил байна. Жишээ нь, Африкийн Килиманжаро уул саванны бүсэд орших тул доод бэлээр нь өвслөг хээр (саванн) тархаж, өндөр лүүгээ болох тутам модлог саванн, шилмүүст ой, хүйтэн таг, мөсөн хучлага болон өөрчлөгддөг.

Манай орны хувьд бол босоо бүслүүрийн хэв шинж ялгаатай. Тухайлбал, Аж Богд уул Алтайн өвөр говийн нөлөөнд оршдог тул бэлд илрэх босоо бүслүүр нь цөлөөс эхэлнэ. Харин Дэглий цагаан уулын хувьд бэлд нь хээрийн хэв шинж илрэх ба түүнээс дээш ойт хээр, уулын таг, мөнх цасан хучлага гэсэн ялгаа үүсдэг бол Асралт Хайрханд тунадас харьцангуй их байдагтай холбоотойгоор тайгын бүслүүр тод ялгарна (Зураг 5.6). Иймд босоо бүслүүр нь өндрийн ялгарлыг илэрхийлсэн газарзүйн бүслэг зүй тогтол юм. Энэ үүднээс байгалийн бүс ба бүслүүр гэсэн нэршил хэрэглэдэг нь угтаа өргөргийн ба өндрийн ялгаралд үндэслэсэн ангилал болно.

**Зураг 5.6.** Уулын босоо бүслүүр илрэх байдал (Дэглий цагаан ба Асралт Хайрхан) (Батчулуун)




### 5.3.2. Байгалийн бүс, бүслүүр

Монгол орны ландшафтын онцлог, түүний хуваарилалт, орон зайд тархах байдал нь тус улсын нутаг дэвсгэр дээр илрэх байгалийн бүс, бүслүүрийн ерөнхий зүй тогтлыг тодорхойлно. Энэ үүднээс бүс, бүслүүрийн ангилал үйлдэхэд ландшафтын зарчмыг баримтлах ёстой болно.

Дээр дурдсанаар байгалийн бүс, бүслүүрийн ангилал хийгдэж хэд хэдэн зураг зохиогдсон боловч бүс, бүслүүрийн хил зааг тойм төдий, нэр төдийлөн оновчтой бус, ойт хээр нь бүс, бүслүүрийн аль нь болох нь маргаантай, говь, цөлийн бүсийн хил зааг, хамрах нутаг ихээхэн өөрчлөгдөх болсон, зарим нутаг өөр бүсэд хамрагдсан зэрэг дутагдалтай талууд байгаагаас үүдэн шинэ ангилал боловсруулах шаардлага гарсан байна. Ялангуяа ландшафтууд орон зайд ялгаран тогтоход нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг болох газрын гадарга нь уур амьсгалын нөлөөгөөр илрэх өргөргийн бүсүүдийн тархалтад төдийлөн нийцдэггүй хойд хэсгийн нутаг дэвсгэрийг байгалийн ямар бүсэд хамааруулах тухай асуудлыг нэг мөр болгох үүднээс Д.Даш нар (2010, 2015) Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн ангиллын зураг зохиоходоо дараах үзэл баримтлалд тулгуурлажээ. Үүнд:

- Монгол орны уулархаг нутгийн ландшафтын босоо бүслүүрийн бүтэц нь уул нуруудын үнэмлэхүй өндөр, газарзүйн өргөрөг, чийглэг агаарын урсгалд уулс хэрхэн байрласан байдал, хажуугийн зүг зовхис зэргээс хамаарна.
- Босоо бүслүүрийн тоо, ландшафтын бүрдэл нь өөр өөр уулт тогтолцоонд харилцан адилгүй байдаг.
- Нам, хотос газраар хотгорын нөлөөлөл тод илэрнэ. Энэ нөлөөлөл хэр тод, хэр хүчтэй болох нь хотгорын хэмжээ, хэлбэр дүрс, гүнээс голлон хамаардаг. Хотгоруудад эргэн тойрных нь уулсыг бодвол нэлээд урдуур өргөргийн ландшафт бүхий босоо бүсшил тод илэрдэг.
- Харин Монгол орны төв ба зүүн өмнөд хэсгийн талархаг нутагт өргөргийн бүсүүд тод илэрч ландшафтын бүрэлдэхүүнд био-уур амьсгалын хүчин зүйл голлож байгаа нь тод харагддаг онцлогтой (БНМАУ-ын Үндэсний атлас, 1990).

Зураг 5.7. Монгол орны байгалийн бүс, бүслүүр (Даш, 2016)



**Бүс, бүслүүрийн газарзүйн онцлог.** Монгол орны хойд ба өмнөд захын цэг өргөргийн хувьд 10 орчим градусын зөрүүтэй учир нарны цацраг ба температур өөрчлөгдөн байгалийн төрх байдлын тодорхой ялгарал үүсэх үндсэн нөхцөл бүрэлджээ. Энэхүү ялгарлын үндсэн дээр байгалийн 4 бүс, 2 босоо бүслүүрийг ялган үзнэ. Байгалийн бүсийг хойноос урагш нь авч үзвэл, ойт-хээрийн бүс, хээрийн бүс, говийн бүс ба цөлийн бүс болно. Өндөр уулсын оройгоор ялгарах 2 босоо бүслүүр нь (1) өндөр уулын ба (2) уулын тайгын бүслүүр юм. Байгалийн эдгээр бүс, бүслүүр нь дотроо дэд бүсүүд болон өндрийн ба хотгорын бүслэлд хуваагдана. Тухайлбал, хээрийн бүс нь нугат хээр, жинхэнэ хээр, хуурай хээр гэсэн 3 дэд бүсэд, говийн бүс нь цөлжүү хээр, заримдаг цөл гэсэн 2 дэд бүсэд, цөлийн бүс нь хээржүү цөл, жинхэнэ цөл, хэт гандуу цөл гэсэн 3 дэд бүсэд тус тус хуваагдах байгаль-нутаг дэвсгэрийн өвөрмөц цогцолборууд болно (Даш, 2016).

**Өндөр уулын бүслүүр.** Өндөр уулын бүслүүр манай орны баруун ба хойд, төв хэсгийг эзлэх уулсын дээд оройн хэсгээр ялгарна. Бүслүүрийн доод хил уулсын газарзүйн байрлалаас хамаарч өөр өөр. Дунджаар авч үзвэл, Монгол Алтайд д.т.д 2,300-2,400 м, Хангайн уулст 2,400-2,500 м өндөрт, Хөвсгөлийн уулст 2,000-2,200 м, дорнод Хэнтийд 2,000-2,050 м, Хэнтийн баруун хэсэгт 2,200 м орчимд, Говь-Алтайн уулст 2,700-2,900 м өндөрт тус тус илэрнэ (Өлзийхутаг, 1989; Шагдар, 1985).

Бүслүүрийн эзлэх талбайн хувьд ч харилцан адилгүй, нийт талбай 56,394.0 км<sup>2</sup> буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 3.6%-ийг эзэлдгээс Хөвсгөлийн уулст 0.8%, Хангайн нуруунд 0.9%, Алтайн нуруунд 1.9% нь тус тус ногдоно (Даш, 2000). Өндөр уулын бүслүүр дотоод ялгаа ихтэй, Хангайн нуруунд уулын нуга, Хөвсгөлийн уулст уулын тундр голлодог бол Алтайн нуруунд цас мөс, ян сарьдаг давамгайлсан нарийн нийлмэл бүтэцтэй юм (Даш, 2000).

**Зураг 5.8.** Монгол Алтайн өндөр уулын бүслүүрт уулын нуга 2,800-3,200 м хүртэл өндөрт тархаж буй байдал, Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум (Ц.Сэр-Од)



**Уулын тайгын бүслүүр.** Энэ бүслүүрт Өвөр Байгалийн уулт тайгын их мужид хамрагдах Хэнтий, Хөвсгөлийн уулс багтах бөгөөд Хөвсгөлийн зүүн хэсэг болох Зэд-Бүтээлийн нуруу үнэмлэхүй өндрийн хувьд харьцангуй намсаж өргөрөг бүсийн шинжийг илүүтэй хадгална. Өөрөөр хэлбэл, манай улсын хилийн гадна орших тайгын бүсийн өмнөд сэжүүр Зэд-Бүтээлийн нуруугаар дамжин орж ирдэг тул уулын тайгын бүслүүр нь Сибирийн тайгын өмнөд зах юм. Уулын тайгын бүслүүр Хөвсгөл, Хэнтийн нуруунд хамгийн их талбай эзлэх ба эдгээр уулст бүслүүрийн доод хил д.т.д 1,700-1,800 м өндөрт оршино. Монгол Алтайн нуруунд энэ бүслүүр илэрдэггүй (Юнатов, 1950; 1954; Өлзийхутаг 1989; Даш, 2000) нь уур амьсгалын нөхцөл хуурай байдагтай холбоотой. Уулын тайгын бүслүүр нийт нутгийн 4.5%-ийг эзлэх ба үүнээс 3.0% нь Хөвсгөл орчимд, 1.5% нь Хэнтийн нуруунд ногдоно. Хан Хөхий, Тарвагатайн нурууны дээд хэсгээр армаг тармаг тохиолдоно.

**Ойт хээрийн бүс.** Тунадас, чийг ихтэй нөхцөлд ургадаг Сибирийн тайга урагшлах тутам холимог болон өргөн навчит ойд шилжиж, улмаар өвслөг хээр болдог. Ийнхүү ойн бүсээс хээрт шилжих завсрын бүс болох ойт-хээрийн бүсэд манай орны нутгийн хойд хэсэг хамрагдана. Ойт хээрийн бүсийг байгалийн бүс ба бүслүүрийн алин болох талаар судлаачид өөр өөрөөр үзэж ирсэн байдаг. Тухайлбал, Н.Өлзийхутаг (1989) байгалийн босоо бүслүүр хэмээн үзэж “уулын ойт-хээрийн бүслүүр” (Өлзийхутаг, 1989; Ундармаа, 2018) гэж нэрлэсэн бол Д.Даш (2000) “ой-уулын хээрийн бүслүүр” хэмээн нэрлэх санал дэвшүүлж байв.

Ойт хээрийн бүс зарим нутагт өргөрөг дагасан бүс байдлаар илрэх нь олонтоо бөгөөд ландшафтын үүднээс хандвал уг бүс нутгийг ой-уулын хээрийн хослол гэж үзэх бүрэн үндэстэй. Энэ хослол нь өргөргийн ба өндрийн бүсчлэлийн аль алины шинжийг давхар хадгалсан байна (Даш, 2000). Манай орны ойт хээр нь өргөргийн бүс ба өндрийн бүсчлэлийн аль алиныг үүсгэх ландшафтын хувьд ой-уулын хээрийн хослолоос бүтэх өвөрмөц нутаг юм. Өндрийн хувьд авч үзвэл, ойт хээр нь Хөвсгөлд д.т.д 1,650 м, Хангайд 1,000-1,500 м, Монгол Алтайд 1,800-2,000 м болно (Өлзийхутаг, 1989). Ойт хээрийн (хангайн) бүсэд тус орны нийт нутаг дэвсгэрийн 15.2% буюу 238,108.0 км<sup>2</sup> талбай хамрагдах ба түүний 7.3%-ийг өргөргийн бүс, 7.9%-ийг өндрийн бүсчлэл бүхий нутаг тус тус эзэлнэ (Даш, 2000).

**Хээрийн бүс.** Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад халхын тэгш өндөрлөгийн уудам тал газрыг хамарч баруун тийш нарийссаар Хан Хөхийн нурууны өмнөд бэл хүртэлх газар нутгийг хамарна. Тухайлбал, Хангайн нурууны өврөөс зүүн тийшээ өргөсөн үргэлжлэх бөгөөд урд захын хил нь говийн бүсийн хойд хил буюу х.ө. 45<sup>0</sup>-46<sup>0</sup>-ын зэргэд орчмоор өнгөрнө. Хээрийн бүсийн зүүн хэсгийн хойд хилийг баримжаалбал, Хангайн нурууны зүүн талаар хойшоо эргэж бараг Орхон, Туул голын бэлчир хүрээд урагшаа эргэж Богдхан уулын урдуур, Хэрлэн гол хүрч Хэрлэнбаян Улаан ба Өндөрхаан уулын өврөөр, Улз голын саваар Хэнтийн нурууны зүүн хойгуур з.у. 113 дугаар голдчийг дагаж улсын хилд хүрэх шугам хэмээн үзэж болно (Шагдар нар, 2006). Хээрийн бүсийн нутгийн хөндлөн гол тэнхлэг нь х.ө. 46<sup>0</sup>-47<sup>0</sup>-ын зэргэдтэй бараг тохирох ба жилийн дундаж температурын 0<sup>0</sup>C, 7-р сарын дундаж температурын +20<sup>0</sup>C, 1-р сарын дундаж температурын -20<sup>0</sup>C-ын изотермтэй бараг давхацна.

Хээрийн бүс нь дотроо нугат хээр, жинхэнэ хээр, хуурай хээр гэсэн 3 дэд бүсээс бүрдэх бөгөөд энэхүү дэд бүсийн ялгаа нь Монголын Дорнод талаас баруун тийш Хангайн нурууны зүүн үзүүр хүртэл тод илэрдэг. Түүнээс баруун тийш Хан Хөхийн нуруу хүртэл хэсэгт нугат хээр огт үгүй болж хуурай хээр давамгайлна. Иймд хээрийн бүс нь бусад бүсүүдээс хамгийн их буюу нийт нутгийн 34.2%-ийг эзлэх ба түүний 4.3% нь нугат хээрт, 10.1% нь жинхэнэ хээрт, 14.3% нь хуурай хээрт, 5.5% нь уулын хээрт тус тус хамаарна.

**Говийн бүс.** Энэ нь хээрийн бүсийн урдуур баруунаас Их Нууруудын хотгор, Нууруудын хөндийг дамжин зүүн тийш зурвас байдлаар үргэлжилж улсын хил (Тагны нурууны өвөр бэл) хүрнэ (Даш, 2001). Нутгийн зүүн хэсэгт х.ө. 44°30'-46°-ийн хооронд өргөргийн бүс нь тод илэрдэг. Ш.Цэгмид (1969) байгалийн бүс, бүслүүрийн ангилалдаа “Говийн бүс” гэх нэрээр авсан нь Ю.Г.Евстифеев (1983), Е.И.Рачковская (1993) нарын говь, цөлийн бүсийг хөрс, ургамалжилтын ялгаагаар нь дэд бүсүүдэд хуваасан ангиллыг харгалзсан хэрэг юм. Олон улсын ландшафтын ангиллаар говийн бүс нь заримдаг цөлтэй утга давхцна. Цөлжүү хээр ба заримдаг цөлийн аль аль нь Говь-Алтайн нурууны ар, өвөр хажуу дагуу өндрийн бүслүүр үүсгэнэ. Үүний нэг тод жишээ бол Аж Богд ууланд ялгарах өндрийн бүслүүр юм.

Монгол Алтайн нурууны салбар Аж Богд уул Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт оршдог. Хамгийн өндөр оргил Хүрэн товон (д.т.д 3,802 м) орчимд альпийн буюу тагийн бүслүүр үүссэн, ургамал сийрэг, доошлон хүйтсэг алаг өвст бүлгэмдэл тархдаг бол бэл хэсгээр нь бут сөөг, сайрын ургамал ургадаг нь хөрс, чийг, дулааны нөхцөл өндрийн бүслүүрээс хамаарч өөрчлөгдөж байгаа хэрэг юм. Тухайлбал, хөрсний хэв шинж нь оройгоосоо доош уулын хүрэн, цайвар хүрэн, говийн бор, хужир мараат, цөлийн бор саарал хөрс болж өөрчлөгдөх тул үет, буурцагт, бутлаг ургамал буюу ерхөг, хялгана, нарийн цагаан өвс, тэсэг, шөвөг, ортууз, агь, гогд, гоньд, тоорой, сухай, заг, гандигар, торлог, шар мод, харгана, баглуур, бударгана, таана, хөмүүл зэрэг олон төрлийн ургамал ургадаг. Энд аргаль, янгир, угалз, хавтгай, хулан, хар сүүлт зээр зэрэг олон зүйл амьтад бий. Аж Богдод тунадас харьцангуй элбэг, 115-140 орчим мм тул өврөөс нь Индэр, Гишүүнтэй, Их гол, ар талаас нь Урт, Дөрөлжийн голууд эх аван урсаж ландшафтын өвөрмөц төрхийг бүрдүүлнэ.

Говийн ландшафт нь хээрийн ба цөлийн аль алины шинжийг давхар хадгалсан байдаг онцлогтой. Бүслэг байдлаар илрэх энэхүү ландшафтын хэв шинжид үндэслэн говийн бүсийг цөлжүү хээр, заримдаг цөл гэсэн 2 дэд бүсэд ангилна. Говийн бүс нь нийтдээ нутгийн 23.4% буюу 366,561.0 км<sup>2</sup> талбайг хамрах ба үүний дотор цөлжүү хээр нь 9.1%, заримдаг цөл нь 14.3% болно (Даш, 1992; 1993).

**Цөлийн бүс.** Цөлийн бүс нь дотроо хээржүү цөл, жинхэнэ цөл, хэт гандуу цөл гэсэн 3 дэд бүсээс бүрдэх ба үндсэндээ х.ө. 44°30'-аас урагш улсын хил хүртэлх нутаг хамрагдана. Гэвч Говь-Алтайн ба Говь Тянь Шянийн салбар уулс уг бүсэд байрладаг тул нутгийн нэлээд хэсэг нь говийн ба хээрийн бүсэд хамрагдана (Даш, 2000). Цөлийн бүсийн зүүн зах нь Гурван Баяны хоолой дагуу нутгийн гүн рүү түрж, улмаар энд Хянганы нуруунаас зүүн тийш тод илрэх уртрагийн бүсчлэлийн нөлөөнд ордог. Босоо бүслүүрээр авч үзвэл, Баруун хуурайн хотгорт цөлийн бүс илэрнэ.

Цөлийн бүс нь нийт нутгийн 19.1% буюу 29,9201.5 км<sup>2</sup> нутаг дэвсгэрийг хамрах ба үүний 6.2%-ийг хээржүү цөл, 9.2%-ийг жинхэнэ цөл, 3.7%-ийг хэт гандуу цөл тус тус эзэлнэ. Цөлийн бүсийн уур амьсгал нэн эрс тэс, жилийн тунадасны хэмжээ 100 мм-ээс бага. Жишээ нь, Эхийн голд жилд нийтдээ 36 мм тунадас унасан тохиолдол бий. Өвөл цасан бүрхэвч нимгэн, цастай байх хугацаа богино. Гадаргын усаар нэн ховор боловч газар доорх усны түвшин дээр байгаа газруудад баянбүрд үүсэх нь элбэг. Цөлийн бүсэд гөлтгөнөт бор саарал хөрс голлох бөгөөд хөрсгүй, хайрга чулуу бүхий газар олон. Ургамал маш сийрэг, тачир бөгөөд чулуурхаг, огт ургамалгүй газар ч элбэг. Говь-Алтайн нуруунд уулсын хажуу дээд биед нимгэн цайвар хүрэн ба хүрэн хөрс тархдаг. Их Богд, Бага Богд уулын оройд нугын хөрс багахан тархсан. Говийн ба цөлийн бүсийн хонхор газарт давсархаг хөрс, хужир, марз, элс их. Ялангуяа салхи, усаар туугдаж ирсэн уусамтгай бодис, давсны хуримтлалаас марз үүсэх нь түгээмэл.

Цөлийн бүс нь бэлэрхэг, дундаж ба нам уулс, цав толгод, ухаа гүвээ, шал тойром, хөндий хотгор ээлжлэн солигдсон эртний амьтан, ургамлын үлдэгдэл агуулсан өвөрмөц тогтоцтой. Хулан, хавтгай, мазаалай, замба гүрвэл зэрэг дэлхийд ховордсон амьтад, элдэв навчит тоорой, потанины улаан тулам, монгол мөнх харгана, мөнгөлөг хонхот харгана зэрэг үлдвэр, унаган ургамлаар баялаг.

## Бүлгийн дүгнэлт

Байгалийн бүс бүслүүрүүд нь дэлхийн экосистемийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эдгээр нь тус бүрийн хувьд өөрийн онцлогтой, өөр өөрийн нөхцөлд амьдардаг амьтан, ургамлыг агуулж байдаг. Тиймээс байгалийн бүсүүдийн тэнцвэрт байдал болон тэдгээрийн тогтвортой байдлыг хамгаалах нь даян дэлхийн байгаль орчныг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгаль хамгаалахын тулд энэхүү бүсүүдийн онцлогийг ойлгож, хамгаалах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай.

Байгалийн бүс бүслүүрүүд нь дэлхийн экологийн системийг тодорхойлогч чухал элементүүд бөгөөд тухайн бүсэд орших амьтан, ургамал, газрын гадарга, гадаад орчин зэрэг нь тодорхой нэгэн хэв шинжтэй байдаг. Эдгээр бүс бүслүүрүүд нь дэлхийн олон янзын нөхцөл байдал, уур амьсгал, географийн байрлалтай холбогдон үүссэн байх бөгөөд эдгээрийг судлах нь байгаль орчныг ойлгох, танин мэдэхэд чухал үүрэгтэй юм.

## 5.4 МОНГОЛ ОРНЫ УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМГИЙН ОНЦЛОГ

### 5.4.1. Монгол орны ургамлын аймгийн судалгааны тойм

*Ургамлын аймаг.* Монгол орны ургамлын аймгийн судалгаа Онон, Улз голын хөндийн ургамлын цуглуулга (Мессершмидт, 1724), Хөвсгөл орчмын ургамлын бүрхэвчийн бичиглэл (Турчанинов, 1830-1832)-ийг хийснээр эхэлсэн гэж үздэг. Хангайн нурууны өвөр, Дундад халх, Говь-Алтайн нурууны урд шувтарга, Ноён уул, Дорноговийн ургамалжилт (Павлов, 1923-1926), Хангайн ургамалжилтын судалгаа (Кондратьев, Козлов, Полинов, 1921-1926)-г шинжлэх ухааны бүтээл болгон хэвлүүлж анхны суурийг тавьжээ (Батчулуун, 2021). В.И. Грубов 1947-1948 онд Монгол орны төв, баруун ба өмнөд нутагт судалгаа хийж, “БНМАУ-ын ургамлын аймгийн конспект (1955)” бүтээл гаргасан нь Монгол орны гуурст ургамлыг бүртгэсэн анхны бүтээл юм. Тэрээр энэхүү бүтээлдээ Монгол орны ургамлын аймагт 1,875 зүйлийг бүртгэж, тархалт ба ургах орчныг нэг бүрчлэн тодорхойлсон өргөн хүрээтэй мэдээллийг багтаасан нь дараа дараачийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

Эдгээр болон судалгааны бусад бүтээлд тулгуурлан, Монгол орны гуурст дээд ургамлын ангилал зүй, зүйлийн бүрдлийг нэгтгэсэн “*Conspectus of the vascular plants of Mongolia*” (Urgamal *et al.*, 2014) хэмээх бүтээл нийтлэгджээ.

Судалгааны дүнгээс үзэл, өдгөө Монгол орны ургамлын аймаг, түүний олон янз байдал нь 19 хүрээнд хамаарах 37 анги, 116 баг, 388 овог, 1523 төрөлд хамаарах 7350 зүйл, дэд зүйлээс бүрдэж байна (Ургамал, Түвшинтогтох, 2017; Хүснэгт 5.1).

**Хүснэгт 5.1.** Монгол орны ургамлын аймгийн олон янз байдал, зүйлийн бүрдэл, эзлэх хувь

Ургамлын бүлэг	Хүрээ	Анги	Баг	Овог	Төрөл	Зүйл, дэд зүйл	Эзлэх хувь (%)
1. Дээд мөөг	2	7	20	56	156	574	7.80
2. Замаг	10	13	39	87	268	2003	27.25
3. Хаг	1	3	12	63	207	1033	14.05
4. Хөвд	1	2	6	74	208	580	7.89
5. Гуурст дээд ургамал	5	12	39	108	684	3160	43.01
<b>Нийт</b>	<b>19</b>	<b>37</b>	<b>116</b>	<b>388</b>	<b>1523</b>	<b>7350</b>	<b>100.0</b>

Монгол орон өргөн удам нутаг дэвсгэртэй уул нуруу, хотгор гүдгэр гадаргатай, эх газрын эрс тэс уур амьсгалтай тул ургамалжилтын хувьд нэлээд өвөрмөц бөгөөд дэлхийн ургамалжлын 3 үндсэн бүс болох ой тайга, хээр, цөлд хамаарах ба тэдгээрийн дунд шилжилтийн буюу завсрын бүсүүд ялгаран босоо бүслүүр үүссэн байдаг (Өлзийхутаг, 1989). Энэ нөхцөл нь ургамалжилтын байдал ихээхэн алаг цоог болох, бүслүүрүүд огцом солигдоход (зарим бүслүүр байхгүй байх, тагийн бүслүүр хээрийн бүслүүртэй шууд хил залгах нь элбэг г.м) нөлөөлнө. Монголд уулын бүслүүрийн хэв шинжүүд солигдох тодорхой зүй тогтол ажиглагдах ба Умардын хэв шинжээс Соёны хувилбар тус орны хойд хязгаараар орших уулт өндөрлөгүүдэд ажиглагдана (Юнатов, 1977).

Монгол орны ургамалжилтыг газарзүйн тархалт, онцлогоос хамаарч 7 хэв шинжид ангилж болохын (Цэгмид, 1969) зэрэгцээ өндөр уулын ургамал болон уулын тайгын ой нь ургамалжилтын бүслүүрийг, хээр (Хүснэгт 5.2), цөлийн ургамалжилт нь бие даасан бүсийг тус

тус илэрхийлнэ. Элс болон цайдам, голын татмын ургамалд тодорхой бүс бүслүүрийн шинж илрэхгүй, хаа сайгүй байх учир бүсийн бус ургамал гэсэн ангилалд багтаадаг болно.

**Хүснэгт 5.2.** Хээрийн ургамалжилтын ангилал (Түвшинтогтох, 2014)

Өндөр Уулын	Өндөр уулын хээрийн дэд шинж: 5 хэвшил	Ленийн ботуульт; Сунагар биелэгт; Крыловын ботуульт; Хүйтсэг алаг өвст; Агьт
Бэсрэг Уулсын	Уулын хээрийн дэд хэвшил: 3 хэвшил	Ленийн ботуульт; Жижиг дэгнүүлт үетэнт; Зүр өвст
	Нугын хээр: 8 хэвшил	Алтайн бутнуурт; Байгалийн хялганат; Нангиад түнгэт; Зогдор улалжит; Зүр өвст; Алаг өвст; Бүйлэст; Гүйлст
Цав толгод, ухаа гүвээт болон тэгш талын	Хуурай хээрийн дэд хэвшинж: 6 хэвшил	Түнгэт; Том хялганат; Крыловын хялганат; Дэрвээн хазаар өвст; Саман ерхөгт; Харганат
	Цөлжүү хээрийн дэд хэвшинж: 12 хэвшил	Саман ерхөгт; Дэрвээн хазаар өвст; Сайрын хялганат; Говийн хялганат; Дорнодын хялганат; Ахарцэцэгт хялганат; Невскийн хиагт; Эмзэг түрүүт; Таанат; Алтан харганат; Хээрийн улаан харганат; Бунгийн харганат
	Цөлийн хээрийн дэд хэвшинж: 9 хэвшил	Говийн хялганат; Сайрын хялганат; Таанат; Улаан харганат; Коржинскийн харганат; Орог тэсэгт; Шаргал шарилжит; Элсний шарилжит; Шарилжит

Монгол орны өнөөгийн ургамлын аймаг уугуул нутаг дээрээ бүрэлдэн тогтсон, өөрийн гэх өвөрмөц онцлогтой шим ертөнц гэдэг нь улам бүр батлагдсаар байна. Энэ нь эн тэргүүнээ газарзүй, бүс бүслүүрийн байршил, экологи-газарзүйн нөхцөл, цаг уурын байдлаас шууд хамаарал бүхий ургамлын аймгийн иж бүрдэл юм.


**Хүснэгт 5.3.** Гуурст ургамлын хамгааллын бүлгүүдийн зүйлийн бүрдэл, эзлэх хувь (Ургамал нар, 2017)

Ургамлын ховордлын зэрэглэл	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйлийн тоо	Эзлэх хувь
Монгол Улсын Улаан ном (2013)-д орсон ургамал	49	103	135	4.27
Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын хавсралтад орсон ургамал	2	6	8	0.25
Ургамлын Улаан дансанд (2011) орсон ургамал	53	116	148	4.68
Устсан (EX)	-	-	-	-
Байгальд устсан (EW)	-	-	-	-
Бүс нутгийн хэмжээнд устсан (RE)	-	-	-	-
Устаж байгаа (CR)	10	14	16	0.51
Устаж болзошгүй (EN)	22	35	39	1.24
Эмзэг (VU)	27	50	55	1.74
Ховордож болзошгүй (NT)	15	21	23	0.72
Анхааралд өртөхөөргүй (LC)	10	10	10	0.31
Мэдээлэл дутмаг (DD)	3	4	4	0.12
Үнэлэх боломжгүй (NA)	1	1	1	0.03

Гуурст ургамлын хувьд 1 овгийн 1 төрөлд багтах 1 зүйл (*Lycopodium clavatum*) шивэрс хэлбэртэн, 2 овгийн 2 төрөлд хамаарах 2 зүйл (*Dryopteris dilitata*, *Botrychium lanceolatum*) ойм хэлбэртэн, 1 овгийн 3 төрөлд багтах 3 зүйл (*Abies sibirica*, *Larix dahurica*, *Pinus pumila*) нүцгэн үртэн, 45 овгийн 97 төрөлд багтах 129 зүйл цэцэгт дээд ургамал Монгол Улсын Улаан ном (2013)-д орсон ба эдгээрийн дотор унаган 24 зүйл, нэн ховор 48 зүйл, ховор 81 зүйл, үлдэц (үйлдвэр) 12 зүйл тус тус багтсан байна.

Доод ба спор бүхий дээд ургамлаас Монгол Улсын Улаан ном (2013)-д 7 овгийн 12 төрөлд багтах 12 зүйл мөөг, 15 овогт хамаарах 18 төрөлд хамаарах 18 зүйл замаг, 10 овгийн 10 төрөлд багтах 15 зүйл хаг, 7 овгийн 12 төрөлд багтах 12 зүйл хөвд орсноос унаган 3 зүйл (*Cladonia mongolica*, *Tonina gobica*, *Tricholoma mongolica*), нэн ховор 4 зүйл (*Aspicillia esculenta*, *Cladonia mongolica*, *Nostoc flagelliforme*, *Tonina gobica*), ховор 53 зүйлийг багтаажээ.

**Зураг 5.9.** Монгол орны гуурст ургамлын хамгааллын бүлгүүд, тэдгээрийн эзлэх хувь



**Хүснэгт 5.4.** Монгол Улсын Улаан ном (2013)-д орсон ургамал, тэдгээрийн зүйлийн тоо, статус

Ургамлын бүлгүүд	Овгийн	Төрлийн	Зүйлийн	Статус			
	Тоо	тоо	тоо	Унаган	Нэн ховор	Ховор	Үлдэц
Доод ургамал, бүгд	39	52	57	3	4	53	0
Мөөг	7	12	12	1	0	12	0
Замаг	15	18	18	0	1	17	0
Хаг	10	10	15	2	3	12	0
Хөвд	7	12	12	0	0	12	0
Дээд ургамал, бүгд	49	103	135	24	48	81	12
Шивэрс хэлбэртэн	1	1	1	0	1	0	0
Ойм хэлбэртэн	2	2	2	0	2	0	0
Нүцгэн үртэн	1	3	3	0	2	1	0
Далд үртэн	45	97	129	24	43	80	0
Улаан номд орсон нийт	88	155	192	26	52	134	12

## 5.4.2. Монгол орны амьтны аймгийн судалгааны тойм

**Амьтны аймаг.** Амьтны тархалтын газарзүй онцлогийг П.К. Козлов (1899-1926), Г.Е. Грумм Гржимайло, В.В. Сапожников, П.П. Сушкин нар Монгол Алтай, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Ховд, Баруун нууруудын хотгор, Увс нуур, Тувагийн нутгаар хийсэн хөхтөн амьтдын судалгааны явцад анх судалсан бөгөөд Монголын зоогеографийн анхны хуваарийг П.П. Сушкин 1930 онд үйлдсэн байдаг (Батчулуун, 2021).

Монгол орны амьтдын төрөл зүйлийн тоо, тархалтын хүрээ зэрэгт уур амьсгалын онцлог, нөхцөл хамгийн гол нөлөө үзүүлнэ. Жишээ нь, өвлийн улиралд цасан бүрхүүл нимгэн байх нь туурайтанд таатай. Цас бага, агаар эрс хүйтэн байдаг нь шавж идэштний тархалтад сөрөг нөлөөтэй тул төдийлөн элбэг бус. Уур амьсгалын хүчин зүйл мэрэгч амьтдын тархалтад багагүй нөлөө үзүүлдэг ажээ. Физик-газарзүйн онцлог, нөхцөлөөс хамаарч Монгол оронд ялангуяа, говь, хээрийн бүсэд эндемик амьтан ховор тархах ба голдуу хөрш зэргэлдээ нутгаас нэвтрэн ирсэн төрөл зүйл бүхий янз бүрийн үед бүрэлдэн тогтсон амьтад голлоно. Амьтдын төрөл, зүйл нь ландшафтын янз бүрийн хэв шинжээс хамааран өөр өөр байх ба говь, цөлийн бүсэд амьтдын бүрэлдэхүүнд элсний шижүүхэй, соотон алагдаахай зэрэг Төв Азийн ууган амьтад нэн элбэг болно (Амгалан, Лхагвасүрэн, 2017).

**Хөхтөн.** Монгол оронд 8 баг, 25 овог, 84 төрөлд хамаарах 145 зүйл хөхтөн бий. Тэдгээрийн дотор зарааны 2, атаахайн 11, гар далавчтаны 20, туулай хэлбэртний 7, мэрэгчдийн 66, махчдын 25, битүү туурайтны 2, салаа туруутны 12 зүйл амьдрах (Батсайхан нар, 2022) ба эдгээрийн дотроос мэрэгчид хамгийн их буюу 45.5% орчмыг эзэлдэг бол мах идэштэн 17.2%, гар далавчтан 13.8%-ийг тус тус эзэлдэг болно. Эдгээрийн дотор хязгаарлагдмал тархалттай, цөөн тоотой, нэн ховор, ховор олон зүйлийн амьтад бий.

Дэлхий дээр тархац нутаг, тоо толгойн хувьд элбэг тохиолддог тал хээрийн зэрлэг туруутны хамгийн сүүлчийн их сүргийн байршил нутаг нь Монголын Дорнод талын хялганат хээр юм. Энэхүү экосистемийг хамгаалах зорилгоор Дорнод Монголын тусгай хамгаалалтай газар нутгуудын сүлжээг хамгаалалтын захиргаатай хамтран байгуулсан байна.

Говийн Их дархан цаазат газар нь дэлхийд ховордож, олон улсын болон Монгол Улсын Улаан номд орсон мазаалай баавгай, хавтгай, хулан, хар сүүлт зээр, ирвэс, аргаль, янгир зэрэг ан амьтны өлгий нутаг бөгөөд Төв Азийн говь цөлийн эмзэг экосистемийг хамгаалах зорилгоор 1975 онд “А”, “Б” гэсэн үндсэн хоёр хэсэгтэйгээр байгуулагдсан байна.

Монгол адууны өвөг, манай орны унаган амьтдын нэг болох тахийг Говийн Их дархан газрын “Б” хэсэг, Хустайн нуруу болон Хомын талын байгалийн цогцолборт газруудад өсгөн үржүүлж байгаа бөгөөд тахь сэргээн нутагшуулах, тус газрын хамгаалалтын ажлыг удирдлагаар хангах, санхүүжүүлэх ажиллагааг 1999 оноос эхлэн Швейцар улсад төвтэй “Олон улсын тахь групп”, Голландын Засгийн газар, Чех улсын Прагийн Амьтны хүрээлэн зэрэг гадаадын төрийн болон төрийн бус олон байгууллагууд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

**Шувуу.** Монгол оронд шувууны ангид хамаарах 23 баг, 70 овог, 237 төрлийн 519 зүйл шувуу бүртгэгдсэн байна (Гомбобаатар нар, 2019). Эдгээрээс 80-аад зүйл нь суурин, 370 гаруй зүйл нь хавар, намрын улиралд нүүдэллэх ба 9 зүйл тус нутагт өндөглөлгүй зөвхөн зусдаг, 50 шахам зүйл манай нутгийг нүүдлийн хугацаандаа дайрч өнгөрдөг, 10 зүйл нь өвлийн улиралд ирж өвөлждөг ажээ.

Монгол Улсын Улаан ном (2013)-д борцгор хотон, цагаан тогоруу, цагаан толгойт ямаан сүүл, могойч загалай, бор бүргэд, усны нөмрөг бүргэд, реликт цахлай, бахим хошуут хургач бор, одой галуу, байгалийн нугас, ундар шумбуур, цэн тогоруу, хар тогоруу, хан бүргэд, ооч ёл, азийн цууцил, монгол хулан жороо, хонин тоодог, жороо тоодгой, усны бух шувуу, бичил одой бух, зээрд дэглий, манхин галуу, хуруут хун, хархираа тогоруу, цагаан сүүлт нөмрөг бүргэд, алтайн хойлог, зэрлэг гургуул, ойн шийхнүүхэй, загийн бор шувуу, шагшуургын шатан сүүлт, өгөөлэй шулганаа, наран хөмрөг, шар элэгт хөмрөг зэрэг 35 зүйл шувууд оржээ.

**Мөлхөгчид.** Монгол оронд хоёр салбар баг, 7 овгийн 24 зүйлийн мөлхөгчид бүртгэгдээд байна. Монгол орны мөлхөгчдийн зүйлийн баялаг бүс нутгаар харилцан адилгүй бөгөөд дийлэнх нь өмнөд болон баруун өмнөд бүс нутгаар тархан амьдардаг. Баруун Хангайн нуруу, Их нуурын хотгорын бүс нутагт мөлхөгчдийн зүйлийн баялаг төдийлөн өндөр бус. Харин Алтайн өвөр говь, Говийн Алтайн нуруу, Алашаа болон Дорнод говийн бүс нутагт мөлхөгчдийн зүйлийн баялаг илүү өндөр байдаг.

Монгол орны Улаан дансанд эмзэг, ховордож болзошгүй болон мэдээлэл дутмаг зэрэглэлээр үнэлэгдсэн говийн махир хуруут гүрвэл, нохой гүрвэл, толбот гүрвэл, тэмээн сүүл могой, нарийн могой, эгэл загалмайт могой зэрэг 6 зүйлийн мөлхөгчдийг Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэн, хамгаалалтад авсан байна.

#### **Зураг 5.10.** Монгол орны зарим зүйл мөлхөгчид



Говийн махир хуруут гүрвэл



Нохой гүрвэл



Зүүнгарын могой гүрвэл



Тэмээн сүүл могой



Эгэл загалмайт могой

**Хоёр нутагтан.** Монгол оронд сүүлтэй хоёр нутагтны баг, гүлмэрийн овгийн 1 зүйл, сүүлгүй хоёр нутагтны баг, бахын овгийн 2, модны мэлхийн овгийн 1, өвсний мэлхийн овгийн 3, нийт 7 зүйл хоёр нутагтан идээшин амьдарна.

Хоёр нутагтны ихэнх зүйл Монгол орны хойд болон зүүн хойд бүс нутаг тухайлбал, Хангайн нуруу, Хөвсгөлийн уулс, Монгол Дагуур, Төв Халх, Дорнод Монголын тал хээр нутаг, Хянганы уулсаар тархан амьдарна. Хэнтийн нуруу, Сэлэнгийн сав нутагт хоёр нутагтны зүйлийн олон

янз байдал илүү өндөр ажээ. Эдгээр бүс нутагт шивэр гүлмэр, модны мэлхий, шивэр мэлхий, шөвгөр мэлхий, дорнодын мэлхий, монгол бах зэрэг 6 зүйлийн хоёр нутагтан бий.

Харин Зүүнгарын бах нь зөвхөн Ховдын Булган голын сав, Баруун говийн ус, намгархаг нутгаар тохиолдоно. Монгол Улсын Улаан номд шивэр гүлмэр, модны мэлхий, Зүүнгарын бах, Дорнодын мэлхий гэсэн 4 зүйлийн хоёр нутагтныг ховор амьтнаар бүртгэжээ. Мөн эдгээр зүйлүүдийг Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад оруулан, хамгаалалтад авсан байна.

**Зураг 5.11. Монгол орны хоёр нутагтны зарим төлөөлөгчид**




Шивэр гүлмэр



Модны мэлхий



A



B

Зүүнгарын бах (А-Эр, В-Эм)



Шөвгөр мэлхий

**Загас.** Манай орны гол мөрөн, цэнгэг болон давст нуурт 8 баг, 1 дэд баг, 15 овгийн 47 төрөлд хамаарах 78 зүйлийн загас амьдардаг. Номхон далайн ай савын усан сангууд загасны зүйлээр баялаг, энд хар мөрний хилэм, булуу цагаан, улаан живэрт, өлгөр цагаан, морин загас зэрэг 48 зүйл, Хойд мөсөн далайн ай савын усан сангуудад Байгалын хилэм, тул, зэвэг, цурхай, алгана, дархадын цагаан, гутаарь зэрэг 37 зүйл, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд Монгол хадран, Алтайн сугас, нүцгэн жараа зэрэг 16 зүйл загас бий. Монгол хадран, Алтайн сугас нь Төв Ази, Монголын унаган загаснууд ажээ (Баасанжав, 2001).

**Шавж.** Өдгөө Монгол орны амьтны аймагт 28 баг, 370 овог, 3200 гаруй төрлийн 130,00 зүйл шавж бүртгэгджээ. Эдгээрийн дотор 3100 гаруй зүйлийн хатуу далавчтан (элдэв цох), 2500-аас цөөнгүй зүйлийн хос далавчтан (ялаа, шумуул), 2300 гаруй зүйлийн сарьсан далавчтан (зөгий, шоргоолж), 1650 гаруй зүйлийн хайрсан далавчтан (өдрийн ба шөнийн амьдралтай элдэв зүйлийн эрвээхэй), 1000 гаруй зүйлийн ижил далавчтан, 170 гаруй зүйлийн шулуун далавчтан (царцаа, дэвхрэг, голио), 70-аад зүйлийн соно тус тус бүртгэгдсэн байна. Шавжийн бүрдэл дотор Төв Азийн уугуул зүйл нэн олноос гадна, уугуул овог, төрөл ч цөөнгүй бий (Адъяа нар, 2016). Хээрийн бүсийн шавжийн аймаг хамгийн олон төрөл, зүйлтэй ба бэлчээр ялангуяа, тариаланд хор хөнөөл учруулж болох сибирийн царцаа, бараан далавчит царцаа, бор туруут царцаа, түүнчлэн голио элбэг.

## Бүлгийн дүгнэлт

Монгол орны гуурст ургамлын аймагт унаган ургамал 120 зүйл, завсрын унаган 495 зүйл, нэн ховор 133 зүйл, ховор 356 зүйл, харь ургамал 51 зүйл, хөл газрын 438 зүйл, усны ургамал 169 зүйл, үлдэц (үлдвэр) ургамал 70 зүйл, зэрлэгшиж буй таримал 47 зүйл, Улаан номд (2013) орсон 135 зүйл, Улаан дансанд (2011) орсон 148 зүйл, CITES-ийн хавсралтад орсон 8 зүйл тус тус байдаг.

Ховордож буй ургамал, амьтдыг хамгаалах нь бидний амьдралын орчинд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ховордож буй ургамал амьтдыг хамгаалах нь зөвхөн тухайн төрөл зүйлийн амьдралын чанарыг сайжруулах төдийгүй дэлхийн экологийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Ургамал болон амьтныг хамгаалахын тулд олон улсын хамгаалалтын стандартуудыг мөрдөх, байгаль орчинд ээлтэй газар тариалан, уул уурхай, ойн менежментийг хөгжүүлэх шаардлагатай.

## 5.5 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ГАЗАРЗҮЙН ТОГТОЦ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ТҮҮХ, СОЁЛ

### 5.5.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ойлголт

Тодорхой хэсэг нутгийг хамгаалалтад авах замаар байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалах явдал дэлхий нийтийн хэмжээнд байгаль хамгааллын сонгодог хэлбэр болж байна. Байгаль орчныг хамгаалах олон талтай, өргөн хүрээтэй арга хэмжээний нэг нь газар орныг хамгаалалтад авах явдал юм. Орчин үед хүний аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр их хэмжээний нутаг дэвсгэр доройтолд орж ялангуяа, хүн ам нягт суурьшсан газруудад байгалийн унаган ландшафт бараг үлдээгүй байна. Ийм учраас дэлхийн олон улс оронд байгалийн уугуул төрхийг хэвээр хадгалах, нөхөн сэргээх ажлыг тусгай хамгаалалтын горимтой нөхцөлд хэрэгжүүлэхээс өөр аргагүйд хүрчээ.

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-оос тусгай хамгаалалттай газар нутгийг “Байгалийн ба соёлын өв, биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалахад зориулан хуулийн хүрээнд хамгаалагдсан далай тэнгис ба хуурай газрын хэсэг нутаг юм” хэмээн тодорхойлсон байдаг.

Тусгай хамгаалалттай газар нутагт хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд аж ахуйн эргэлтээс бүрмөсөн буюу түр хугацаагаар чөлөөлөгдсөн, шинжлэх ухаан, түүх, соёл, гоо сайхны ач холбогдол бүхий газрууд багтах бөгөөд энэ нь хуурай газрын шим мандлын салшгүй хэсэг мөн. Түүнчлэн *“Тухайн газар нутаг дахь биологийн олон янз байдал, байгалийн нөөц, баялаг болон түүх, соёлын дурсгалт зүйлсийг зөв зохистой ашиглах, хамгаалах асуудал нь тусгайлан гаргасан хууль тогтоомж ба менежментийн үр ашигтай зохион байгуулалтаар зохицуулагдаж буй газар нутгийг тусгай хамгаалалттай газар нутаг гэнэ”* хэмээн тодорхойлжээ (Энэ тодорхойлолтыг Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-оос 1992 оны 2-р сард Венесуэлийн нийслэл Каракас хотод зохион байгуулсан “Үндэсний парк ба тусгай хамгаалалттай газар нутаг” сэдэвтэй Дэлхийн олон улсын 4 дүгээр чуулганаас батлан гаргасан байна).

Хамгаалалтад авч буй газруудыг дэлхийн улс орнуудад 170 орчим янзаар нэрлэх бөгөөд тэдгээр нь улс орон бүрийн, заримдаа тухайн бүс нутгийн онцлогийг хадгалсан байдаг. Иймээс тусгай хамгаалалттай газруудын ангилал, үүрэг зорилго, ач холбогдол, ашиглалт, хамгаалалтын горим улс орон бүхэнд харилцан адилгүй байна.

Хамгаалалттай газар нутагт явуулж байгаа бүхий л үйл ажиллагаа нь хойч үеийнхээ төлөө, биологийн олон янз байдал, байгалийн унаган төрхийг хамгаалахад дэлхийн улс орнуудын оруулж буй томоохон хөрөнгө оруулалт юм. Хамгаалалттай газар нутгийн олонх нь бүс нутгийнхны хувьд ач холбогдолтой ялангуяа, нутгийн уугуул иргэдийн амьжиргаа болон байгалийн нөөцийн тогтвортой нийлүүлэлтэд нөлөөлж, хүмүүст дэлхий ертөнц дээр амар тайван байх урам зориг өгч уриалан дуудсан газар болдог. Хамгаалалттай газар нутаг нь соёлын чухал үнэ цэнийг илтгэдэг. Тэдгээрийн зарим нь тогтвортой газар ашиглалтын туршлага болдог. Мөн түүнчлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, судалгааны ажилд чухал ач холбогдолтой төдийгүй бүс нутгийн эдийн засагт аялал жуулчлалыг хөгжүүлснээр жинтэй хувь нэмэр оруулж байна. Биологийн олон янз байдлыг хамгаалахад тусгай хамгаалалттай газар нутаг онцгой ач холбогдолтой.

Дэлхий дээр 2000 оны байдлаар 30,000 гаруй хамгаалалттай газар нийт 13,250,000 км<sup>2</sup> талбайг (Хятад болон Энэтхэгийн газар нутгийг нийлүүлсэнтэй тэнцэх хэмжээний) эзлэн оршиж байна. Эдгээрээс 500 сая га талбай бүхий 4500 газар I-III ангилалд, 348 сая га талбай бүхий 5900 газар IV-VI ангилалд орж байна. Эдгээр нь манай гаригийн нийт талбайн дөнгөж 6%-ийг эзлэх бөгөөд үүний 4%-ийг дархан газар, байгалийн цогцолборт газар, нөөц газрууд эзэлдэг байна. Далай тэнгисийн маш бага хэсэг (1%) нь хамгаалагдсан (<http://www.iucn.org/themes/wspa/protectedareas.htm>) бөгөөд цаашид загасны нөөц баялгийг хамгаалах, загас агнуурын тогтвортой менежментийг хангах зорилгоор 20% хүртэл хамгаалалтад авах зорилго тавьжээ.

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-оос гаргасан ангиллаар авч үзвэл, дэлхийн хэмжээнд дархан цаазат газар 5,201, байгалийн цогцолбор газар 11,169, хамгаалалттай ландшафт 5,578, нөөцийг зохицуулалттай ашиглах газар 2,897 байна. Улс орон бүрийн тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал өөр өөр учраас тэдгээрийг нэгтгэн дүгнэхэд багагүй бэрхшээл учирдаг байна. Тухайлбал, АНУ, Австралид 30 ялгавартай, Канадад 20, Англид 10 ялгавартай ангилал тус тус байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн нийт талбайг ангилал тус бүрээр нь авч үзвэл, байгалийн цогцолборт газар, нөөцийг зохицуулалттай ашиглах газар хоёр хамгийн их талбайг эзэлдэг ажээ. Дэлхийн хамгийн том тусгай хамгаалалттай газар болох Дани улсын Гренландын байгалийн цогцолборт газар 70 сая га талбайг хамрах бол манай орны Говийн Их дархан газар дэлхийд 15-р байрт орно.

### 5.5.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн олон улсын ангилал

Хамгаалалттай нутаг дэвсгэрийн статусыг 1940 онд Вашингтоны конвенцоос анх томъёолон гаргажээ. Дэлхийн улс орнуудад хамгаалалттай нутаг дэвсгэрийн олон янзын ангилал хэрэглэгдэж байгаа бөгөөд эдгээр ангиллуудыг үндэслэн 1978 онд Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-оос хамгийн түгээмэл, тодорхой үйл ажиллагаа явуулдаг 10 ялгавартай ангиллыг олон улсын хэмжээнд хэрэглэж болох юм хэмээн үзээд албан ёсны ангилал болгосон байна. Энэхүү ангиллаар 1) Дархан цаазат газар, 2) Байгалийн цогцолборт газар, 3) Дурсгалт газар, 4) Зохицуулалттай байгалийн нөөц газар, 5) Хамгаалалттай ландшафт, 6) Байгалийн нөөц газар, 7) Антропологийн нөөц газар, 8) Байгалийн иж бүрдлийг хамгаалах нөөц газар, 9) Шим мандлын дархан газар, 10) Дэлхийн өвд орох газар гэсэн ялгавруудыг тогтоожээ.

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-оос Олон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн жагсаалтыг гаргахдаа дээр дурдсан бүх газруудыг нэгтгэж байв. Сүүлийн үед Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), Мониторингийн төвөөс хамтран боловсруулсан тусгай хамгаалалттай газар нутгийн шинэ ангиллыг олон улсын түвшинд мөрдөх болсон (IUCN, 1998). Үүнд:

- Хатуу хамгаалалтай дархан цаазат газар (Strict protection)
- Байгалийн цогцолборт газар (National Park)
- Байгалийн дурсгалт газар (Natural Monument)
- Биологийн төрөл зүйл, амьдрах орчныг хамгаалах газар (Habitat/Species Management Area)
- Хамгаалалттай ландшафт (Protected Landscape)
- Нөөц газар (Managed Resource Protected Area) гэсэн 6 ялгавартай ангиллыг тогтоожээ.

Энэ ангиллын дархан цаазаттай газар нь дотроо дархан цаазат газар (1а), онгон эзлүүд газар (1б) гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Хамгаалалттай газруудын ангиллыг нэрээр нь бус I, II, III гэх мэт дугаараар нь тэмдэглэх (IUCN, 1998) явдал түгээмэл болжээ (Хүснэгт 5.5). Эдгээр ангилалд багтах газрууд нь үүрэг зорилго, хамгаалалтын горимын хувьд хоорондоо ялгаатай ([www.gov.na.ca/en/la/pareas/what isa.htm](http://www.gov.na.ca/en/la/pareas/what%20isa.htm)).

**Хүснэгт 5.5.** Олон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, тодорхойлолт (Оюунгэрэл, 2004)

Ангилал	Нэр	Тодорхойлолт
I a	Хатуу хамгаалалттай дархан цаазат газар (Strict Nature Reserve): судалгаа шинжилгээ явуулах зорилготой тусгай хамгаалалттай газар	Хуурай газар болон далай бүсүүдэд орших онцлог экосистем, биологийн төрөл зүйл бүхий мөнхийн загвар нутаг
I б	Зэрлэг онгон газар (Wilderness Area): Зэрлэг онгон нутгийг хамгаалахад зориулсан тусгай хамгаалалттай газар	Байгалийн унаган төрхөө алдаагүй томоохон бүс нутаг, далай тэнгисийн хэсгийг хэвээр нь хадгалах зорилгоор хамгаалалтад авсан газар
II	Байгалийн цогцолборт газар (National Park): экосистемийг хамгаалах болон аялал жуулчлалд зориулсан тусгай хамгаалалттай газар	Хуурай газрын болон далай тэнгисийн экосистем, алдралд орсон газар нутгийг сэргээх болон хэт ашиглалтаас хамгаалах, шинжлэх ухаан, боловсрол, аялал жуулчлалд зориулан хамгаалалтад авсан газар
III	Байгалийн дурсгалт газар (Natural Monument): байгалийн өвөрмөц төрх байдлыг хамгаалах зорилготой тусгай хамгаалалттай газар	Ховор болон өвөрмөц тогтоц бүхий байгаль, соёлын онцгой дурсгал, мөн гоо зүйн болон соёлын ач холбогдлыг агуулж буй бүс нутаг
IV	Амьдрах орчин (Байгалийн төрөл зүйлийг хамгаалах менежментийн бүс Habitat) (species management area)	Тодорхой биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах, идэвхтэй менежмент хийлгэх зорилгоор хамгаалалтад авсан хуурай газар, далай тэнгисийн бүс нутаг. Ерөнхийдөө хөндлөнгийн оролцоотой менежментээр хамгаалагдахаар зохицуулагдсан тусгай хамгаалалттай газар
V	Хамгаалалттай ландшафт (Protected landscape Seascape) хуурай газар болон далай тэнгисийн ландшафтыг хамгаалах зорилготой тусгай хамгаалалттай газар	Хуурай газар, далай тэнгис, эрэг орчмын нутгийг хамрах бөгөөд биологийн төрөл зүйлийг хамгаалах, хүн, байгалийн харилцан шүтэлцээг дэмжих, экологи, соёл, гоо зүйн ач холбогдолтой тусгай хамгаалалттай газар нутаг
VI	Нөөц газар (Managed Resource Protected Area): Байгалийн экосистем, нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах зорилготой тусгай хамгаалалттай газар.	Байгалийн нөөцийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах зорилготой байгалийн хувиралгүй экосистемийг зонхилон багтаасан газар нутаг

ТАВДУГААР БҮЛЭГ

### 5.5.3. Газар нутгийг дархлан хамгаалж ирсэн түүхийн тойм

Хүн төрөлхтөн хөгжлийнхөө түүхэн урт хугацааны явцад дэлхийн ургамал, амьтан, ашигт малтмалыг маш ихээр ашиглан ховордуулж, байгаль орчноо их хэмжээгээр бохирдуулж, сөрөг нөлөө үзүүлсээр иржээ. Сүүлийн 400 жилд дэлхийн ой модны гуравны хоёр хувийг, 400 зүйлийн ан амьтныг бүрмөсөн устгаж, 600 зүйл амьтныг асар ихээр цөөрүүлснийг шинжлэх ухаан батлаад байна.

Дэлхийн улс орнууд байгалийн баялгаа хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хүрээлэн буй орчноо цэвэр ариун байлгах талаар байнга анхаарч байдаг билээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд байгаль орчин, ховор амьтан, ой, ургамлаа зэргээ хамгаалахын тулд зөвхөн тухайн улс дангаараа зүтгээд байхгүй хил залгаа улсуудтайгаа, цаашилбал дэлхий нийтээрээ хамтран ажиллах болсон. Байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүрээлэн буй орчноо цэвэр ариун байлгах, зохистой ашиглах зэргээр байгаль хамгаалах ажлыг өргөн хүрээтэй явуулж байгаагийн нэг өвөрмөц хэлбэр нь газар нутгаа дархлан хамгаалах явдал юм. Аливаа орны байгаль хамгаалах төрийн бодлогын цөмд нь тусгай хамгаалалтад авсан газар нутгийн асуудал орж, дэлхий нийтийн хэмжээнд улс орны байгаль, соёлын өвийг хадгалан хамгаалах хамгийн зохистой хэлбэр болжээ. Манай улсын тогтвортой хөгжил, экологийн аюулгүй байдлыг бүрдүүлэх үндэс нь байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах явдал мөн.

Монгол орны байгалийн унаган төрхийг үеийн үед хадгалан хамгаалах, биологийн төрөл зүйлийг болон байгаль, түүх, соёлын дурсгал бүхий газар нутгийг хамгаалалтад авах явдал чухлаар шаардагдаж байсан бөгөөд одоо ч шаардагдсаар байна. Монголчууд ан амьтан, байгаль орчноо хамгаалдаг өнө эртний түүхтэй билээ. Газар нутаг, уул усаа дархлан хамгаалах ажил бүр эрт дээр үеэс улбаалан ирсэн бөгөөд энэ түүхийг 3 үед ангилан хувааж үзэж болох юм (Оюунгэрэл, 2004).

**I үе шат буюу хувьсгалын өмнөх үеэс 1921 он хүртэлх үе.** Манай ард түмэн байгалиа хамгаалж, зөв харьцаж ирсэн эртний сайхан уламжлалтай. Өнөө бидний үед бичиж, уншиж, ярьж заншаад буй тусгай хамгаалалттай газар нутгийн угшил нь эрт цагт амьдрал тэтгэсэн, ариун дагшин аглаг уулсыг онголж дархлан тайж тахьдаг арга хэлбэр байв. Бичигдмэл эх сурвалжийн охь дээд нь болсон Монголын нууц товчоонд Хэрэйд аймгийн Ван хан Тоорил XII зуунд Туулын хар түнгэ (шугуйд)-д өвөлжиж ахуйдаа өмнө этгээдийн их ууланд ан ав хийх, гал хөс түлэхийг хатуу цаазлан хориглож байсан мэдээ үлдсэн нь өнөөгийн Богдхан уулыг тухайн үед дархалж онголсны нотолгоо мөн.

Оросын эрдэмтэн И.Д. Лаптев энэ талаар бичихдээ “Монголчууд байгальтай харьцаж талаар Европчуудаас олон зуун жилээр түрүүлсэн байна ... Хубилай хааны хуулиудын тухай хадгалагдаж үлдсэн мэдээ үүнийг нотолж байна” гэжээ. Түүнчлэн XIII зууны үед Монголд ирж байсан Гильом де Рубрук, Плано Карпини, Марко Поло зэрэг жуулчдын аян замын тэмдэглэлд тэр үеийн Монголчууд газар дэлхий, уул ус, ургамал амьтан, жигүүртэн шувуудыг хайрлан хамгаалж байсан тухай эртний сонин баримт үлдээжээ. Тухайлбал, Марко Поло “... Монголд өртөө замын хоёр хажуугаар мод тарьсан тул зуны цагт нар шарахгүй сүүдэртэй, өвлийн цагт цас дарчихвал ээрэм талд зам алдан төөрөхгүй таатай юм... Жил бүр 3-р сараас 10-р сар хүртэл туулай, буга, бор гөрөөс, цагаан зээр, хар сүүлт зэрэг ан гөрөөсний үржих цагт нь хаан, ван, эрхтэн, дархтан ямар ч хүн ан агнах эрхгүй. Туулай, буга, согоо, бөхөн, зээр агнах тусгай тогтсон хугацаатай гэсэн хууль Монголд байх юм” гэх мэтээр тэмдэглэсэн байна. Эндээс үзвэл, Монголчуудын байгаль, ан амьтнаа хамгаалж ирсэн уламжлал нь эртний улбаатай бөгөөд энэ нь Чингисийн “Их засаг” хууль, XVI зууны үеийн хууль цаазын бичиг “Халх журам” зэрэгт ч тусгалаа олж байжээ. Тухайлбал, “Халх журам” хуульд Богдхан уул, Хан Хэнтий, Хөгнө Хан,

Зоргол, Суман улаан, Төвхөн Хаан зэрэг гоо үзэсгэлэнт 16 уулыг дархлан тэдгээрт ан гөрөө хийх, газар малтах, мод бэлтгэх зэрэг үйл ажиллагааг албан ёсоор хориглож байжээ.

1778 онд тэр үеийн Монголын тэргүүний сэхээтний нэг сайд Юндэндоржийн санаачилга, хичээл зүтгэлийн үр дүнд Манжийн хааны зарлигаар 1778 оноос Богдхан уул, 1779 оноос Хэнтий Хан уул, 1818 оноос Отгонтэнгэр уулыг тус тус онголон, тайж тахиx болжээ. 1809 оноос Богдхан уулын 28 амыг тусгайлан хамгаалах цагдаатай болгосон бол 1911 онд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн Богд хаант Монгол Улсыг тунхагласны дараахан 1912 онд ариун дагшин энэ уулыг хамгаалах захиргааг байгуулж, энэ нутаг дэвсгэрт орох зөвшөөрлийг Богд эзэн хаан гардан олгодог хүртэл дэг журам тогтоож байжээ. 1808 онд Их хүрээгээр дайрч өнгөрсөн Оросын жуулчин С. Грибовский “хэдийгээр энэ уул хамгийн сайхан модтой ч дархан цаазтай болохоор зомгол ч авдаггүй юм байна” гэж тэмдэглэсэн байдаг.

Эдгээр цухас дурдсан баримт болон түүхийн бусад эх сурвалжид бичсэнээс үзвэл, Монголын төр, Монголчууд Богдхан уулыг бүр XII зуунаас эхлэн олон зууны турш үе улиран дархлан цаазалж, цагдан хамгаалж ирсэн нь тодорхой ажээ. Ийм ч учраас газар нутгийг тусгай хамгаалалтад авч хамгаалсан хүн төрөлхтний түүхийн эхлэлийг XII зуунаар, уулын амыг тусгайлан хамгаалах цагдаатай болгосон 1809 оныг анхны байгаль хамгаалагчид томилогдсон тооллын эхлэл, уулыг хамгаалах захиргаа байгуулагдсан 1912 оныг анхны хамгаалалтын захиргаа байгуулагдсан эх хэмээн үзэх бүрэн үндэстэй байна.

**II үе буюу 1921-1990 он.** 1921 онд Ардын хувьсгал ялмагц Ардын засгийн газраас дархан цаазтай газрын хамгаалалтыг улам чангатгах, ховор ан амьтан болон байгаль хамгаалах талаар арга хэмжээ авч, тогтоол, шийдвэр, дүрэм заавар удаа дараа гарган мөрдүүлж байв. 1923 онд гаргасан “Монгол улсын уурхайн дүрмийн 1 ба 2 дугаар зүйлд дархан газрыг чандлан хамгаалах” тухай зааж, улмаар 1924 онд ангийн хууль гарган дагаж мөрдүүлжээ. 1925 онд “Монгол улсын хязгаарын доторх ой мод, газрыг захирах дүрэм” гаргаж, Богд уулын дархалж цаазалсан газрыг хэсэг хэсгээр хуваан хнххязгаарлах ба мөн газрын модыг үнэ тогтоож үл болохоос гадна, их, багын зэргээр нэг буюу хэдэн эргүүл цагдаатай байлгана. Цааз бүхий ой модыг ашиглах хэмээвээс Засгийн газрын зөвшөөрлөөр болох ба унасан хийгээд хатсан босоо модыг зайлуулах, гал түймэр унтраах хэргээр цаазтай орж гарч болно гэж заасан байдаг. Энэ нь Ардын засгийн газраас газар нутгийг дархлан хамгаалах ажлыг шинэ нөхцөлд бататгасан хэрэг байв.

1925 онд хэвлэгдсэн Ж.Цэвээний “Монголын дархан сүлд цаазтай газруудын учир” хэмээх номд “Монголд маш эртнээс нааш дархалж ирсэн уул, ус олон байгааг хянавал, эрхбиш нийтийн эрх ашиг тусын тулд усны эхийг цэвэр ариун авч байх, ус булгийн ундарга багасахаас хамгаалах, ой модыг хамгаалах, ан амьтан гөрөөсний үр төлийг үл таслах, элс шуурах явдлыг тогтоох, газрын хөрс шороо гэмтээж үржилгүй болгох зэрэг хор хөнөөлөөс хамгаалагдсан мэргэн арга мөн” гэжээ.

1926 онд тахь, хуланг дархлан цаазалснаас гадна, 1930-1932 онд тус улсын нутаг дэвсгэр дэх бүх анг журамтай агнах, хамгаалах тухай тогтоол гаргаж 20 гаруй зүйлийн ан амьтныг дархалжээ. 1944 онд ан агнах, загас барих тухай хуулийг баталж, загас болон ан гөрөөсийг журамтай агнах, хугацааг нарийвчлан тогтоох, ховор амьтдыг хамгаалах, өсгөх талаар нэн чухал арга хэмжээ авсан байна.

1953 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 52 дугаар зарлигаар ховор ан амьтан, жигүүртэн шувууг хамгаалах, булга, халиу, заарт харх, суусар, минж, илбэнх, хүдэр, тахь, хулан, хавтгай, мазаалай, цаа гөрөөс, бөхөн, буга, согоо, аргаль, янгир, хандгай, хун,

хойлог, хотон, алтан гургуул зэрэг 21 зүйлийн амьтан агнахыг бүрмөсөн цаазлан хоригложээ (Намнандорж, 1976). Энэ үеэс хойш дархан газрын хамгаалалтыг чангатгах, шинэ дархан газрууд байгуулах талаар дэс дараатай арга хэмжээ авч иржээ. Тухайлбал, 1957 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Нагалхаан, Батхааныг, 1965 онд Уран уул, Тулга Тогоо, Жалавч, Булган уул, Хорго, Хасагт хайрхан, Булган гол, Ёлын ам, Лхачинвандад зэрэг газруудыг дархан цаазтай болгосон нь улсын нийт нутгийн 0.12% буюу 1964 км<sup>2</sup> талбайг эзэлж байв. Улмаар 1975 онд говийн байгаль, ховор ан амьтдыг хамгаалах зорилгоор Говийн Их дархан газар, 1976 онд Хөх Сэрхийн нуруу зэрэг нийтдээ 13 дархан газартай, 50 гаруй зүйлийн дархан цаазтай болон агнахыг хориглосон амьтантай болсон байна (Намнандорж, 1976).

**III үе буюу 1990 оноос хойших үе.** 1990 оны ардчилсан хувьсгалын дараагаар засаг төрийн тогтолцоо ч өөрчлөгдөж, байгаль хамгаалах ажил шинэ шатанд гарав. Үүнтэй уялдан байгаль хамгаалах асуудал төр засгийн бодлогын цөмд байх болж, улмаар байгаль хамгааллын дээд хэлбэр болох газар нутгийг дархан хамгаалахад ихээхэн анхаарах болсон. 1990 он хүртэл тусгай хамгаалалттай нутгийг зөвхөн дархан цаазат газар гэсэн ганц ангилалд хамруулж ирснээс гадна, агнуурын нөөц газар гэсэн өвөрмөц ангилал байсныг дурдах нь зүйтэй. Эдгээрт 13 дархан газар, 32 нөөц газар багтаж байв. Эдгээр дархан газруудыг байгуулахдаа байгалийн үзэсгэлэнт байдлыг илүүтэй харгалзсан тул дархан газрын өнөөгийн шаардлагыг төдийлөн тоогоогүй, нутаг дэвсгэрийн хувьд харьцангуй бага талбайтай байхаас гадна, судалгаа шинжилгээний ажил тэр бүр хийгддэггүй байлаа. Иймд тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрийн орны өвөрмөц онцлогт тулгуурлан олон улсын ангилалд дүйцүүлэн боловсруулах бодит шаардлага урган гарсан юм (Оюунгэрэл, 2004).

#### 5.5.4. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал


Монгол Улсын дархан цаазат газруудын анхны тодорхойлолтыг өгч, тусгай хамгаалалттай газар нутгийн анхны ангиллыг тогтоосон хүн бол эрдэмтэн, судлаач О.Намнандорж юм. Дархан газрын тодорхойлолтыг өгөхдөө бүрмөсөн дархалсан, хагаслан дархалсан, орон нутгийн чанартай дархалсан газрууд хэмээн ангилсан нь манай оронд тусгай хамгаалалттай газар нутгийг ангилах анхны оролдлого байсан (Намнандорж, 1976)-аас гадна, хамгаалалтад авбал зохих 100 гаруй газар нутгийн нэрсийг гаргаж аль нь ямар ангилалд хамаарахыг тогтоосон нь тусгай хамгаалалттай газар нутгийн зохистой сүлжээ бүрдүүлэхэд ач холбогдлоо өгсөөр байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг боловсруулах талаар ажилласан анхны судлаачдын нэг бол Я.Даш бөгөөд тэрээр Монгол орны байгалийн бүх хуваарилалтыг илэрхийлэх унаган төрх бүхий тодорхой хэсгийг “Мөнхийн их загвар” болгон удаан хугацаагаар судлахаар аж ахуйн бүх үйл ажиллагаанаас чөлөөлөн хамгаалах зориулалттай нутгийг дархан цаазтай газар, ургамал амьтны удмын санг ариглан “Мөнхийн бага загвар”-т тооцон байгалийн үзэсгэлэн, зарим нөөц баялгийг тусгайлан хамгаалж, тэнд амралт зугаалга, аялал жуулчлал зохион явуулах нутгийг улсын байгалийн парк, хөрс ургамал, амьтны болон геологи, ус зүйн нөөцийг арвижуулах экологийн зохицуулалтад аж ахуйн үйл ажиллагааг тусгай горимоор тодорхой хугацаанд хянан зохицуулж хамгаалах “Орон цагийн өөрчлөлтийн хувьсах загвар” нутгийг нөөц газар, газар хөрс, ургамал, амьтны түүхэн хөгжлийн үе шатыг илтгэн харуулах тогтоц бүхий шинжлэх ухааны түүх соёл, гоо зүйн холбогдолтой объектыг “Шинжлэх ухааны соёлын үнэт фонд”-д тооцон хамгаалахыг дурсгалт газар гэж ангилахыг санал болгосон (Даш, 1979) байна. Тэрээр дархан цаазтай газарт Богдхан уул, Хасагт хайрхан, Хөх Сэрх, Говийн Их дархан газар, байгалийн паркт Хорго, Булган уул, Ёлын ам, нөөц газарт Нагалхаан, Лхачинвандад, Батхаан, Булган гол, дурсгалт газарт Урантогоо, Тулга-Бүрхээр-Жалавчийг тус тус хамруулах санал тавьж байжээ.

Ангиллын талаар Б.Мандал (1987), Ц.Мөнхжаргал (1989) зэрэг олон судлаачдын бүтээлд дурдсан нь бий. Ц.Мөнхжаргал (1989) дархан цаазтай газар, үндэсний дархан газар буюу байгалийн үндэсний цогцолбор, байгалийн дурсгалт газар, нөөц газар гэсэн ангилалтай байх нь зүйтэй гээд Богд уул, Говийн Их дархан газруудыг дархан газар, Нагалхаан, Батхаан, Булган уулыг үндэсний дархан газар буюу байгалийн цогцолборт газар, Лхачинвандад, Хасагт хайрхан, Хөх Сэрх, Булган голыг нөөц газар, Хорго, Урантоого, Тулга, Бүрхээр, Жалавч, Ёлын ам зэргийг байгалийн дурсгалт газарт оруулсан байна. Эдгээр судлаачдын хийж байсан ангилал нь 1995 онд батлагдсан Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан ангиллуудтай үндсэндээ тохирч байгаа юм.

1990 оноос тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг дэлхийн жишигт ойртуулах, нэгдсэн ангилал тогтоох, түүний хүрээнд хууль дүрэм боловсруулах ажлууд тодорхой үе шаттайгаар хийгдэж ирсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн олон улсын ангиллыг баримтлан өөрийн орны өвөрмөц онцлогт тохируулан дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн 4 үндсэн ялгавартай ангиллыг баримтлах саналыг боловсруулсан (Оюунгэрэл, Даш, Авирмид, 1990; 1991) бөгөөд мэргэжлийн эрдэмтдийн санал дүгнэлтийг үндэслэн энэ ангиллыг УИХ-аас 1994 онд баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-д бүрэн хэмжээгээр тусган дэмжиж, одоо хүртэл мөрдөгдөж байна (Оюунгэрэл, 2004). Ийнхүү Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг олон улсын жишигт тохирох 4 үндсэн ялгавартай ангиллын дагуу бүрдүүлж байна. Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар 121 газрыг дээрх 4 ангиллын хүрээнд улсын тусгай хамгаалалтад аваад байна.

**Зураг 5.12.** Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд



**Дархан цаазат газар.** Энэхүү ангилал нь Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Ia ангилалтай тохирдог. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Дархан цаазат газар нь олон төрлийн хамгаалалттай нутаг дэвсгэрүүдийн дотроос хамгийн дээд хэлбэр нь бөгөөд байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалах, удаан хугацаагаар хамгаалж судлахаар аж ахуйн үйл ажиллагаанаас чөлөөлөгдсөн, тухайн нутгийнхаа шинж байдал, онцлогийг төлөөлж чадахуйц загвар нутаг юм.

Байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалах, байгалийн үзэгдэл, үйл явцыг өөрийн нь хөгжил хөдөлгөөн дунд нь судлах, байгаль хамгаалах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилгоор дархан газрыг байгуулдаг тул дархан газарт аж ахуйн ямар нэг объект байх ёсгүй бөгөөд тэнд байгаа байгалийн баялгийг ашиглах, ан амьтдыг үргээж байршлыг нь алдагдуулах үйл ажиллагаа байж болохгүй. Нэг үгээр хэлбэл, дархан газар нь байгаль хамгааллын дээд хэлбэр учраас байгалийн унаган төрхийг хэвээр хадгалж буй ямар ч өөрчлөлтгүй байгалийн жишүүр хэсэг юм (Даш, 1989, Оюунгэрэл, 1990).

Үүнээс гадна, дархан цаазат газрыг байгуулах зайлшгүй нэг нөхцөл нь эрдэм шинжилгээний ажил явуулах асуудал болно. Дархан газрын гол чиглэл бол хамгаалалтын горимыг чанд мөрдөж байгалиа судлах, амьтан, ургамлыг нь өсгөж үржүүлэх, хамгаалах ажил юм. Уудам газар нутаг эзэлсэн дархан цаазат газар байгуулах ерөнхий үндэслэлийн нэг бол сүүлийн үед илүү анхаарал хандуулах болсон байгалийн экосистемийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр болно.

**Хүснэгт 5.6.** Улсын тусгай хамгаалалтад авсан дархан цаазат газрууд

№	Дархан цаазат газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
1	Хөх Сэрх	75,749	1977	Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Ховд аймгийн Ховд сум
2	Богдхан уул	42,271	1957, 1978	Улаанбаатар хот, Төв аймаг
3	Хасагт хайрхан	26,760	1965	Говь-Алтай аймгийн Шарга, Жаргалант сум
4	Хан Хэнтий	1,748,103	1992	Төв аймгийн Эрдэнэ, Мөнгөнморьт, Батсүмбэр, Хэнтий аймгийн Батширээт, Өмнөдэлгэр, Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал сум
5	Нөмрөг	311,205	1992	Дорнод аймгийн Халх гол сум
6	Дорнод Монгол	589,905	1992	Дорнод аймгийн Матад, Халх гол, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум
7	Монгол Дагуурын "А" хэсэг	92,880	1992	Дорнод аймгийн Чулуунхороот, Гурванзагал, Дашбалбар сум
8	Монгол Дагуурын "Б" хэсэг	102 926	1992	Дорнод аймгийн Чулуунхороот, Гурванзагал, Дашбалбар сум
9	Отгонтэнгэр	95,510	1992	Завхан аймгийн Отгон, Алдархаан сум
10	Увс нуурын ай сав	441,223	1993	Увс аймгийн Тэс, Давст, Малчин, Наранбулаг, Тариалан, Баруунтуруун, Сагил, Түргэн, Бөхмөрөн, Ховд сум
11	Хорьдол сарьдаг	226,926	1997	Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ.

№	Дархан цаазат газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
12	Алтан элсний хэсэг	150,244	1993	Увс нуурын сав газар
13	Түргэн уул	130,473	1993	Увс аймаг
14	Цагаан Шувуут	33,305	2008	Увс аймаг
15	Ноён уулын 1-р хэсэг	21,665	2020	Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сум
16	Ноён уулын 2-р хэсэг	2,652	2020	Сэлэнгэ аймгийн Мандал сум
17	Зэд-Хантай-Бүтээлийн нуруу	604,265	2011	Булган аймгийн Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ сум
18	Улаан тайга	431,694	2003, 2011	Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Баянзүрх сум
19	Говийн Бага “А” хэсэг	1,147,813	1996, 2006	Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сум
20	Говийн Бага “Б” хэсэг	682,687	1996, 2006	Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сум
21	Говийн Их “А” хэсэг	4,633,300	1997	Баянхонгор, Говь-Алтай
22	Говийн Их “Б” хэсэг	1,835,724	1997	Ховд, Говь-Алтай

Нийт 22 газар буюу Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 8.8%-ийг эзлэх 13,798,732 га нутаг дэвсгэрийг дархан цаазат газрын ангиллаар хамгаалалтад аваад байна. Хамгаалалтад орсон дархан цаазат газрууд талбайн хувьд харилцан адилгүй байгаа бөгөөд хамгийн том дархан цаазат газар бол манай оронд төдийгүй дэлхийд дээгүүр орох Говийн Их дархан цаазат газар юм. Хэмжээгээрээ хамгийн бага нь Ноён уулын 2-р хэсэг юм.

**Байгалийн цогцолборт газар.** Энэхүү ангилал нь Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны II ангилалтай тохирдог.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Байгалийн цогцолборт газар нь экологи, түүх, гоозүйн хувьд онцгой ач холбогдолтой хүн амын амралт, аялал жуулчлалд зориулагдсан онцгой газар юм.

Байгалийн цогцолборт газар нь аялал жуулчлал, амралт сувилал, сургалтын болон эрдэм шинжилгээний ач холбогдолтой ландшафт, ус, ургамал, амьтан, амьгүй байгалийн объект, түүх соёлын дурсгалыг хамгаалах, амралт, аялал жуулчлалыг явуулах бүх талын нөхцөл бүрдүүлэх, түүх, соёлын дурсгал болон байгалийн сайхныг танилцуулах, сурталчлах, амралт, аялал жуулчлалын зорилгоор ашиглах нөхцөлд байгаль хамгаалах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зэрэг үүрэгтэй байна (Даш, 1989).

Байгалийн цогцолборт газар нь унаган байдлаараа байгаа амьд байгалийн орд буюу музей, ландшафтын онцгой орчин төдийгүй эрүүл энхийг тэтгэх их нөөцийг агуулж байдаг. Байгалийн цогцолборт газрыг байгуулах бодит шалтгаан нь хүн амын өсөн нэмэгдэж буй амралт, аялал

жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой юм. Энд байгалийн цогцолборын тэнцвэрт харьцааг алдагдуулахгүй, түүнийг алдралд оруулахгүйгээр хүн амын тав тухтай амрах зугаацах бүх боломжийг бүрдүүлэх учиртай. Иймээс томоохон хот, аймаг, сумдын ойролцоо, очиход дөхөм байгалийн үзэсгэлэнт газрыг сонгон авахын зэрэгцээ хамгийн гол нь үйлдвэрийн хөгжил, хүн амын нягтшил, аялал жуулчлалын эрэлт хэрэгцээг ихээхэн харгалзах шаардлагатай (Оюунгэрэл, 1989).

Байгалийн унаган төрх, хөрс, ус, ургамал, амьтан, түүх, соёлын дурсгалыг хадгалан байгалийн иж бүрдлийг хамгаалах, аялал жуулчлалыг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр зохион байгуулах, хүний танин мэдэхүй, гоо сайхан, экологийн хүмүүжил олгох, хүн байгалийн харьцааг зөв зохицуулах шинжлэх ухааны үндэслэл боловсруулахад оршино. Цогцолборт газрыг сонгохдоо дархан газрын адил байгалийн иж бүрдэл, ландшафтын онцлогийг төлөөлсөн байдлыг харгалзахын зэрэгцээ амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд боломжтой газрыг сонгож байгуулдаг.

Монгол Улс байгалийн үзэсгэлэнт газар нутаг ихтэй, аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломжтой учраас байгалийн цогцолборт газрыг өргөнөөр байгуулах бодлого баримталж байна. Одоогийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 8.6% буюу 13,946,402 га газрыг байгалийн цогцолборт газрын ангиллаар хамгаалалтад аваад байна (Хүснэгт 5.7).

**Хүснэгт 5.7. Улсын тусгай хамгаалалтад авсан байгалийн цогцолборт газрууд**

№	Байгалийн цогцолборт газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
1	Хөвсгөл нуур	838,070	1992	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Ренчинлхүмбэ, Цагаан Үүр, Ханх, Чандмань-Өндөр
2	Хорго-Тэрхийн цагаан нуур	77,267	1965, 1995	Архангай аймгийн Тариат сум
3	Говь гурван сайхан	2,694,307	1665, 1993, 2000	Өмнөговь аймгийн Сэврэй, Баяндалай, Булган, Ханхонгор, Хүрмэн, Гурвантэс сум
4	Горхи-Тэрэлж	293,168	1993	Төв аймгийн Эрдэнэ сум
5	Алтай Таван Богд	636,161	1996	Баян-өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл, Сагсай, Алтай сум
6	Хангайн нуруу	888,455	1996, 2004, 2020	Архангай аймгийн Чулуут, Булган, Цэнхэр, Хотонт, Ихтамир, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзийт, Уянга, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Галуут сум
7	Хар-Ус нуур	850,272	1997	Ховд аймгийн Мянгад, Дөргөн, Чандмань, Манхан, Буянт сум
8	Ноён хангай	59,088	1998	Архангай аймгийн Хангай, Төв аймгийн Алтанбулаг сум
9	Хустайн нуруу	50,620	1993, 1998	Төв аймгийн Баянхангай, Аргалант сум
10	Хяргас нуур	341,301	2000	Увс аймгийн Завхан, Наранбулаг, Цагаанхайрхан, Малчин, Хяргас сум
11	Хан Хөхий	221,589	2000	Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай Цагаанхайрхан, Хяргас сум

№	Байгалийн цогцолборт газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
12	Сийлхэмийн нуруу “А” хэсэг	69,935	2000	Баян-Өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур сум
13	Сийлхэмийн нуруу “Б” хэсэг	77,943		
14	Цамбагарав уул	111,462	2000	Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сум
15	Тарвагатайн нуруу	545,609	2000	Архангай аймгийн Цахир, Завхан аймгийн Алдархаан, Идэр, Булнай, Их-Уул сум
16	Онон-Балжийн “А” хэсэг	320,241	2000	Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Норивлин, Баян-Адрага,
17	Онон-Балжийн “Б” хэсэг	105,006	2000	Дорнод аймгийн Баян-Уул сум
18	Тужийн нарс	70,011	2002	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Шаамар сум
19	Мянган Угалзатын нуруу	63,167	2002	Ховд аймгийн Цэцэг сум
20	Хөгнө Тарна	84,390	2003	Булган аймгийн Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант сум
21	Дарьганга	62,860	1993, 2004, 2019	Сүхбаатар аймгийн Дарьганга, Наран сум
22	Мөнххайрхан уул, Үенчийн хавцал	506,096	2006, 2011	Баян-Өлгий аймгийн Булган сум, Ховд аймгийн Мөнххайрхан сум
23	Орхоны хөндий	90,000	2006	Архангай аймгийн Хашаат, Хотонт, Өвөрхангай аймгийн Хархорин сум
24	Их Богд уул	262,183	2012	Баянхонгор аймгийн Богд, Жинст, Баянговь сум
25	Ачит нуур-Дэвэлийн арал	211,553	2009, 2020	Увс, Баян-Өлгий аймаг
26	Булган голын эх, Их Онгог	246,082	2019	Ховд аймаг
27	Монгол элс	451800	2010	Говь-Алтай аймгийн Жаргалан, Баян-Уул, Хөхморьт, Завхан аймгийн Алдархаан, Дөрвөлжин сум
28	Хомын тал	411,404	2020	Завхан аймгийн Дөрвөлжин сум
29	Молцог элс	488	1996	Өмнөговь аймгийн Булган сум
30	Их Газрын чулуу	175,906	2012	Дундговь аймгийн Гурвансайхан, Говь-Угтаал сум
31	Өндөрхаан уул	8,820	2012	Хэнтий аймгийн Мөрөн сум

№	Байгалийн цогцолборт газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
32	Гутайн даваа, Хөмүүл гол	102,641	2020	Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сум
33	Заг-Байдрагийн голын эхэн сав	116,309	2012	Баянхонгор аймаг
34	Тэнгис Шишгэдийн гол	869,070	2011	Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Цагаан нуур, Ренчинлхүмбэ сум
35	Улаагчины хар нуур	253,800	2010	Завхан аймаг Цэцэн-Уул, Сантмаргац, Завханмандал, Эрдэнэхайрхан сум
36	Тэсийн гол, Булнайн нуруу	369,631	2019	Хөвсгөл аймаг, Завхан аймаг
37	Чигэртэйн голын ай сав газар	178,367	2012	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум

Байгалийн цогцолборт газар нь дархан цаазат газруудыг бодвол хамгаалалтын хувьд харьцангуй зөөлөрч зохион байгуулалттай аялал жуулчлал хөгжүүлэх зорилготой учраас талбайн хэмжээгээр томоохон байх боломжтой. Манай орны байгалийн цогцолборт газруудаас хамгийн том нь Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газар юм. Дараа нь Хөвсгөл нуур, Хан Хөхий - Хяргас нуур, Тарвагатайн нуруу, Хангайн нуруу, Алтайн Таван Богдын байгалийн цогцолборт газрууд орох бөгөөд хамгийн бага нь Молцог элс, Хустайн нуруу, Ноёнхангай, Мянган угалзат, Дарьгангын байгалийн цогцолборт газрууд юм.

**Байгалийн нөөц газар.** Энэхүү ангилал нь Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны VI ангилалтай тохирдог. Нөөц газар, нөөцийг зохицуулалттай ашиглах газар зэрэг ангиллууд нь байгалийн тодорхой нөөцийг хамгаалах зорилготой билээ. Тэгэхээр өргөн утгаар нь авч үзвэл, тусгай хамгаалалттай газар нь байгалийн нөөцийг хамгаалж байна гэж үзэж болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн **нөөц**, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ” хэмээн тодорхойлжээ. Байгалийн нөөц газрыг дараах төрөлд хуваана. Үүнд:

- Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар
- Ховор, ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар
- Эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар
- Газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар зэрэг болно.

Нөөц газрын ангилал нь тодорхой хугацаагаар байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор хамгаалалтад авч, нөхөн сэргэсний дараа хамгаалалтаас гаргах эсвэл зайлшгүй шаардлагатай гэж үзвэл өөр ангилалд оруулах боломжтой ангилал юм (Оюунгэрэл, 1991).

Шинжлэх ухаан, техникийн өндөр хөгжлийн өнөө үед байгаль орчныг бохирдуулах хүчин зүйл ихэссээр байгаа төдийгүй ховор амьтан, ургамал устаж үгүй болсоор байна. Дэлхийн нийт нутаг дэвсгэрийн 20% орчмыг байгалийг унаган төрхөөр нь хадгалан үлдэх нөөц газар эзлэх ба ирээдүйд эдгээр газрууд одоогийнхоос илүү зүй зохистой ашиглагдах аж ахуйн хөгжлийн нөөц болох ёстой гэсэн тооцоог эрдэмтэд гаргасан байна (Helliwell, 1975). Хүн төрөлхтөн биологийн олон төрөл зүйлийг устгаж байгаа нь өөрсдийнхөө хэрэгцээг хангадаг байгалийн нөөцийн хомсдолыг бий болгож байгаа юм. Тиймээс биологийн төрөл зүйлийг хамгаалах явдал нь улс орныг тогтвортой хөгжүүлэх, хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох асуудалд шийдвэрлэх ач холбогдолтой.

Байгалийн нөөц газрын хувьд одоогийн байдлаар байгалийн иж бүрдлийг хамгаалах газрууд зонхилох хэсгийг эзэлж байна.

**Хүснэгт 5.8. Улсын тусгай хамгаалалтад авсан нөөц газрууд**

№	Байгалийн нөөц газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
1	Нагалхан уул	3,076	1957,1995	Төв аймгийн Эрдэнэ сум
2	Батхаан уул	21,850	1957,1995	Төв аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Бүрд сум
3	Лхачинвандад	58,800	1964,1995	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум
4	Манханы	7,657	1965,1995	Ховд аймгийн Буянт, Манхан сум
5	Угтам уул	46,160	1993	Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун сум
6	Шаргын	313,804	1993	Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Халиун сум
7	Загийн ус	273,606	1996	Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Мандах, Өмнөговь аймгийн Манлай сум
8	Алагхайрхан уул	36,400	1996	Говь-Алтай аймгийн Бугат сум
9	Бурханбуудай уул	52,110	1996	Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Халиун сум
10	Эргэлийн зоо	60,910	1996	Дорноговь аймгийн Хатанбулаг сум
11	Их нарт	43,740	1996	Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сум
12	Тосонхулстай	469,928	1998	Хэнтий аймгийн Баян-Овоо, Норовлин, Дорнод аймгийн Хөлөнбуйр, Цагаан-Овоо сум
13	Хар ямаат	50,594	1998	Дорнод аймгийн Сэргэлэн, Гурванзагал сум
14	Яхь нуур	251,388	1998	Хэнтий аймгийн Баян-Овоо, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум
15	Дэлгэрхангай уул	48,447	2011	Дундговь аймгийн Дэлгэрхангай сум
16	Ханжаргалант	60,000	2003	Булган аймаг

№	Байгалийн нөөц газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
17	Намнан уул	29,600	2003	Булган аймгийн Хутаг-Өндөр, Баян-Агт, Хөвсгөл аймгийн Тариалан сум
18	Баянцагааны тал	332,362	2014	Дорнод аймгийн Хөлөнбуйр, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар сум
19	Онгон таван булаг	155,912	2011	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум
20	Хэрлэн тооно уул	4,461	2012	Хэнтий аймгийн Дархан-Уул, Дэлгэрхаан сум
21	Арван наймын богд уул	25,670	2011	Дорноговь аймгийн Мандах сум
22	Бүрдэнэ булаг	36,159	2011	Дорноговь аймгийн Эрдэнэ сум
23	Дэлгэрхаан уулын	48,447	2011, 2019	Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум
24	Дархан уулын	4,854		
25	Мэнэнгийн цагаан хоолойн	45,748	2020	Дорнод аймгийн Матад сум
26	Халх таван уулын	99,464	2019	Дорнод аймгийн Баянтүмэн сум
27	Хөх нуурын	94,779	2019	Дорнод аймгийн Чойбалсан сум
28	Улз голын	102,527	2019	Хэнтий аймгийн Баян-Адрага, Норовлин, Батноров сум
29	Ташгай таван нуурын	155,178	2019	Дорнод аймгийн Халхгол сум
30	Жаран тогооны тал (А)	97,514	2019	Дорнод аймгийн Матад, Булган, Чойбалсан сум
31	Жаран тогооны тал (Б)	91,095	2019	Дорнод аймгийн Матад, Булган, Чойбалсан сум
32	Баяндун уулын	53,021	2019	Дорнод аймгийн Баяндун сум
33	Зотол хаан уулын	42,628	2019	Сүхбаатар аймгийн рдэнэцагаан сум
34	Хурх хүйтний хөндийн	193,593	2019	Хэнтий аймгийн Батширээт, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адрага сум
35	Гүн гашууны хоолойн	141,319	2019	Дорноговь аймгийн Хөвсгөл сум
36	Тост, Тосонбумбын	743,061	2020	Өмнөговь аймгийн Гурвантэс сум
37	Чойрын Богд уулын	5,265	2011	Говьсүмбэр аймаг
38	Хар Азаргын нурууны	192,580	2011	Говь-Алтай аймгийн Халиун, Цээл сум
39	Хөх нуур Бумбатын	206,805	2019	Баянхонгор аймгийн Гурванбулаг, Завхан аймгийн Отгон сум

№	Байгалийн нөөц газрын нэр	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
40	Дулаан хайрханы	39,035	2019	Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Өлзийт сум
41	Хүрээмандал уулын	19,129	2012	Баянхонгор аймгийн Хүрээмарал сум
42	Чингэлтэй хайрхан уул-1	2,571	2020	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг
43	Чингэлтэй хайрхан уул-2	1,814		
44	Алтан хөхий уулын	190,346	2010	Ховд аймгийн Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь, Өлгий сум
45	Булган хангай уулын	11,407	2012	Увс аймгийн Хяргас сум
46	Тэсийн голын	103,704	2006	Хөвсгөл, Завхан, Увс аймаг
47	Сутай уулын	172,714	2019	Говь-Алтай аймгийн Тонхил, Ховд аймгийн Дарви, Цэцэг сум

Нийт 47 газрыг байгалийн нөөц газрын ангиллаар хамгаалалтад аваад байна. Монгол орны улсын тусгай хамгаалалтад орсон байгалийн нөөц газруудаас хамгаалах зорилгоосоо шалтгаалж талбайн хэмжээ нь янз бүр байна. Томоохонд орох нөөц газар бол зээр, бөхөн хамгаалах зорилго бүхий Шарга Манхан, Тосон хулстай, Яхь нуур, Загийн ус зэрэг газрууд юм.

**Дурсгалт газар.** Энэхүү ангилал нь Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны III ангилалтай тохирдог. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Дурсгалт газар нь “байгалийн” болон “түүхийн” дурсгал гэж хуваагддаг. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоцтой байгаль эхийн бүтээсэн ховор нандин дурсгалууд орно. Тухайлбал, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, явар, цонж, өрх, рашаан булаг, баянбүрд, манхан элс, солир, галт уулын тогоо гэх мэтийн өвөрмөц тогтцууд хамаарна. Байгалийн дурсгалт газрууд хамгаалах газраас шалтгаалж янз бүр байж болно. Түүхийн дурсгалт газарт сүг зураг, бичигт хад, агуй, эртний булш, бунхан гэх мэт зүйлс хамаарна.

Дурсгалт газрууд нь байгалийн тодорхой объектыг хамгаалдаг. Ялангуяа, байгаль түүх, соёлын дурсгал, зайлшгүй хамгаалах шаардлагатай багахан ч гэсэн газрыг хамгаалах нь чухал бөгөөд энэхүү цэгэн тодорхой объектууд нь хамгаалалттай нутаг дэвсгэрийн сүлжээ бүрдүүлэхэд салшгүй нэг хэсэг болно. Манай орны дурсгалт газруудаас хамгийн том нь Ганга нуур, Ээж хайрхан уул бөгөөд энэ нь байгалийн мужийн төлөөлөлдөө өөрийн үүрэгтэйгээс гадна, байгалийн иж бүрдлийн үзэсгэлэнт, өвөрмөц байдлыг төлөөлдөг байна. Хамгийн бага талбайг Булган уул, Сүйхэнт эзэлдэг. Ялангуяа Сүйхэнт нь чулуужсан мод бүхий ховор тогтцыг тэр хэсэгт нь л хамгаалдаг байна.

Түүх соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог бууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш, бунхан, эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз,

суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон чухал үйл явдал болсон газрыг оруулж болно.

**Хүснэгт 5.9.** Улсын тусгай хамгаалалтад авсан дурсгалт газрууд

№	Дурсгалт газрууд	Талбайн хэмжээ (га)	Хамгаалалтад авсан он	Хамрагдах аймаг, сумын нэр
1	Булган уул	1,840	1965, 1995	Архангай аймгийн Цэцэрлэг сум
2	Уран тогоо-тулга уул	5,800	1965,1995	Булган аймгийн Хутаг-Өндөр сум
3	Ээж хайрхан	22,475	1992,1995	Говь-Алтай аймгийн Цогт Алтай сум
4	Хүйсийн найман нуур	11,500	1992, 1995	Өвөрхангай аймгийн Уянга сум
5	Хангал нуур	3,913	2012	Хэнтий аймаг Өмнөдэлгэр сум
6	Сүйхэнт	4,830	1996	Дорноговь аймгийн мандах сум
7	Биндэрьяа хан уул	5,736	2012	Хэнтий аймаг, Биндэр, Өмнөдэлгэр
8	Даян дээрхийн агуй	31,303	2006	Хөвсгөл аймаг Цагаан-Үүр сум
9	Хүрэн бэлчир	11,842	2010	Баянхонгор аймаг Заг сум
10	Дархан хаан уул	1,646	2012	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум
11	Мөнгөт Цахир	630.8	2012	Увс аймаг Давст сум
12	Цагаан дэлийн агуй	116.0	2019	Дорноговь аймгийн Айраг сум
13	Баянхонгор хайрхан уул	2,368	2020	Баянхонгор аймаг Галуут сум
14	Бага газрын чулуу	2,718	2011	Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сум

Хамгаалалтад авсан дурсгалт газрууд (14 газар) бүгдээрээ байгалийн дурсгалт газар юм. Дурсгалт газар нь мөн л хамгаалах зорилго объектоосоо хамаарч янз бүр байна. Байгалийн дурсгалт газрууд нь хэмжээний хувьд харьцангуй том байх бөгөөд түүх соёлын дурсгал нь бага хэмжээний объектыг хамгаалах болохоор бага талбай эзэлдэг.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO)-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг шинжлэх ухааны судалгаанд суурилан хөгжүүлэх зорилго бүхий Хүн ба Шим мандлын хөтөлбөр (Man and Biosphere Programme)-т манай улсын 7 тусгай хамгаалалттай газар нутаг бүртгэгджээ (Хүснэгт 5.10).

**Хүснэгт 5.10.** НҮБ-ын Хүн ба Шим мандал хөтөлбөрт бүртгэгдсэн газрууд

№	Бүртгэсэн он	Тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Талбайн хэмжээ (га)	Талбайн хэмжээ (км <sup>2</sup> )
1	1991	Говийн Их дархан цаазат газар	6,469,023	64,689
2	1996	Богдхан уулын дархан цаазат газар	42,271	422
3	1997	Увс нуурын ай сав	441,223	4,412
4	2004	Хустайн байгалийн цогцолборт газар	48,400	484
5	2005	Дорнод Монголын дархан цаазат газар	589,905	5,899
6	2007	Монгол Дагуурын дархан цаазат газар	92,880	928
7	2023	Онон - Балжийн байгалийн цогцолборт газар	105,005	1,050
<b>Нийт</b>			<b>7,788,707</b>	<b>77,884</b>

Улс орны хил хязгаарыг үл харгалзан байгалийн, соёлын болон хосолмол (байгаль, соёлын), дэлхийд хосгүй үнэт зүйлсийг Дэлхийн өв гэх бөгөөд эдгээрийг олон улсын тусгай шалгуур үзүүлэлтээр тогтоодог. Монгол Улсаас 2 газар Дэлхийн байгалийн өв, 4 газар Дэлхийн соёлын өвөөр тус тус бүртгэгдсэн байна (Хүснэгт 5.11).

**Хүснэгт 5.11.** Монгол Улсаас НҮБ-ын Дэлхийн байгалийн болон соёлын өвд бүртгэгдсэн газрууд

№	Бүртгэгдсэн он	Дэлхийн өвөөр бүртгэгдсэн газрын нэр	Өвийн төрөл
1	2003	Увс нуурын ай сав газар	Байгалийн өв
2	2004	Орхоны хөндийн соёлын дурсгалт газар	Соёлын өв
3	2011	Монгол Алтайн нурууны хадны сүг зургийн цогцолбор	Соёлын өв
4	2015	Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар	Соёлын өв
5	2017	Дагуурын ландшафт	Байгалийн өв
6	2023	Буган хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор	Соёлын өв

### Бүлгийн дүгнэлт

Хамгаалалттай газар нутгийн олонх нь бүс нутгийнхаа хувьд ач холбогдолтой, ялангуяа нутгийн уугуул иргэдийн амьжиргаа болон байгалийн нөөцийн тогтвортой нийлүүлэлтэд нөлөөлж хүмүүст дэлхий ертөнц дээр амар тайван байх урам зориг өгч уриалан дуудсан газар болдог.

Хамгаалалттай газар нутаг нь соёлын чухал үнэ цэнийг илтгэдэг. Тэдгээрийн зарим нь тогтвортой газар ашиглалтын туршлага болно. Мөн түүнчлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, судалгааны ажилд чухал ач холбогдолтой төдийгүй бүс нутгийн эдийн засагт аялал жуулчлалыг хөгжүүлснээр жинтэй хувь нэмэр оруулдаг. Биологийн төрөл зүйлийг хамгаалахад тусгай хамгаалалттай газар нутаг онцгой ач холбогдолтой.

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг олон улсын жишигт тохирох 4 үндсэн ялгавартай ангиллын дагуу бүрдүүлж байна. Манай улсын хэмжээнд одоогийн байдлаар 121 газрыг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, нөөц газар болон дурсгалт газар гэсэн 4 ангиллын хүрээнд улсын тусгай хамгаалалтад аваад байна.

**Асуулт, даалгавар**

- Чулуун зэвсгийн үеийн дурсгал Монгол орны аль бүс нутагт түгээмэл тархсан байдаг вэ? шалтгааныг тайлбарлана уу.
- Яагаад Чандманы соёл, дурсгал хэмээн нэрийдсэн вэ? Аль үед хамрагдах вэ?
- Бусад улс орноос ялгарах онцлог бүхий соёлын нэр юу вэ? шалтгааныг тайлбарлана уу.
- Хадны сүг зургийн олдцыг харвал эртний хүмүүс Монгол орны хаагуур нутагладаг байсан бэ?
- Байгалийн бүс гэж юу вэ? хаана үүсдэг вэ?
- Байгалийн бүслүүр гэж юу вэ? тайлбарлана уу?
- Байгалийн бүс, бүслүүрийн ялгааг тайлбарла?
- Монгол орны амьтдын тоо толгой буурахад нөлөөлсөн хүчин зүйл юу вэ?
- Нэн ховор болон ховордсон ургамлын зүйлүүд Монгол орны аль бүс нутагт илүү тархаж байна вэ? яагаад?
- Тусгай хамгаалалттай газар нутгийг ямар зорилгоор хамгаалалтад авдаг вэ?
- Байгалийн цогцолборт газар болон байгалийн дурсгалт газрын ялгаа, тэдгээрийн онцлог?
- Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалснаар ямар ач холбогдолтой вэ?

**Бие даалтын сэдэв**

- Хүүхдийн сэвлэг үргээх ёслол
- Цагаан сарын уламжлалт баярыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон ашиглах боломж
- Цагаан идээ, ундаа бэлтгэх уламжлалт арга технологи
- Уламжлалт тоглоом наадгай орон нутгийн соёлыг илэрхийлэгч болох нь
- Хүүхэд хүмүүжүүлэх Монгол ёс заншил, эрт ба эдүгээгийн ялгаа
- Байгаль хамгаалах уламжлал ба уул усыг дээдлэх ёс
- Цагаан агуйн хуучин чулуун зэвсгийн суурин
- Рашаан хадны дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон ашиглах боломж
- Ноён уулын Хүннүгийн язгууртны булш
- Гурван Цэнхэрийн агуйн хадны бичээс, дурсгал
- Дорнод Монголын цагаан зээрийн шилжилт хөдөлгөөн
- Ойт хээрийн бүс ба говийн бүсийн амьтан, ургамлын хэв шинж, тэдгээрийн ялгаа
- Алтайн уулархаг нутгийн нэн ховор, ховор амьтдын тархалт, газарзүйн орчин
- Говь, цөлийн бүсийн нэн ховор, ховор амьтдын тархалт, газарзүйн орчин
- Дорнод Монголын тал хээрийн бүсийн нэн ховор, ховор амьтдын тархалт, газарзүйн орчин
- Хэнтийн уулархаг нутгийн нэн ховор, ховор ургамлын тархалт, газарзүйн орчин
- Говь, цөлийн бүсийн нэн ховор, ховор ургамлын тархалт, газарзүйн орчин
- Дорнод Монголын тал хээрийн бүсийн нэн ховор, ховор ургамлын тархалт, газарзүйн орчин

## Мэдлэг сорих тест

1. Монгол хөөмий аль аймгийн ямар сумаас гаралтай вэ? Мөн хэдэн төрөл байдаг вэ?
  - а. Говь-Алтай аймаг, Жаргалан сум (4 төрөл)
  - б. Ховд аймаг, Дарви сум (5 төрөл)
  - в. Ховд аймаг, Чандмань сум (4 төрөл)
  - г. Говь-Алтай аймаг, Баян-Уул сум (5 төрөл)
2. Цэгийн оронд тохирохыг нь сонгоно уу. “..... нь нэргүй зохиогчтой, мэргэжлийн тодорхой бэлтгэл шаарддаггүйгээрээ шилмэл болоод нийтийн соёлоос ялгаатай байдаг”.
  - а. Соёлын үнэлэмж
  - б. Ардын соёл
  - в. Соёлын хэм хэмжээ
  - г. Соёлын бэлгэ тэмдэг
3. Төв Азийн хөрс шорооноос одоогоос 800,000 жилийн тэртээд холбогдох эртний хүний ул мөр бүхий бууц . . . . . сумын нутагт орших Цагаан агуйгаас олдсон байна.
  - а. Баянхонгор аймгийн Баянлиг
  - б. Баянхонгор аймгийн Бууцагаан
  - в. Баянхонгор аймгийн Галуут
  - г. Баянхонгор аймгийн Жинст
4. Увс аймгийн Сагил сумын Можоогийн хадны зурагт ямар амьтдыг сийлсэн байдаг вэ?
  - а. Янгир, үхэр, тэмээ
  - б. Хонь, ямаа, үхэр
  - в. Аргаль, янгир, тэмээ
  - г. Аргаль, үхэр, адуу
5. Монгол оронд буган чулуун хөшөөний дурсгал аль аймгуудаар элбэг тархалттай байдаг вэ?
  - а. Архангай, Дорнод, Сүхбаатар
  - б. Архангай, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Завхан
  - в. Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь
  - г. Баянхонгор, Өвөрхангай, Төв, Архангай
6. Цэгийн оронд тохирохыг нь сонгон гүйцээнэ үү. Хүрлийн үйлдвэрлэлийн үеийн нэн чухал олдвор бол хүрэл тогоо юм. Үүнийг ерөнхийд нь гурван хөлт, цөгцөн ёроолт гэж 2 хувааж үздэг. Ийм тогоо Төв Ази, Монгол орноос Дунай мөрөн хүртэлх нутгаас олддог. 1988 онд Монголын археологичид . . . . . Тахилтын хотгорт малтсан Хүннү нарын язгууртны том булшнаас Цөгцөн ёроолт тогоо олсон.
  - а. Ховд аймгийн Манхан сумын
  - б. Ховд аймгийн Алтай сумын
  - в. Ховд аймгийн Зэрэг сумын
  - г. Ховд аймгийн Дуут сумын
7. Хүрэл зэвсгийн үе одоогоос хэдэн мянган жилийн тэртээгээс эхэлсэн гэж үздэг вэ?
  - а. 9000
  - б. 8000
  - в. 6000
  - г. 7000
8. Монгол орны хойд ба өмнөд захын цэг өргөргийн хувьд хэдэн градусын зөрүүтэй байдаг вэ?
  - а. 11
  - б. 12
  - в. 10
  - г. 13
9. Монгол орны нутаг дэвсгэрт байгалийн үндсэн хэдэн бүс, бүслүүр илэрдэг вэ?
  - а. 4 бүс, 2 босоо бүслүүр
  - б. 2 бүс, 4 бүс
  - в. 3 бүс, 2 босоо бүслүүр
  - г. 4 бүс, 4 босоо бүслүүр
10. Монгол орны эртний амьтан, ургамлын үлдэгдэл агуулсан өвөрмөц тогтоцтой бүс?
  - а. Хээрийн бүс
  - б. Говийн бүс
  - в. Ойт хээрийн бүс
  - г. Цөлийн бүс

11. Хээрийн бүсийн урдуур баруунаас Их Нууруудын хотгор, Нууруудын хөндийг дамжин зүүн тийш зурвас байдлаар үргэлжлэх бүсийн нэр юу вэ?  
 а. Хээрийн бүс б. Говийн бүс  
 в. Ойт хээрийн бүс г. Цөлийн бүс
12. Жилийн дундаж температурын  $0^{\circ}\text{C}$ , 7-р сарын дундаж температурын  $+20^{\circ}\text{C}$ , 1-р сарын дундаж температурын  $-20^{\circ}\text{C}$ -ын изотермтэй бараг давхацдаг бүсийн нэр юу вэ?  
 а. Хээрийн бүс б. Говийн бүс  
 в. Ойт хээрийн бүс г. Цөлийн бүс
13. Монгол бөхөн нь аль аймгийн нутгаар элбэг тархсан байдаг вэ?  
 а. Говь-Алтай, Завхан б. Ховд, Увс  
 в. Баян-Өлгий, Увс г. Говь-Алтай, Ховд
14. Монгол Улсад халиу агнахыг хэдэн онд хуулиар хатуу хориглосон бэ?  
 а. 1940 б. 1930 в. 1935 г. 1945
15. Монголд 1985 оны байдлаар 30 гаруй мазаалай бүртгэгдсэн бол одоогийн байдлаар хэчнээн мазаалай бүртгэлтэй байгаа вэ?  
 а. 41 б. 46 в. 50 г. 44
16. Монгол оронд хар сүүлт зээр агнахыг хэдэн онд хуулиар хориглосон бэ?  
 а. 1963 б. 1966 в. 1965 г. 1964
17. Монгол оронд хэчнээн зүйлийн хөхтөн амьтан байдаг вэ?  
 а. 141 б. 140 в. 142 г. 143
18. Хэдэн онд УИХ-аас “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль»-ийг баталсан бэ?  
 а. 1992 б. 1994 в. 1993 г. 1995
19. Нагалхаан уул аль аймагт байдаг вэ?  
 а. Төв б. Хэнтий в. Булган г. Хөвсгөл
20. Уран тогоо уул нь ямар галавын үеэр унтарсан галт уул вэ?  
 а. Юра б. Дөрөвдөгч в. Гуравдагч г. Палеоген
21. Архангай аймгийн Эрдэнэбулаг сум буюу Цэцэрлэг хотын ар талд сундлаа гурван оройтой, хажуу сугаар нь ухаа цайвар боржин хад, цохио суваргалсан энэ уулын ар шилээр саглагар хуш, боргоцойгоо дааж ядан найгаж, зүр гур зөрөлдөн, ганга жалгаар нь амтат жимс бөнжийнө. Үнэмлэхүй өндөр нь 1980 м, дархалсан талбай нь 48 км квадрат. Энэ уулын нэр?  
 а. Батхаан уул б. Уран тогоо уул в. Булган уул г. Уран уул
22. Өндөр уулын мөнх цас, мөсөн гол, ян сарьдаг, уулын нуга, хээрийн экосистемийн онцлогийг төлөөлсөн үзэсгэлэнт байгальтай, аргаль, янгир, буга зэрэг хөхтөн, хойлог, тас, ёл зэрэг жигүүртний байршил нутаг бөгөөд уулын спорт, байгалийн аялал жуулчлал хөгжүүлэхэд нэн тохиромжтой нутаг тул 1996 онд УИХ-ын 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан. Энэ газрын нэр?  
 а. Мөнх сарьдаг б. Отгонтэнгэр хайрхан  
 в. Алтай Таван Богд г. Сутай уул

23. Аль нь байгалийн цогцолборт газар вэ?

- а. Хүрээмандал уул
- б. Батхаан уул
- в. Өндөрхаан уул
- г. Цагаан шувуут уул

24. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор Ховор амьтны жагсаалтад орсон амьтныг сонгон тэмдэглэнэ үү.

- а. Шөвгөр мэлхий
- б. Шивэр гүлмэр
- в. Цоохор хонин гүрвэл
- г. Сум могой

25. Доорх шувуудаас аль нь Монгол Улсын Улаан номд орсон бэ?

- а. Шар шувуу
- б. Цармын бүргэд
- в. Одой галуу
- г. Ногтруу

26. Амралт, аяллын үйлчилгээний аль төрөл байгальд бага хөнөөлтэй вэ?

- а. Зан үйлийн аялал
- б. Рашаан сувилал
- в. Байр сууцны үйлчилгээ

27. Нутгийн соёл, уламжлалын хүндэтгэл гэж?

- а. Үзэл бодлыг ойлгох
- б. Импортын хэрэглээнээс татгалзах
- в. Байгаль хамгаалах

28. Амралт, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй эрхлэгч гэж?

- а. Тусгай хамгаалалттай газар нутагт бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд
- б. Улсын бүртгэлийн газарт бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүн
- в. Суманд бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага

29. Амралтын газрын дотоодын авто зам гэж?

- а. Амралтын газрын нутаг дэвсгэрийн гаднах авто зогсоол
- б. Амралтын газрын нутаг дэвсгэр хүрэх авто зам
- в. Амралтын газрын нутаг дэвсгэр дэх авто зам

30. Жуулчны баазын ариун цэврийн хэвийн нөхцөл?

- а. Хиншүү, тоос, шороогүй хүний ажиллаж, амьдрах эрүүл, аюулгүй орчин
- б. Хиншүү, тоос, шороогүй хүний ажиллах аюулгүй орчин
- в. Хиншүү, тоос, шороогүй хүний амьдрах эрүүл, аюулгүй орчин

31. Жуулчны баазын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал?

- а. Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад үүсэж, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмс
- б. Үйлчилгээний явцад үүсэж, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмс
- в. Хэрэглээний болон үйлдвэрлэл, үйлчилгээний явцад үүсэж, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмс

32. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар Дархан цаазат газрыг хэдэн бүсэд хуваадаг вэ?

- а. Онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс
- б. Онцгой бүс, аялал жуулчлалын бүс, хязгаарлалтын бүс

- в. Онцгой бүс, хязгаарлалтын бүс, орчны бүс  
г. Онгон бүс, хамгаалалтын бүс, орчны бүс
33. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар Байгалийн цогцолборт газрыг ямар бүсэд хуваадаг вэ?  
а. Онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс  
б. Онцгой бүс, аялал жуулчлалын бүс, хязгаарлалтын бүс  
в. Онгон бүс, хязгаарлалтын бүс, орчны бүс  
г. Онцгой бүс, хамгаалалтын бүс, орчны бүс
34. Эко тээврийн хэрэгсэл гэж?  
а. Механик хөдөлгүүртэй  
б. Дотоод шаталтын хөдөлгүүртэй  
в. Гибрид хөдөлгүүртэй  
г. Бензинээр ажилладаг
35. Тусгай хамгаалалттай газар нутаг аялах жуулчдын багийн тоо хэдээс хэтрэхгүй байвал зохимжтой вэ?  
а. 5  
б. 10  
в. 15  
г. 20
36. Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын газрын зураг гэж?  
а. Газрын гадаргын аялал жуулчлалын бодит нөөцийг хавтгайд тодорхой тусгаг, масштабд оруулан томъёолсон тэмдэг, тоон үзүүлэлт, план  
б. Газрын гадаргын аялал жуулчлалын бодит нөөцийг хавтгайд тодорхой тусгаг, масштабд оруулан томъёолсон тэмдэгт дүрслэл  
в. Газрын гадаргын аялал жуулчлалын бодит нөөцийг хавтгайд тодорхой тусгаг, масштабд оруулсан хэмжээ
37. Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын зах зээл гэж?  
а. Амралт, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт явагдаж байгаа тусгай хамгаалалттай газар нутгууд  
б. Амралт, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт явагдаж байгаа тусгай хамгаалалттай газар нутаг болон зэргэлдээх сумдын нутаг дэвсгэр  
в. Амралт, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт явагдаж байгаа нутаг дэвсгэр
38. Өвлийн улиралд ямар төрөл, хэлбэрийн аялал давамгайлдаг вэ?  
а. Долоо хоногийн амралтын өдрийн аялал  
б. Нийтийн баярын өдрийн аялал  
в. Ээлжийн амралтын өдрийн аялал  
г. Гэр бүлийн аялал
39. Нутгийн хоолны нөхөрлөлийн гишүүн  
а. Нөхөрлөлд хөрөнгө оруулдаг этгээд  
б. Нөхөрлөлөөс үр ашиг хүртдэг этгээд  
в. Нөхөрлөлд хөрөнгө оруулаад, ашгийг хүртдэг этгээд  
г. Нөхөрлөлд хөрөнгө оруулаагүй ч боломжтой үед ашиг хүртдэг этгээд
40. Байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрт газар эзэмших гэж?  
а. Газрыг хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгах  
б. Газрыг гэрээнд заасан дагуу өөрийн өмчлөлд байлгах  
в. Газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгах  
г. Зохих хууль тогтоомжийн дагуу өмчилсөн байх

## Ашигласан болон гүнзгийрүүлэн сонирхож унших материал

- Баасанжав, Г., Цэнд-Аюуш, Я. (2001). *Монгол орны загас*. Адмон ХХК. Улаанбаатар
- Батчулуун, Е (редактор) (2021). *Монгол орны физик газарзүй*. Сурах бичиг. Мөнхийн Үсэг ХХК. Улаанбаатар
- БНМАУ-ын Үндэсний атлас. 1990. Москва-Улаанбаатар
- Буюн, Д. (2006). *Нийгмийн тухай мэдлэг*. Улаанбаатар. х. 123
- Гомбосүрэн, Ц. (2008). *Философи*. Улаанбаатар
- Даш, Д. (1992). *Говь, говийн бүсийн тухай*. “Даян дэлхийн өөрчлөлт-говь, цөл” сэдэвт симпозиумд хэлэлцүүлсэн илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар
- Даш, Д. (1993). *Ойт хээрийн ландшафт, түүний зарим онцлог*. ШУА-ийн мэдээ. Дугаар 3. Улаанбаатар
- Даш, Д. (2000). *Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн тухай шинэ үзэл баримтлал*. Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 1:183-196
- Даш, Д. (2001). *Их Нууруудын хотгорын элсэн хуримтлалын ландшафт, байгаль хамгааллын асуудал*. Мөнхийн Үсэг ХХК. Улаанбаатар. 180 х.
- Даш, Д. (2015). *Монгол орны ландшафт экологийн асуудал*. Адмон принтинг. Улаанбаатар
- Даш, Д. (2016). *Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн тухай*. Геофорум сэтгүүл. Дугаар 1. Монголын газарзүйн боловсролын нийгэмлэг. Улаанбаатар
- Даш, Д. (2010). *Монгол орны ландшафт-экологийн асуудлууд*. Улаанбаатар
- Дорж, Д., Цэвээндорж, Д. (1978). *Монголын Палеолит*. Улаанбаатар
- Дорж, Д. (1963). *Монголын хүрлийн үеийн хадны зураг*. Улаанбаатар
- Доржсүрэн, Ц. (1957). *Төв, баруун аймгуудад археологийн шинжилгээ, хайгуулын ажил явуулсан тухай*. Эрдэм шинжилгээний бүтээл. 2:108
- Евстифеев, Ю.Г., Панкова, Е.И., Якунин, Г.Н. (1983). *Почвенный покров Заалтайской Гоби*. Глава в коллективной монографии.
- Лувсанцэрэн, Г. (1999). *Монголын соёлын түүх*. Адмон ХХК. Улаанбаатар. 392 х.
- Монгол Улсын Улаан ном. (2013). (Mongolian Red Book\_2013) Third Edition. Улаанбаатар. 517 х.
- Мөнхсайхан, М. (2006). *Соёл судлал*. Улаанбаатар
- Одонтуяа, Л. (2004). *Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог*. Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар
- Окладников, А.П. (1981). *Петролифы Монголии*. Ленинград
- Оюунгэрэл, Б. (2004). *Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг*. Адмон. Улаанбаатар
- Оюунгэрэл, Б. (2012). *Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн аялал, жуулчлалын бүсүүдийн нөөц, даацын судалгаа*. ГЗХ. Улаанбаатар
- Өлзийхутаг, Н. (1989). *Монгол орны ургамлын аймгийн тойм*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар. 206 х.

- Пэрлээ, Х. (1976). *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. Улаанбаатар
- Рачковская, Е.И. (1993). *Растительность Гобийских пустынь Монголий*. СПб., Наука, 135 стр.
- Төрбат, Ц. (2022). *Монголын эртний өв: Монголын буган хөшөө*. Тэргүүн боть. МУИС. Улаанбаатар. 144 х.
- Түвшинтогтох, И. (2014). *Монгол орны хээрийн ургамалжилт*. Бемби сан. Улаанбаатар. 610 х.
- Ундармаа, Ж. (2018). *Rangeland ecosystems of Mongolia*. Мөнхийн Үсэг ХХК. Улаанбаатар
- Цэвээндорж, Д., Баяр Д., Цэрэндагва, Я., Очирхуяг, Ц. (2002). *Монголын археологи*. Улаанбаатар. х. 36-146
- Цэвээндорж, Д., Баяр, Д. (1999). *Монголын нутаг дахь түүх-соёлын дурсгал*. Улаанбаатар
- Цэгмид, Ш (Ред). (1969). *Монгол орны физик газарзүй*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар
- Цэцэнбилэг, Ц., Батжаргал, Ж (Ред). (2017). *Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ*. (Эмхэтгэсэн: О. Баасантогтох, Ё. Ундрал, Ж. Пүрэвханд). Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар. 363 х.
- Чулуунбаатар, Г. (2001). *Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик судалгааны ажлын арга зүй*. Бемби сан. Улаанбаатар
- Юнатов, А.А. (1950). *Основные черты растительного покрова Монгольской Народной Республики*. Москва, Изд-во Академии наук СССР
- Юнатов, А.А. (1954). *Кормовые растения пастбищ и сенокосов Монгольской Народной Республики*. Москва, Изд-во Академии наук СССР
- Urgamal, M. (2014). *Conspectus of the vascular plants of Mongolia*. (Editors: Ch. Sanchir, Ts. Jamsran). “Admon” Press. Ulaanbaatar, Mongolia. 334 pp.

## Тестийн зөв хариулт

### Нэгдүгээр бүлэг

1	2	3	4	5	6	7	8	9	10
г	г	в	а	а	г	г	а	в	г
11	12	13	14	15	16	17	18	19	20
а	г	а	в	а	а	а	г	а	г
21	22	23	24	25	26	27	28	29	30
г	а	а	а	г	а	г	а	а	г
31	32	33	34	35	36	37	38	39	40
б	в	а	а	в	а	в	г	б	в

### Хоёрдугаар бүлэг

1	2	3	4	5	6	7	8	9	10
г	а	б	в	б	б	б	в	г	б
11	12	13	14	15	16	17	18	19	20
г	б	в, г	г	г	г	б	г	в	в

### Дөрөвдүгээр бүлэг

<b>Харилцааны үндэс ба соёл</b>									
1	2	3	4	5	6	7	8	9	10
Б	б	Б	а	б	б	б	а	а	б
<b>Манлайлал ба үр дүнтэй харилцааны арга барил</b>									
1	2	3	4	5	6	7	8	9	10
а, г	а	Б	а	а	а	а	а	а	а
<b>Эерэг хандлага ба хувь хүний манлайлал</b>									
1	2	3	4	5	6	7	8	9	10
б	г	А	б	а	а	г	г	а	г
<b>Стрессийн удирдлага ба багаар ажиллах ур чадвар</b>									
1	2	3	4	5	6	7	8	9	10
б	б	В	а	б	б	а	б	б	а

### Тавдугаар бүлэг

1	2	3	4	5	6	7	8	9	10
в	б	а	в	б	а	г	в	г	г
11	12	13	14	15	16	17	18	19	20
б	а	г	б	б	в	а	б	а	б
21	22	23	24	25	26	27	28	29	30
в	в	в	б	в	а	а	б	в	а
31	32	33	34	35	36	37	38	39	40
в	а	б	а	б	б	в	а	в	в

# ХАВСРАЛТ



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/189 дүгээр “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр батлах тухай” тушаал ба хавсралтууд



**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2024 онь 05 сарыг 29 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

**Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын  
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн байгаль хамгаалагч, туслах байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчид зориулсан “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, сургалтад хамрагдсаныг батлах “Гэрчилгээний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг хангах, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнахыг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар (Д.Ганзориг)-т, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нар, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярмаа)-т, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Гоцбаяр)-т даалгасугай.

Б.Бат-Эрдэнэ  
Б.БАТ-ЭРДЭНЭ

## БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### НЭГ.СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Байгаль хамгаалагчдын хоёрдугаар чуулганы зөвлөмжийн 1.1, 2.2 дахь заалт болон байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, байгаль хамгаалагчдын дунд явуулсан судалгааны үр дүнг үндэслэн сургалтын хөтөлбөрийг боловсрууллаа. Тухайлбал, 2023 онд 700 гаруй байгаль хамгаалагчдаас авсан асуулга судалгаагаар, тэдний 90% хууль, эрх зүйн орчны мэдлэг чадвараа сайжруулах, 65% биологийн олон янз байдлын мониторингийн судалгааны арга зүйг эзэмших, 40% галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгслийг зүй зохистой хэрэглэх дадал чадварыг эзэмших, 30% нь тухайн орон нутгийнхаа амьтан, ургамлын зүйлүүдийг таньж тодорхойлох, судалгааны багаж хэрэгслийг бүрэн ашиглаж сурах, 20% хэрэг, зөрчил илрүүлсэн тохиолдолд хэргийн газрын үзлэгийг зөв, тодорхой гүйцэтгэх, мөн олон нийттэй харилцах, яриа таниулга хийх зэрэг харилцааны үр чадвараа сайжруулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байдаг. Иймд олон улсын сайн туршлагаас судалж, энэ бүгдийг өөрийн орны онцлог, нөхцөл байдал, хууль, эрх зүйн орчинтой тусган боловсрууллаа.

### ХОЁР.СУРГАЛТЫН ЗОРИЛГО

Сургалтын хөтөлбөрийн зорилго нь тодорхой үе шаттай, богино хугацааны, системтэй хөтөлбөрөөр байгаль хамгаалагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой практик мэдлэг, үр чадварыг сайжруулж, чадавхжуулахад оршино.

### ГУРАВ.СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЛБАН ХААГЧИД

Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч, туслах байгаль хамгаалагч болон идэвхтэн байгаль хамгаалагч нар хамрагдана.

### ДӨРӨВ.СУРГАЛТЫН ҮЕ ШАТ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ДАВТАМЖ

Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр анхан, дунд, ахисан гэсэн 3 үе шаттай байна. Ажилд анх томилогдож буй байгаль хамгаалагчид анхан шатны сургалтад хамрагдана. Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр тус бүрийн үргэлжлэх хугацаа 40 цаг буюу ажлын 5 өдрөөс ихгүй байна. Анхан, дунд болон ахисан шатны мэргэшүүлэх сургалтыг жилд нэг удаа зохион байгуулна.

### ТАВ.СУРГАЛТЫН ХЭЛБЭР, АРГА ЗҮЙ

Байгаль хамгаалагчийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тухайн орчин нөхцөлд нь оролцооны аргад тулгуурлан дадлага ажил, бодит жишээ, үзүүлэн таниулах материал, хэрэг зөрчлийн тохиолдол дээр хэлэлцүүлэг өрнүүлэх, ярилцах, газрын зураг, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж дээр ажиллуулах зэрэг оролцооны хэлбэрээр зохион байгуулна.

### ЗУРГАА. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Сургалт эхлэхийн өмнөх болон дараах сорилоор байгаль хамгаалагчийг үнэлэх бөгөөд сургалтад хамрагдсан байгаль хамгаалагчид тухайн шатны хөтөлбөрийн агуулгыг

Бүрэн эзэмшсэнийг батлах сертификат олгоно. Сорилын үр дүнд анализ хийж хөтөлбөрийг сайжруулах, агуулгад өөрчлөлт оруулах үндэслэл болгон ажиллана.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нар, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга байгаль хамгаалагчийн үр дүнгийн гэрээг үнэлэхдээ сургалтад хамрагдсаныг батлах сертификатыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн үр дүнгийн гэрээ дүгнэх журмыг баримтална.

**БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АНХАН ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Үндсэн агуулга	Сургалтын хэлбэр	Цаг	Хэнд хамаарах
<b>Нэг. Байгаль хамгаалагч, түүний ажил үүрэг</b>			
Байгаль хамгаалагч гэж хэн бэ, үнэ цэнэ Байгаль хамгаалагчийн ёс зүйн хэм хэмжээ Байгаль хамгаалагч хүний эрхийг хамгаалагч болох тухай Байгаль хамгаалагчийн эрх үүрэг Байгаль хамгаалагчийн нийгмийн баталга Байгаль хамгаалагчийн албан тушаалын тодорхойлолт, тавигдах шаардлага	Лекц (100%)	6	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Хоёр. Байгаль хамгаалагчийн хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл</b>			
Байгаль хамгаалагчийн нэг бүрийн тусгай хэрэгсэл, тэдгээрийг зөв зохистой ашиглах заавар, зөвлөмж Байгаль хамгаалагчийн хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд Газрын зургийн төрөл, түүнийг хэрэглэх заавар Луужингаар зүг чиг олох, чиглэл хэмжих заавар Байршил тогтоогч багаж (GPS)-ийн бүтэц, зохион байгуулалт, хэрэглэх заавар Автомат камерын бүтэц, ажиллах зарчим, хэрэглэх заавар Дроны төрөл, бүтэц, ажиллах зарчим, хэрэглэх заавар Гэрэл зургийн аппаратын төрөл, хэлбэр, хэрэглэх заавар	Дадлага (100%)	6	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Гурав. Аюулгүй ажиллагаа ба анхны тусламжийн тухай</b>			
Аюулгүй ажиллагааны тухай Анхны тусламжийн хайрцаг, техник Амьтанд хазуулж, хатгуулсан үед үзүүлэх анхны тусламж Ясны хугарал, битүү бэртэл, гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж Цус алдах үед үзүүлэх анхны тусламж Ой хээрийн болон орон байрны түймэрт өртөж түлэгдэх үед үзүүлэх анхны тусламж Усанд живсэн хүнд үзүүлэх анхны тусламж Химийн бодист хордох болон химийн бодисын ослын үед үзүүлэх анхны тусламж Цахилгааны ослын үед үзүүлэх анхны тусламж Нүд гэмтэх үед үзүүлэх анхны тусламж Зүрхний даралт өөрчлөгдөх болон зүрхний шигдээсний үед үзүүлэх анхны тусламж Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх	Лекц (30%) Дадлага (70%)	8	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Дөрөв. Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, тайлагнал</b>			
Хээрийн судалгааны ажлын зорилго, цар хүрээг тодорхойлж, төлөвлөх Эргүүл хяналтын ажлын зорилго, төрөл, цар хүрээг тодорхойлж, төлөвлөх Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг бүртгэж тэмдэглэх, мэдээлэх Ажлыг тайлагнах, тайлан бичих заавар, зөвлөмж	Лекц (50%) Дадлага (50%)	4	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Тав. Биологийн олон янз байдлын судалгаа, мониторинг (БИОСАН)</b>			

Хөхтөн амьтдын тархац байршил, тоо толгой, нягтшилыг үнэлэх судалгааны арга <ul style="list-style-type: none"> <li>○ Цэгэн ажиглалтын арга</li> <li>○ Шугаман замналын арга</li> <li>○ Хос ажиглагчийн арга</li> <li>○ Автомат камерын арга г.м</li> </ul> Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	6	БХ ТБХ ИБХ
Шувуудын тархац, нягтшилыг үнэлэх судалгааны арга <ul style="list-style-type: none"> <li>○ Цэгэн ажиглалтын арга</li> <li>○ Шугаман замналын арга</li> <li>○ Дээж талбайн арга г.м</li> </ul> Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	4	БХ ТБХ ИБХ
Загас, хоёр нутагтан, мөлхөгчдийн тархац, амьдрах орчны сонголт болон нягтшилыг тодорхойлох судалгааны аргууд (дээж талбайн арга, шугаман замналын арга г.м) Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	2	БХ ТБХ ИБХ
Байгалийн ургамлын тархац нутаг, ургах орчин, арвийг тодорхойлох судалгааны аргууд (дээж талбайн арга, арвийг тодорхойлох арга г.м) Хээрийн тэмдэглэл хөтлөх, мэдээлэл цуглуулах хуудас бөглөх заавар	Лекц (30%) Дадлага (70%)	4	БХ ТБХ ИБХ
<b>Нийт</b>		<b>40</b>	

**Тайлбар:** Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (УБЭБХ), байгаль хамгаалагч (БХ), туслах байгаль хамгаалагч (ТБХ), идэвхтэн байгаль хамгаалагч (ИБХ).

## БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ ДУНД ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Үндсэн агуулга	Сургалтын хэлбэр	Цаг	Хэнд хамаарах
<b>Нэг. Байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчин</b>			
Байгаль орчны салбарын бодлого Байгаль орчны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, нэгдэн орсон гэрээ конвенц Байгаль орчны салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчин	Лекц (30%) Дадлага (70%)	8	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Хоёр. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа</b>			
Зэрлэг амьтан авран хамгаалах үйл ажиллагааны тухай ойлголт Зэрлэг амьтан аварч, асран хамгаалж буй олон улсын сайн туршлага Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт, багц стандартын тухай Зэрлэг амьтан авран хамгаалагчдын ёс суртахуун ба эзэмшвэл зохих үндсэн мэдлэг, чадвар, дадал Зэрлэг амьтдад үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ Хөхтөн, шувуу, мөлхөгчид болон хоёр нутагтан амьтдыг аврах, асран хамгаалах	Лекц (50%) Дадлага (50%)	4	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Гурав. SMART программын сургалт</b>			
SMART программын үндсэн хэрэглээ, ач холбогдол, танилцуулга SMART программын бүтэц, зохион байгуулалт Газрын зургийг бэлтгэх, нэр оруулж, зураглах SMART программын өгөгдлийн моделиуд, ажиллах зарчим	Лекц (30%) Дадлага (70%)	4	УБЭБХ БХ ТБХ
SMART программын мобайл хувилбарын бүтэц, үүрэг ажиллагаа, холбоос үүсгэх, эргүүлийн хяналтын мэдээг экспорт хийх Тухайн бүс нутагт эргүүл хяналтын ажлыг зохион байгуулах календарчилсан төлөвлөгөө гаргаж, бэлтгэх Тайлангийн загвар, лавлагаа үүсгэх	Лекц (30%) Дадлага (70%)	4	УБЭБХ БХ ТБХ
SMART программыг ашиглан хээрийн эргүүл, мониторингийн ажлыг зохион байгуулах Хээрийн дадлага ажил хийх	Лекц (30%) Дадлага (70%)	8	УБЭБХ БХ ТБХ

<b>Дөрөв. Харилцааны ур чадвар ба хувь хүний хөгжил</b>			
Харилцааны ур чадвар гэж юу? Харилцааны үндсэн ойлголтууд Харилцааны соёл, ёс зүй, зарчим Харилцааны хэлбэр (аман, бичгийн г.м) Гэр бүл болон ажлын байран дахь харилцаа	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Удирдан, манлайлах чадвар Дотоод, гадаадын түншүүдтэй харилцах арга хэлбэр, зарчим Нутгийн иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг бэлтгэж, хүргэх, танилцуулах, ухуулга ярианы аргууд Аман судалгаагаар мэдээлэл цуглуулж, боловсруулах арга техник	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Сайн зан үйлийг үлгэрлэх, эерэг хандлагатай байх Мэргэжлийн, хүндэтгэлтэй, ёс зүйтэй, хариуцлагатай, хууль ёсны дагуу аюулгүй ажиллах Үр дүнтэй, санаачилгатай ажиллаж, шийдвэр гаргах болон асуудал шийдэхэд оролцох Бусдыг дэмжих, урамшуулах, харилцах, ил тод, шийдэмгий, үнэнч, идэвхтэй байх Хувийн хариуцлага хүлээх, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох зэрэг хувь хүний манлайлах чадварууд	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
Ажлын байрны стресс, түүнийг даван туулах арга, техник Багаар ажиллах, хамтран ажиллах, эелдэг харилцах, анхаарал халамж тавих Хэрүүл маргаанаас зайлсхийх, маргааныг шийдвэрлэх, хамтран ажиллагсадтайгаа маргаан үүсгэхээс урьдчилан сэргийлэх	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Тав. Хөтөч тайлбарлагч</b>			
Орон нутгийн түүх, соёл, уламжлал, ёс заншил Орон нутгийн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийн онцлох дурсгалууд, булш бунхан, археологийн олдворууд, түүх соёлын дурсгал Байгаль, газарзүйн тогтоц, бүс бүслүүрийн онцлог Нэн ховор, ховор, ховордож буй ургамал, амьтад, тэдгээрийн тархац байршил, амьдралын онцлог Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн түүх, соёл, байгаль, газарзүйн тогтоц, биологийн олон янз байдлын хамгаалалтын дэглэм, онцлог	Лекц (50%) Дадлага (50%)	4	УБЭБХ БХ ТБХ ИБХ
<b>Нийт</b>		<b>40</b>	

**Тайлбар:** Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (УБЭБХ), байгаль хамгаалагч (БХ), туслах байгаль хамгаалагч (ТБХ), идэвхтэн байгаль хамгаалагч (ИБХ).

## БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АХИСАН ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Үндсэн агуулга	Сургалтын хэлбэр	Цаг	Хэнд хамаарах
<b>Нэг. Зөрчил илрүүлэх, шалгах хууль, эрх зүйн үндэслэл, онцлог</b>			
Гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа, онцлог Зөрчил илрүүлэх, шалгах хууль зүйн үндэслэл Зөрчлийн тухай хууль, түүний агуулга, зөрчлийн тухай ойлголт, шинж, онцлог Зөрчлийн тухай хуульд заасан зарчим, үйлчлэх нутаг дэвсгэр, хөөн хэлэлцэх хугацаа Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай	Лекц (100%)	3	УБЭБХ БХ
<b>Хоёр. Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг хэрэг зөрчлийн мэдээлэл цуглуулах, үзлэг хийх арга техник</b>			

Мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах арга техник Хэргийн газрын үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа Галт зэвсэгт хийх үзлэг, арга техник ба аюулгүй ажиллагаа Эд мөрийн баримтад хийх үзлэг, арга техник Шинжилгээ хийлгэх ажиллагаа Мэдүүлэг авах, ярилцлага хийх арга техник Нотлох, хянан шийдвэрлэх ажиллагаа	Лекц (30%) Дадлага (70%)	16	УБЭБХ БХ
<b>Гурав. Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал</b>			
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Агаарын тухай хууль болон Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Амьтны тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	3	УБЭБХ БХ
Байгалийн ургамлын тухай хууль болон Ургамал хамгааллын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Ойн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Ашигт малтмалын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	3	УБЭБХ БХ
Газрын хэвлийн тухай хууль болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	1	УБЭБХ БХ
Усны тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	3	УБЭБХ БХ
Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах, түүний шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
Генетик нөөцийн тухай хууль зөрчих, зөрчлийн шинж, онцлог, анхаарах асуудал	Лекц (30%) Дадлага (70%)	2	УБЭБХ БХ
<b>Нийт</b>		<b>40</b>	

**Тайлбар:** Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч (УБЭБХ), байгаль хамгаалагч (БХ).

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн  
А/199 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

# СЕРТИФИКАТ

№ .....

.....  
/овог, нэр/

## **БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АНХАН ШАТНЫ 40 ЦАГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ТУЛ СЕРТИФИКАТ ОЛГОВ.**

Төрийн нарийн бичгийн дарга .....  
/овог, нэр/

.....  
/гарын үсэг/

..... он ..... сар ..... өдөр